

# В.Гюго

## ШООВДОР ХҮМҮҮС

### ОРШИЛ

Францын алдарт хүү, дэлхийн сонгодог зохиолч Виктор Гюго хорин таван мянган франкаар толгойгоо үнэлүүлж хонгор хайрт Франц нутгаасаа харгисуудад хавчигдан хөөгдөөд харь холын хүний оронд хоргодож явахдаа гучин жилийн турш оюундаа боловсруулсан уран чадварлаг “Шоовдор хүмүүс” гэдэг алдарт романыгаа анхны хэсгийг 1862 онд Брюссель, Парис хотуудад нэг зэрэг хэвлүүлжээ. Тэр дорхиноо Англи Америк, Герман, Итали, Орос орнуудад орчуулагдан гарч олон түмний сонирхлыг их татжээ.

Үргэлжлэлүүд нь удсан ч үгүй хэвлэгдсэн аж.

Энэ роман Виктор Гюгогийн уран бүтээлийн хоёр дахь үед хамрагдана.

1848 оны хувьсгал, түүний дараа Луй Бонапартаас хувьсгалын эсрэг үйлдсэн эргэлт Виктор Гюгогийн уран бүтээлд шинэ үе нээлээ. Зохиолч Францын улс төрийн үйл амьдралд улам идэвхтэй оролцохын хамт янэ бүрийн оны дарлагдсан ард түмний эрх чөлөөний хөдөлгөөнд цуцалтгүй оролцох болж өөрийн зохиолуудад тэдний хүсэл эрмэлзлийг харуулж эхлэв.

Яруу найраг, үргэлжилсэн үгийн ба нийгмийн зохиолч Виктор Гюго ардчилсан үзэлтэй, дэлхийн утга зохиолын тэргүүний зүтгэлтэн боллоо. Гюго хөрөнгөтөн нийгмийн дунд гаслан зовж байгаа ганц нэг хүний амьдралыг харуулж байсан бол 1848 оны хувьсгалын дараа ард түмний амьдралын нийтлэг чанарыг харуулах боллоо. Жишээ нь хөрөнгөт нийгмийн дотроос дарлагдсан ард түмний амьдрал “Шоовдор хүмүүс” гэдэг романд гардаг Жан Вальжан, Фантинь, Козетт, Гаврош нарын байдалтай яг адил юмаа. Ядуучууд, баячуул хоёрын хоорондоо дандаа гардаг бодит үнэн тэмцэлийг “Инээмтгий хүн” гэдэг романдаа хурцаар тодорхойлжээ.

Гюго ард олны амьдралыг цаашид гүнзгий харуулахын тулд бодит байдлыг тусгасан гуч дөчөөд оны шилдэг зохиолчдын туршлагыг гарамгай судалжээ.

Нэгдүгээр интернационал байгуулагдаж эрх чөлөөний хөдөлгөөнд ажилчин анги идэвхтэй оролцож ирэхэд Виктор Гюго шалгарсан хувьсгалч нарын тэмцлийг зохиолдоо харуулахаар шийджээ.

Гэсэн ч Виктор Гюго тэмцлийг жинхэнэ хувьсгалч зохиолч шигээр харуулж чдахгүй төөрөлдсөн удаатай.

Виктор Гюго 1848-1851 он хүртэл францын үндэсний хурлын депутат байх үедээ хөрөнгөтний төрийн хуурамч хорт бодлого францын ард түмнийг хэрхэн мэхлэн төөрөгдүүлж байгааг биеэр үзжээ. “Бүтээсэн ажилгүй, шийдвэрлэсэн зүйл ч үгүй” хөрөнгөтний хууль тогтоох хурлыг Виктор Гюго буруушааж 1849 оны 6 дугаар сард хэлсэн үгэндээ: “Ард түмний ашиг сонирхлын үүднээс... хоёрдугаар сарын хувьсгал шийдвэрлээгүй ард түмний зовлонгийн асуудлыг шийдвэрлэх цаг болсныг хөрөнгөтөн нар анхаарахгүй хоосон өнгөрүүлж байна” гэжээ.

Гюго депутат байхдаа Францын түрэмгий гадаад бодлогыг шүүмжилж гэгээрлийн бүх салаа мөчрийг гартаа авахыг оролдсон шашны эсрэг боловсрол гэгээрлийг чөлөөтэй болгохын төлөө, хувьсгалт хэвлэлийг хэвээр байлгах, шоронд хоригдогсдын эсрэг хандсан хэвлэлийг устгахын төлөө тэмцэхийг уриалсан үг хэлэв. Гурван сая хүнийг

эрх чөлөөгүй болгохоор бэлтгэсэн харгис хуулийн төлөвлөгөөг Виктор Гюго шууд эсэргүүцэн:

“Харгис та нар сонгогчдын нэрсийг дураараа хасацгааж, манай иргэдийн нэрсийг сая саяар нь жагсаалтаас арилгаж, францчуудыг улс төрийн тэгш эрхгүй болгох эрхээ эдэлсэн ч манай ард түмний сэтгэлд төрүүлсэн эсэргүүцлийг яасан ч арилгаж чадахгүй! Танай төрийн үй түмэн бохир, алдааг олны санаанаас та нар хэзээ ч салгаж чадахгүй! Түүхийн хөгжлийг та нар зогсоодог юм биш. Зүй ёсоороо ирж байгаа цагийг та нар өөрчлөх хүчин алга! Газар дэлхийн хөгжлийг зогсоож, ардчилсан үзлийн өсөлтийг хориглох сачий та нарт байхгүй!” гэжээ.

Цусаа урсгаж олсон францын ард түмний ололтыг харгисууд бузраар сорж байгааг тэвчиж шууд чадаагүй явсан Гюго ардчилсан үзэл, ялах ирээдүйн сайхан цаг ирнэ гэдэгт бүрэн төгс итгэж байлаа: 1849 оны 8 дугаар сард Гюгогийн санаачлагаар энх тайвны талынхны олон улсын анхдугаар их хурал Парист хуралдлаа. Гюго энэ их хурлыг нээж “Дундат зууны үеийн эрүү шүүлтийн зэвсгийг өнөөдөр үзвэрийн газар сонирхуулахаар тавиад байгаагийн адилаар их буу, бөмбөгийг үзвэрийн газар шилжүүлэх өдөр ирнэ... Даян дэлхийд энх тайван тогтоож болохоор барахгүй энх тайван зайлшгүй ялна” гэж ирээдүйг зөгнөн хэлжээ.

Гюго 1828 оны хувьсгалын ололтыг хамгаалахын төлөө тэмцсэнээрээ уран бүтээл гаргахад чухал алхам хийлээ.

Гюго харгисуудад хавчигдан хөөгдөж Брюссель ороод тэндээсээ нормандын Джерсей, Гернсей арлууд дээр очиж амьдарч байхдаа хоёрдугаар хаант засгийг цөхрөлгүй шүүмжлэн хэрэгжүүлэв. Гюго энэ үеэр Брюссельд 1852 оны 8 дугаар сард “Өчүүхэн Наполеон” гэдэг улс төрийн шог зохиол хэвлүүлээд франц руу нууцаар дэлгэрүүлсэн байна. Үүний зэрэгцээгээр “Гэмт хэргийн түүх” гэдэг зохиолоо бичиж эхлээд “Ялалт” гэдэг яруу найраг эхлэн хэвлүүлэв. “Ялалт” гэдэг найраглал бичсэнээрээ Гюго үхэшгүй мөн ардын яруу найрагч болон алдаршиж чадлаа.

Депутат байхдаа харгис хүчний эсрэг, Луй Бонапартын төрийн эргэлтийн өөдөөс явуулж байсан тэмцлүүд “Өчүүхэн Наполеон”, “Гэмт хэргийн түүх”-д товойн гардаг. Энэ хоёр зохиол Гюгогийн гал хурц шог зохиолын дээж мөн. Зохиолч арван хоёрдугаар сарын хоёронд болсон хэргийн харгис гэмт чанарыг уудлан үзүүлж олон түмнийг тэмцэлд босгохоор дээрх хоёр зохиолоо бичжээ. “Гэмт хэргийн түүхэд” Гюго арван хоёрдугаар сарын төрийн харгис эргэлт, түүний эсрэг гарсан тэмцлийг өдөр дараалан уран шогоор сэтгэл хөдөлгөм хурцаар бичсэн юм.

Шинжлэх ухааны социализмын үндэс тавьсан суут хүн, К.Марк Гюгогийн “Өчүүхэн Наполеон” гэдэг зохиолыг Бонапартын төрийн эргэлтийн тухайбичсэн зохиолуудын дотроос олны анхааралд татахуйц бүтээл мөн гэж тэмдэглээд тэр номын гол дутагдлыг заахдаа:

Виктор Гюго төрийн эргэлт үйлдсэн гэмт этгээдийг уран шогоор эсэргүүцсэн төдийгөөр хязгаарлагдаж байна. Уг үйл явдлыг гэгээн өдөр гэнэт цахилгаан цахисан мэтээр дүрслээд зөвхөн ганц хүний харгислалыг товойлгож байна. Түүний үйл ажиллагааг багасгахын оронд даян дэлхийн түүхэнд гараагүй хүний хувийн санаачлагын чадлыг өндөрт дэвшүүлснээ Гюго мэдэхгүй байна” гэжээ.

Марксын энэ тодорхойлолт зөхөн дурдсан зохиолын сайн муу хоёр талыг илэрхийлснээр зогсохгүй түүхийг үзсэн зохиолчийн үзэл санааг илчилж байна. Гюго хэдийгээр харгислалыг уран шогоор эсэргүүцсэн боловч тухайн үеийн ангиудын тэмцлийн чанарыг ойлгосонгүй төөрөлджээ.

Гюго 1852-1853 онуудад өөрийн бүтээлийн тэргүүнд ордог “Ялалт” найраглалаа бичлээ. Гюгогийн яруу найраглалд хувьсгалын үнэр шингэсэн учраас Владимир Ильич Ленин сонирхон уншдаг байлаа гэж Крупская бичсэн байдаг.

Гюгогийн “Ялат” найраглал утгаараа орчин үеийн хөрөнгөтний яруу найргийн эсрэг үндсээрээ чиглэсэн учир харгисуудын дунд тэвчишгүй жигшлийг төрүүлсэн байна.

1848 оны хувьсгал ялагдсаны дараа францын хөрөнгөтний яруу найрагт ард түмний үзэл санааг гаргахаас зайлсхийж нийгэмд ашигтай урлагаас дургүйцэх урсгал гарч, парнасын бүлгийн яруу найрагчид амьдралыг чухалчлан харуулахын оронд цэвэр хэлбэр хөөцөлдөх арга руу шилжсэн байна.

Францын утга зохиолд соёлын бууралт гарч байсан энэ үед Гюго орчныхоо амьдралд идэвхтэй оролцохыг уриалсан цог бадрангүй эрс баатар зорилгод чиглэсэн “Ялалтаа” хэвлүүлж харанхуй шөнийн нам гүмийг бусниулж хамаг олныг нойроос сэрээн харгис дайсныг яллан цээрлүүлэхийг эрмэлзэв. Харгисуудад ялагдсан, хөөгдөж харь газар одсон боловч хатан зориг нь шантраагүй яруу найрагч Гюго шунахай дайсныг үзэн ядаж өшөө хорслоо авахыг зориг төгөлдөр ури лан дуудсан нь тэр үедээ үзэгдээгүй гайхамшиг байлаа.

Ариун санааныхаа дээж болсон эх орноо

Алс замынхаа чиг болгосон эрх чөлөөгөө

Хүний газар хөөгдөж яваа хүү чинь

Хүсэл мөрөөдлийнхөө чимэг болгож явна.

Гэж арван хоёрдугаар сарын төрийн эргэлтийн нэг жилийн ойд зориулсан шлэгтээ дурдсан байдаг.

Бонапартын засгийн газар ял хэлэлцэхгүй болгосон шийдвэр гаргаж яруу найрагчийг төрсөн нутагтаа ирэхийг нэг бус удаа мэдэгдсэн боловч Гюго:

Эх орондоо эрх чөлөө тогтоогүй цагт эргэж очих эрмэлзэл алга гэдгээ эрс шулуун, нуулгүй хэлж байна гэж хариулсан билээ.

Эх оронд нь тогтсон харгис дэглэмийн эсрэг хүний газар толгой хоргодож явсан шүлэгч арван есөн жил зоригтой тэмцсэн явдал францын давшилт соёлд үзэл санааны үнэлшгүй их дэмжлэг болсон байна.

“Ялалт” найраглалд хоёрдугаар хаант төрийн цуст харгис, худал хуурмаг чанарыг шүүмжлэн харуулжээ.

Гюгогийн улс төрийн бодит туршлага түүний уран шүлгийн бүтээлийг баяжуулж шог хурц шинжтэй болгожээ. Нилээд олон шүлэгт цус харгислахын мөн чанарыг гаргасан байна.

Жишээ нь “Арван хоёрдугаар сарын дөрөвний шөнийн тухай” шүлэгт Бонапартын будлиу согтуу цэрэг, булбарай жаал хүүхдийг булшлан алсныг харуулдаг. Үхсэн жижиг хүүхэд, гозойж байгаа гар, ангайсан ам, үжирсэн биеэ галд ээж суугаа эмгэн зэргийг шүлэгтээ үзүүлсэн явдал зохиогчийн санааг тод болгосон байна.

Ялалтын дотор эх орны тухай сэдэв гол суурь эзэлдэг. Хатуу харгис дэглэмд дарагдсан эх орноо гашуудлын хувцас нөмөрсөн эмэгтэйгээр дүрсэлсэн байдаг. “Эх ор®н” гэдэг шүлэгт гардаг гашуудлын хувцас өмссөн эмэгтэй:

“Босоцгоо иргэдээ! Гайлдах цэргээ татан дайчилцгаа!” гэж уриалдаг байна. Эх орноо чөлөөлөх зэвсэгт тэмцэлд шууд дуудсан “Унтаж байгаа хүмүүст” гэдэг гайхамшигт шүлэг бий. Тэр шүлэг францын ард түмнээс фашизмын эсрэг тэмцэхэд өргөн дэлгэрч олон түмнийг зоригжуулж байлаа.

“Унтаж байгаа хүмүүст” гэдэг шүлэг:

Унтаж байгаа нойроос сэр!  
Улигт дайсныг даран сөнөөж  
Удамт нэрээ сэргээн босго!  
Аймшигт бүгчим нойроос сэрж  
Атаат дайсны давуу хүчийг  
Арлын зоригоор сөнөөн устгая!  
Ерэн гуравдугаар оны туяаг  
Ертөнц даяар түгээн мандуулж  
Илүү хүчит дайсныг дарсан  
Өвгөд дээдсийн сургаалыг баримтлан  
Атаат дайснаа арилган сөнөөе  
Алдсан эрхээ байлдан олъё! Гэжжж.

Хүнд харгислалд байсан францын ард түмнийг Гюго ингэж баатарлаг тэмцэлд уриалсан байна.

Ард түмнийг мөлжигч дайсныг үзэн ядсан Гюгогийн тэмцэл ганхан “Ялалтаар” зогссонгүй түүний бусад зохиолуудад илэрлээ олсон байна.

III Наполеон 1855 онд Лондонд очсоны дараа Английн засаг захиргаа гададад зугтан яваа француудаас Джерсей аралд гаргаж байсан “Хүн” гэдэг сэтгүүлийг цаазлан хориглосон байна. Гюго английн энэ харгис арга хэмжээг эсэргүүцэхэд түүнд дэмжлэг үзүүлэхийн оронд Джерсей арлаас хөөжээ. Үүний улмаас Гюго Гренсей аралд шилжин суугаад яруу найргийн олон хэлбэрийн зохиолыг маш шургуу бичих ажилд орлоо. Хорин таван жилийн тйрш бодож боловсруулсан “Ажиглалт” гэдэг арван мянга гаруй шүлгээс бүрдсэн яруу найргийн хоёр боть зохиолоо 1856 онд бичиж гаргажээ. Арван мянга гаруй шүлгээс бүрсэн энэ зохиол бол Гюгогийн утга уянгын шүлгийн алдарт зохиолуудын нэг мөн. Амьдралын олон талыг харуулсан энэ зохиол Гюгогийн намтартай нягт холбоотой.

Гюго энэ зохиолоо сэтгэл санааны толь гэж нэрлэжээ. Энэ зохиолд бага насны амьдрал үзүүлсэн шүлгүүд, янаг амрагийн уянгат шүлгүүд, байгалийн сүрт үзэсгэлэн ба шүлэгчийн ганцаардмал амьдралын бодлыг илчилсэн шүлгүүд олон бий.

“Ялалтыг” төрийн харгис эргэлт гарсны дараахан эзэрхэг дэглэм бүрэн бэхжилээ олоогүй байхад бичсэн бол “Ажиглалтыг” түрэмгий засаг бага зэрэг сууршлаа олсон хойно зохиосон байна. Далайн эрэг хавцал, эрчит их долгион дунд, төрсөн нутгаас алс байсан Виктор Гюго байгаль ертөнц хүний зол заяаны тухай гүн их бодолд орсон байна. Шүлэгчийн үзэл хурц гүн болж, хүнгэнэн шуугисан хөх буурал далайн цохилоо харахад зарим үед гунигтай болдог аж. Шүлэгчийн бодоход:

Хатан гандсан хоосон газар дээр  
Харц ядуучууд жаргал үзэлгүй  
Хамаг хүчээ шавхан хөдөлмөрлөж байхад  
Харин тэдний дундаас тэргүүний хүмүүс  
Хорсол заналд автагдан хоосон тарчилна.  
...Улалзах галын утаа, урсах цус  
Уудам дэлхийг бүрхэн, зовлон түгж  
Үхлийн дайн араатан мэт асан дүүлэн  
Уул хад, өргөн тал, өтгөн ойд  
Унтах нойргүй занчилдах шиг...  
санагддаг байлаа.

Нийгмийн доторхи эрх тэгш бус, өлсгөлөн ядуу байдал яруу найрагчийн сэтгэлийг улам тарчлаах боллоо. “Хаврын нэг өдөр харагдсан нэгэн зүйл” гэдэг шүлэгт ажилч

хөдөлмөрчин ганц бие эхнэр амраг дөрвөн үрээ тэжээж чадалгүй харангадан үхэж байгааг харуулсан байдаг.

Гаслант нийгмийн байгаль ертөнц ч хүртэл бүгчим харанхуй болсноор үзүүлдэг. Эргээ цохиж дэSh харваад эргэлдэн буцалж эвхрэн хөөсөрдөг далайн хатуу давалгаан, үлээх салхит й шивнэлдэн байгаа уйтгарт харанхуй шөнө, од ми-ид гялбан харвасан огторгуйн хязгааргүй мандал, далайн далбаа шогоггүй хөвсөн онгоц ертөнцийн уудамд тэнүүчлэн нисэгч газрын хар бөмбөрцөг гай зовлон алдаа эндүүрлийг туулсаар гэрэлт ирээдүйг зөгнөн яваа нь Гюгогийн яруу найрагт бас гардаг.

Газрын бөмбөрцөг орчлонгийн хязгааргүйд

Гаслант бидний үүр чирсээр

Очих чиггүй тэнүүчлэн тойроход

Өнцөг буландаа гэрэлтэй тэнгэр

Өнөөх бөмбөрцгийг хүрээлэн гэрэлтүүлээд

Алтан нарны туяа туссан

Алсын эрэг гэрэлтэн сүүмэгнэн...

Байх шиг шүлэгчийн санаанд бодогсдон байж.

Гюго хүний зол жаргалын асуудалд зориулсан “Хувьсгал” гэдэг найраглалаа 1857 онд хэвлүүлжээ. Өнгөрсөн үеийн францын вангуудын үйлдсэн гэмт бузар хэргийг “Хувьсгал” найраглалд ширүүн шүүмжилжээ. Хувьсгал хүн төрөлхтөнг давшилтад хүргэнэ гэдэг дүгнэлтийг шүлэгч анх удаа хийсэн байна. Хувьсгал бол хүн төрөлхтөнг өндөр уулыг бүрхэн өнгөт цагаан цас шиг гэрэлт ирээдүйд хүргэж чадна гэжээ.

Гюго Гренсей арал дээр байхдаа хүн төрөлхтний түүхт зориулсан маш том туульс бичихээр шийдээд нас эцэслэтлээ үргэлжлэн зохиож “Үеийн үеий домог” гэж нэрлэжээ. “Үеийн үеийн домгийн” эхний хэсгийг 1859 онд, хоёрдугаар хэсгийг 1877 онд, гуравдугаарыг 1883 онд хэвлүүлжээ.

Хүн төрөлхтний түүх, үлгэр, гүн уха н, шинжлэх ухаа-ы олон салбарыг үзүүлэхийг эрхэмлэсэн энэ зохиолз шашин ба эртний үлгэр домог, түүхийн үнэн бодит үйл явдал, туульсын аялгуу, гүн гүнзгий хүсэл мөрөөдөл эртний үеэс эхлээд одоо үе хүртэл гардаг. Гюго хүн төрөлхтний түүхийг өөрийн мэргэн оюунаар шүүрэн тунгааж түүхийн туршид ард түмнийг мөлжиж байса- харгисуудыг буруушаан шүүмжилжээ. Ард түмнийг дарлагчдын харгислалыг түүхийн дагуу харуулсанд “Үеийн үеийн домгийн” гол агуулга оршино.

Харгис хаад ноёд, жанжингуудыг магтан сайшаасан түүхчдийг идэвхтэй эсэргүүцсэн байна. Католик шашин мөнхийн баатар эр болгон дэвшүүлсэн Скандинавын ванг Гюго эсэргүүцэж хуучин вангаа алаха ажлаар “баатарлаг алхам” хийсэн гэмт хэрэгтэн гэж шүүмжилжээ. ХИҮ Лүй ванг хөрөнгөтний түүхчдээс нар шиг ачит ван гэж өргөмжилснийг Гюго францын ард түмнийг боолчон тарчлааж байсан алан хядагчдын нэг мөнөөр “Үеийн үеийн домог” Шинэ үед хүн ардын эртний ба дундат зууны үеэс илүү олноор алан хядаж хатуу харгислал зохиож байна гэж “Дайны дараа”, “Эйлау булш” гэх мэтийн шүлэгт шүүмжилсэн байдаг. Ван, хаадыг алан хядагч нар болгон илчлэхийн хамт хүн төрөлхтний хөгжил дэвшилтэд замаар явж байна гэж Гюго үзжээ. Гэхдээ Гюго ангийн тэмцлийн мөн чанарыг тодорхойлох талаар “Өчүүхэн Наполеон”-д гаргасан алдаагаа давтсаныг тэмдэглэх хэрэгтэй.

Гюго гадаадад байхдаа жижиг хэлбэрийн жүжгийн зохиол олныг бичжээ. Тэдгээрийг зохиогч нас Үарсны дараа “Чөлөөт театр” гэдэг нэртэйгээр эмхтгэн хэвлэв.

Мөн энэ үед Гюго Парисын байдлыг харуулсан “1000 франк” гэдэг драм бичсэн байна. Тэр драмыг францын Парисын театруудын нэг захирал театрт гаргахаар шийдэж Гюгогоос санал асуухад хариуд нь:

“Миний зохиолыг театрт тавихын өмнө над мэтийн бүх хүмүүст эрх чөлөө хэрэгтэй. Францад бидний тэр эрх чөлөөг хассан... Францад эрх чөлөө дэлгэрэх цагт миний зохиол гарахаа л гарна. Тэр өдрийг би хүлээе” гэж тавихыг эсэргүүцсэн байна.

Францын эзэн хааны эсрэг эвлэршгүй тэмцсэн Гюгогийн “Ялалт”, “Үеийн үеийн домог” дэлхий дахинд, тарж бөмбөрцгийн өнцөг булан бүхнээс шүлэгчийн бүтээлийг ажиг хүлээх боллоо: Гюго “ард түмний алдар нэр болсон хүн” гэж үзэх болсон байна. Гюго хөөгдөн явахдаа уран зохиол бичихээр хязгаарлагдсангүй нийгмийн зүтгэлтний хувьд их ажил зохиожээ.

1861 онд франц, английн засгийн газрууд Хятад руу цэргийн дээрмийн экспедиц явуулсанд Гюго экспедиц зохион байгуулагчдын нэгэнд явуулсан захидалдаа Дорно дахины соёлын их орон руу хоёр дээрэмчин шүлс савируулан довтлов гэж дурдаад: “Ялагч хоёр этгээдийн нэг өврөө дүүртэл мөнгө дээрэмдэхийг нөгөө нь хараад улангасан өрсөлдөн авдраа дүүртэл алт мөнгө хулгайлаад гар гараасаа барилцан европ руу баясан буцаж ирлээ. Өөрсдийгөө боловсон гэж гайхуулдаг европынхон ийм бузар дээрэм үйлдсэн түүхтэй” гэж зохиолч жигшин буруушаажээ.

Дарлагдсан ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг идэвхтэй дэмжигч Гюго Испанийн алдарт хувьсгалч Гарибальдийн тэмцлийг цуцалтгүй өргөмжилж, Критийн эх оронч нараас туркийн дарллын эсрэг явуулсан тэмцлийг дэмжин “удахгүй хувьсгал гэдэг нэртэй аянга” ниргэх гэж байна гэжээ. Гюго испанд гарсан хувьсгалыг 1868 онд хүлээн зөвшөөрч баяр хүргэхийн хамт Кубын эх орончдыг хамгаалан: “Ямар нэг үндэстэн өөр үндэстэнг дарлах эрх байхгүй. Хүн хүнийгээ дарангуйлах эрхгүйтэй адил нэг ард түмэн нөгөөгөө мөлжих эрх байхгүй” гэжээ.

Гюго 1869 онд Лозанд болсон олон улсын энх тайвны нөхдийн хоёрдугаар их хурлыг даргалж байхдаа:

“Бидэнд ямар энх тайван хэрэгтэй вэ? Бид ямар ч шалтгаангүй энх тайван бүхнийг хүсдэг үү? Үгүй! Тийм биш! Бид энх тайван болгоны өмнө өвдөг сөгдөж нуруугаа бөхийлгөхгүй. Банз шаахайтай энх тайвныг бид хүсээгүй... Эрх чөлөө олгох энх тайван бидэнд хэрэгтэй! Эрх чөлөөт болохын тулд эцсийн шийдвэрт цохилт өгөх хувьсгал хэрэгтэй. Эрх чөлөөтэй энх тайван тогтоохын төлөө эцсийн дайн хэрэгтэй ч байж магадгүй юм” гэжээ.

Дарлагдсан ард түмний эрх чөлөө тусгаар тогтнолын төлөөний тэмцлийг эцэлтгүй дэмжин зүтгэж явахдаа Гюго “Шоовдор хүмүүс”, “Далайчид”, “Инээмтгий хүн” гэх мэтийн алдарт сайхан романууд бичжээ.

Амьдралыг гүн гүнзгий харуулж, нийгмийн эрх тэгш бус байдлыг шүүмжилсэн “Шоовдор хүмүүс” гэдэг романд ард түмний амьдралыг маш өргөн, түүхийн хөгжлийн дагуу үзүүлжээ.

Дараа дараагаар солигдож байсан аль ч харгис засгийн үед ядуучуудын амьдрал сайжирсангүй.

Өлсөж туйлдаад өвчинд баригдсан өнчин дүү нараа тэжээж, аргаа барагдаад алгын чинээн хатсан талх хулгайлаад амь насныхаа турш тарчлах болсон Жан Вальжан, хайрт нялх охиноо тэжээх мөнгө олж чадахаа байгаад хар үс, цагаан шүдээ худалдаж эс болохоор эвий биеэ янхан болгон хувиргадаг Фантинь, хонгор эхээсээ хагацаж ховдог шунахай Тенардьегийнд зарцлагдан үүрийн бүрэнхийгээр урт багсгар

шүүр бариад шүд хавшин чичирч байгаа Козетт, хог шороонд дарагдсан гудамжаар тэнүүчлэн хоолны шавхруугаар ходоодоо тэжээж ядан явдаг боловч хувьсгалт тэмцэлд өчүүхэн насаа зориулдаг галтай цогтой Гаврош хүү эд бүхнийг эзэрхэг хөрөнгөтний засагт нийгэм элэглэн шоовдорлож эргэж буцашгүй хатуу гасланд оруулсныг “Шоовдор хүмүүс”-т шүүмжлэн харуулжээ.

Жан Вальжаныг мөрдөж хавчиж, Фантинийг үхэлд хүргэсэн хөрөнгөтний ёс суртахуун, өмч хөрөнгөний манаач Жавераар харгис нийгмийн хатуу сохор хууль цаазыг харуулжээ. Хөрөнгөт ертөнцийн шунхай ховдог харгис шуналтыг дээрэмчин Тенардьегээр төлөөлүүлэн үзүүлжээ.

Харгис нийгэм ба шоовдорлогдсон ядуу хоосон ард түмэн хоёрын тэмцлийг үнэн байдлаар нь “Шоовдор хүмүүс” романд гаргажээ. Гюго сонгож авсан гол сэдвээ уншигч нарын өмнө тод товойлгож үзүүлэхээр үйл амьдрал, өмссөн хувцас, үзэл санаагаар эрс төгс хүмүүсийг шилж олдог. Жишээ нь: Жавер цагдаа хөрөнгөтний эрх ашгийн төлөө амь насаа хайрлахгүй тэмцэж, ноогдсон үүргээ биелүүлэхийн тулд ямар ч гэмт хэргээс буцдаггүй байхад арван есөн жил харанхуй гянданд тамлуулсан Жан Вальжин өөрөө өлсөж даарч байсан ч олсноо олонтой хувааж идэх, эцсийнхээ ганц зоосыг гуйлгачин хүнд өгч тус хүргэх ариун цагаан сэтгэлтэй.

Гюго нийгмийн зохион байгуулалт, шудрага бус учраас түүнийг өөрчлөн байгуулах хэрэгтэйг зохиолынхоо эхнээс аваад эцэс хүртэл номножээ. Харгис шударга бус нийгмийг хэрхэн яаж өөрчлөх вэ? гэдэг азуултад Гюго хоёр янзын хариулт өгсөн байна. Нэгд зэвсэг барьж хувьсгал гаргах хэрэгтэй, хоёрт хүний оюун билгийг сайн хөгжүүлэхийг уриалжээ. Хүний ухаан мэдрэл, билэг оюуныг туйлд нь гартал хөгжүүлбэл ертөнцийг өөрчилж болно гэж үзэв.

Гюго ингэж нэг талаар зөв дүгнэлт хийсэн боловч нөгөө талаар тэр үеийнхээ орчны нөхцөлд автагдан төөрөлдсөөр байна.

Зохиогч өөрийн үзэл санааг гуйвалтгүй болгохоор Мириэлийг 1793 оны цайн депутат хувьсгалчтай эзгүй хээр газар уулзаад ламыг хувьсгалчийн өмнө сөгтгөн өршөөл гуйлгаж, нас барж байгаа хувьсгалчийн үзэл ялж байгаагаар бичсэн байдаг. Христосын шашны лам Мириэль хувьсгалчийг буруутган зэмлэхээр очоод ярихынхаа дундуур өршөөл гуйдаг нь Гюгогоос хувьсгалыг зүй ёсны хэрэг болгон зөвтгөх гэсэн оролдлого мөн.

1832 оны зургадугаар сарын бослогын үеэр бэхлэлт дээр уулзсан Анжолрас, Жан Вальжан хоёрын үйл ажил харилцан адилгүй Анжолрас хувьсгалын төлөө улаан цусаа урсган тэмцсээр үхэхэд Жан Вальжан зөвхөн босогчдыг хамгаалах төдийгөөр зэвсэгт бослогод оролцолгүй, өөрийн нь өдөр шөнөгүй мөрдөж явсан Жаверыг суллан тавьдаг. Энэ нь хүний энэрэнгүй цагаан сэтгэл эзэрхэг харгислалыг ч хүртэл өөр болгоно гэсэн Гюгогийн санааны илрэл.

Хувьсгалч нарын гараар цаазлагдаагүй гарч, Жан Вальжанаар амиа авруулсан харгис цагдаа Жавер амиа хорлож үхдэг явдал хөрөнгөтөн нарыг хэрэг, түүний төлөө зүтгэгчид саяныг үзэх золгүй, мөхөж сөнөхийн тэмдэг.

Хувьсгал эрх чөлөөтэй жаргалт амьдралд хүргэнэ гэдгийг “Шоовдор хүмүүст” үзүүлээд, ирээдүйг мөрөөдсөн мөрөөдлөө хувьсгалч Анжолрас Үзлэлт дээрээс хэлсэн үгээр дамжуулан илчилсэн байна. Бослогын удирдагч Анжолрас ард олны үнэнч төлөөлөгчөө дайны бууны галын дундуур бэхлэлт дээр гарсан Анжолрас: “Ардуудаа! Бид өнөөдөр ялагдсан ч, ялсан ч ялгаагүй хувьсгал бүтээж байгаа илсууд. Түймрийн гал бүх хотыг гэрэлтүүлэх адил хувьсгалын туяа бүх хүн төрөлхтөнг гийгүүлж болно. Агуу түүхт арван есдүгээр зууныг бодвюл хорьдугаар зуун хотол олноор жаргах үе боллоо... Гачигдал, ажилгүйдлийн уршгаар үүсдэг өлсгөлөн

дарлал, янхан завхайрал ярилцаж байгаа цаг харанхуй гаслангаар дүүрэн байна. Энэ хүнд бэрхийг туулж бид ирээдүйн суурь тавьж байна. Ирээдүйн сэрэлт амьдралыг хувьсгал бидэнд олгоно!” гэж зарладаг.

Франц үндэсний хөнгөн гавшгай баясгалант сэргэлэн чнарыг өөртөө шингээсэн тэнэмэл хүү Гаврош зэвсэг, нэгтэй нөхдөө ямагт дэмжиж, харгис хөрөнгөтнүүдийг өчүүхэн сэтгэлийнхээ угаас үзэн яддаг.

Гаврош бослогод оролцож явахдаа жаргалын дээдийг эдэлж байна гэж боддог байлаа. Гаврошийн хөгжилт яруу дуу, хэвлүүн үг нь босогчдыг зоригжуулж итгэлийг нь сэргээдэг. Чадлынхаа хирээр чулуу мод зөөж бэхлэлт халхавч босголцон, буу зэвсэг аль гэж шаардаж явсан Гаврош сум барагдаж хүнд байдалтай болоход суман мөндрийг сөрөн гүйж, хөшгөн утааны доогуур сүүдэгнэн үсэрч дайсны үхсэн цэргүүдпийн дайзтай сум хоосолж явтлаа араатны суманд дайрагдан амиа алддаг. Үхэх сэхэхээ үзэлцэж байгаа ширүүн тулалдаа-ы үеэр зэвсэг нэгтэй нөхдөдөө тус хүргэхийн төлөө амиа хайрлахыг мэдэхгүй тэмцсээр явж үхдэг Гаврош бол харгис дарлалт ертөнцийн эсрэг ирээдүйн залуу үе зэвсэг барин босож эрх чөлөө, зол жаргалаа байлдан авах цаг ойртсоны илрэл мөн.

Амьсгаа хураах хүртлээ баясгалант дуу аялсаар, буудалцаж байгаа нөхдөдөө зориулсан барьсан саваараа дүүрэн сум цуглуулаад баатарлагар нас бардаг Гаврош шиг баатар бүх дэлхийн утга зохиолд төдий л олн гардаггүй.

Гюгогийн “Шоовдор хүмүүс” роман, түүний дотроос ялангуяа бяцхан баатар Гаврошийг францын ард түмэн онц хүндэтгэдэг. Энэ зохиол францын хөдөлмөрчдийн удирдагч Морис Торезын хүмүүжилд их нөлөө үзүүлсэн байна. “Шоовдор хүмүүс” францын ард түмнийг хувьсгалт тэмцэл бүхэнд зоригжуулж байлаа.

Гюгогийн “Шоовдор хүмүүс” романыг өөрийн хэлэнд дэлхийн ихэнх улс орнуудын хэвлэж уншигч олны сэтгэлийг баясгасаар байна. Түүний дотор Монголын ард түмэн бас их анхаарал тавьж сонирхон уншсаар. Энэ романы дотроос хэсэглэн авч “Гаврош”, “Козетт охин” гэдэг нэрийн дор манай улсын хэвлэл хоёр удаа уншигчдын сонирхолд толиуулсан.

Гэсэн ч “Шоовдор хүмүүсийг” бүрэн бүтнээр хэвлэсэн удаагүй.

Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа уншигчдын сонирхолд өчүүхэн ч гэсэн тус болохын тул Виктор Гюгогийн “Шоовдор хүмүүс” романыг 1951 онд Парисын Галлимарын номын худалдаанаас хэвлэсэн франц эхээс нь гол санааг бүрэн багтаан товчилсон орчуулга хийж дэвшүүлэв.

Хэрэв уншигч олон “Шоовдор хүмүүсийг” бүрэн бүтнээр нь монгол монгол хэл дСэрээ орчуулж унших хүслээ улсын хэвлэлийн газар тавивал цөмийг орчуулах зориг төгөлдөр байгаагаа орчуулагч илэрхийлж байна.

Дараах жилүүдэд Гюго олон сайхан зохиолууд бичлээ. Хатуу ширүүн бйагалийн дунд амьдралын төлөө тэмцэж байгаа хөдөлмөрчин олны амьдрал харуулсан “Далайчид” гэдэг романаа “Эрх чөлөөнд дуртай, энэрэнгүй зөөлөн эрэг хадтай, эртний норманд нутгийн өнцөгт” өргөмжлөн дэвшүүлж 1866 онд бичив. 1869 онд, английн эрх баригчдын амьдрал, ядуу хоосон ардуудын байдлыг үзүүлсэн “Инээмтгий хүн” гэдэг роман, франкопруссийн дайн Париссын Коммуны үеийн явдлыг харуулсан “Ширүүн тэмцлийн жил” гэдэг түүвэр зохиолоо 1872 онд, арван наймдугаар зууны францын хөрөнгөтний ардчилсан хувьсгалыг магтан дуулсан “93 дугаар он” гэдэг романаа 1874 онд, шашны сүмийн худал хуурамч хорт ажиллагаа, хөрөнгөтний хуулийн эзэрхэг чанар зэргийг шүмжилсэн “Урлаг” (1877), “Шашин” (1880), “Пат лам” (1878), “Илжиг” (1880) гэх зэрэг яруу н айргууд бичиж, ардчилсан шинэ үзлийг зогсолтгүй

дэмжсээр, ард түмний хоорондын эв найрамдал, энх тайвны төлөө тэмцэн, эзэрхэг хөрөнгөтний түрэмгий бодлогыг үзэн ядаж эсэргүүцсээр явж 1855 онд Гюго нас барсан билээ.

Виктор Гюго 1877 онд Лионы ажилчдад хандаж хэлсэн үгэндээ харгис засаг, ард түмэн хоёрын эсрэг тэсрэг ялгааг тодорхойлж:

“Вангууд ямар бодолтой вэ? Дайн хийх бодолтой. Ард түмэн ямар бодолтой вэ? Энх тайвнаар амьд°ах хүсэлтэй... Вангууд зэсвэглэж байхад ард түмэн хөдөлмөрлөж байна. Ард түмний агуу их тайван хөдөлмөр аюулт хэргийг боловсруулан бэлтгэж байгаа вангуудын эсрэг хандаж байна” гэж хэлсэн билээ.

Ямар нэг ард түмэн нөгөөгөө дарлан мөлжиж ноёрхох ёсгүй гэж үзээд ард түмний тэгш эрхийн төлөө тэмцэж өнгөрсөн Гюгогийн тэмцлийг францын харгис хүчин одоо ч гэсэн эсэргүүцэн баллаад олон жилийн турш Алжирын ард түмнийг хуучин ёсоор колончилон мөлжиж байхын тулд цус урсгасан бузар дайн явуулсаар амжилт олохгүй нурж байна.

Ард түмнийг хувьсгалт тэмцэлд уриалсан Гюгогийн бүтээлийн аль үнэт хэсгийг 1950 онд “Ляруссийн” хэвлэлээс хураангуйлан гаргасан “Шоовдор хүмүүс”-т оруулаагүй хассаныг зохисгүй гэж үзээд жинхэнэ бүтэн эхээс нь товчлон орчуулаад нийтийн сонирхолд толиуулав. Уншигчид саналаа ирүүлнэ байх гэж урьдчилан талархлаа дэвшүүлэгч

Ж.Намсрай

## ТЭРГҮҮН ХЭСЭГ

### Фантинь Нэгдүгээр дэвтэр

#### ЭНЭРЭНГҮЙ СЭТГЭЛТ НОЁН МИРИЭЛЬ

I

Ноён Шарль-Франсуа-Бьенвеню Мириэль 1815 од Динь хотын захирагч лам байв. Далан тав орчим настай өвгөн Мириэль 1806 оноос эхлэн Динь хотын захирагч лам болжээ.

Үнэн худал нь үл мэдэгдэх дам ярианаас үзэхэд, ноён Мириэль Экс нутгийн засаг захиргааны газрын түүхийн зөвлөх явсан хүний хүү Мириэлийн эцэг төрсөн хүүдээ өмч хөрөнгө, албан тушаалаа өв замлгамжлуулахын тулд эрх тушаалтны гэр бүлийн дунд ихэд дэлгэрсэн заншлаар хүүгээ арван найм буюу хорин настайд нь гэрлүүлсэн юм гэлцэнэ. Шарль Мириэль гэрлэсний дараа олны дотор хов жив яриа хоног, өдрөөр үргэлжилсээр байв. Гялалзсан цэвэр царайтай, ов заль ихтэй, оюун ухаан сэргэлэн, пагдгар нуруутай Мириэль өөрийн амьдралын өсөх үеийг зугаа цэнгэл, янаг амрагт зориулжээ. Хувьсгал ялахад нийгэмлэгийн үйл амьдрал хурамхан зуур хурдан өөрчлөгдөж, хуучин төрийн эрх ямбатны гэр бүл хавчигдан хөөгдөж харсан зүгтээ сарнин бутарч замхрав. Ноён Шарль Мириэль хувьсгалын анхны өдрөөс эхлэн Итали орон руу оргон зугтав. Айл гэр болсоор үр хүүхэд төрүүлээгүй байсан эхнэр нь Италид очоод он жилийн удаанд тарчилсан архаг өвчнөөс болж нас баржээ. Ганц бие үлдсэн ноён Мириэлийн амьдрал цаашда ямар өөрчлөлт гарсныг хэн ч мэдсэнгүй а. Харин Иалид оочод сахил хүртэн лам болоод эргэж ирснийг хүн бүхэн ярилцдаг байж.

1804 онд ноён Мириэль Бриньоль хотын захирагч лам бол өндөр настай, тайван ганцаардмал амьдралд орсон байв.

Мириэль ямар нэг хэргийн учир Парис хот орж ажил хэргээ бүтээж явах зуураа католик шашны дээд тушаалтан Фешийнд очиход эзэн хаантай тулгаран учирчээ. Мириэль эзэн хааныг ихэд сонирхон харж байхыг ажсан Наполеон:

-Та намайг юунд ингэж хараа вэ? гэж асуухад ноён Мириэль,

-Хүндэт хаан минь, та намайг үзэж хүн гэж үзэж байхад би таныг агуу их хүн гэж сайн үзэж байна. Иймээс та бид хоёр харилцан нэг нэгийгээ ашиглаж болох юмаа гэж хариулжээ.

Мөн өдрийн орой эзэн хаан Наполеон түүний нэр алдрыг Фешаас асуусан аж. Хэд хоногийн дараа ноён Мириэль Динь хотын захирагч ламаар томилогдсон гайхалт мэдээ сонсогдов.

Мириэлийн залуу насны тухай дээр дурдсан яриа байсан боловч чухам үнэн худлы нь хэн ч мэддэггүй байж. Хувьсгалаас өм-ө Мириэлийн гэр бүлийн тухай улсууд тун бага мэддэг байлаа.

Хов жив ярих хушуу уртдан олонтой, ахицтай юм боддог ухаантнаар ховорхон жижиг хотод орсон хүн болгоны хувь заяаг ноён Мириэль туршин үздэг байв.

Мириэль Диньд ирээд есөн жил өнгөрөхөд тэндхийн хүмүүсийн сонирхол буурч илүү дутуу үг ярихаа больжээ. Ноён Мириэль өөрөөсөө арав дүү ноёхон Батистинтай хамт Диньд хүрэлцэн иржээ. Батистин бол Мириэлийн төрсөн ганц охин дүү нь бөлгөө...

Мирэль Батистинаас гадна ажил өвчин хоёрт дарагдан захилж бачимдаж явдаг зарц эмгэн Маглуараа мөн авч иржээ...

Захирагч лам албан тушаалдаа ормогц Динь хотынхон ажилдаа аль хир хүн болохыг ажин хүлээх боллоо.

## II

### НОЁН МИРИЭЛЬ ХАЛАМЖИТ ХҮН БОЛОВ

Динь хотын захирагч ламын ордон больницын барилгатай зэргэлдээ байдаг байж. Өнгөрсөн зууны үед Парисын их сургуулийн доктор Ани Пюжегийн барьсан энэ ордон өргөн дэлгэр өнгө саруулхан...

Гэтэл больницын барилга хоёрхон давхар хүйтэн хавчгар.

Мириэль ирээд гурав хоносны дараа больницоор явж үзээд больницын захирлыг дуудан аваачаад:

-Ноён захирлаа! Одоо танай больницод хэдэн өвчтөн хэвтэж байна вэ? гэхэд

-Хорин зургаан хүн хэвтэж байна гэж хариулна. Захирагч лам:

-Тоолоход хорин зургаа байсан юм гэсэн захирал:

-Зай бага учраас орнууд маш чигжүү тавигдсан юм гэв.

-Би түүний чинь бас хараад мэдсэн шүү.

-Өрөөнүүд өвчтөнд тохиромжгүй, агаар салхи олигтой ордоггүй юм.

-Тийм ч байх гэж би бодсоон.

-Нартай өдөр өвчтөнүүд гараад суухад цэцэрлэгийн талбай хүрэлцдэггүй.

-Тийм ч болов уу? гэж бодсон.

-•үнд байдлыг тэвчихээс өөр арга байдаггүй юм даа ноёнтон минь гэж захирал хэлэхэд түр зуур дугуй байсан лам больницын захирлаас гэнэт:

-Ордны нэгдүгээр давхрын тасалгаанд хэдэн ор багтана гэж та бодож байна гэж асуухад захирал гайхаш тасарч

-Тнаы зоогны өрөөнд үү? Гэв.

Мириэль тооцоо хийж, хэмжээ авч байгаа мэт маягтайгаар өрөөг ажин харж байснаа:

-Энд чинь хориос доошгүй ор багтмаар юм. Энэ байдал тохирохгүй. Та нар хорин зургаан хүн тав зургаан жижиг тасалгаанд багтааж байхад бид гуравхан хүн жараад хүнд багтах зайтай байр эзэмшин суугаа явдал буруу байна. Та нар миний байранд ороод, би та нарын байрыг эзэлчээд байгаа юм байна шүү дээ. Та нар надад байраа өг. Эндхийн эзэн нь та нар юм шүү гэжээ.

Маргааш өдөр нь хорин зургаан өвчтөнүүд захирагч ламын өрөөнд нүүж, лам больницын байшинд орж байраа солилцов.

## III

Мириэль, дээд давхартаа гурван өрөөтэй, доод давхартаа мөн гурван өрөөтэй байшинд оржээ. Мириэль өөрөө доод давхарт, хоёр эмэгтэй дээд давхрын өрөөнд суудаг байв. Гудамж руу харсан хаалгатай нэгдүгээр тасалгаанд хоолоо идэж, хоёрдугаар өрөөндөө унтаж, гуравдахдаа уншилгаа уншдаг билээ. Уншлагын өрөөнөөс ганцхан унтлагын өрөөг дамжин дарагш гарч болох, унтлагын өрөөнөөс заавал хоолны өрөөгөөр дамжин гарч болох аж.

Унтлагын газарт тусгай хөшгийн цаана зочдод зориулан ор зассан бйадаг байлаа. Хөдөө нутгаас сүм хЕйдийн ажил хэргээр ирдэг лам нарыг энд зочлон хонуулдаг байжээ.

Хуучин больницын эм олгодог газрын жижиг барилгын гал тогоо ба §оорь болгон хувиргажээ.

Нэг хоёрдугаар давхрын бүх өрөөнүүдийг нийтийн байр, эмнэлгийн газартай адилаар цайлган буджээ.

Ноёхон Батистины тасалгааны хананы будаг дор уран зураг байгааг зарц эмэгтэй Маглуар он жил өнгөрсөн хойно олж харсан аж. Магадалбал энэ байшин эмнэлгийн газар болохоос өмнө дээр үед Динь нутгийн ардуудын хурлаа хийдэг газар байсан нь илэрчээ.

Мириэлийн хоёр давхар байшинг Батистин, Маглуар хоёр эмэгтэй гайхалтай нямбайгаар цэвэрлэдэг байж. Ариун цэвэр байдал Мириэлийн цор ганц гэрийн чимэг мөн байж “Ариун цэвэр байх нь ядуучуудад саад болдоггүй юм” гэж Мириэль хэлдэг байлаа.

Мириэлийн урьдны хөрөнгөөс хоол цайны зургаан мөнгөн хэрэглэл үлдсэн байв. Эдгээрийн цэвэр гялалзсан өнгө зарц эмэгтэй Маглуарын сэтгэлийг өдөр болгон баясгана “Мөнгөн халбага, сэрээгээр хоол иддэгээ би тийм ч амархан зогсоож чадахгүй” гэж Мириэль бас хэлдэг байжээ.

Мириэльд хоол цайны мөнгөн хэрэгслээс гадна өв залгамжлан авсан лааны хоёр том мөнгөн тавиур байжээ. Лааны энэ хоёр тавиур захирагч ламын унтдаг өрөөнд гялтганан гялбаж байлаа. Мириэлийнд гаднын зочин ирэхэд зарц Маглуар мөнгөн тавиуртай хоёр лаагаа асааж ширээн дээр тавьдаг байлаа.

Мириэлийн унтдаг өрөөний орны толгой дээр хананд зоосон жижиг шургуулга байдаг байлаа. Зарц эмэгтэй Маглуар орой болгон зургаан мөнгөн хэрэглэл ба утгадаг халбагаа тэр шургуулга руу хийгээд түлхүүрээ цоожноос нь салгаж авалгүй үлдээдэг заншилтай байжээ.

Мириэлийн байёинд цоожтой хаалга нэг ч байсангүй. Дээр үед бөх цоожтой байсан хоолны өрөөний цоож түгжээг Мириэль дөнгөж ирсэн өдрөө авахуулж хаяжээ.

Иймээс гаднын хэн боловч энэ байшинд дуртай саадгүй орж гарах бололцоотой байв.

Мириэлийн дүү эмэгтэй Батистин, зарц авгай Маглуар хоёр үүд хаалга нь цоожгүй болохоор үнхэлцгээ хагартлаа айж шөнө өнгөрүүлдэг байхад Мириэль огт ажиггүй онгорхой хаалгатай унтдаг байж.

## IY

### **ДҮҮ НЬ АХЫНХАА ТУХАЙ БИЧСЭН НЬ**

Мириэлийн гэрийн доторхи амьдрал байдал, хамт суудаг хоёр эмэгтэй өөрсдийнхөө бүх санаа бодол сэтгэл зүрхээ Мириэльд хэрхэн захируулж байсныг харуулахын тулд Батистинаас өөрийн бага насны танил эм эгтэй ноёхон до Буошевронд бичсэн захидлыг энд сийрүүлэн бичье.

“18... оны 12 дугаар сарын 16

Хайрт хонгор чамайгаа бид өдөр болгон дурсан суудаг. Чамайгаа бид үргэлж дурсдаг заншилтай. Өдөр шөнө өнгөрөх тусам улам ч их дурсах юмаа. Мань Маглуар гуай байшингийнхаа хана дээврийг цэвэрлэж яваад хэд хэдэн шинэ нээлт хийсэн

учир манайх танайхаас гоё ганганы хувьд өчүүхэн ч дордохгүй болсон шүү. Маглуар гуай бүх хуучин будаг цаасыг ховхолж цэвэрлэсэнд дороос нь сонин хачин юм их гарлаа. Миний суудаг байрн алтаар зурсан хуучин уран зургаар дүүрэн... Маглуар гуай үлдсэн хог шороог арчин цэвэрлэж дуусгаад зундаа тосон будгаар будах болно. Тэхэд миний унтлаганы өрөө ёстой нэг музей болж хувирах нээ. Үүнээс гадна мань Маглуар дээвэр дооос эртний хийцэтэ© хоёр жижиг модон сандал олсоон. Түүнийг алтаар будуулахад зургаа долоон франк зарцуулагдах төлөвтэй. Сандал будуулах мөнгөө ядуучуудад өгсөн дээр гэж шийдлээ. Угийн үзэмж муутай юмыг будуулаад ч юу базаах вэ дээ...

Би хуучинтайгаа адилаар буянаа эдэлсээр жаргаж байна. Миний ах тун зан сайтай хүн юмаа. Юу байгаагаа бүгдийг ядуу, өвчтэй хүмүүст хайрлахгүй өгсөөр байна. Бид мөнгөөр их дутмаг байна. Энд өвөл нь сүрхий хүйтрэх юм. Ядуу гачигдалтай хүмүүст ямар нэг зүйл туслах хэрэгтэй болох юмаа. Манайх дулаахан, гэгээ гэрлээр зүгээр...

Ах маань хачин зантай хүн юмаа. Лам болгон тийм байх ёстой гэж өөрөө ч хэлэх юм. Манай байшингийн хаалгууд үргэлж онгорхой цоожгүй байдаг. Дуртай хүн бүр ахын өрөөнд орох боломжтой байна. Миний ах шөнө ч гэсэн огт айхгүй зоригтой хүн юмаа.

Маглуар бид хоёр айж санаа зовоход манай ах их дургүй. Ах маань дандаа өөрийгөө хүнд аюултай байдалд оруулдаг. Түүний нь бид мэдсэн ч мэдээгүй юм шиг байвал санаанд нь тохирдог. Зангий нь сайн мэдээд санаанд нь тохируулж явбал чухал юмаа.

Дээрэмчдийн эрхшээлд орсон газраар өнгөрсөн жил ганцаараа дажгүй яваад ирсэн. Бид хамт явъяа гэхэд аваагүй юм. Бид явж арван таван хоног алга байгаад ямар ч осо аюултай учралгүй эрүүл энх буцаж ирсэн. Яваад сураггүй болохоор улсууд түүнийг лав үхсэн байх гэлцэж байсан чинь харин зүв зүгээр гэртээ буцаж ирээд “тонуулсан хүн ийм байдаг юм уу?” гээд авдраа онгойлгоход дээрэмчдээс бэлэглэсэн үнэт эдлэлээр дүүрсэн байлаа...

Миний бие зүгээр сайн боловч би өдрөөс өдөрт эцэж тураад байх боллоо. За баяртай цааш нь бичье ч гэсэн цаас минј дууслаа. Үүрдийн жаргалыг ерөөж ёслогч Батистин”.

**V**

## **ҮЗЭГДЭЭГҮЙ ГЭРЭЛТЭЙ УЧИРСАН НЬ**

Дээр дурьдсан захидал бичсэний дараахан захирагч лам Мириэль дээрэмчдээр дүүрэн газраар явснаасаа улам илүү бэрх хэрэг нэгийг үйлдэв гэж хотын бүх хүмүүс хоорондоо ярилцах болов.

Динь хотын орчимд гав ганцаараа амьдран суудаг нэг хүн байж. Энэ хүн, дээр үед ардын их хурлын гишүүн байсан аж. Түүний нэр Ж гэдэг байж.

Ж Динь хотынхны дунд нэр алдаргүй байж “Их хурлын гишүүн байсан хүн гэв үү! Пөх! Тиймэрхүү хүмүүс чинь “нөхөр! Чи!” гэж нэг нэгийгээ дууддаг байх үеийн юм гэнэлээ!” гэлцдэг байж. Хамгийн зэрлэг шахуу болсон тэр хүн хааныг устгахын төлөө саналаа өгөөгүй боловч тийм саналтай улсуудыг дэмждэг байсан ажээ...

Яваад хүрэх замгүй, ярьж хөөррөх хүнгүй толгодын дунд таг ганцаараа суудаг Ж-гийн дотоос гарсан хүн дөчин тав орчим минут алхаад хүрэх байлаа.

Ж тэндээ өчүүхэн газар эзэмшиж газрын ангалагт ганцаараа суудаг учир хавь ойрд нь айл амьтан нутаглах нь битгий хэл аян жингийн хүн ч хавилдуу өнгөрдөггүй юм. Ж тэнд очиж нутагласнаас хойш өтгөн өвс ургаж очих замыг бүрхсэн юм гэлцэнэ. Ж-гийн байдаг газрыг, дээрэмчдийн байрласан газартай, улсууд адилтгах болжээ.

Мириэль Ж-г дурсан санаад их хурлын ахмад гишүүний байгаа газар луу байн байн ширтэхдээ: “Тэнд гон бие гозон толгой нэг биш” гэж боддог байсан аж.

“Тэр хүнтэй чи очиж уулз” гэж сэтгэл зүрх нь хэлэн цохилдог байлаа.

Зан саот захирагч лам Ж-гийн зүг хэдэн удаа зүглэсэн авч дандаа замаас а буцдаж байсан аж.

Гэтэл нэг өмөр их хурлын хуучин ахмад гишүү-ий үе мөч нь татаад үхэх шахаж, хамт байлцсан малчин ганц хүүгээ эмчийн хойноос ирүүлсэн гэнэ гэдэг яриа хотын дотуур цууриатжээ. Зарим нэг нь “Тэгж амьдарснаас түргэн үхсэн нь дээрээ” гэлцжээ.

Мириэль дээл хувцсаа өмсөөд тэр зүг явжээ.

Нар алсын гүвээний цаагуур орох гэж байхад Мириэль олны хараал идсэн тэр газарт хүрэв...

Хаалганы дэргэд дугуйтай зөөлөн сандал дээр суусан буурал үстэй хүн жаргах нарыг ширтэн инээж байв.

Буурал өвгөний хажууд бяцхан хүү зогсож аягтай сүүгээ өвгөний зүг сарвайна...

Мириэль улам дөхөж очиход хөлийн чимээ сонссон өвгөн эргэж хараад үнэн сэтгэлээс гайхна.

-Намайг энд ирсэн цагаас хойш анх удаа гаднын хүн ирлээ. Таны алдар хэн гэдэг вэ? гэж өвгөн асуухад лам:

-Миний алдар Мириэль гэдэг гэдэх

-Мириэль гуай юу. Би таны нэрийг сонссон. Таныг ардууд сайхан сэтгэлт Мириэль гэдэг үү?

-Тиймээ.

Өвгөн инээмсэглэж:

-Морилж хайрла гээд ламтай золгох гэсэнд лам золголгүй:

-Би хууртсандаа баяртай байна. Та ч Эв эрүүл хүн шиг байна шүү дээ гэхэд өвгөн хариуд нь:

-Ноёнтон минь, би удахгүй эдгэрнэ гээд түр зуур дуугүй байснаа:

-Би гурван цагийн дараа үхнэ. Би эмнэлгийг бага зэрэг гадарладаг болохоор үхэл ирж байгааг анддаггүй юм. Өчигдөр миний хөлийн таваг хөрч эхэлсэн юм, өнөөдөр өвдөг хөрөөд одоо бүсэлдэг хүртэл хөрөөд байгааг би мэдэж байна, зүрхэнд хүрмэгц зүйл дуусах нь тэрээ. Нар хичнээн сайхан юм бэ? Би сүүлчийн удаа ертөнцийг харахын тулд гадаа гарсан юмаа. Та надтай ярьж хөөрвөл хөөр. Би ядрахгүй. Үхэж байгаа хүнийг харахаар ирдэг чинь тун сайн хэргээ. Ийм үед гэрчтэй байх хэрэгтэй юмаа. Юм болгонд учир шалтгаан байдаг. Би өглөө үүр цайтал амьд байх юм сан. Би гурван цагаас илүү амьд байж чдахгүй. Удахгүй харанхуй болно. За тэр ч хамаагүй хэрэг! Үхэхэд зовох юу байх вэ! Үхэхэд өглөө хэрэггүй. За тийм ч баг. Би одны гэрэлд үхнээ гээд өвгөн бяцхан хүүгийн зүг эргэж:

-Харьж унт. Өнгөрсөн шөнө турш чи миний дэргэд сахиж хоносон. Ядарсан байлгүй, явж унт гэсэнд бяцхан хүү овоохой руу оров.

Хойноос нь харж байсан өвгөн:

-Хүүг унтаж байх үеэр би үхнэ. Үхэл нойр хоёр айл зэргэлдээ юм шив дээ гэж шивнэв...

Бөх сууж цангинасан хоолойгоор ярьж байсан Ж ная хүрсэн боловч хөнгөн шалмаг хэвээрээ байдаг өвөгчүүдтэй адилхан байв. Хувьсгалын баатарлаг тэмцлийн дунд хатуужин төрдөг зоригтой хүмүүс олон байдаг. Энэ өвгөн бол бүх хатуу бэрхийг давсан шинжтэй. Энэ өвгөн үхэхэд тун ойртсон авч эрүүл чийрэг хүнтэй адилхан хөнгөн хөдөлгөөнтэй, хурц цэцэн хараатай, чиг шулуун хоолойтой, ханагар тэнүүн цээжтэй, үхлийг ч саатуулж чадмаар байлаа... Ж ганцхан хүссэнээрээ үхэх гэж байгаа мэт санагдана. Үхэвч хүний гарт ороогүй чөлөөтэй хэвээрээ байна. Хөл нь хөдлөхөө больж, үхэл тэндээс эхэлж, хөрч мэдээ тасарч байхад толгой нь эрүүл саруул нар шиг тодхон тунгалаг ажиллагаатай хэвээрээ, дорно зүгийн үлгэр домогт гардаг цээжин бие нь амьд ажиллагаатай, бөгсөн бие нь гантиг болсон хаан эзний хачин дүртэй адил харагдана.

Өвгөний сандлын хажууд байгаа чулуун дээр Мириэ«ь суумагцаа:

-Та эзэн ваныг устгахын төлөө саналаа өгөөгүй явдалд би баяртай байна гэхэд Ж хариуд нь:

-Та миний төлөө их бүү баярла, би хэмжээгүй бэрх хатуу харгислалыг устгахаар саналаа өгсөн юм гэв.

-Юу гэнэ? Гэж лам асуув.

-Хүнд нэг л хатуу харгислал байдаг. Түүнийг харанхуй бүдүүлэг ёс гэдэг. Энэ хатуу харанхуй харгислалыг устгахын төлөө би саналаа өгсөн. Энэ харанхуй харгислал вангийн засгийг үүсгэсэн, өөрөөр хэлбэл энэ засгийн үндэс нь худал хуурмаг ёс байдаг. Боловсролын эх үндэс нь бодит үнэн мөн. Хүнийг ганцхан мэдлэг боловсрол жолоодож чадна...

Би харанхуй харгислалыг устгахын төлөө, өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийг янхан болгон мөлждөг дарлалыг устгах, эрэгтэйчүүдийг боолчилдгийн эсрэг, хүүхдийг харанхуй бүдүүлэг байлгадийн эсрэг, эд бүгдийг устгахын төлөө саналаа өгсөн. Бүгд Найрамдах Улсын төлөө саналаа өгсөн. Бүгд Найрамдах Улсын төлөө саналаа өхдөө эд бүхний төлөө саналаа бас өгсөн юм. Би ах дүүгийн нөхөрлөл, энх тайвны төлөө, үүрийн гэгээн туяаны төлөө саналаа өгсөн хүн... Гаслан зовлонгийн үүр болсон хуучин ертөнцийг бид устгасан юм. Гэсэн ч бидний хэрэг бүрэн төгс ялаагүй. бид хуучин ертөнцийг өнгөцхөн устгаад түүнийг үзэл санаанаас салгаж таягдаж чадаагүй юм. Харгислалыг устгаад санаа амрах биш харин түүний үлдэгдлийг санаа бодлоос арилгах хэрэгтэй юм. Тээрэм нь эвдэрсэн боловч салхи нь салхилсан хэвээрээ байна шүү дээ.

Та нарт устгасан устгалт ашигтай байж болох юм, сөнөөлтийн дараа уур хилэн гардгаас би айж байна.

Үнэн шудрага ёсонд бас уур хилэн гэж байдаг юм шүү дээ ноёнтон лам гуай минь. Шудрага ёсны энэ уур хилэн бол дэвшилтийн нэл хэсэг мөн юм... Францын хувьсгал нь Христийг буй болгосноос хойш гарсан хүн төрө«хтний хамгийн сүрт хөдөлгөөн мөн. Энэ нь бүрэн төгс ялаагүй ч гэсэн хамгийн ачтай хэрэг болж өнгөрсөн. Энэ хувьсгал нийгэмлэгийн долторхи аль мууг илрүүлэн, амьдран, олны дотрыг онгойлгож хөгжлийг тарьсан, сайн сайхныг сэргээсэн юм...

Мириэль тэсэж чадсангүй,

-Юу Ерэн гуравдугаар он ямар болсон бэ? гэхэд үхэх гэж бйсан хүн өндийгөөд хамаг хүчээ шавхан байж,

-Мөн! Зүйтэй! Ерэн гуравдугаар он! Энэ үгүүдийг би хүлээж байсан юм. Мянга таван зуун жилийн турш үүл хуралдаж арван таван үеийг өнгөрөөж байж сая нэг аянга ниргэж ангасан газрыг ундаалсан юм...

Та арван долдугаар Луй хааны нэрийг дурдлаа. Хоёул ярилцъя, нэг нэгээ ойлгоё. Дээр доргүй зовон тарчилж байгаа гэмгүй бүхнийг, хүүхэд болгоныг хайрлаж энхрийлэх үү? яах вэ? Та зөвшөөрвөл би татгалзахгүй. Ер нь ерэн гуравдугаар оноос эрт эхлэн арван долдугаар Луй хаан хүртэлх хугацаанд алагдсан хүмүүсийг хайрлан харамсаж дурсъя. Хааны төлөө хар нулимсаа асгаруулахаа больё. Хэрэв та надтай адилаар ард түмний хүүхдийг харамсан энхрийлбэл би мөн таны аяыг дагаж хаад ноёдын хүүхдийг мөн харамсан гашуудалцах болно.

-Би бүгдийг харамсан гашуудаж байна гэж лам хэлэв.

-Бүгдийг адилхан үзэж байна уу! Гаслангийн жигнүүр хэрэв тэнцэхгүй бол түүний хүнд талд ард түмний гаслан зовлон байх болно. Ардт үмэн хамгаас илүү гаслан зовж байгаа юм...Ноёнтон минь сонс! Ард түмэн аль эртнээс зовж байна. Байгаарай жаахан байзнаарай. Та ямар учраас энд ирж арван долдугаар Луй хааны тухай яриа үүсгэв ээ? Би таныг танихгүй. Би энэ газар ирж нутаглахнаас хойш нэг ч удуу гадагш гараагүй дандаа ганцаараа зөвхөн энэ жижиг хүүгийн яамт амьдран сууж байлаа. Гэсэн ч би таны тухай сураг чимээ сонсоход та төдий л их муу хүн биш бололтой дуулдсан. Зальт этгээдүүдэд ард түмнийг мөлжин дарлах олон янзын арга байдаг. Би таныг танихгүй. Та ямар учраас энд ирээ вэ? Таны нэр алдар хэний хэн гэдэг вэ?

Мириэль доошоо харж:

-Би өт байна гэв.

-Морин тэргэнд суугаад давхиж явдаг газрын өт та юу? гэж Ж хэлэв.

Ж-гийн амьсгаа нь давхцаж бөглөрөх шахсан авч нүдний нь хараа саруулхан хэвээрээ байж өөрийнхөө бодлыг тайван үгээр төгсгөл болгосон нь:

-Гүжирмэгээр бий болсон давшилтыг хувьсгал гэж нэрлэдэг. Хувьсгал төгсөж хүн төрөлхтөн сүрхий донсолсны дараа алхам урагшаа давшсанаа сая мэдэх болцгоож байна.

-Захирагч ноён ламаа! Би амьд насандаа их юм бодож, судалж сонирхож өнгөрөөлөө. Эх орныхоо уриалгаар би жаран настайдаа анх улсын хэрэгт гарбие оролцож эхэлсэн. Би буруу хазгай эндэл осолтой тэмцэж, харанхуй хатуу дарлалыг устгаж, эрх ба зарчмыг тунхаглаж явлаа. Манай орон руу дайсан довтлоход биеэрээ хамгаалж эх орон францаа амь голоороо хайрлаж хамгаалж ирлээ. Би хэзээ ч гэсэн баян яваагүй, одоо хоосон хэвээрээ. Би төрийн удирдагчн арын нэгний тоонд орон, дарлагдсан олныг дэмжин ядарсан хүний сэтгэлийг сэргээж, хүн төрөлхтнөөс гэгээн гэрэл өөд урагшлах хөдөлгөөнийг дэмжиж явлаа. Зарим үед та мэтийн эсрэг дайсандаа тус болж ч явсан... Би чадлынхаа хирээр үүргээ биелүүлж, тохиолдсон боломжит газартаа тустай юм бүтээж явлаа. Намайг дараа нь мөрдөн хавчиж, цөлсөн юм... Одоо би наян зургаан настай би үхнэ. Та надаас юу хүсээ вэ? гэхэд лам:

-Өршөөл хүссэн юм гээд сөгдөн сууж толгойгоо өндийлгөтөл их хурлын гишүүн Ж нас барж нам гүм болсон байжээ.

Мириэль гүн их бодолд дарагдан гэртээ буцаж хариад шөнө турш ном айлдаж мөргөл хийж хоножээ... Энэ үеэс эхлэн Мириэль ядарч зовсон амьтдыг ихэд х айрлан үзэж туслах болсон аж.

Ж-гийн тухай ямар нэг өчүүхэн зүйл сонсвол Мириэль маш гүн бодолд орох болжээ. Ж Мириэльд чухал ямар нөлөө үзүүлснийг хэн ч мэдсэнгүй...

# ХОЁДУГААР ДЭВТЭР

## УНАЛТ

I

### ӨДӨРЖИН ЯВСАН НЬ

1815 оны аравдугаар сарын эхний нэг өдөр нар жаргахаас цагийн өмнөхөн үл таних хүн жижиг Динь хотод орж иржээ. Жижиг хотын цөөхөн ардууд энэ үеэр зарим нь үүдэн дээр зогсож алсаас яваа аяны тэр хүнийг гайхан ширтэнэ. Тэр хүн шиг хоосон хнийг лоход бэрхтэй шиг санагдана. Тэр хн дунд зэрэг нуруутай, булчинт чийрэг биетэй, ид нас гүйцсэн шинжтэй. Харахад дөчин зургаа буюу дөчин найм орчим настай бололтой. Наранд түлэгдэн салхинд үлээгдэн борлож, хөлсөнд хучигдсан нүүрий нь үрчгэр магнайгий нь шилэн саравч халхалжээ. Мөчидхөн товчилсон хиртэй дотуур цамцны цаанаас үстэй цээж үл мэдэг цухуйна. Үрчийсэн ороолтоор хүзүүгээ ороож, нэг өвдөг нь цоорхой нөгөө өвдөг нь сэмрэн цайрсан цэнхэр хөх өмдтэй, цоорхой тохойгий нь ногоон цэмбээр нөхсөн гадуур уранхай бор цамцтай тэр хүн дүүртэл нь юм чихэж нямбайгаар товчилсон цоо шинэ цэрэг үүрэг үүрч хүнд том модон таяг тулж, төмөр хадаасаар хадсан зантгар шаахайг ороолтгүй нүцгэн хөлдөө углажээ. Үсээ хяргуулсан боловч сахал нь урт ургасан харагдана. Алс зам туулж наранд шарагдаж хөлс нь цувж шороо тоосонд дарагдсан тэр хүнийг харахад нүд хальтармаар. Ахар шөрөвгөр үс нь өрвийн боссон нь саяхан хяргуулсны шинжтэй.

Түүнийг таних хүн нэг ч байсангүй. Бодвол ердийн нэг аяны хүн бололтой. Хаанаас ирсэн бэ? гэвэл өмнө зүгийн тэнгисийн эргээс ирсэн бизээ. Учир нь тэр хүн долоон сарын өмнө Наполеон хаан Канаас Парис орохдоо явж өнгөрсөн тэр замаар динь хот руу орж иржээ. Тэр хүн өдөржин явж тун их ядарсан төлөвтэй. Динь хотын эрэг дээр үеий нэхсэгт суудаг эмэгтэйчүүд, тэр хүний Гасенди цэцэрлэгийн модны ёроолд зогсоод оргилолт булгаас ус ууж байхыг харжээ. Хоёр зуугаад алхам яваад зах зээлийн талбайн худгаас дахин ус ууж байхыг хүүхдүүд мөн үзжээ. Бодвол тэр хүн маш их цангаж явжээ.

Пуашевер гудамжны өнцөгт хүрээд зүүн тийш эргэж хотын захиргааг чиглэв. Захиргаа руу далд орж хорин тав орчим минут болоод буцаж гарахад хаалганы хажуугийн чулуун сандал дээр цагдаа сууж байхыг үзээд малгайгаа авч сөгдөн мэндлэв.

Цагдаа хариу мэнд хүргэлгүй тэр хүнийг далд ортол нь анхааран харсаар хоцров.

Тэр үед Динь хотод олны хүндэтгэлийг хүлээсэн Жакен Лабар гэгч даргатай “Кольбасын загалмай” “гурван Довэн” гэдэг хоёр зочид буудаа байжээ.

Аянчин тэр буудлын зүг явж очод гал зуухны өрөөнд ороход зуух бүхэнд гал улалзан асаж дулаан сайхан байв. Амттай сайхан хоол хийж тогоо болгоныг дамжин харайж байсан ахлах гаднаас хүн орж ирэхийг мэдээд эргэж харалгүй:

-Ноёнтонд юу хэрэгтэй вэ? гэв.

-Хоол идэж, унтаж хоноод явъяа гэж гаднаас ирсэн хүн хэлэхэд тогоо:

-Мөнгө л байвал болохоо л болно гэв.

Явуулын хүн цамцныхаа халааснаас том арьсан түрийвч гаргаж:

-Над мөнгө байна шүү гэв.

-Мөнгтэй хүнд би тусалъя гэж тогооч хариулав.

Явуулын хүн түрийвчээ буцааж хийгээд, үүргээ авч хаалганы дэргэд тавиад таягаа барьсан хэвээрээ зуухны ёроолд очиж суув. Динь хот уулын дунд байдаг болохоор аравдугаар сард хүйтэн салхи салхилдаг юм.

-Хоолтой түргэн золгож болох уу? гэхэд

-Одоохон, хоол өгнө гэж тогооч хэлэв.

Явуулын хн цаашаа харж зууханд дулаацаж байх зуур буудлын эзэн Жакен Лабар өврөөсөө харандаа гарган цонхон дээр хэвтсэн хуучин сонины захаас урж аваад нэг хоёр мөр юм бичээд наалгүйгээр эвхэж зарц жаал хүүд өгөөд чихэнд нь хэдэн үг шивнэсэнд хүү хотын захиргааны зүг гүйж алга болов.

Явуул хүн эд бүхнийг огт харсангүй сууж байснаа,

-Түргэн хоол идэх арга байна уу? гэсэнд тогооч:

-Одоохон өгнө гэв.

Хүүхэд гартаа бичиг барьсаар буцаж ирээд эзэнд өхөд түргэн задалж үзээд анхааралтай маягтайгаар уншиж бодолд оров. Тэгээд явуул хүнд ойртон очоод:

-Би таныг эндээ хонуулж чадахгүй нь ээ гэхэд явуул хн босон харайж:

-Юу! Мөнгө төлөхгүй байх гэж та айгаа юу? Над мөнгө байна. Урьдчилн төлсөн ч болно шүү гэхэд эзэн:

-Танд мөнгө байсан ч над байр өрөө алга гэв.

-Тэгвэл намайг агтны байранд хонуулаач дээ гэж гуйхад эзэн:

-Агтны байранд зай бас байхгүй гэв.

Байшингийн дээвэр дор ороод атга сүрэл дээр хоносон ч болно шүү. Одоо юуны түрүүнд хоолоо идье.

-Би танд хоол өхгүй.

-Би өлсөж үхэх шахаж байна. Би өглөөний нартай уралдаж гараад дөчин найман километийн хол зам тууллаа. Би мөнгөтэй. Гомдоохгүй үнэ төлнө. Би юм идье.

-Яах ч арга алгаа.

Явуул хү гал зуухны зүг эргэн хараад инээд алдан

-Арга алгаа! Энэ их хоолыг яах юм бэ? гэв.

-Улсууд захиалаад авсан юм.

-Хэн?

-Өртөөчнүүд.

-Хичнээн хүн байгаа юм бэ?

-Арван хоёр

-Хориод хүнд хүрэх хоол байна шүү дээ.

-Бүгдийг захиалж аваад үниг урьдчилан төлсөн юмаа.

-Би буудлын газар ирсэн хойно хоол идэж хоноод явъяа.

-Та эндээс тонил! Гэж эзэн хэлэв.

Явуул хүн таягийнхаа төмөр углуургат үзүүрээр гал руу цуцал түлхэж оруулаад гэнэт эргэн харж учраа тоочихоор амаа ангайтал эзэн ширтэн харж аяархан дуугаар:

-Та олон юм бүү ярь! Би таны нэрийг хэлж өгөх үү? Та чинь Жан Вальжан гэдэг нэртэй хүн шүү. Та ямар ажил амьдралтай хүн болохыг бас хэлж өгөх үү? Таныг орж ирэхийг хараад би муу санаалж хотын захиргаа руу хүүхэд гүйлгэсэнд ийм хариу ирүүлсэн байна. Та уншиж чаддаг уу? гэснээ хотын захиргаанаас ирсэн бичгээ задалж харуулаад, жаахан дуугүй байснаа:

-Би ч хүн болгонд сайхан зан гаргадаг заншилтай. Та эндээс арил гэв.

Ирсэн хүн уруу царайлж үүргээ үүрээд гарч одов. Уйтгарт бодолд орсон тэр хүн өмнөх замаа ажиг харалгүй алхлан явсаар байгаад ядарсан, өлссөнөө дахин мэдээд унтаж хонох газар хайвч зочид буудлууд цөм хаалттай. Ядуу овоохой, тавтай тохирох газар харж явтал Шаффо гудамжны өнцөгт нэг жижиг гуанзны газар харагдав. Ойртон очиж цонхоор харвал зуухандаа гал өрдөж, жижиг дэн асаан ширээн дээр тавиад хэд хэдэн хүн тойрон сууж юм ууж байсан ба дэгээнээс дүүжилсэн төмөр тогоонд хоол буцалж байжээ. Аянчин тэр гуанзны хаалга онгойлгож ортол, гуанзны эзэн:

-Хэн бэ? гэсэнд

-Хоол идэж хоноод явах хүсэлтэй хүн байна гэв.

-Хоол идэж унтаж хоноод явж болно оо.

Гаднаас хүн ороход дотор байсан хүмүүс цөм эргэж харцгаав. Гуанзны эзэн:

-Та галд ойр суугаад дулаацаж бай. Хоол тогоон дээр буцалж байна. Удахгүй болно гэв.

Гуанзанд сууж байсан хүмүүсийн нэг нь загасчин байж. Загасчин гуанзанд ирэхээс өмнө лабарын хашаанд морио тавихаар очжээ. Тэхэд тэндхийн хүмүүс бөөгнөрч яриа хөөр болж байхыг ажаад загасчин мөн өдрийн өглөө ер бусын аягүй нэг хүнтэй замд тохиолдоход тэр хүн нь аваад явахыг гуйсанд загасчин хурдлан давхиж зугтсанаа цугларсан улсад хэлжээ. Тэр загасчин тогоочийг дохиогоор дуудан ирүүлж хэдэн үг шивнэн хэлэв.

Явуул хүн бодол бодон галын өмнө суусаар байж.

Тогооч түүн дээр очоод мөрнөөс нь чангааж:

-Одоохон зайл гэв.

Явуулын хүн эргэн хараад:

-Юу? Та бас мэдээ юу?

-Тиймээ мэдсэн,

-Намайг өөр буудлаас нааш нь ирүүлсэн юм.

-Таныг эндээс бас хөөж байна.

-Та намайг хаашаа яв гэ вэ?

-Харсан зүгтээ яв.

Ирсэн хүн үүргээ үүрч таягаа тулаад тэндээс гарч одов.

Анхны буудлаас авахуулаад ажин дагаж явсан хүүхдүүд түүнийг чулуугаар шидэхэд уур нь хүрч таягаар зангахад тэд шувуу шиг бүртэгнэн алга болжээ.

Шоронгийн хаалганы өмнөр өнгөрөх үедээ хонхы нь цохисонд өчүүхэн цонх онгойжээ.

-Харг лзагч ноён минь ээ! Та хаалага онгойлгож намайг эндээ оруулж хонуулахгүй юу гэж гуйхад нэг хүн:

-Шорон гэдэг чинь зочид буудал биш байдаг юм. Энд хонохыг хүсээд байвал та баригдаж хоригдол болоод ирээ гэжээ.

Олон цэцэрлэгт жижиг гудмаар алхаж явтал цонх нь гэрэлтэй жижиг байшин харагдав. Ойртоод цонхоор нь шагайхад, хэдэн модон сандалтай, ширээ тасалгаан дунд засаатай, хажуугий нь хананд буу өлгөөстэй байжээ. Зан сайтай, зөөлөн сэтгэлтэй, дөч гаруй настайэрэгтэй хүн ширээний хажууд суугаад өвөр дээрээ жижиг хүүг эрхлүүлэн цовхчуулж байх ба зэрэгцэн суусан залуу эхнэр өлгийтэй хүүг хөхүүлж суув. Эцэг, эх, хүүхэд багачууд цөм инээд алдан байхыг үзээд лав зан сайтай айл байна. Унтаад явъяа гэхэд үгүй гэхгүй байх гэж бодоо хаалгы нь гурав дахин аяархан тоншсонд гэрийн эзэн эрэгтэй дэнгээ бариад хаалгаа онгойлгосонд

-Өршөөгөөрэй ноёнтон минь. Мөнгөөр аяга хоол өгөөд намайг энэ шөнө гадаа байгаа саралж дотроо хөлсөөр хонуулахгүй юу? Тэгж үзээч дээ? гэхэд гэрийн эзэн:

-Тан хэн бэ? гэв.

-Би Пюи-Муасоноос гараад бүтэн өдөр дөчин найман километр хол яваад ядарч байна. Та намайг хөлсөөр нэг хонуул ач дээ.

-Мөнгө төлөөд хонох сайн хнийг унтуулаад явуулахаас би татгалзахгүй. Та яагаад өртөө буудалд очсонгүй вэ?

-Тэнд байр алJa.

-Хаанаас байхгүй байх вэ! Од®о яармаг, худалдаа арилжааны цаг биш шүү дээ. Лабарын буудалд очив уу?

-Очсон

-Юу гэж байна вэ?

-Намайг хонуулахгүй гэсэн юм.

-Шаффо гудамжны буудалд очив уу?

-Намайг мөн адилхан хөөсөн. Гэрийн эзэн тариачин итгэлгүй байдалтай болж ирсэн хүнийг толгойноос нь хөл хүртэл нь ширтээд гэнэт муухайгаар:

-Нөгөө ярилцдаг хүн үү? Гэж хашгираад гэдрэгээ гурав алхам ухарч дэнгээ ширээн дээр тавиад хананаас өлгөөтэй буюгаа шүүрэн авч буцаж ирээд:

-Зайл эндээс! Гэхэд ирсэн хүн:

-Аяга ус ч гэсэн өгөөч дээ гэхэд эзэн:

-Буудлаа шүү! гээд хаалгаа хааж дотроос нь түгжив.

Нар жаргаж харанхуй болоход Альпын хүйтэн салхи сэнгэнэн үлээнэ...

Цааш явж газар овоохой олоод хаалгаар нь мөлхөн орж сүрэл дээр тэрийн хэвтэж ядарсандаа огт хөдөлж ядан байтлаа нуруундаа үүрсэн үүргээ авч дэр хийхээр шийдэн оосры нь тайлах гэтэл чих дүжрэм хуцах чимээ гарч харанхуй дундаас арзайсан шүдтэй нохойн зантгар толгой цухуйв.

Явуулын хүн нохойн үүрэнд орсноо мэдэж үүргээрээ бамбай хийж таягаараа нохойг айлган бөгсөөрөө ухарсаар гадагш гарч хотын гадаа хөдөө талын дунд гунихран явахдаа: “Нохй ч гэсэн надаас дээр амьдралтай байна” гэж хашгирав. Харанхуй шөнө хөдөө талаар уйтгарлан тэнэж явсан хүн гэнэт хот руу буцахаар шийджээ.

Хотод ирэхэд хэрмийн халга хаалттай байхаар хэмхэрхий хананы цоорхойгоор шурган оод... Хэвлэлийн газрын хаалганыд эргэдэх чулуун сандал дээр найдвараа алдан хэвтэж байв. Ойролцоо байгаа сүмээс настай эмэгтэй хүн гарч яваад харанхуй дотор нэг хүн хэвтэхийг ажиж:

-Көхөр минь энд юу хийж хэвтэнэ вэ? гэжээ.

Тэр хүн уурлаж:

-Би унтахаар хэвтэж байна гэв.

-Чулуун дээр үү? Гэхэд хэвтээ хүн:

-Та цэрэгт байсан уу?

-Тиймээ, цэрэгт байсан.

-Та өртөө буудалд очихгүй яагаа вэ?

-Төлөх мөнгө алга.

-Над дөрөвхөн сү байна. Та үүнийг ава. Танаас би ор нэхэхгүй... Ингэж хэвтээд шөнө өнгөрөөж та чадахгүй. Та өлсөж даарсан байна. Хонуулах зөөлөн сэтгэлтэй хүн олдохгүй байна уу?

-Би хаалга бүхнийг тоншсон,

-Юу гэх юм бэ?

-Газар болгонд хөөгөөд байх юм. Эмэгтэй, тэр хүнийг түшиж босгоод гудамжны нөгөө талд ойрхон байгаа нэг байшинг зааж өгөөд  
-Та тэр байшингийн хаалга тогшсон уу? гэж асуухад  
-Үгүй, тогшоогүй гэв.  
-Та тэр хаалгыг очоод тогш гэжээ.

## II

### ХООЛОНД ОРОХ ҮЕД

Мөн орой нь Динь хотын захирагч лам зугаалганаас буцаж ирээд өрөөндөө орж удтал ажил хийж суужээ...

Зарц эмэгтэй Маглуар ламын өрөөнд орж орны толгой дээрх шургуулгаас хоолны мөнгөн хэрэгсэл аахад лам ажлаа зогсоож хоолоо идэхээр гарав.

Маглуар агай хоолныхоо ширээг зуухны дэргэд засаж дээр нь дэн асаагаад, зууханд галаа дүрэлзтэл түлжээ.

Захирагч ламынхан цугларч хоолоо идэх гэж байтал нэг хүн хаалгыг хүчтэй тогшив.

-Ороо ор гэж лам хэлэв.

## III

### БАЙДГАА ЯРЬСАН НЬ

Ямар нэг хүн хүчтэй зоригтойгоо түлхсэн адил хаалгаа бүрэн онгойход бидний мэддэг унтах орон хайж явсан нөгөө хүн орж ирээд хаалгаа хаалгүй нэг алхаад, нуруундаа үүрэгтэй, гартаа таягтай хэвээрээ ядарсан, ууртай маягаар харж зогсоход захирагч лам Мириэль зөөлнөөр харав.

Лам орж ирсэн хүнээс хэрэг зориг, хэт явдлы нь асуух гэж амаа ангайтал ирсэн хүн:

-Миний нэр Жан Валж्यान гэдэг. Би арван есөн жил шоронд суусан хоригдол хүн. Би дөрөвхөн хоногийн өмнө суллагдаад Понтральо орохоор явж байна. Тулон хотоос гарсаар дөрөв хонолоо. Өнөөдөр дөчин найман километр явган алхлаа, энд ирээд нэг өртөө буудлын газар очиж шар паспортоо үзүүлсэнд намагй тэндээс хөөсөн. Дараа нь өөр нэг буудалд очиход тэндээс “тонил” гэж хөөлөө. Намайг хэн ч хавьтуулахгүй байна. Шоронгийн манаачаас, очиж хоноод явъя гэсэн чинь бас хөөлөө. Нохойн үүрэнд орсон чинь намайг хазаад хөөчлөө. Тэгээд хөдөө гарч хээр хоноёг эснээ тэнгэр бүрхэг болохоор бороо орох магад гээд буцаж ирлээ. Хот дотор ирээд чулуун дээр хэвтэж байтал буянаа дэлгэрсэн нэг эмэгтэй дайралдаад танай хаалгыг очиж тонш гэж зааж өглөө. Тэр ёсоор би таны хаалгыг тоншсон. Энэ чинь буудлын газр мөн үү? Би мөнгөтэй, арван есөн жил хоригдлын жил хийгээд зуун есөн франк арван таван сү олсон. Надад төлөх мөнгө байна. Би дөчин наймна километр яваад тун их өлсөж ядарлаа. Танайд хоноод явж болох уу? гэв

-Маглуар гуай та энэ хүнд хоол хийж гө гэж лам хэлэв.

Жан Вальжан өврөөсөө том шар паспорт гаргаж:

-Энэ бол миний паспорт шар өнгөтэй. Энэ паспортаас болж би газар болгоноос хөөгдөж явна. Та уншиж үзвэл үз. Би өөрөө уншиж чадна. Шоронд

байхдаа уншиж сурсан юм. Ном сурах дуртай хүмүүсийг сургадаг сургааль байсан юм. Энэ паспорт дээр бичсэнийг хар: “Жан Вальжан хоригдож байгаад суллагдсан юм. Шоронд арван жил болсон. Түүний дотроос цонх хагалж хулгай хийсний шийтгэл таван жил, дөрвөн удаа оргон зугтахыг оролдсоны арван дөрвөн жил, бүгд арван есөн жил, энэ маш аюултай хүн” гэсэн байна. Ийм учраас намайг цөм хөөгөөд байгаа юм. Та намайг гэртээ хонуулах уу? Танайх чинь буудлын газар уу? Намайг хооллоод хонуулаад явуулж чадах уу? Танайд агтны саравч бий юу? гэхэд Мириэль,

-Маглуар гуай энS хүнд тусгай цэвэр даавуутай ор засаж өг гээд ирсэн хүний зүг эргэн харж:

-Та суу, дулаац. Одоохон хамт хоол идье. Хоол идэж байх хооронд танд ор дэр засаж бэлэн болгог гэхэд,

-Лав уу? Яаж болох юм бэ? Та намайг гэртээ хонуулах гэж үү? Над шиг олиггүй хоригдлыг гэрээсээ хөөхгүй гэж үү? Улсууд дандаа намайг “Зайл чи муу нохой!” гэдэг байхад та намайг “ноён” гэж хүндэтгэж байна. Та намайг лав хөөнө байх гэж би бодож байсан юм. Би хэн болохоо нуулгүй хэлсэн. Намайг нааш явуулсан тэр буянт эмэгтэйд баярлалаа. Би одоохон хоол иднэ. Тэгээд бусадтай яг адилаар цагаан даавуутай орон дээр унтана. Би арван есөн жилийн турш орон дээр унтаж яваагүй... Би мөнгөтэй, хоол, орон сууцны мөнгө төлнө. Таны нэр алдар хэн гэдэг билээ? Хэлснээр мөнгө төлнө. Та буянтай амьтан байна. Та чинь өртөө буудлын эзэн үү? Гэхэд лам хариуд нь,

-Би лам хүн гэв.

-Лам хүн үү та!.. Тэгвэл надаас мөнгө хөлс авахгүй болох нь ээ гэж ярьж байсан Жан Вальжан үүргээ таягных а хамтаар нэг буланд тавиад, паспортоо өвөртөлж суув.

Дараа нь:

-Та буянтай хүн. Надаас зовохгүй байна. Лам хүн ийм л байх сайхан. Та хөлс мөнгө авахгүй байхаа? гэхэд лам:

-Авахгүй. Мөнгөө хадгалж бай. Та хэдэн франктай вэ? Зуун ес гэв үү үгүй юу?

Гэв.

-Арван таван сүтэй.

-Бүгд зуун есөн франк арван таван сүтэй юу? Үүнийг та хэдий хир хугацаанд ажил хийж олсон бэ?

-Арван есөн жил

-Арван ес! Гээд лам санаа алдав...

Маглуар авгай хоолоо бэлдэж ширээ засаад хоолныхоо зургаан мөнгөн хэрэгслийг тавьжээ. Тэгээд бүгд хамтран хоол иджээ.

Хоолны дараа лам:

-Би таныг өрөөнд чинь оруулж өгье. Та миний хойноос яв гэхэд Жан Вальжан дагаж одов.

Жан Вальжан унтахаар явж байхад Маглуар авгай хэдэн мөнгөн хэрэгслээ ламын орны толгой дээрх шургуулга руу хийж байлаа.

Лам ирсэн зочноо унтах газар нь оруулаад:

-Сайхан нойрсоорой. Маргааш өглөө та явахаасаа өмнө манай үнээний халуун сүү уугаад яваарай гэхэд зочин хариу баяр хүргэв.

Хэтэрхий ядарсан Жан Вальжан цэвэр сайхныг ажиж амжилгүй дэнгээ унтраагаад өмссөн хувцсаа тайлалгүйгээр орон дээр унаж бөх гэгчээр унтав...

## ЖАН ВАЛЬЖАН

Шөнө дундын үед Жан Вальжан сэрэв.

Жан Вальжан ядуу тариачны гэрт төрөөд бага насандаа бичиг сурсанүй. Насанд хүрмэгцээ мод хөрөөдөгч болжээ. Эх нь Жан Матье, эцэг нь Жан Вальжан гэдэг байж... Жаныг бүр бага байхад нь эх нь арчилгаа муутайгаас болж савны халуунаар нас баржээ. Аав нь мод хөрөөдөгч байгаад өндөр модноос унаж үхжээ. Жан Вальжан долоон хүүхэдтэй ганц эгчтэйгээ үлджээ. Тэр эгч нь нөхөтэйгөө хамтран бяцхан Жаныг тэтгэн өсгөж байтал нөхөр нь бас нас баржээ. Долоон хүхдийн ууган нь наймтай, отгон нь нэг настай ажээ. Жан Вальжан хорин тав хүрээд цгийг төлөөлөн хүүхэдтэй эгчээ асардаг байв. Хүнд хөдөлмөр хийж бага хөлс авч залуу насаа өнгөрөөж амар жаргал, янаг дурлалыг ч үзсэнүй. Эгчтэйгээ хамтран ажиллаж амь зууж байтал сүрхий ширүүн өвөл нэг тохиолдож Жан Вальжан ажилгүй болоход долоон хүүхэд амь залгах хэлтэрхий тлахгүй болж хоосорчээ.

Нэг ням гаригийн орой талх худалдагч Мобер Изабо гэгч унтахаар бэлтгэж байтал дэлгүүрт нь тортой цонхыг хэн нэг хүн хага цохих шиг болсонд гүйн очиж харвал нэг гар тэр хагархай цонхоор орж хатсан талх шүүрээд гарах нь үзэгджээ. Изабо гүйн харахад хулгай хар эрчээрээ зугтав. Изабо гүйсээр гүйцэж очиход хулгайч талхаа хаяж амжсан байв. Хулгайчийн гараас цус цувж байлаа. Талх хулгайлсан хүн Жан Вальжан мөн байжээ.

Хэргийг 1795 онд мөрдөн шүүгээд “шөнийн цагаар айл гэр үймүүлж цонх хагалан хулгай хийсэн” хэргээр Жан Вальжанг таван жил шоронд хорьж ажил хийлгэхээр тасалжээ. Долоон нялх дүүгээ өлсөөж алахгүйн тулд Жан Вальжан тэгж хулгай хийсэн ажээ.

Жан Вальжаныг Тулон руу явуулжээ. Вальжан Тулон ортлоо хорин долоон хоногийн турш хүзүүндээ гинж дөнгөтэй явжээ.

Урьдын бүх юм өөрчлөгдөж Жан Вальжан гэхийн оронд 24601 дүгээр хүн гэдэ болжээ. Долоон хүүхэдтэй эгч, долоон дүү нь яасныг огт мэддэггүй явах болжээ.

Дамын хүний яриагаар бол Жан Вальжан эгч нь хамгийн бага хүүтэйгээ хамт Парис хотод сууж өөрөө хэвлэх үйлдвэрт ажил хийж хүү нь долоон нас хүрээд сургуульд орсон бололтой. Бусад зургаан хүүхэд үхсэн эсэх нь үл мэдэгдэнэ. Эх нь өглөө эрт зургаан цагт ажилдаа очдог учир хүүгээ хамт авч яваад сургуулийн нь гадаа бүтэн цаг орхидог ба хүү хүйтэнд даарахдаа элгээ тэвэрч өвлийн хүйтэн өглөө харанхуйд дугжирч байхыг үйлдвэрийн ажилчид нэг бус удаа харжээ. Бороотой өдөр нэг эмгэн тэр хүүг овоохойдоо орулж муур тэврүүлэн дулаацуулдаг байж. Долоон цаг болоход сургууль сая онгойж тэр хүүхэд хичээлдээ ордог гэнэ гэсэн алсын дам яриа Жан Вальжанд сонсогджээ. Энэ яриа чухам үнэн худлыг Жан Вальжан хэзээ ч лавлаж мэдэж чадсангүй өнгөрчээ.

Шийтгэгдээд дөрвөн жил болохын эцэст Жан Вальжаны оргон зугтах ээлж иржээ. Хоригдлуудын тусламжаар Жан Вальжан оргож хоёр өдөр чөлөөтэй яваад орой нь баригджээ. Энэ хэргийн учир хоригдох хугацаа нь гурван жилээр нэмэгджээ. Зургаа дахь жилдээ бас оргох ээлж нь ирж оргох гэж байгаад баригдаж дахин таван жил хоригдог болжээ. Арав дахь жилдээ мөн ээлжиндээ оргож яваад баригдаж дахин гурван жил нэмэгдүүлжээ. Арван гурав дахь жилдээ дахин оргоод дөрвөн цагийн дараа баригдаж гурван жилийн ял нэмүүлжээ. Бүгд нийлж арван есөн жил шоронд

суужээ. 1796 онд цонх хагалж талх хулгайлсан хэргээр шоронд орсон бол 1815 онд шоронгоос суллагджээ.

## V

### СЭХЭЭРЭЛТ

Жан Вальжан арван есөн жил шоронд суугаад сэтгэл санаа нь яаж өөрчлөгдсөнийг товчхон ярья.

Юуны өмнө нийгмийг мөрдөн шүүж үзээд түүнд тохирох ял оноожээ... Өөрийнхөө хувь заяаг муутгасан хариуцлагыг нийгэмд хүлээлгэж, бололцоот цаг ирвэл тооцоогоо хийнэ гэж шийджээ. Вальжанаас нийгэмд учруулсан хохирол, нийгмээс Жан Вальжанд учруулсан хохирол хоёрын хооронд тэнцүүр алга болохыг тогтоожээ. Эцэст нь Жан Вальжаныг шийтгсэн явдал бол үнэн шудрага хэрэг биш гэж дүгнэжээ...

Нэг зовлонгоос ангижирч нөгөө зовлонтой учирч явахдаа амьдрал гэдэг дайн байлдаан юм. Ээн дайнд ялагдагсдын тоонд өөрөө орж явдгаа аажмар мэджээ. Дайн хийх цор ганц зэвсэг нь үзэн ядах үзэл болжээ. Тэр зэвсгээ Жан Вальжан улам хурцлахаар шийдэж дөчин настайдаа шоронд байхдаа бичиг үсэг сурчээ. Ухаанаа хичнээн хөгжүүлбэл занах хүч нь төдийчинээн гүнзгийрдгийг ухамсарлажээ. Ингэж арван есөн жилийн дарлал боолчлолын туршид Жан Вальжаны сэтгэл нь нэг талаар хөгжиж нөгөө талаар доройтжээ. Нэг талаас сэтгэлд нь гэрэлт нэвтэрч нөгөө талаас харанхуй бүдүүлэг авир суужээ.

## VI

### ЖАН ВАЛЬЖАН НОЙРНООС СЭРЭВ

Шөнийн хоёр цагийн хонх дуугарахад Жан Вальжан нойроос сэргээ.

Дөрвөн цаг унтахад ядрал нь гарч нойр нь ханажээ. Удаан унтаж заншаагүй учир Жан Вальжан эрт сэрсэн аж.

Нойрноо сэрээд байх үед оройн хоолон дээр тавьсан мөнгөн хэрэгслүүд нүдэнд нь харагдаж санааг нь зовооно. Янз бүрийн бодолд дарагдан тарчилж байснаа гурван цаг болмогц өндийж шалан дээр тавьсан үүргээ тэмтрэн үзээд, хөлөө унжуулж шаланд хүргэнгүүт гэнэт доошоо суув.

Нилээд дуугүй сууж байснаа гутлаа тайлж орны хөлд аяархан тавив. Дараа нь хуучин байдалдаа орж бодол бодон нам гүм байв.

Дахин босож шийдэж ядан хэдэн секунд өнгөрөөгөөд чагнан үзвэл байшингийн дотор чив чимээгүй байна...

Жан Вальжан гартаа дэн бариад зэргэлдээ өрөөнд орохоор гэтэв... Чагнан үзэхэд ямар ч чимээ грсангүй болохоор хаалга онгойлгон оров... Жан Вальжан юм мөргөхгүйн тулд маш болгоомжлон урагшаа явсаар орны дэргэд очив...

Жан Вальжан гэнэт малгайгаа өмсөж унтаж байга ламыг харалгүй явсаар орны толгой дээр байсан шургуулганд хүрэв. Эвдэхээр завдан байтал шургуулгын түлхүүр зүүлттэй байхыг мэдэж онгойлгон хайрцагтай мөнгөн хэрэгслийг аваад учир тоймгүй дуу чимээтэйгээр хурдан алхаж үүрэгтээ хүрээд мөнгөн хэрэгслүүдийг үүрэг дотроо

хийгээд, хайрцгий нь газар хаячаад цэцэрлэгийг дамжин гүйж, хашаанаас мултарсан барс адил үсрэн далд оров...

Маргааш өглөө нь нар дөнгөж гарах үеэр Мириэль цэцэрлэг дотуур зугаалж явтал Маглуар авгай сандран гүйж ирээд:

-Гэгээн лам минь, гэгээн лам минь та мөнгөн хэрэгслүүд хаашаа алга болсныг мэдэв үү? Манайд хоносон зочин хулгайлж аваад явсан байх аа. Тэр хүн шөнө босоод явсан байна билээ гэв.

Лам түр зуур дуугүй байснаа төлөв маягаар:

-Мөнгөн хэрэгслүүд бидний юм мөн үү дээ? Би тэр мөнгөн хэрэгслүүдийг удаан хэрэглэх ёсгүй хүн юм. Мөнгөн хэрэгслүүд чинь ядуу хүмүүсийн хөрөнгө болох ёстой. Хоносон зочин ямар хүн байсан бэ? Лав ядуу хүн байсан байх гэжээ...

Хэдэн минутын дараа Мириэль урьд орой нь Жан Вальжан сууж байсан суудал дээр сууж цайгаа ууж дуусаад босон явах гэж байтал хүн хаалга тогшив.

-Ороо ор гэж лав хэлэв.

Хаалга онгойход айж сандарсан хэсэг хүн орж ирэв. Тэдний гурав нь нэг хүнийг заамдан чирчээ. Гурав нь цагдаа, дөрөвдөх нь Жан Вальжан байлаа. Эднийг харсан Мириэль угтан чадлынхаа хирээр хурдан алхалж очоод Жан Вальжанд:

-За та ирээ юү? Тантай учирсандаа баяртай байна. Та яах нь энэ вэ? Би танд лааны тавиуруудыг бас өгсөн юм. Тавиурууд бусдынхаа адил мөнгө юм шүү, худалдвал хоёр зуун франк хүрнэ. Та энэ тавиуруудаа өөрийнхөө хоол цайны хэрэгслүүдийн хамтаар аваачихгүй яагаа вэ? гэв.

Цагдаа:

-Энэ хүн зугтаж яваа маягтай болохоор бид барьсан, нэгжихэд хоол цайны мөнгөн хэрэгслүүд гарсан. Гэтэл энэ хүн гэмгүй болж байх шив дээ? гэсэнд лам:

-Та нар учраа ойлголцсонгүй бололтой гэхэд цагдаа,

-Тэгвэл энэ хүнийг суллах уу? гэсэнд

-Суллаа сулла гэж лам хэлэв.

Цагдаа нар аргаа алдаад ар тийшээ ухарч байгаа Жан Вальжаныг суллав.

Гайхша тасарсан Жан Вальжан:

-Намайг суллаж байгаа юм гэж үү? Үнэн үү? Гэхэд цагдаа нарын нэг нь:

-Таныг сулж байна. Та юугий нь ойлгохгүй байна вэ? гэв.

Лам өгүүлрүүн:

-Нөхөр минь та ядахдаа мөнгөн тавиуруудаа марталгүй алваад яваарай гээд зуухан дээр байсан лааны тавиурыг авч Жан Вальжанд өгөв.

Цагдаа нар гарч одов.

## VII

### ЖААХАН ХҮҮ ЖЕР,Е

Хэргээс мултарсан Жан Вальжан хөөгдөн яваа адил хурдлан гүйжх отоос гадагш гарч арван хоёр километр орчим хол газар сууж, элдийг эрэгцүүлэн бодож байтал баясгалант дууны аялгуу сонсдов.

Эргэж харвал арав орчим насны жаал хүү аялан дуулсаар алган дээрээ арав таван мөнгөө тавиад тоглон наадж айсуй.

Жан Вальжаны үзээгүй бяцхан хүү дөчин мөнгийг дээш нь хаясанд тэр нь Жан Вальжан руу үсрэн ойртов.

Жан Вальжан тэр мөнгийг хөл дороо оруулан гишгэв.

Үүнийг харсан жаал хүү огт айсан шинжгүйгээр Жан Вальжаны дэргэд ирээд:

-Та миний мөнгийг яасан бэ? гэхэд Жан Вальжан:

-Нэр чинь хэн бэ? гэв

-Жаал хүү Жерве гэдэг.

-Зайл эндээс гэж Жан Вальжан хэлэхэд Жерве:

-Ахаа, миний мөнгийг өгөөчээ гэж олон дахин уйлан гуйж байснаа

-Та хөлөө ав. Би мөнгөө авъя гэв.

Ямар ч үг дуугараагүй сууж байсан Жан Вальжан гишгэсэн мөнгөн дээрээс хөлөө авалгүйгээр үсрэн босч:

-Амьд мэнд дээрээ арил гэж зандрахад айж сандарсан Жерве хүү хар эрчээрээ гүйсээр эргэж харалгүй далд оров.

Уруу царайлж удтал суусан Жан Вальжан босон харайж хөл дороо байсан мөнгийг авч хүүд өх гээд “Жаал хүү Жерве, Жерве!” гэж хашгиравч хариу юу ч сонссонгүй учир тэр хүүг байдаг чадлаараа эрж сураглаад олсонгүй, харсан зүгтээ алхаж яваад замдаа ламтай тохиолдож Жерве хүүг сураглан асуугаад сураг гаргаж чадсангүй. Тэгээд хүүгээс булаан авсан дөчин мөнгийг гаргаж:

-Лам гуай та энэ мөнгийг авч ядуу хүнд өгөөрэй. Би хулгайч хүн, та намайг баривчлан ав гэсэнд лам айн сандарч мөриндоо ташуур өгч тоос манарган давхиж алга болжээ.

Хийсэн хэргийнхээ буруу уршгийг ухаарсан Жан Вальжан уйл уйлсаар ухаа орж учраа ойлгожээ.

## ГУРАВДУГААР ДЭВТЭР

### 1817 он

I

### 1817 он

Арван наймдугаар Луй хаан 1817 онд хаан ширээнд суусныхаа хорин оавдахь жил мөн гэж нэрлэжээ...

Мөн онд ноён Брюгьер дө Сорсумын алдар нэр манджээ... Напелеон Дархан Елен арал дээр сууж, пруссууд францыг эзэмшсэн хэвээрээ байлаа...

1817 онд Парисын дөрвөн залуу “хачин тоглолт” хийхээр шийджээ...

Тэр дөрвөн залуу цөмөөрөө оюутнууд байжээ. Нэрсийг дурдвал Феликс Тломьес, Листолье, Файмель Блашвель гэдэг залуучууд нэг бүрд сэтгэлийг татсан охинууд байсан. Блашвель Фавиуритэд, Листолье Дашад, Файмель Зефинд, Толомьес нарны гэрэл шиг алтан шаргал үстэй Фантинд сэтгэлтэй болсон ажээ.

Залуу оюутнууд урьд нь бие биеэ таньдаг байж, залуу охидууд сая танилцаж үерхэх болжээ. Иймэрхүү дурлалын явдлууд дандаа өөртөө тохисон нөхөрлөл үерхийг бий болгодог.

Толомьест дурласан Фантиний дурлал хамгийн анхны үнэн сэтгэлийн гүнзгий дурлал байжээ.

Ард түмний гүн дундаас алдаг оног цэцэглэдэг ариун цогцос төгс алиа хонгор охидын нэг нь Фантинь мөн санж. Нийгмийн гаслангийн гүн дотроос төрсөн Фантинийн гарал үүслийг гаднаас хараад олоход бэрхтэй Фантинь тэнгисгийн Мөнрейль хотод төрж, төрөл садан нь чухам хэний хэн гэгч байсныг хэн ч хэлж эс чадна. Эцэг эх хоёры нь хэн ч мэддэггүй билээ. Нэрий нь Фантинь гэхээс өөр зүйлийг мэдэх хүн байсангүй. Яагаад Фантинь гэдэг нэртэй болсныг ч мэдэх амьтан олдсонгүй. Түүнд овог ч байсангүй. Өмсөх гуталгүй улаан нялх хөлөөр гүйж явахыг үзсэн анхны нэг үл таних хүн анх тэгж дууджээ. Тэр хүний дуудсанаар Фантинь нэртэй болсон юм. Өмсөх малгайгүй учраас борооны усанд толгойгоо өөрийн эрхгүй норгодгин адилаар өгсөн тэр нэрийг олон таван үлгүй хүлээн авчээ. Тэгээд түүнийг улсууд жижигхэн Фантинь гэх болжээ. Үүнээс өөр зүйлийг хэн ч мэддэггүй санж. Ийм байдлаар Фантинь амьдралын замд анх алхжээ. Арван настайдаа хотоос гарч хөдөөгийн нэг жижиг хөрөнгөтнийд зарцлагдаж байгаад арван таван нас хүрч амраг орноо орхиж “аз жаргал” хайхаар алс Парис оржээ. Угийн гуа сайхан Фантинь удтал хэвийнхээ байдлыг адалгүй явжээ. Фантиний мяндсан шаргал үс, яралзсан цагаан шүд нь тун ч сайхан байжээ. Үс шүд хоёры нь харсан хүн “толгойдоо алттай, амандаа сувдтй” тун сайхан байна гэлцдэг байж.

Фантинь амьдрахын тулд ажил хийж, амраглан дурлажээ. Ариун сэтгэлийнхээ гунигийг арилгахаар Толомьес залууд амраглан дурлаж.

Гэтэл нэг өдөр Толомьес бусад гурван нөхдөө дуудаж сэжигтэй хэдэн үг хэлжээ. Толомьесын сэжигт үгийг дагж цөмөөрөө дараагийн ням гаригт дөрвүүлээ залуу охидоо урьж зугаалахаар шийджээ.

## II

### ДӨРВӨН ХОС ЗАЛУУ

Дөрвөн залуу оюутнууд дөрвөн охидыг дагуулан өглөөний таван цагт Сен-Клу орохоор гарч “Хар толгой” гуанзанд цай ууцгаав. Тэндээс цаашилж өнгийн цэцэг дэлгэрч, ноон мод найгасан өргөн тэнүүн газраар хөлөө эцтэл зугаалж хэлээ эцтэлээ ярилцаж өлгөн шугуй дотор сэтгэл зүрхийг ханган дуулцгааж явжээ.

Энэ өдөр өглөөнөөс аваад орой болтол алтан нарны туяа ариун дэлхийг гийгүүлж, агаарын зөөлөн салхи тасралтгүй сэнгэнэж байгаль дэлхий баясан цэнгэж тун ч аятайхан байлаа. Түүний дотор зугаалж яваа хос дөрвөн залуу нар шиг туяарч цэцэг шиг цэнгэж явсаар “Бамбард” ресторанд ороод ширээ дүүрэн архи дарс зууш хоол захиалж цадтал идэж ханатал ууцгаан, наргин дуулж оройн таван цаг хүргэв. Олны дотроос Толомьес улам хөгжилтэй, шүлэг уншиж уран хошин үг хаяж цэцэрхэж байтлаа Сен мөрний эрэг дээр ачаатай морин тэрэг онхолдохыг харан мэл гайхаж цэл хөхрөв. Онхолдсон морин тэргийг тойрон олон амьтан цугларч шуугихад залуучууд цөм цонхоор гадагш харсанд Фантинь:

-Ядарсан морь байна даа! гэв.

Дали хашгиран:

-Юу! Фантинь морины төлөө уйлах гэж байна. Мөн ч уяхан дотроо! Гэв.

Фавурит охин гараа салаавчилж гэдийн зогсож Толомьесыг харснаа:

-Та бидэнд сонин юм үзүүлнэ гэсэн яалаа гэж шулуухан асуужээ. Толомьес хариуд нь:

-Зүйтэй! Цаг болоод байна. Ноёдоо, эхнэрүүддээ сонин юм үзүүлэх цаг иржээ. Эрхмүүд минь биднийг түр хүлээж байгаарай гэхэд залуучууд гарахаар боло. Битгий их удаарай. Бид та нарыг хүлээж байх болно шүү гэж Фантинь хэлэв.

### III

## ЗУГААЛГЫН ТӨГСГӨЛ

Үлдсэн охидууд цонх тохойлдон зогсож дэмий донгосоцгоон заримда цонхоор шагайж инээдмийн үг ярилцах байхад залуучууд гадагш гарч санй өд°өөр зугаалж яваа олны дунд орж бараа тасрахыг харжээ.

Удсан ч үгүй нэг морин тэрэг голын эргээр хурдлан давхиж явснаа гэнэт зогсоод цаашаа давхиж далд орохыг оридууд харжээ. Тэхэд Фантиний дотор арза гэж:

-Хачин юм даа! Тэрэг зогсдоггүй газар морин тэрэг зосгоод явчлаа шүү гэжээ.

Нилээд азнасны дараа хоол зөөгч гартаа захидал барьсаар орж ирэхэд Фавурит:

-Энэ чинь юу вэ? гэхэд зөөгч

-Саяын явсан ноёдууд энэ захидлыг та нарт өгөөрэй гэсэн юм гэв.

-Та тэр дор нь авч ирж өгөхгүй яасн бэ?

-Нэг цаг өнгөрсний дараа өгөөрэй гэж тэд тушаасан юм гэж зөөгч хэлэв. Фавурит цаасыг зөөгчийн гараас хурдан шүүрэн авч үзвэл үнэхээр захидал байлаа.

-Сонин юм даа! Хаяг алга, “сонин чинь энэ дээ” гэж бичсэн байна гэж уншив.

Тэр захидлыг түргэн задлан уншвал:

“Хайрт амрагууд минь ээ!”

Бид ах дүүтэйг та нар мэднэ. Ах дүү төрөл садны учрыг та нар төдий л сайн мэдэхгүй байхаа. Иргэний хуулинд аав ээж хоёрыг сайхан санаат салан задгай хүмүүс гэж нэрлэжээ. Бидний ах дүү төрөл садныхан хөгшчүүл олон таван үг ярьж, эр эм хёор биднийг золбин хүүхдүүд гэж нэрлэж байна. Тэд биднийг гэртээ ирэхийг шаардаж байна. Бид эцэг эхийнхээ үгнээс гардаггүй. Та нар энэ захидлыг хүлээн аваад уншиж байх үед бид морин тэргэнд суугад эцэг эхдээ очиж явах болно. Биднээс хагацлаа гэж гунихрахын оронд өөр хүнтэй хувь заяагаа холбосон дээр байхаа... Бид бүтэн хоёр жил үерхэн цэнгэсэн. Муу юм битгий бодоорой” гэжээ.

Дор нь: Блашвелье

Файмель

Феликс Толомьес гэж үсгээ зурцгаасан байв.

Жич: “Хоолны мөнгө бид төлсөн” гэжээ.

Үлдсэн охидууд хайр дураа өгсөн Фантинь охин гэртээ бичаж ирээд уйлан гунихирч байв. Толомьест анх дурлаж хайр сэтгэлээ өгсөн Фантинь давхар биетэй болж хоцорчээ.

## ДӨРӨВДҮГЭЭР ДЭВТЭР

# ХҮНД ҮРЧЛҮҮЛСЭН ХҮҮХЭД ХЭЭР ХАЯГДСАНТАЙ АДИЛ

I

## ХОЁР ЭХ УУЛЗСАН НЬ

Манай зууны эхэнд Парис орчмын Монфермейльд жижиг өртөө буудлын газар байлаа. Тэр буудал өнөөдөр устаж үгүй болжээ. Тэр өртөө буудлын эзэн нь авгай нөхөр хоёр Тенарде байжээ.

Тенардыегийн гадаа дүүжин дээр нэг нь гурван настай, нөгөө нь хоёр настай хоёр хөөрхөн охин наадаж байлаа... Хажууд нь үүдэн дээр царай муутай эх сууж охидоо хөдөлгөхийн хамт дуу аялан сууж байтал нэг хүн сэм ойртон ирээд чихэнд нь:

-Та яасан хөөрхөн хүүхэдтэй хүн бэ! гэхийг сонсоод эргэн харвал хоёр алхмын цаана нялх хүүхэд тэвэрсэн эмэгтэй зогсож байжээ.

Хүүхэд тэвэрсэн эмэгтэй нилээд том маш хүнд бололтой үүрэг үүрсэн харагдана. Тэвэрсэн хүүхэд нь хоёр гурван настай, дагина шиг хөөрхөн биедээ тохирсон жижиг хувцастай, эрүүл улаан ягаан хацартай ажээ. Алим шиг мөнжгөр ягаан хацры нь харсан хүн хайрлаж үнсэхгүй өнгөрөхийн аргагүй. Тэврүүлсэн охин эхийнхээ гар дээр унтсаар.

Охиноо тэвэрсэн эх гунигтай, ядарсан царайтай жилчин шиг хувцастай, насаар залуу эх, гар дээрээ унтуулсан охиноо энэрэнгүй нүдээр энхрийлэн харна.

Хүүхэд тэвэрсэн эх Фантинь байлаа. Фантинь энэ хугацаанд бараг танигдахгүй болтлоо өөрчлөгджээ. Ойртож сайн ажиглавал түүний гуа сайхан хэвээрээ, баруун хацраар нь бага зэрэг үрчлээс гарсан ба их хуйлсан болов уу гэмээр хоёр нүд нь улайсан харагдана...

“Хачин шоглолт” болсноос хойш арван сар өнгөрчээ. Энэ арван сарын дотор юу өөрчлөгдсөнийг тааварлахад хүнд бишээ.

Толомьест хаягдсан өдрөөс эхлэн Фантинь зовлонд учирч, Фавурит, Зефин, Дали гурваас бүрмөсөн хагацжээ.

Эцэггүй хүүхэдтэй ганцаараа хоцорсон Фантиний ажлын чадвар муудаж, зугаалан цэнгэх нь улам ихэсжээ. Толомьестой учирснаас болж ажлаа муу хийх болж ажлаа алдаж гэдэс тэжээх нөхцөлгүй болсон байна.

Арай гэж уншиж чадахаас биш бичиж чаддаггүй байсан Фантинь тохиолдсон хүнээ гуйж хоёр гурав дахин Толомьест захиа бичүүлж явуулсан боловч нэг ч удаа хариу авсангүй. тэгээд байдал өөр болсныг ойлгож хүнд зовлонд учрах магад гэж боджээ. Фантинь ойртон айсуй зовлонгоос мултрах аргаа хайх боллоо. Төрсөн нутаг тэнгисийн Монрейль хот орж таних ах дүүтэй учран ажил олж амьдрахаар шийджээ. Анхны хагацлаас улам илүү хүнд бэрх хагацалтай учирна байх гэж бодохоос зүрх чичрэн элэг эмтрэх болсон Фантинь хамаг өөдтэй хувцас, гоё эдлэлээ борлуулж амьсүнс болсон ганц охиндоо зориулах болжээ. Бүх юмаа хоёр зуун франкаар худалдаад аар саар өрөө төлж наядхан франктай үлджээ. Энэ нь маш бага мөнгө байлаа.

Фантинь өнчин охиноо тэврэн Парисаас гарах үед дөнгөж хорин хоёр хүрч байылаа. Замаар яваа энэ хоёр амьтныг харсан хүний өр өвдөж, санаа алдахгүйгээр зөрөхөд бэрх байв. Фантинд нялх охиноос өөр хэн ч нарт ертөнцөд байсангүй.

Фантинь охиноо хөхөөрөө тэжээдэг байсан учраас тэнхээ тамир нь муудах хэр хэр ханиах болжээ...

Охиноо тэврээд Тенардьегийн гадаа ирэхэд Тенардые авгай эргэн хараад хаалганы хажууд суу гэж дохижээ. Тэгээд хоёр эмэгтэй ярилцаж эхлэв.

-Намайг Тенардые гэдэг юм. Бид энэ буудлын эзэн улсуудаа гэж хоёр охины эх хэлэхэд, Фантинь:

-Би ажилчин хүн. Нөхөр минь нас барж Парист ажил олдоход бэрх болохоор нутаг харьж ажил олохоор явна. Өнөө өглөө Парисаас гараад хүүхэд тэврэн явсаар ядарсан учир замын морин тэргэнд сууж Вилемонболь хүрээд тэндээс Монфермейль хүртэл явган ирлээ. Зарим газар охиноо хөтөлж үзсэн боловч саяхан гарсан учир огт газар хороохгүй юм. Тэгээд тэврэн явахад охин минь унтачлаа гэх мэтээр өөрийнхөө намтрыг бага зэрэг өөрчлөн яриад охиноо үнсэхэд охин сэрж гялалзсан томцэнхэр нүдээрээ юм харав.

Дараа нь инээд алдан эхийн гараас доош мултарч газар буугаад дүүжлүүр дээр байсан хоёр хөөрхөн охиныг үзээд зог тусаж гайхахдаа хэлээ гаргав.

Тенардые авгай охидоо буулгаад:

-Гурвуул наадацгаа гэв.

Гурван хүүхэд гэр барьж тоглож байх зуур хоёр эмэгтэй яриагаа үргэлжлүүлэв.

-Таны өөдсийн чинь нэр хэн бэ?

-Козетт.

-Хэдэн настай вэ?

-Удахгүй гурав хүрнэ.

-Манай их охинтой чацуу юм...

эв нэгтэй тоглож байгаа гурван охидыг харсан Тенардые:

-Хүүхдүүд гэдэг амьтан мөн амархан танилцах юм даа харахгүй юу, эгч дүү гурав шиг байна шүү гэх баярт үгийг сонссон нөгөө эх гөлрөн ширтэж:

-Би танайд охиноо үлдээе болох уу гэхэд Тенардые зөвшөөрч байгаа үгүй хоёр нь эс мэдэгдэхээр гайхан хөдлөв.

Козеттын эх:

-Би өөдөс охиноо нутагтаа авч харьж чадахгүй нээ. Хүүхэдтэй очвол тэнд ажил олдноо, хол хэрэг... Энэ хэд чинь эгч дүү болцгоог. Би удахгүй охиноо авахаар буцаж ирнэ. Би охиноо танайд орхиё болох уу? гэхэд Тенардые авгай:

-Ярилцъя гэв.

-Би сар бүрийн өртөгт зургаа- франк төлж чадна гэж хэлэхэд гэр дотроос нэг эрэгтэй хүн:

-Долоон франкаас доошгүйг төл. Хагас жилийн хөлсийг урьдчилан төл гэхэд авгай нь:

-Зургаан долоо дөчин хоёр гэхэд Фантинь:

-Би төлнө гэв.

-Түүнээс гадна арван таван франкийг анхны зардал болгож төлөөрэй гэж эрэгтэй хүн хэлэв.

-Бүгд нийлж тавин долоон франк гэж авгай нь хэлнэ.

-Би төлнө. Би наян франктай. Нутагтаа явган явж хүрэхэд миний үлдэх мөнгө хүрнэ байх. Нутагтаа очиж ажил хийгээд хэдэн мөнгө хуримтлуулж байгаад өөдөс охиноо авахаар түргэн буцаж ирнэ.

-Хүүхэд чинь хувцастай юу гэж эрэгтэй хүн асууна.

-Бий байлгүй яах вэ! Бүрэн хувцас нь миний үүрэг дотор байна. Энэ лав танай нөхөр байх гэж тэр дороо мэдсэн юм.

-Бүх хувцсы нь та үлдээгээд яваарай гэж эрэгтэй хүн хэлэв.

-Тэгэлгүй яах вэ! Охиноо нүцгэн орхивол нүгэл байгаа даа гэж Фантинь гайхна.

Эзэн хаалгаараа шагайж:

-Тохиръё болно гэв.

Охиноо үлдээхээр ярилцан тохироод тэндээ хонож байдаг бүх юмаа Козетт охиндоо орхин хөнгөн болсон үүргээ үүрч өглөө нь алс замдаа гарсан Фантинь удахгүй охиноо авахаар эргэж ирнэ гэж боджээ.

Өөдсөн охиноо танихгүй айлд орхихоор түргэн шийдсэн боловч өнчин зүрхэнд нь хагацлын хар зовлон үлджээ.

Тенардьегийн айлын эмэгтэй Фантиньтай гудамжинд дайралдаад буцаж ирэхдээ:

-Охиноо орхисон эмэгтэйгийн уйлж явааг хараад өр өвдөж уушиг зүрх минь амаар гарах шахлаа гэжээ.

-Би одоо зуун арван франкныхаа өрийг төлнө. Надад яг тавин франк дутаад байсан юм гэжээ.

## II

### ОЛИГГҮЙ ХОЁР ХҮНИЙГ ӨНГӨВЧХОН ТОДОРХОЙЛЪЁ

Тенардьегийнхэн ямар чанартай улсууд вэ? Энэ талаар хоёрхон үгийг энд дурдаад хойно бусдыг нэмж бичье.

Тенардьегийнхэн, хүний үнэргүй мөртөө хөсрийн бохир зальтай, хүсэж сурсан эрдэмтэй атлаа хүний адагт шилжсэн бүдүүлэг амьтнаас бүрддэг завсрын ангид ордог. Дунд ба доод анги хоёрын хооронд орсн ангид багтдаг. Тенардьегийнх доод ангийн зарим алдаа болон дунд ангийн бүх олиггүй талыг биедээ шингааж, ажилчин хний сайн чанар ч үгүй, овтой зальтай хөрөнгөтний шинж ч үгүй аж.

Ашигт цаг тохиолдвол аюулт хортон болох төлөвтэй адгийн амьтнууд мөн. Тенардые өөрөө төрөлхийн олиггүй зантай, эхнэр нь адуусны шинж авиртай. Эр эм хоёулаа аль муу муухайг хийж гүйцэтгэхэд дээд зэргийн авьяастай... Урагшаа явахын оронд байнга бүдүүлэг руу ухардаг, амьдралдоо олсон туршлагаа зөвхөн хар санаагаа хөгжүүлэхэд хэрэглэдэг, улам завхар улам доройтдог шинжийг хадгалсан хүмүүст Тенардьегийнхэн байжээ...

Тенардьегийн хэлдгээр бол цэрэгт ахмадын алба хааж байхдаа 1815 оны дайнд оролцон зарим талаар баатар зориг гаргаж явжээ...

Эхнэр нь нөхрөөсөө арван хоёр арван тав дүү юм санж.

Бага залуугаасаа эхлэн хөрөнгөтний үзэл санаа нэвтэрсэн шалиг завхай романууд олныг уншиж сэтгэлээр доройтжээ.

Тенардьегийн их охин Эпонинь, бага охин нь Азельма гэдэг нэртэй байлаа.

## III

### БОЛЖМОР

Олиггүй зам гаргаснаараа хувийн эрх ашгийг бүрэн хангаж чадахгүй юмаа. Тенардьегийн үйл амьдрал өөдлөхгүй байсаар байлаа.

Тенардые Фа-тинаас тавин долоон франкс авсны ачаар тавьсан өрнөөс нэг удаа хагацжээ. Сар болоод тэдэнд бас мөнгө хэрэгтэй болоход Тенардыегийн эхнэр Козетт охины хувцсыг Парис оруулан үнээр нь худалдуулж оронд нь жаран франк авчээ. Жаран франкаа зарж дуусмагцаа Тенардыегийнхэн Козетт охиныг гуйлгачин ирсэн адил үзэж аль муугаар харьцах болсон байна. Козетт өмсөх юмгүй болж Тенардыегийн хүүхдийн урагдаж хуучирсан өмд цамцыг өмсөж, нохойноос арай дээхнүүр муурнаас арай доохнуур тооцогдож хоолны үлдэгдлийг идэх болсон байна. Козетт охин нохой муур хоёртой дандаа хамт ширээн дор орж нэг хар идүүрээс хоол унд идэх болжээ.

Монрейльд очин суурьшсан Фантинь эх сар бүр захиа бичүүлж Тенардыегийн илгээхэд тэднийх дандаа “Козетт туйлын сайн байна” гэж хариулдаг байлаа.

Фантинь эхний хагас жил өнгөрмөгц долоодох сарын хөлсөнд долоон франк явуулаад дараа саруудад нь мөнгөө тогтмол гуйвуулсаар байлаа. Тенардые жилийн эцэс болохоос өмнө шунал нь буцалж:

-Долоохон франк төлөөд өрөө таглаад байна гэж бодоо юу даа Фантинь чинь! Долоон франкаар юу хийх юм бэ? гэж чамлаад арван хоёр франк явуулж байхыг шаардсан захиа бичив.

Козеттын бие сайн “жаргалтай байна” гэсэн Тенардыегийн худал ятгалтад итгэсэн Фантинь арван хоёр франк гуйвуулсаар байв.

Нэг хүнийг хайрлан үзэхдээ нөгөө нэгийг үзэн яддаг заншилтай хүн байдаг. Тенардыегийн авгай өөрийн охидод туйлын хайртай учраас бусдын үрийг үзэн яддаг байв. Эх хүний хайрын сэтгэл элдвийн муухай хэлбэрт ордгийг санахад гуниг төрдөг, алгн чинээ газар эзлэн суудаг Козеттыг харсан Тенардые авгай, тэр хөөрхий өөдөс амьтныг төрсөн хоёр охиныхоо байрыг эзлэн, амьсгалах агаары нь бага болгож байна гэж үздэг байлаа...

Тенардыегийн хоёр охин үргэлж эхийн энхрий хайрлалыг хүлээн жаргаж байхад Козеттын хөдлөх хөдөлгөөн, дуугарах дуу болгон нь хараал зүхэлд ордог байв.

Төрсөн эхийн янаг хайраар хүрээлэгдсэн хоёр жижиг охины хамт байсан нялх хонгор Козетт түмэн янзын хараал зандралыг амсаж суухдаа орчлон хорвоогийн жам ёсны талаар ухаарч мэдсэн зүйл огт байсангүй.

-Эцэг эхийнхээ заншлыг дагагч Эпонинь Азельма хоёр эвий жаахан Козеттыг мэн элдвээр ад үздэг боллоо...

Он жил дараалан өнгөрөхөд орон нутгийн олны дунд “Тенардыегийнхэн яасан сайн улсууд вэ! Хоосон мөртлөө хаягдсан охиныг тэжээгээд байх юм” гэдэг яриа дэлгэрэв.

Фантинь охиноо хаячаад ор сураггүй алга болсон юм гэж бүгд бодох болжээ.

Гэтэл Тенардые, Козеттыг төрсөн эцэг байхгүй учраас эх нь нөхөргүй боловч хүүхэдтэй гэдгээ ил хэлэхээ зовдгийг ашиглан “муу турсага” өсөх тутам идэх нь ихдэж байна, сар болго нарван таван франк төлж байхыг шаардаж, зохих мөнгөө төлөхгүй бол эхэд нь хүргүүлнэ гэж сүрдүүлжээ... Тэхэд Фантинь арван таван франк төлөх болжээ.

Заяасан бие нь өсөх бүр зовлон зүдрэл нэмэгдсээр аж:

Хэт багадаа хоёр охины тоглоом байсан Козетт таван нас дөнгөж хүрээд гэрийн зарц боллоо. Харсан хөндлөнгийн хүн “Таван настай! Хаанаас тав хүрээ гэж!” гэлцэнэ. Козетт тав хүрсэн нь үнэн.

Нийгмийн талхигдалд нэрвэгдэхгүй нас гэж байдаггүй юм шүү!

Хоршоо дэлгүүрээс хоол унд худалдан авах, өрөө тасалгаа гудамш хашааг шүүрдэж цэвэрлэх, аяга сав угаах хүнд хүчир юм зөөлгөх зэрэг ажлуудыг Козеттоор хийлгэх боллоо...

Хэрэв Фантинь өнгөрсөн гурван жилийн дотор Тенардьегийнд ирсэн бол хүүхдээ яасан ч танихгүй сан, Тенардьегийнд тарган цатгалан сэргэлэн цов®о ирсэн Козетт охин эцэж тураад хөнхийн цайжээ.

Үнэн шударга бус ёс Козеттыг уйтгар гунигт оруулж өлсгөлөн гуйланчлал өнгө царайг нь бузарлажээ.

Санаанд багтамгүй гаслан зовлонгоор дүүрсэн ганц том ганган гялгар нүдий нь харахад элэг эмтэрч зүрх шимширнэ.

Түмэн нөхөөс болсон өөдгүй муу дээлтэй, зургаан нас арай хүрээгүй өчүүхэн ядуу охин, хүйтэнд бээрч хөхөрсөн эрэвгэр арван хуруундаа багтахшгүй бүдүүн иштэй том шүүр бариад, өвлийн хүйтэн өглөө, бүлтгэр нүднээсээ нулимс бөмбөрүүлэн гадаа гудамж цэвэрлэж байгааг харахад хайрлах сэтгэлийн халуун нулимс хацрыг дагаад бөнжигнөнө.

Нутгийн хүмүүс түүнийг “Болжмор” гэж нэрлэжээ.

Бор шувуунаас илүүгүй зай эзэлдэг, юм болгоноос урьдаар айж цочдог, тосгон айлуудын дотрос хамгийн түрүүнд үүрийн гэгээтэй уралдан босож гудамжинд гардаг Козеттыг уран хошин үг уртай олон түмэн “Болжмор” гэж нэрлэсэн аж.

Хөөрхий энэ болжмор хэзээ ч гэсэн жиргэн шулганадаггүй байлаа.

## **ТАВДУГААР ДЭВТЭР**

# **ДОРОЙТОЛ**

I

## **ХАР ШИЛНИЙ ҮЙЛДВЭРИЙН ДАВШИЛТЫН ТҮҮХ**

Монфертейль тосгоныхны боддогоор хүүхдээ хаяад явсан эх яасан бол оо? Хаана ямар ажил рийж байгаа болоо?

Жаал охин Козеттоо Тенардьегийнд орхисон эх цааш явсаар тэнгисийн орчмын Монрейль хотод 1818 онд хүрэлцэн иржээ.

Фантинь төрсөн нутгаа орхиж гараад арваад жил өнгөрч, тэнгис орчмын Монрейль нутгийн байдал энэ завсар өөрчлөгдөж, Фантинь нэг өлсгөлөнгөөс ангижирч нөгөө өлсгөлөн зовлонд учирч байх хооронд, төрсөн эх нутаг нь баян чинээлэг болсоор байж.

Монрейль нутагт эрт балар цагаас эхлэн хар хув, хар шилний тухай үйлдвэр ихээхэн хөгжиж ирсэн боловч түүхий эдийн үнэ өндөр учраас үйлдвэрийн үйлдэхүүн ахиц дорой байдаг байж. Үйлдэхүүний ахиц муу болохоор ажилчдын цалин бага байсан байна.

Фантинийг Монрейль нутагтаа буцаж ирэх үеэр “Хар шилний таваарын” үйлдвэрлэлд үзэгдэж сонсогдоогүй өөрчлөлт гарсан байжээ.

1815 оны сүүлчээр нэг үл таних хүн Монрейльд ирж суугаад зохих эдийг бүтээхдээ модны давирхайн оронд шилийг хэрэглэх, тухайлбал гарын бугуйвчийг хийхдээ

давтамал төмөр гохын оронд цутгамал гох хэрэглэх аргыг олжээ. Энэ өчүүхэн өөрчлөлт үйлдвэрт бүтэн хувьсгал гаргажээ.

Энэ өчүүхэн өөрчлөлт нь түүхий эдийн өртгийг маш хямдруулсны улмаас нэгдүгээрт ажилчдын цалинг нэмэгдүүлэх, хоёрдугаарт таваарын үйлдвэрлэлийг сайжруулах, гуравдугаарт үйлдэхүүнийг хямд үнээр худалдах зэрэг бололцоонууд бий болжээ.

Ингэж нэг санаачлага гурван төрлийн үр дүн үзүүлжээ.

Энэ аргыг нээсэн хүн гурван жил болоогүй байхад их баяжиж эргэн тойрныхоо хүмүүсийг баян чинээлэг болгосон явдал тун сайн хэргээ. Нээлт хийсэн хүний намтрыг мэдэх хүн орон нутагт огт байсангүй учир харийн хүн гэж үздэг байж.

Тэр хүн Монреильд ирэхдээ мөнгө төгрөгөөр маш цөөхөн, дээр хаяхад хэдэн зуун франктай байсан гэлцэнэ...

Монрейд ирсэн тэр хүн өөрийн байдал, өмссөн хувцас, үг яриагаараа ажилчин хүнээс огт ялгагдахгүй байж.

Дам ярианаас үзвэл арван хоёрдугаар сарын нэг өдрийн оройн бүрэнхийгээр шуудай үүрч, булдруут таяг тулсан нэг хүн Монреиль хотод орж ирэхийн үеэр нийтийн байшинд гэнэт их түймэр асчээ. Үл таних тэр хүн оволзож байгаа улаан гал руу гялалзсан нүдээ цавчилгүй амь хайрлахгүй дайран орж түймэрт шатах гэж байсан хоёр хүүхдийг аварчээ. Тэр хүн гэнэт зориг гаргаж гавъяа байгуулсан болохоор паспорты нь үзье гэж хэн ч хоргоосонгүй... Тэр цагаас хойш түүнийг Мадлен гуай гэж нэрлэжээ.

## II

### МАДЛЕН

Энэ хүн тавин настай, бодол болсон хашир байдалтай цагаан сэтгэлтэй. Үүнээс өөр зүйлийг хэн ч үл мэднэ. Үйлдвэрт шинэ өөрчлөлт гаргасны улмаас Монреиль хот худалдааны томоохон төв болсон байна...

Мадлен гуай орлого их олдог болж хоёрдахь жилдээ эрэгтэй ба эмэгтэйчүүдийн хоёр салбар бүхий том фабрик байгуулсан байна. Өлсгөлөнд учирсан хүн бүхэн тэнд очвол ажил олж, хэрчим талхтай бардам золгоно...

Мадлен гуайг ирэхээс өмнө тэр нутаг уналтын байдалд байсан бол одоо тэнд хөдөлмөр өрнөж хөгжил эхэлжээ. Газар болгон хөдөлмөр өрнөж хөгжил нэвтрэн өлсгөлөн гуйланч байдал мартагдах болж...

1820 онд Мадлен банкинд зургаан зуун гучин мянган франк хадгалуулсан байна. Энэ зургаан зуун гучин мянган франкийг банкинд хийхийн өмнө хоосон ядуучуудын хэрэгцээнд сая гаруй франк зарцуулсан байна.

Үүнээс гадан Мадлен гуай өөрийнхөө мөнгөөр өвчтөнүүдийг эмчлэнсувилж, эмэгтэйчүүдэд зориулан нэг, эрэгтэйчүүдэд зориулан хоёр сургууль байгуулсан байна. Тэр үеийн франц оронд байгаагүй, хүүхдийг хүмүүжүүлэх газрыг бий болгож, өндөр настан, тахи<sup>о</sup> дутуу ажилчдад зориулан тусламж үзүүлэх газрыг үүсгэн барьжээ. Мадлены фабрик ажилчны төв болмогц орон сууцаар гачигдаж байсан ажилчдад зориулж шинэ орон сууцны газруудыг барьж ажилчдыг оруулахын хамт тэнд эм олгодог аптека нэгийг бас нээжээ...

Шинэ санаачлага гаргасандаа Мадлен гуай ноён Мадлен нэртэй болж. Ноён Мадлен хотын дарга ноён болж хувирсан аж.

### III

#### МАДЛЕНЫ ГАШУУДАЛ

Динь хотын захирагч лам ноён Мириэль наян хоёр хүрээд нас барсан тухай мэдээг сонинууд 1821 оны эхээр зарлажээ... Мириэль нас барахаасаа нэлээд хэдэн жилийн өмнө хоёр нүдгүй болсон авч сохорсондоо ер гутаж гунилгүй дүүгээрээ өргүүлсээр амьдарч байсныг сонинд мөн дурджээ...

Мириэлийн нас нөгцсөн тухай мэдээг Монрейлийн нутгийн сонин хуулан хэвлэсэн байж.

Маргааш өглөө нь Мадлен ноён гашуудлын хав хар хувцас өмсөж явах болсныг харсан олон үгэнд дуртай нэг чинээлэг настай эмэгтэй:

-Саяхан нас бардаг Динийн захирагч лам ноён дарга таны садан төрөл хамаатан гэдэг үнэн үү? Гэж асуусанд Мадлен:

-Миний хамаатан бишээ гэхэд

Садан биш юм бол та юунд гашуудлын хувцас өмссөн юм бэ? гэж эмэгтэй сонирхоход Мадлен:

-Би залуудаа зарц нь явсан хүн гэж хариулжээ...

### IV

#### МӨРДӨЛТИЙН ЭХ

Ноён Мадлентай зөвлхөөр гуч дөчин километрийн цаанаас ардууд ирцгээнэ. Мадлен м ргаан будлианыг тасалж бүтэлгүй явдлыг зогсоон дайснуудыг эвлэрүүлж байлаа. Хүн бүр өөрийн ашиг сонирхлыг өмгөөлүүлэхээр Мадленыг урина. Мадлен ч гэсэн өөрөө хүн болгонд тус болохоос татгалзахгүй явда учраас олны дотор хайр хүндэтгэлийг их олжээ.

Гэтэл Мадлены сайн сайхан санааг хайхардаггүй, хий байгаа ажлы нь мушгин хардаг хүн нэг байж...

Сайхан зантай тайван байдалтай Мадлен олны хайрыг хүлээн гудамжаар нэг бус удаа өнгөрч явахад, гялгар бор хувцастай хүрээг нь буулгасан дэлбэгэр малгайтай, бүдүүн мод барьсан үл таних өндөр хүн гэнэт Мадлены хойноос хараад далд ортол ширтэж байгаад хоёр гараа зөрүүлэн сугавчилж толгойгоо аяархан сэгсэрч уруулаа хамартаа хүргэн “энэ ямар учиртай хүн бэ? Би урьд нь үзсэн хүн шиг байх юм. Юу ч гэсэн би энэ хүнд мэхлүүлэхгүй дээ” гэсэн маягтагаар нүүрээ үрчийлгэнэ.

Үүнийг анх харсан хүний дотор арзас гэж хавьтсандаа халгүй олиггүй ширүүн амьтан байна гэж бодогдмоор. Түүни нэр Жавер. Цагдан сэргийлэх газар алба хаадаг.

Жавер Монрейльд цагдан сэргийлэхийн харгалзагчийн уршигтай мөртлөө ашигт үүргийг гүйцэтгэхээр ирсэн аж.... Мадлен, Жаверыг Монрейльд ирэхээс өмнө том үйлдвэрийн баян эзэн болжээ.

Хэрэв уншигчид бидний адилаар хүн болгон адгуусны ертөнцийн ямаро нэг шинж шингэсэн байдаг юм гэж бодвол цагдан сэргийлэхийн түшмэл Жавер ямар шүү маягийн амьтан болохыг амархан тодорхойлж чадна.

Олон гөлөг гаргасан гичийн нохой гөлөгнүүдийнхээ дотроос бусдыгаа залгих төлөвтэй олиггүй амьтан байвал түргэн устгахыг эрмэлздэгийг Астур тариачин андахгүй.

Бусдыгаа залгидаг тэр шунахай ховдог гөлгийг хүний царайтай болго тэгвэл яаг Жавер болно.

Ханилсан нөхрөө цөллөгөнд явуулсан төлөгч эмэгтэйгээс орон дотор гарсан Жавер, нийгмээс хөндий байгаагаа ухаарч хэзээ нэг цагт дотор нь нэвтрэн орохоор зоригложээ. Нийгэм рүү дарйан довтолог, түүнийг мөн хамгаалдаг хоёр ангийн хүмүүсийг нийгэм хайр гамгүй таягдан хаядгийг Жавер ойлгож тэр хоёр ангийн нэгийг шилж авахаар шийдсэн байна. Үзэл санаа үнэнч шударга ёсны өчүүхэн төдий үүслийг өөртөө шингээсэн Жавер төрүүлж өгсөн төлөгч эх шиг хүмүүсийг хэт үзэн яддаг аж. Жавер цагдан сэргийлэх газар ажилд орж амжилт олоод дөчин насандаа цагдан сэргийлэх газрын харгалзагч байцаагчийн албан тушаалд дэвшжээ...

Жавер сэтгэл хатуу, хар санаанд булагдсан гунигт төлөвтэй, гэмгүй маягтай мөртөө гэдгэр их зантай, эсрэг шураг шиг өрөмдсөн хүйтэн харцатай.

Хардах мөрдөх мушгих ажил Жавзрын амьдралын гол агуулга. Ертөнцийн хамгийн бартаат газраар шув шулуун зам гаргасан Жавер өөрийн үүргийн ашигтайд итгэн түүнийгээ нэн өндрөөр тахиж, тгнуулын ажил хийдэг байв. Жаверын гарт орсон хүн шиг үйл лайтай амьтан үл тохиолдоосой. Жавер цөллөгнөөс оргох гэсэн эцгээ баривчлан хорьж, цагдаагийн хяналтаас зайлах гэсэн эхээ ховлон мэдээлэхээс буцахгүй шинжтэй...

Жавер номыг үзэн яддаг боловч алдаг оног олдог чөлөөт цагаараа шүд зуун уншдаг байсан учир бүр нэг балар харанхуй ч биш байж...

Зан сайтай цагтаа тамхи үнэрлэж суугаа нь хүнтэй адил санж.

Шүүх Яамны жил бүрийн тоо бүртгэлээр “үл бүтэх этгээдийн” эгнээнд ордог хүмүүст Жавер аянга мэт ширүүн байдг. “Үл бүтэх этгээдийн” тоонд орсон хүмүүс ганцхан Жавер гэдэг нэрийг сонсоод зугтан арилдаг, Жаверыг нүдээрээ харвал аргаа алдарч гөлрөн зогсдог ажээ.

Жавер ийм аюут хүн санж.

Номн Мадлены нүд анивчилгүй хардаг хүн, Жавер мөн Жаверын нүд таавар, муу хар санаагаар дүүрэн! Ноён Мадлен яваандаа Жаверын энэ байдлыг мэдсэн боловч онц анхаарсангүй. Мадлен Жавертай нэг ч удаа уулзаж маргаж явсангүй. Жаверын хар санаат муухай харцыг ажиггүй тэсвэрлэж, бусдын адилаар сайн зантай харьцдаг байж.

Гэтэл Жавер, Мадлен ноёны өнгөрсөн явдлыг нууцаар тагнаж байв. Гэсэн ч Мадлены ердийн хэт номхон тайван байдлыг хараад эргэлздэг байж.

Нэг удаа Жаверын аймшигт дүр Мадлены анхаарлыг татжээ. Чухам ямар нөхцөлд татсаныг дурдъя.

## V

### ӨВГӨН ФОШЛЕВАН

Мадлен ноён нэг өглөө Монрейль хотын довонт мухар гудамжаар явж байтал хавьд чимээ гарахыг сонсож харахад улсууд цугларсан үзэгдэв. Тэр зүг явж очвол өвгөн Фошлеван гэдэг нэртэй настай хүн морин тэрэг нь онхолдоход тэргэндээ даруулжээ...

Амьсгаа авч чадахаа байх шахсан өвгөн Фошлеван:

-Настай хүнийг аврах сайн хүн байвал ирж туслаачээ! гэж хашгирна.

Ноён Мадлен цугларсан улс руу харж:

-Юм өргөдөг машин байна уу? гэж асуухад нэг тариачин

-Олж ирэхээр хүн явсан гэв.

-Хичнээн удах болоо?

-Хорин тав зургаан минут болно доо...

-Хорин дөрөв таван минут яаж хүлээдэг юм бэ? гэж Мадлен хэлэхэд:

-Хүлээхээс өөр арга алга! Гэв.

-Тэрэг у«ам доошоо газар суугаад байгааг та нар харахгүй байна уу?

-Харж л байнаа!

-Тэргэн доор хөндий зай байгаа цагт мөлхөн ороод өргөвөл болох байна.

Тэгвэл хагас минутын дотор өвгөнийг аварч болно. Хэн зориг гаргасан хүнд таван алтан Луй өгнө. Хэн мөнгөнд дуртай вэ? гэж Мадлен хэлэхэд нэг нь ч дуугарсангүйд

-Арван луй өгье гэв.

Цугларагсад цөм доошоо харцгаана. Тэдний дотроос нэг нь:

-Учиргүй тэнхээтэй хүн хэрэгтэй. Муухан хүн ууцаа хугална шүү гэв...

-Хорин луй өгье гэж Мадлен хэлэхэд дуу гарах амьтан байсангүй.

-Хүсэлтэй хүн ч байна л даа гэж нэг хүн хэлэхэд Мадлен эргэн харсанд Жавер харгалзагч байжээ.

Жавер үргэлжлүүлэн:ъ

-Хүч дутаад байна. Ингэж онхолдсон тэргийг ууцаараа хөшөөд өндийлгөдөг хүн ер бусын тэнхээтэй байх ёстой гээд Мадленыг ширтэн харснаа:

-Таны хүсээр үүнийг өргөх чадалтай хүн нэг бийг би мэднэ шүү Мадлен гуай гэхэд Мадлен цочив.

Жавер Мадленыг ширтсэн хэвээрээ хайхрамжгүй маягаар:

-Тийм чадалтай хоригдол хүн бий гэхэд

-Тийм үү! Гэж Мадлен хэлэв.

-Тулоны шоронгийн нэг хоригдол тийм хүчтэй хүм юм.

Мадлены царай цайв. Энэ үеэр онхолдсон тэрэг улам газар шигдэн суусаар байлаа.

Өвгөн Фошлеван:

-Бүтэж үхлээ! Хавирга минь шажигаж байна. Өргөж үзээч! Аргалаа чээ таминь!

Гэхэд Мадлен эргэн хараад:

-Энэ өвгөний амийг авраач, хорин алтан луйгээр шагнуулах хүн алга гэж үү?

Гэсэнд нам гүм байв. Жавер:

-Өргөдөг машинтай тэнцэх чадалтай хүн нэг байсныг би амьдралдаа ганц удаа үзсэн юм. Тэр хүн бол дээр дурдсан хоригдол байсан юм гэв.

Мадлен өө°ий нь алдалгүй ширтэж байгаа Жавер, орчин тойронд хөдлөлгүй зогсож байгаа тариачдыг харж гунигтайгаар инээд алдаад үг ч хэлэлгүй сөгдөн сууж гялс гэн тэргэн дор шурган оров.

Мадленыг тэргэн дороос дахин гарч чадахгүй байх гэж бодсон хүмүүс амьсгаа хурааж дуу гаралгүй зогсоно.

Гэтэл хүнд тэрэг оволзон хөдөлж газар ёигдсэн дугуй нь хөндийрөхөд эцсийнхээ хүчийг шавхан тэргийг нуруугаараа өргөж байсан Мадлен чичирсэн хоолойгоор:

-Бушуухан тусалцгаа! Гэв. Мадленыг харж зориг орсон бусад хүмүүс нэг зэрэг ханцуй шамлан ухасхийж тэргийг хамжин өргөж өвгөн Фошлеваны амийг аврав.

Мадлен тэргэн дороос босоход хувцас нь урагдаж цонхийж цайсан нүүрнээс нь хөлс цувна. Амиа авруулсан өвгөн Фошлеван Мадлены өвдгийг үнсэж баяр хүргэж байхад Мадлен өөрий нь үргэлж ширтэн байгаа Жаверыг тайвнаар харна.

## VI

### ФОШЛЕВАН ПАРИС ОРЖ ЦЭЦЭРЛЭГЧ БОЛОВ

Тэрэг онхолдоход Фошлеван өвдөг мултарчээ. Мадлен тэр өвгөнийг өөрийн фабрикийн дэргэд байгуулсан эмнэлэгт аваачиж хэвтүүлэх тушаал өгөв. Маргааш өглөө нь өвгөн нойроос сэрж харахад дэргэд нь мянган франкийн билет, Мадлен өөрийн гараар “таны тэрэг морь хоёры чинь худалдаж авлаа” гэсэн зурвас байжээ. Фошлеван эдгэрсэн боловч өвдөг нь нугарахаа больсон учир сувилагч нар ба нутгийн лам нарын зөвлөснөөр Мадлен нөгөө өвгөнийг Парис хотын Сент-Антуан хороонд байдаг эмэгтэйчүүдийн сүмд цэцэрлэгчийн ажилд оруулжээ...

Олны амьдрал сайжирч орон нутагт юм элбэг дэлбэг болсо нүеэр Фантинь төрсөн нутаг Монрейльдээ ирж эмэгтэйчүүдийн үйлдвэрт орж шинэ ажилтай золгож чадлын хирээр ажил хийж бага зэрэг мөнгө олж амьдрах болсон аж. Авдаг цалин нь хүрэлцээгүй боловч өөрийн биеэр хөдөлмөр хийж байгаадаа гол санаандаа хүрлээ гэж сэтгэл тэнүүн болжээ.

## VII

### НОЁХОН ВИКТЮРНЬЕНИЙ ХОРТ САНАА

Хөлс багатай ч гэсэн хөдөлмөр хийж бие дааж амьдрах болсон Фантинь нэг жижиг өрөө хөлслөн аваад дотор нь дараа авах цалин дээрээсээ үний нь суутган төлөхөөр тохирч, гэрийн хэрэгслийг авч тавьсан аж.

Фантинь нөхөрт хаягдсанаа нуухын тулд нялх жижиг охинтой гэдгээ хүнд мэдэгдэхгүйг аль болохоор хичээнэ.

Ажил хийж эхэлсэн анхны өдөөс эхлэн Фантинь олсон мөнгөө Тенардьегийн рүү гуйвуулж, дагавар захидлаа бичээч хүнээр татлуулж явуулдаг байлаа.

Фантиний захидал бичүүлж явуулаад байхыг ажилчин эмэгтэйчүд мэдээд “Фантинь захиа бичээд учир ургуулдаг боллоо” гэлцэх болж, тэгээд Фантинийг нууцаар ажиглах болж, нөгөө талаар Фантиний мяндсан зөөлөн үс, мяралзан яралзсан шүдийг хараад бас атаархана.

Хайр дураа өгсэн хүнээ дурсах, заяасан хонгор үрээ бодоходоо ч юмуу даа Фантинь гэнэт эргэж мэлмэрэн гарах нулимсаа дуслуулж байхыг улсууд мөн үзжээ.

Фантинь сардаа хоёр удаагаас доошгүй захиа бичүүлж “Монфермейльд байгаа буудлын эзэн эрхэмсэг ноён Тенардьед” гэж хаяглан явуулдгийг сүвэгчлэн мэдсэн үгэнд дуртай өөдгүй ноёхон Виктюрньен Монфермейль хүртэл савсагнан давхиж очоод ирэхдээ: “Би гучин таван франкаа үсрнийхээ үр ашийг үзлээ. Мэдэх гэсэн юмаа ч мэдлээ. Тенардьегийнд гаднын хүний хүүхэд байгааг нүдээрээ харлаа” гэжээ.

Ноёхон Виктюрньен, Фантиний эмэгтэйчүүдийн үйлдвэрийн байцааг байсан аж.

Фантинь үйлдвэрт орж ажил хийсээр жил гаруй болж байтал гэнэт нэг өглөө байцаагч эмэгтэй Викторньен Фантиньтай учирч хотын дарга Мадлены нэрий нөмнөөс тавин франк өгч, Фантинийг ажлаас хөөсөн гэж мэдэгджээ.

Фантинь ажлаас хөөгдөж аргагүй хүнд байдалд орох үеэр зургаан франкийн оронд арван хоёр франк авч байсан Тенардьегийнхэн арван таван франк нэхэх болжээ.

Орон сууц, гэрийн хэрэгслийг урьдаар зээлэн авсан Фантинь өрөө төлөөгүй байж хотоос яахан зайлж чадах аж. Ажлаас хөөгдөх үед авсан тавин франк, тавьсан өрий нь ч таглаж хүрэхгүй байв. Гэтэл Викторньен байцаагч Фантинийг үйлдвэрээс түргэн зайлахыг шаардаж, ажлаас хөөгдөж, авах цалингаа хасагдсан Фантинь аргаа алдарч хүч сулаад ар гэртээ сажлан харина...

Фантинийг ажлаас хөөж аль муугаар тарчлаасныг Мадлен гуай ер мэдээгүй байлаа...

Мадлен гуай гачигдал зовлонд учирсан ажилчдад тусламж үзүүлэн олгож бай гэж гаргасан мөнгөнөөс тавин франк гаргаж Викторньен Фантиньд олгожээ.

Аргаа алдсан Фантинь ажил хайж амь зуухаар айл болгоныг хэсүүчлэн оровч авах амьтсан олдсонгүй. Нутгаа сольж ө өр газар очъё гээд ч чадсангүй. Зээл тавьж гэрийн хэрэгсэл авсан худалдаачинд очиж учраа гаргахад тэр худалдаачин : “өрөө төлөхгүй зугтвал чамайг хулгайлж гэж баривчлан хорих болно”г эжээ. Байрны эзэн эмэгтэй “нас залуу цус шингэн хойно чи өрөө төлж чадна байх” гэжээ.

Фантинь тавин франкаа орон байрны эзэн, гэрийн хэрэгсэл всан худалдаачин хоёрт хувааж өгөөд, зээл авсан хэрэгслээсээ худалдаачинд буцаан өгсөн боловч цаана нь зуу орчим франкийн өртэй үлдэв. Мөнгө хогшлоо өрөнд суутган өгсөн Фантиньд гарц хэрэгэр ор үлджээ.

Фантинь гарнизоны цэргүүдийн хатуу эсгий цамц оёж өдөртөө арван хоёр сү олох авч Тенардьегийнд өдрийн арван сү төлөх ёстой. Энэ үеэс эхлэн Фантинь Тенардьегийнд тогтмол мөнгө явуулж чадахаа байж...

Амьдрал нь ийм хүнд байх үед Фантинь айлынхаа эмэгтэйд: “Хэрэв би шөнөдөө таваас илүүгүй цаг унтаж бусад цагт нь дандаа гунихралд орсон хүн хоол бага иддэг шүү дээ. Нэг талаас өлсгөлөн зовлонд оро нөгөө талаас яах ч аргаа барагдахдаа би цатгалан явах болно доо” гэжээ...

Алгын чинээ охиноо тэжээхээр аль бадаг аъяасаа гаргаж амралтгүй зүтгэх болсон Фантинь бие суларч хуучнаасаа илүүгээр ханиах болж “Миний гар мөн ч халуун байна, та бариад үз дээ” гэж хажуугийнхаа хүнд хэлэх болов.!

Гэсэн ч Фантинь өглөөгүүр туг шигүүн, торго шиг зөөлөн үсээ хугархай самаар самнаж суухдаа санаа нь амарна.

## VIII

### ХОРТ САНААНЫ УРШИГ

Фантинийг өвлийн адаг сарын үед ажлаас халж, зун өнгөрч дахин өвөл болоход түлэх түлшгүй, цадтал идэх хоолгүй, суух тусгай орон сууцгүй амь наана там цаана болж цухалдаж байтал авлагат хүмүүс Фантинаас өрөө нөхөж өөд нар харуулсангүй. Өглөөнөөс орой шөнө болтол зүтгэвч олсон нь тун цөөн. Тавьсан өр улам нэмэгдсээр. Тенардьегийн шунал хурцдаж ихийг авахыг эрмэлзэхдээ, өвлийн хүйтнээр өчүүхэн охин Козетт нүцгэн явах шахаж байгаа учир дулаан ноосон хувцас

авах мөнгө нэмж явуул гэж шаардана. Ийм үгтэй захидал авсан Фантинь түүнийг гараасаа бүтэн өдөр салгалгүй бодолд дарагдан зогсоод орой бүрэнхийгээр үс тайрдаг газар очиж үсээ даруулсан саама авсанд, туг ширүүн мяндсан зөөлөн үс нь задран бүсэлдгий нь бүрхэн багсалзана.

-Яасан ч сайхан үс вэ дээ! гэж үс тайрагч хэллээ.

Фантинь:

-Миний үсийг ямар үнээр авах вэ? гэхэд

-Арван франкаар авъя гСэнд Фантинь

-Тайрч аваа гэв.

Үсээ худалдаж олсон мөнгөөрөө дулаан ноосон өмд авч Тенардьегийнд илгээв. Хөөрхий эхийн явуулсан дулаан хувцсыг Тенардые хүлээн аваад өөрийн охин Эпотиньд өмсгөжээ. Ядуу болжмор хүйтэнд дагжсан хэвээрээ.

Фантинь: “Миний өөдөс охин одоо дулаан хувцастай босон. Би охиноо толгойтой үсээрээ хувцаслаасан” гэж боджээ. Хяргуулсан толгойгоо нууж тоорцог өмсөж явах болов.

Орхисон ганц үрээ гэсээр олсноо дуусаад, үсээ худалдсан Фантинь орчин тойрноо үзэн ядах боллоо. Өөрт нь учирсан хамаг зовлон үйлдвэрийн эзнээс болсон гэж бодоход Мадленыг занан зүхнэ...

Фантинь яагаад ч дууссан хамаагүй хэрэг гэж шийдээд анхны тохиолдсон нэг хүнтэй сууж... Тэр хүн нь тэнүүлч хөгжимчин, адгийн муу амьтан учир Фантинийг аль муугаар доромжлон занчсанаас болж удсан ч үгүй салан оджээ...

Фантиньд туссан ханиад улам хүндэрч үе үе хүйтэн хөлс цувах боллоо.

Гэтэл Тенардые дор дурдсан захидлыг Фантиньд илгээсэн нь: “Миний нутгаар дэлгэрсэн халдварт өвчнөө° Козетт өвдлөө. Тэр өвчнийг хижгийн халуун гэдэг гэнэ. Үнэтэй эм хэрэгтэй боллоо. Байдаг мөнгөөр эм авсаар дууслаа. Долоон хоногийн дотор дөчин франк олж явуулахгүй бол охин чинь үхлээ” гэжээ.

Фантинь тачигнатал инээж хажуугийнхээ эмгэнд:

“Галзуурсан хогнууд дөчин франк гэнэ ээ! Хоёр Наполеон дөчин франктай тэнцдэг билүү! Би хаанаас түүнийг олох юм бэ? Тэнэг тариачдыг яая даа” гэжээ.

Фантинь байрнаасаа гадагш гарч нөгөө захидлыг дахин уншаад учир тоймгүй инээж гудамжаар гүйж яваад ер бусын нэг тэрэг тойрсон олон хүнийг үзэв. Тэргэн дээр улаан дээлтэй илбэч алиалагч хүн зогсож хиймэл эрүү шүд, янз бүрийн эм худалдаж байв.

Фантинь мөн олны дотор орж нийтийн адилаар инээн хөхөрч байтал алиалаг хүн түүнийг хараад “Чи яасан сайхан шүдтэй юм бэ? Чи үүдэн хоёр шүдээ над худалд! Би чамд шүд бүрийн өртөгт нэг наполеон өгье” гэхэд ард байсан эмгэн хүн:

-Хоёр наполеон олдоно гэдэг мөн ч хувьтай хүн ээ! гэжээ.

Фантинь хоёр чихээ таглаад гүйж явтал хойноос нь:

-Хоёр наполеон гудамжинд хэвтэж байдаггүй юм шүү. Чи сайн бодож үз. Тохирье гэж шийдвэл орой “Мөнгөн талбай” буудалд очоорой. Би тэнд байж байна гэжээ.

Хоёр шүдээ худалд гэснийг бодохоос Фантинь их уурлаж:

“Намайг хэт доромжиллоо. Би хэдий ядуу ч гэсэн шүдээ худалдахдаа хүрээгүй” гэх мэтээр цуг байсан эмгэндээ хэлэв.

Эмгэн:

-Шүдний чинь оронд ямар үнэ өгнө гэв дээ! гэхэд

-Хоёр наполеон гэв!

-Хоёр наполеон чинь дөчин франктай тэнцэнэ шүү.

-Тиймээ дөчин франктэй тэнцэнэ гэж Фантинь хэлээд... Эмгэнээс:

-Та хижгийн халуун гэдэг өвчин мэдэх үү? Гэв.

-Мэднэ, Горигүй өвчин дөө.

-Эм их хэрэгтэй юү?

-Тоймгү их хэрэгтэй.

-Чухам ямар эрхтэн өвддөг юм бэ?

-Бүх бие тэр хэвээрээ өвдөнө.

-Хүхэд өвдөх үү?

-Өвдөөд үхэх гэж байх уу?

-Зөндөө үхдэг...

Тэр оройгоо Фантинь гэрээсээ гарч “мөнгөн талбай” буудалд очиж үүдэн хоёр шүдээ булга татуулж худалдаад дөчин франк олж, Фантинь үүдэн хоёр үдээрээ олсон дөчин франкаа Тенардьегийн рүү явуулжээ.

Гэтэл Тенардьегийнх зөвхөн мөнгө авахын тулд хэлсэн байв. Энэ үед Козетт охин өвдөөгүй эрүүл гүйж явжээ...

Фантинаас авлагатай хүмүүс өрөө нэхэж гудам, шатаар ер явуулахаа болиход Фантинь бүтэн өдөр бодон бодон нүдээ шуу гүйтэл уйлна. Фантиний хоёр нүд улам гялалзаж, зүүн талын дал доогуур нь улам өвдөх болж хүчтэй ханиалгах явдал ихэснэ. Фантинь, Мадлен гуайг үзэн ядах ав зовлонгоо хэнд ч хэлдэггүй байж. Хоногт арван долоон цаг тасралтгүй юм оёж, байдаг хүчээ шавхана...

Нийгмийн хатуу амьдралаас хордсон Фантинь хүн дүрээ алдаж зэрлэг араатны шинжтэй болсоор...

Фантиний амьдрал улам хүндэрсээр байхад Тенардьегийнх захидал ирүүлж дахин зуун франк олж явуулахыг шаарджээ.

Эцэг эхийн заяасан эгэл биеийн хүчийг барсан Фантинь арав таван мөнгө олохын тулд ачит биеэ янхан болгож хувиргав.

Фантиний түүх юуны түүх вэ? Фантиний түүх бол боолыг худалдан авч байгаа нийгмийн түүхээ.

Өлсгөлөн гуйланчлалд учирч ядран ганцаардаж хаягдсан хүмүүс боол болдог. Арга ядарч, алгын чинээ талхнаас ариун сэтгэлээ худалддаг хүмүүсийг нийгэм боол болгон дарладаг...

Европын соёлт орнууд боолчлолыг устгасан гэдэг худлаа. Нийтийн анхаарлыг төөрөлдүүлэхийн тулд цуурхал тарааж байна. Боол-лол хэвээр байна. Боолчлолын хүнд гинж эмэгтэй хүн дээр тохогож байна. Тэр хатуу догшин нэр нь янхан мөн...

Нийгмийн байгууламж, түүний дотор буй амьдралыг, Фантинь нүдээрээ харж зүрхээрээ амсжээ...

Гэсэн ч үүгээр хүний амьдрал төгсөж, амсах зовлон эцэс боллоо гэвэл эндэгдэл болох биз ээ!

## IX

### НОЁН БА МАТАБУАГИЙН ЗУГААЦАЛ

Боловсон газар бүдүүлэгт ордог, хоцрогдсон хөгжилгүй газар боловсонд ордог, хэлдэг нь алдар нэр, гавъяа шагнал, баян хөрөнгө, хийдэг нь цэнгэл завхайрал болсон, ухаанд нь ухна шингэжг учирсан биед нь зовлон шингэсэн олиггүй харчуул Монфермейль мэтийн хүйтэн хотуудад олон тохиолддог. Тэд театрт ороод урлаг

ойлгодог хүн болох гэж исгэрдэг, баатар зоригтон болох гэж цэргийн дарга нарыг өддөг, дэлүү болтлоо архидаж, батга болтлоо тамхи татан Парист байхдаа Лондон үзсэн болдог, Лондонд очвол Парис маяг үзүүлэх гэж оролдсоор явж өтлөх насанада хэнд ч хэрэггүй болдог... Тиймэрхүү хүмүүсийн нэгэнд ордог ноён Баматабуа 1823 оны нэгдүгээр сарын эхний нэгэн өдөр нялх цастай гудамжинд гар цэргийн дарга нарын хоолны газрын хажуугаар бүжгийн зуны хувцас өмсөж толгойгоо цэцгээр чимээд урагш хойш холхож яваа хөөрхий эмэгтэйг өдөж: “Үүдэн шүдээ үм татуулсан өлөгчи чи, өөд уруугаа гүйгээд яах ч билээ дээ. Угаадсы нь өтгөсгөж, уяагий нь уртасгавал гар өх эм юм” гэх мэтээр хор малтаж хосгүй муугаар доромжлоход эмэгтэй хүн шүд зуун тэвчиж огт дуулаагүй мэт дүр үзүүлэн сүлжинэ. Хэлсэн үгий нь тоохгүй болохоор ноён Баматабуа эмэгтэйн хойноос гэтэж яваад газраас бөөн цас авч хоёр нүцгэн далын хоорондуур хийсэнд тэр эмэгтэй дуу алдан чарлаж амандаа орсноор хара ж ноёныг барин авч чадлын хирээр чимхлэн үгтээв.

Энэ байдлыг үзсэн улсууд цугларан тойроход үүдэн шүдгүй эмэгтэй© Баматабуаг ноцож харагдана. Тэр эмэгтэй Фантинь байлаа.

Олны дундаас өндөр хүн ялгаран гарч эмэгтэйгийн захаас чангааж “миний хойноос яв!” гэхэд эмэгтэй тэргүүнээ дээш өргөж харвал Жавер цагдаа байжээ.

Энэ үймээний үеэр Баматабуа зугтан далд оров. Жавер, Фантинийг дагуулж аваачаад үзсэн бүхнээ бүртгэн бичиж дуусаад хүн доромжилсон хэрэгт зургаан сараар шоронд хорихоор ял ноогдуулжээ.

Жавер ял ноогдуулж байхад нэг хүн гаднаас ороод мэдэгдэлгүй хаалга хаагаад зогсож байтлаа “зургаан сар ял тулгав” гэхийг сонсож:

-Байцаагч ноён Жавер аа! Та энэ эмэгтэйг суллан тавь! Гэв.

Энэ үгийг сонссон Фантинь, Мадленд үл итгэн Жавер лүү хандаж учирсан зовлонгоо тоочихдоо Фантинийг ажлаас халж аюулт замд оруулсан хүн Мадлен юм гэж дурдахыг Мадлен сонсож учрыг ойлгож:

-Би таны хэлснийг сонслоо. Би юү ч мэдээгүй явсан юм. Таныг манайд ажилд орсныг ч би мэдээгүй. Тэндээс хөөгдсөнийг ч мэдээгүй явлаа. Та надтай уулзаж ярихгүй яасан юм бэ? Би таны өрийг төлье. Жаал охины чинь хаа байгаа газраас нь олж авч ирье. Та өөрөө охин дээрээ очъё гэвэл бас тусалъя. Та ямар, ажил хийлгүй амьдран сууж болно. Хичнээн мөнгө хэрэгтэй гэнэ вэ, түүнийг танд өгч байя гэв.

Охинтой нь уулзуулж өгье. Хэрэгтэй бүхнээр ханг я гасан баярт сайхан үгийг сонссон Фантинь баярлахда ухаан алдан унав.

## **ЗУРГАДУГААР ДЭВТЭР**

### **ЖАВЕР**

I

#### **АМРАЛТЫН ЭХ**

Фантинийг Мадлены хэлснээр Мадлены гэрт байгуулсан эмчилгээний газарт авч ирэв... Фантинь бараг бүтэн шөнөдөө солиорч дэмий донгосож хоноод үүрээр нам унтав.

Маргааш нь үдийн үед Фантинь сэрэхэд хөшигний цаана хүн байх шиг болохоор хөшгөө онгойлгож харвал Мадлен сууж байхыг үзээд:

-Та юу хийж суугаа юм бэ? гэж асуув.

-Таны бие ямар байна вэ? гэхэд эмэгтэй:

-Зүгээр, би бага зэрэг унтсан. Бие гайгүй болж байх шиг байна. Удахгүй зүгээр болох байхаа гэв...

Энэ үеэр Жавер буруугаа хүлээж ажлаас чөлөөлж өхийг гуйсан захидал "Цагдан сэргийлэхийн нарийн бичгийн дарга ноён Шабульед" гэж хаяглан Парис хот рүү явуулав.

Мадлен, Тенардьегийнд захиа бичиж Фантиний төлөх зуун хорин франкийн оронд гурван зуун франк гуйвуулжээ. Энэ гурван зуун франкаас зохих өрөө суутгаад үлдэх мөнгөөр нь Козетт охиныг түргэн авчирч өвчтэй эхтэй нь уулзуул гэж Тенардьегийнд мэдэгджээ.

Тенардые тэр мөнгийг хүлээн аваад Эпонин, Азельма хоёртоо эм авч байсан баримтыг засаж Козеттод эм худалдан авч байсан баримт болгон өөрчилж "өрөндөө гурван зуун франк авлаа" гэсэн хуурмаг тооцоо гарган ирүүлэхэд, Козеттыг явуулахаа болихоор шийджээ.

Мадлен хариуд дахин гурван зуун франк нэмэн явуулж "Козеттыг түргэн авч ирж өгөөч" гэж хүсжээ.

Хариуд нь Тенардые:

-Козеттыг бид явуулахгүй гэж хэлжээ.

Энэ үеэр Фантиний бие сайжирлыг олоогүй хэвээрээ...

Мадлен өдөрт хоёр удаа эргэн орж ирэхэд Фантинь,

-Козеттойгоо удахгүй уулзах хувь заяа Үайна уу? гэхэд Мадлен

-Удахгүй иүлзана... Козеттын хойноос би хүн явуулъя. Болохгүй бол өөрөө ч яваад ирье дээ гэж.

Фантиниы хэлснээр:

"Ноён Тенардые та энэ захирдлыг хүргэж очсон хүнд Козеттыг өгөөд явуулаарай. Аар саар зардал мөнгийг төлөх болно. Ёсолсон Фантинь" гэсэн үгтэй захидал бичиж авчээ.

## II

### ЖАН ГЭДЭГ НЭР ШАН БОЛОХЫН УЧИР

Нэг өглөө Мадлен ноён ажлаа хийж суутал Жавер орж иржээ.

Юм бичиж суусан Мадлен үзгээ тавиад:

-За Жавер ямар хэргээр ирээ вэ? гэсэнд Жавер:

-Би буруу хэрэг хийсэн байна. Намайг ажлаас хөөж өгөөч гэжээ.

Ажлаас хөөгдөх болсны учрыг лавлан асуувал, Жавер:

-Манай тойрогт Шанматье гэдэг өвгөн байсан гэнэ. Энэ намар саяхан өвгөн Шанматье цэцэрлэгийн хашааны хаалгаар орж дотроос нь алим хулгайлж байгаад баригджээ. Нутгийн шоронд хорьж хэрэг таслах гэтэл шорон засварт орж Шанматьег Аррас аймгийн шоронд аваачиж хийж, гэтэл Аррасын шоронд хоригдол Брэвэ гэгч Шанматьег үзмэгцээ:

-Хүүш! Би энэ хүнийг таних юм байна. Хашир хандгайг хараач хөө! Чи чинь Жан Вальжан байна гэсэнд өвгөн:

-Юу? яасан Жан Вальжан! Гэж гайхжээ. Брэвэ:

-Одоо л хойгуураа тавих нь! Битгий баширла. Чи Жан Вальжан мөн! Хорин жилийн өмнө чи Тулоны шоронд надтай хамт байсан гэж гэнэ шүү...

Лавлан үзсэн Вальжаны нэр нь Жан гэдэг, эх нь хүнтэй суух хүртлээ Матье гэдэг байж. Шоронгоос гараад хуучин хэргээ нуухын тулд Жан Матье гэж нэршиж явсныг хөдөө нутгийн хүмүүс хазгай дуудаж Шан Матье болгосон нь лавтай... Үүний учрыг бүрэн сайн тодруулахын тулд Тулоны шоронгийн данс бичиг шүүрдсэн гэнэ. Брэвэгээс ондоо, насаараа шоронд суух Кошпайль, Шенильде гэдэг хоёр хоригдол Жан Вальжаныг таних юм гэнэ. Тэр хоёр хоригдлыг Тулоноос Аррасад ав ирж Жаны хэрэг таслахад гэрчээр суулгах гэнэ. Тэр хулгайн хэргээр баригдсан хүн Жан Вальжан мөн болох нь. Маргааш тэр Жан Вальжаны хэрэг таслах гэнэ. Би тэнд очно.

Учир иймд би таныг буруу таньж хардаж явсан байна. Тэхлээр та намайг өршөөнө үү гэж Жавер Мадлены өмнө буруугаа хүлээжээ.

## ДОЛДУГААР ДЭВТЭР

### ШАН МАТЬЕГИЙН ХЭРЭГ

Мадлен Жавертай уулзсаныхаа дараа үдийн үед Фантиньтай очиж уулзад гадуур явж алс явах унаа хөлслөн авч маргааш өглөө нь таван цагт бэлэн байхыг шаарджээ.

Маргааш нь Мадлен эрт гарав. Саадуудтай тохиолдон туулсаар явж зорьсон газартаа хүрч буцахад чухал бэлтгэлээ хийгээд хэрэг тасалж байга шүүхийн цуглааны газар очив...

Мадлен гэнэт хаалга онгойлгож ороод тэр хаалгаа мөн хаж орчныгоо ажин ширтэв...

Хэрэг таслахыг харахаар цугласан улсуудын нэг нь ч гаднаас хүн орж ирэхийг үзсэнгүй. Тэдний хараа харгис хоёр цагдаагийн хооронд модон сандал дээр сууж байгаа хүнийг ширтжээ.

Хэрэгтний ширээнд суусан хүнийг харсан Мадлен айн цочиж: “Бурхан минь, би ахиад энэ хүн шиг болох юм гэж үү?” гэж бодов.

Хэрэгтэнд тулгасан ялын төлөвлөгөөнд “Энэ этгээд зөвхөн хэдэн алим хулгайлаад зогссон хулгайч биш ээ. Хичнээн хэлэвч засрал авдаггүй аюулт энэ хэрэгтэн хоригдол байгаад цагдаагийн хүналт хараанаас оргон зугтсан хүн юм. Хэрэгтний нэр нь Жан Вальжан гэдэг. Жан Ва«ьжаныг шүүхийн газар хайсаар ирж. Жан Вальжан үүнээс найман жилийн өмнө замаар явсан жаал хүү Жервег тонон дээрэмдсэн байна. Энэ хэргийг тусгайд нь авч шийтгэх болно. Жан Вальжан саяхан шинээр дахин хулгай хийсэн байна” гэж дурджээ.

Дурдсан ялыг сонссон, гэрч нарын санал гэрчилгээг үзсэн хэрэгтэн гайхсан байдалтай боловч бүх биеэрээ “би хэрэг хийгээгүй. Тулгаж байгаа ялыг хүлээхгүй” гэсэн дохио үзүүлнэ...

Шүүхийн хурлын дарга:

-Хэрэгтэн танд хэргээ үгүйсгэж батлах баримт байна уу? гэж ялтнаас асуухад ялтан:

-Би Парис хотод ноён Балугийнд тэрэгний дархан байсан. Тэрэг засах ажил хүнд боловч дандаа гадаа хашаан дотор агаарт байх ашигтай. Сайн буянт эзэн дайралдвал хааяа нэг өдрийн од шиг байшин дотор ажил хийдэг. Өвлийн хүйтэнд гар

хөлдөх шахаад хоёр гараа үрж байхыг эзэд харвал цаг алдаж ажил хийхгүй байна гэж зандаг. Ажил нүсэр хүнд учраас хүн яагаа ч үгүй залуудаа хөгширдөг. Дөч хүрвэл дээд заяа. Би тавин гурван настай, ажил хийхэд тун их ядрах юм. Парис хотынхон яхир хатуу: “зөнөг өвгөний ажил хийж байгаа царайг” гэх мэтээр хараадаг. Би чадлынхаа хирээржил хийсэн боловч настай хүн гэж миний хөлсийг хасдаг. Надад нэг охин бий. Тэр минь юм угаалганы газар ажилладаг. Өглөөнөөс аваад орой болтол бүсэлдэгтэ тулсан хиртэй усанд зогсож элдвийн бохир хирт уур амьсгалж, гараа шалбартал юм угаагаад, сөгдөж унатлаа ядардаг байсан. Амьдрахад мэт хүнд байсан учраас охин минь нас барсан. Бид жаргал эдэлсэнгүй... Би ноён Балугийнд зарцлагдаж явсан. Та нар яваад Балугаас лавлаж асуу гэхэд цугларагсад цөм инээд алдахад хэрэгтэн учры нь ололгүй олныг дагаж өөртөө бас инээлээ...

Ялтан гэнэт суудлаасаа босон харайж:

-Прокурор та ёдрын олиггүй хүн! Та муу хүн. Би анхандаа учраа Өлохгүй ээдрээд байсан юм. Би юу ч хулгайлаагүй. Би хүнтэй адил өдөр бүр хоол идж явдаг чадвартай хүн биш. Аадар ширүүн бороо орсны дараа би ус шавхай болсон замаар буцаж явахдаа үзүүртээ алимтай хугархай мөчир зам дээр хэвтэж байсныг олж авсан. Хэрэгт орохоо мэдсэн бол би түүнийг тоож авахгүй байсан. Би шоронд орсоор гуран сар боллоо. Намайг дандаа шүүхийн газраар чирсээр байна. Би бичиг үсэггүй ядуу хоосон санаснаа хэлж чаддаггүй хүн. Би хулгай хийгэггүй. Газар хэвтсэн мөчир авсан. Намайг “Жан Вальжан, Жан Матье” гэх юм. Би эд нарыг хүн болсоор үзээгүй, мэдэх ч үгүй. Тэд бодвол тариачид байлгүй. Би өөрөө Балугийнд ажил хийж байсан. Миний нэр Жан Матье. Би төрсөн газраа ч мэдхгүй. Хүн болгонд эхээс төрөх газар байдаггүй шүү дээ. Миний эцэг эх хоёр лав тэнэмэл улсууд байсан байх. Би лавтй сайн мэдэхгүй шүү. Намайг багад минь “Жаалаа” гэдэг байсан бол одоо “Өвгөн” гэх болсон. Би ийм л нэртэй хүн. Та нар үнэмшвэл үнэмш, үгүй бол битгий үнэмш! Би Оверни, Фавероль зэрэг газарт нутаглаж явсан... Би хулгай хийж яваагүй. Худлаа гэвэл ноён Балугаас асуугаарай гэв.

Ялтан хэргээ хүлээхүй үг хэлсэнд гэрч нарыг дуудан ирүүлж нүүэлдүүлэх болов. Гэтэл Жавер цагдаа мэдүүлгээ өгөөд ар талдаа ажилтай учир явчсан байлаа. Үлдсэн хоёр гэрч нарыг дуудан ирүүлэв.

Гэрч Брэвэ:

-Би энэ хүнийг танина. Үнэ хүн Жан Вальжан мөн. Жан Вальжан мянга долоон зуун ерэн гурван онд Тулоны шоронд ороод, тэндээс мянга найман зуун арван таван онд суллагдсан юм. Би нэг жилийн дараа тавигдсан. Би энэ хүнийг сайн таньж байна. Надад эргэлзэх зүйл алга гэв.

Шенильдьегээс асуухад:

-Энэ хүн Жан Вальжан мөн. Бид хоёр таван жил хамт нэг гинжтэй байсан, нүүрээ буруулчихаад чи яах гэсэн юм бэ? гэжээ.

Кошпайлийг оруулж ирэхэд:

-Жан Вальжан мөн байна. Бид үүнийг хүч ихтэй болохоор дэнжүүр гэдэг байсан юм гэв.

Яг энэ үеэр даргын хажууд хүн хөдлөх шиг болж:

-Брэвэ, Шенильдье, Кошпайль нараа! Намайг хар та нар гэв! Бүгд тэр зүг харж:

-Ноён Мадлен дуугарлаа гэлцэв...

Ноён Мадлен гэрч Кошпайль, Брэвэ, Шенильдье нарын дэргэд ойртон:

-Та нар намайг танихгүй байна уу? гэхэд тэд гурвуулаа мэл гайхаж толгой сэгсэрнэ. Ноён Мадлен шүүгч өмгөөлөгч нарын зүг эргэж:

-Яллуулж байгаа хүнийг чөлөөлөх тушаал өгч намайг баривчил. Та нарын эрж байгаа хүн энэ биш, би байна. Би Жан Вальжан гэдэг байна... Та нар хүнд алдаа хийхээ шахлаа. Энэ хүнийг чөлөөлөө. Би үүргээ биелүүлж заяагүй хоригдол болов. Энд юу болж байгааг би ганцаараа сайн мэдэж байна. Намайг барьж хорь... Би нэрээ сольж өөр нэртэй болж баяжин хотын даргад өргөмжлөгдсөн. Үнэнч хүмүүсийн тоонд орох гээд чадсангүй. Би өөрийнхөө амьдралын түүхийг яривал их цаг хэрэгтэй. Би Динь хотын захирагч Мириэлийг тоносон үнэн, жаал хүү Жервег би бас дээрэдсэн. Жерве хүүгийн мөнгө одоо миний гэрт зуухан дээр байгаа. Над өөр хэлэх юм алга. Намайг шоронд хий та нар. Би ар талдаа ажил ихтэй. Одоо явлаа. Миний байгаа газрыг та мэднэ. Дуртай цагтаа барьж шоронд хориорой гээд Мадлен нэртэй байсан Жан Вальжан гарч одов.

Нэг цагийн дараа шүүгчид Шанматьег суллахад Шанматье учраа ололгүй мансуурсаар эрх чөлөөтэй золгов.

## **НАЙМДУГААР ДЭВТЭР**

# **АРААРАА ТАВЬСАН НЬ**

I

## **МАДЛЕН ҮСЭЭ ТОЛИНД ХАРАВ**

Фантинь шөнөдөө халууран дэмийрч байгаад үүрээр унтав... Энэ үеэр чимээгүй сэм оргож ирсэн Мадлен сувилагчаас:

-Ядуу эмэгтэйн бие ямар байна вэ? гэж асуусанд,

-Зүгээр... гээд ноён Мадлен таныг байхгүй хойгуур нь бид таныг Козеттыг авч ирэхээр явсан гэж эхэд нь хэлсэн. Одоо та хүүхдий нь авч ирээгүй ганцаараа орвол бид юу гэж хэлэх билээ? гэв.

-Бурхан мэднэ бизээ.

Үүр гэгээрэн цайхад ноён Мадлен нүүр харагдав. Сувилагч Мадлены нүүрийг харснаа:

-Бурхан минь! Та ямар зовлонд учраа вэ? Үс чинь бүгдээрээ цав цагаан болсон байна гээд эмнэлгийн жижиг толь гаргаж Мадленд өгсөнд үсээ толинд хараад:

-Бүгд цайсан байна! гэв.

Мадлен аяархан хаалга онгойлгож Фантиний өрөөнд ороод цонхны хөшиг нээхэд Фантинь унтсаар...

Фантиний амьсгаа нь цаазаар авахуулах ял заагдсан үрээ тэвэрч унтаж ядан мигшиж байгаа эхийн цээж адил хэржигнэн сонсдоно. Одоохон дэвж хөөрөн нисэх гэж байгаа үл үзэгдэх далавч мэт түүний бие нь дэржигнэн чичирнэ...

Цэцгээ зулгаалгасан иш өөрийн эрхгүй ганхан хөдлөх адил үхлийн өгөр гарт амь голоо атгуулсан хүн чичигнэн салганана.

Мадлен орны толгой дээр зогсож байтал Фа-тинь нүдээд нээж хараад тайван баясгалант дуугаар:

-Козетт хаа байна? гэж асуув.

## ФАНТИНИЙН СЭТГЭЛ ТАЙВШРАВ

Огт хөдлөлгүй тайван хэвтээ Фантинь:

-Би таныг тэнд очсон гэж мэдсэн. Би нойрондоо таныг эртнээс хойш үзсэн, хийж байгаагүй чинь бас ажиж байлаа. Козетт хаа байна вэ? Юунд миний өвөрт оруулахгүй байна аа? Би сэрэхтэйгээ хамт охиноо үзэх сэн гэхэд Мадлен хариулах үгээ олж ядан байна.

Аз болоход энэ үеэр доктор орж ирээд:

-Эвийн Фантинь минь элдвийг бүү бодож санаагаа зовоо. Хүүхэд чинь энд байна гэхэд Фантиний нүд гялалзан нүүр сэргээд:

-Охины минь аваад ирээч дээ! гэв.

Эмч хариуд нь:

-Өвчтэй байхад чинь хүүхэд үзүүлбэл бие улам муудах болно. Бие сайжирсан цагтаа үзэж болно гэхэд Фантинь:

-Би эрүүл байна. Эрүүлээ! Энэ доктор яасан юмны учир мэддэггүй хүн бэ! Би хүүхдээ үзвэл өөр юу ч хэрэг алга гэхэд эмч:

-Та яагаа ч үгүй байхад биеэ зовоож байна. Таны бие олигтой сайжраагүй цагт би хүүхэдтэй чинь уулзуулахгүй. Хүүхдээ зөвхөн үзээд яах юм бэ! Хүүхдийнхээ төлөө амьд явах хэрэгтэй. Бие чинь сайжирсан цагт би хүүхдий чинь авч ирнэ гэв.

Ядуу эхийн урам хугарч:

-Өршөөгөөрэй доктор минь, өршөөгөөрэй. Би хэт нүсэр хүнд зовлонд автагдаагүй сэн бол юунд ийм юм хэлэх вэ дээ. Та намайг тайван байлгахыг оролдож байгааг би мэдэж байна. Би хичнээн ч хүлээсэн чадна. Гэсэн ч надад охины минь харуулахад гарз гарах юу байх вэ дээ. Миний охин ээжийнхээ нүдэнд өчигдрөөс хойш харагдаад байна. Үзүүлсэн үзүүлээгүй би охиноо харсаар байна. Надад охины минь авч ирээд өгчвөл бид хоёр аяархнаар ярилцах сан. Монфермейль рүү хэрэг болгож хүн явж авч ирсэн охиноо би үзье гэлгүй яах вэ дээ! Би удахгүй сэтгэл тайван жаргалтай болно... Миний бие эрүүл болсон шүү. Надад халуун ч алга. Намайг бүрэн тайван болох дээр та нар: “За одоо охины нь авч ирж өгье” гэлцэх байгаа биз дээ элцээд Мадленаас мянга түмэн асуулт тавьж эхлэв:

-Та замдаа сай явж ирэв үү? Та яваад охины минь олоод ирдэг мөн ч сайн хү юмаа. Тусы чинь үхтлээ би мартаггүй. Козеттын бие сайн байж уу? Замдаа тэр минь ядрав уу? Ээжээ танихаа больсон байхаа. Өөдөс юм чинь юугаа ч ойлгох вэ дээ. Хүүхдийн ухаан санаа бор шувууныхтай адил. Өнөөдөр үзсэнээ маргааш өөр юм хармагцаа мартдаг. Козеттын хувцас цэвэрж байж ууе Тенардьегийх аль хир асарч тэтгэж хооллож байсан байна вэ? Ийм асуудлыг би гачигдал зовлонто өдрүүдэд бодоод хичнээн зовдог байсныг хэлэхийн арга алга! Одоо зовлон өнгөрч би жаргалтай золголоо. Би охиноо нүдээрээ харах сан, яая даа! Миний охин аль хир хөөрхөн амьтан байна вэ дээ? Яасан хөөрхөн амьтан вэ гэлцдэг үнэн байх аа? Замдаа даарч хөрсөн бол уу даа муу охин минь? Ганцхан минут би охиноо харж болохгүй юм уу? Дөнгөж харуулаад цааш нь буцаагаад явж болохгүй юу? Та эндхийн эзэн шүү дээ. Тусалж байна шүү дээ. Гэтэл Мадлен Фантиний гарыг атгаж:

-Козетт шиг хөөрхөн охин алга. Бие нь эрүүл энх байна. Удахгүй та хоёр уулзана, бүү зо. Та хэт хурдан ярьж, гараа байн байн гадагш гаргаж салхи цохиулаад ханиалгаж байна гэв.

Эмч гарсны дараа Фантинь гэнэт:

-Хөөрхий миний охины дуугарч байгааг! Мөн байна гээд битгий дуугар гэж гараараа дохиод амьсгаа хураан чагнаж эхлэв.

Энэ үеэр гадаа хашаан дотор охин инээд алдаж тоглон наадаж, дуулан цэнгэж байлаа.

Танихгүй хүүхдийн чимээг сонссон Фантинь:

-Хар! Миний охин Козетт тоглож байна. Ээж нь дуугий нь таньж байна гэв.

Хүүхдиэн шуугих чимээ тасарсан хойно Фантинь дэрээ дэрлээд ганцаараа “Козетт бид хоёр ёстой жаргана. НСгд, бид хөөрхөн цэцэрлэгтэй болно. Ноён Мадлен цэцэрлэг өгнө гэсэн. Миний охин тэр цэцэрлэгт эрхэлж наадах болно. Козетт лав цаан толгой сурсан байх. Би бичиг дуудуулна. Ногоон дээгүүр тоглон наадаж явахыг би нүдээрээ харж суух болно. Козетт одоо долоотой” гэв.

Фантинь дахиж үг ярьсангүй амьсгаа ч авсангүй тохойлдон өндийтөл хоёр эцэнхий мөр цамцны дороос цухуйна. Саяхан сэргэлэн гялалзж байсан нүүр өгөр цагаан болж нүдээ бүтэлзүүлэн тасалгааны нөгөө булан руу гөлрөн ширтэж нэг гарааа Мадленыг нударч нөгөө гараараа эргэж харахыг зангав.

Мадлен эргэн харвал Жавер ирсэн байв.

Шанматьег чөлөөлснийхөө дараахан шүүх цуглааны дарга прокурор хоёр хоорондоо “тэнгис орчмын Монрейль хотын дарга ноёныг баривчлах тухай” асуудлыг зөвлөн ярилцаад... баривчлах тухай тушаал бэлтгэж байцаагч Жавер луу яаралтай элч илгээсэн аж. Баривчлах тушаалд: “Тэнгис орчмын Монрейоль хотын дарга Мадлен буюу урьд шоронд байгаад чөлөөлөгдсөн хоригдол Жан Вальжаныг баривчлах эрхийг цагдан сэргийлэхийн байцаагч Жаверт шийтгэн олгов” гэж дурджээ. Энэ тушаалыг хүлээн авсан Жавер тэр дороо сэтгэл баясан тогтож ядан босон харайж инээмсэглэн иржээ...

### III

## ЭРХЭЭ ЭДЭЛСЭН ЖАВЕР

Хотын дарга ноён Фантинийг Жаверын гараас аварч авснаас хойш үзээгүй байсан Фантинь аймшигт хүнийг хараад айхдаа:

-Намайг аварч үзээчээ! Мадлен гуай гэж хашгирав.

Үүнээс хойш бид Мадлен гэхгүй Жан Вальжан гэдэг жинхэнэ нэрээр нь нэрлэх болно шүү.

Жан Вальжан:

-Битгий санаа зов. Жавер тантай хэрэгтэй болоод ирээгүй байхаа гээд Жаверт:

-Та ямар хэргээр ирснийг би мэдэж байна гэсэнд Жавер:

-Олон юм бүү ярь! Бушуухан яв миний хойноос! Гэв.

Жавер Жан Вальжаныг заамдаад авахад Жан Вальжан уруу царайлан бөхийхийг харсан Фантиньд ертөнц балрах шиг санагдаж:

-Ноён даргаа! Гэхэд Жавер буулиа гартал ярзайн инээж:

-энд ямар ч ноён дарга алга! Гэв.

Жан Вальжан заамдуулсан гарыг зайлуулахыг оролдсонгүй харин:

-Жавер... гэж үг хэлэх гэтэл Жавер:

-Чи намайг цагдан сэргийлэх газрын байцаагч ноён гэж дууд гэв.

Жан Вальжан аяархан дуугаар,

-Надад гурван хоногийн эрх чөлөө олгож хайрла! Гуравхан хоног. Би гурав хоногийн дото рэнэ ядуу хөөрхий эмэгтэйгийн хүүхдийг авчирч өгье Хэлсний чинь тоогоор мөнгө төлье.

Та намайг дагаад явсан ч болно гэв.

Энэ үгийг сонссон Фантинь:

-Миний хүүхдийн хойноос явна гэв үү? Миний охин энд байна гээг худал болох нь ээ! Сувилагчаа! Козетт хаа байна вэ? Нааш нь өгөөч ээ!... гэж үглэв.

Жавер газар дэвсэж:

-Чи бас уу! Хогийн эмэгтэй чи наад амаа тагла! Хоригдлуудыг хотын дарга болгон дэвшүүлж, янхнуудыг ямбат нохой шиг тахидаг цаг өнгөрсөн гэж мэд! Тийм олиггүй орон хаа байна! Юм болгон өөрчлөгдөх цаг болсон гэж бодоцгоо! Энд ноён Мадлен гэдэг хүн алга! Харин миний гарт баригдсан хулгайч дээрэмчин хоригдол Жан Вальжан байгааг ойлго! Гэв.

Фантинь хөшсөн гараа тулж гэнэт өндийгөөр ямар нэг үг хэлэх гэсэн мэт Жан Вальжан, Живер, сувилагч нарыг харахад амьсгаа нь давхцан хоолой хяхтнан шүд нь даг даг хавшин, усанд живсэн хүн барих юм лэмтрэн хайх адил хоёр гараа урагш сунгаж агаар самардаад: дэрэн дээрэ намсгэн унахад толгой нь ор цохиж санжигнаж, хараа нь мөс шиг гөлөрч, ам нь ангайн хоцров.

Орчлонд амьд явахыг хичээн, олдсон ганц үрээ хүн болгохыг хүсэн мөрөөдөгч хөөрхий эх Фантинь амьсгаа хурааж гол тасрав...

Жавер, Жан Вальжаныг барин авч хотын шооронд түгжив. Жан Вальжаны хийсэн бүхэн хоёрхон цагийн дотор мартагдаж, хайхрах хүн ч олдохоо болив. Өглөөнөөс аваад үйлдвэийн хаалга хаалттай янзаараа.

Байшингийн дотор сувилагч хоёр эмэгтэй, ламаас өөр хүн хэн ч үлдсэнгүй.

Ноён Мадлен гэртээ эргэж ирдэг цаг болоход сувилагч эмэгтэйн нэг нь хуучин Мадлены ерөөний түлхүүр, лаа хоёрыг авч гараад ноён Мадлены тавьдаг байсан газар тавив...

Гэтэл энэ үеэр Мадлен гэнэт орж ирэхэд эмэгтэй гайхаш тасарч хэрхэн яагаад шоронгос мултарч ирснийг лавлахад, Мадлен:

-Би шоронгийн цонх эвдэн үсэрч гараад оргон ирлээ гээд ерөөндөө оров.

Удсан ч үгүй Жавер хойнос нь нэхэмжлэн ирэхэд Жан Вальжан дотогшоо онгойдог хаалганы ард орж тасалгааны нэг буланд нуугдав.

Жавѣр хаалаг онгойлгож:

-Би шоронгоос оргосон Жан Вальжан гэдэг хүн мөрдөн хайж ирлээ. Өнөөдөр танайд оргодол хүн ирэв үү? Гэж Жан Вальжаны ерөөнд зогсож байсан эмэгтэйгээс асуухад хариуд нь:

-Үгүй. Хэн ч ирээгүй гэв.

Цагийн дараа нэг хүн өтгөн ой, мананг зүсэн тэнгисийн орчмын Монрейль хотоос Парисыг чиглэн холдсоор байв. Тэр хүн Жан Вальжан байжээ. Хүн болгнд хорвоо дээр ганц эх байдаг.

Тэр хэийг газар гэдэг. Энэ газар эхийн хэвлийд гасланд эх Фантинь аялжээ...

ДЭД ХЭСЭГ

## КОЗЕТТ ОХИН

## ВАТЕРЛОО

Ватерлоог үнэндээ хувьсгалын эсэргүү хүчний ялалтын г азар болгох байв. Энд Европ тив Францын эсрэг, Петербург, Берлин, Вена хотуудад Парисын эсрэг хандсан юм. Эд хуучин хэвшмэл ёс шинийн эсрэг, эзэрхэг түрэмгий гүрнүүд, босч тэмцсэн францчуудын эсрэг хандсан билээ.

Ватерлоогийн тулалдааны дара Европын байдал түгшүүртэй болж, Наполеон алга болсон хйоно агуу тоам зай байр үлдэв.

Энэ онгорхой зай руу олон вангууд тольд нүүрээ харж буй адилаар өнгийв. Хуучин Европ түүнийг өөрчлөлт хийхдээ ашиглав. Дархан холбоо үүсэн тогтв...

Дайны хажууд дажин гэгчээр зэвсэгт цэргүүд хядалдан өнгөрсний сүүлээс хулгай дээрэм үүсэж олз ашиг хайгчид олонтой гардаг...

Их бууны эцсийн галлалт зогсоход Ватерлоогийн тулалдааны төв агсан Мон-Сен-Жаны тал эзгүй хоосон болсон аж...

Дайнд хамгийн жигшмээр хэлбэр нэг байдаг. Энэ нь ялалтын дараа үхсэн хүүрүүдийг тонон дээрэмдэх явдал мөн.

Тийм шившигт явдлыг хэн үйлдэж, үхсэн хүний өвөр халаасыг ухдаг билээ? Гавъяа ялалтын хойгуур гараа бузарлаж явдаг хүн хэн бэ?

Арим Үүхний хойно сүүл гардаг, эр сүүл үлдэгдэл дотроос буруутан этгээдийг хайх хэрэгтэй.

1815 оны зургадугаар сарын 18-ны шөнө дундын үед үл таних нэг хүн дайн болж өнгөрсөн талбараар сүүдэгнэн гэтэж явж... Тэр хн тоо томшгүй их хүүрүүдийг малтан шагайж нүд хальтрам бохир нэгжилт хийж улаан цусан дундуур гатчин алхана.

Тэр хүн гэнэт зогсов:

Хэдэн алхмын цаана үхсэн хү-ий нүүр, адууны сэгийн дороос сарны гэрэлд гар гозолзон харагдана. Ажвал алтан бэлзэг аж.

Тэнүүлч хүн тэр дороо суун тусаад босоход хуруунд байсан бэлзэг харагдахаа болив. Тэр хүн гэдрэг эргэж алсыг чагнан ажиж байтлаа гэнэт цочин зог тусав. Ар талаас нь чангаах шиг болоход цочсон хүн эргэн харвал нөгөө гозгор гар дээлийн хормойноос базсан байв.

Хүн айж:

-Хүүш! Хөдөлж байна. Харгис цагдаа биш байна гайгүй хэрэг! Гэхэд атгасан гар суларч тэнийв.

-Энэ хүүр чинь амьд байна. Татж гаргаад үзье байз хөө! Гээд хүн бөхийж хавь ойрын дарсан юмыг зайлуулж толгойг нь гаргаад дараа нь биеий нь суга татав. Хувцасны байдлыг ажвал цэргийн дарга аж. Сэлэмж цавчуулсан ангархай нүүрнээс цус цувж, хоёр нүд аниатай хэвээр. Нөгөө тэнүүлч хүн шархадсан даргын энгэрээс зүүлттэй одонг тас татан өвөрлөөд цагны халаасыг тэмтэрч цагийг авав. Драа нь хантаазны халаасыг ухаж түрийвчтэй мөнгийг бас авав.

Энэ үед дарга нүдээ нээж:

-Баярлалаа! Гэж ядарсан дуугаар хэлэв.

-Тэнүүлчин үг ч хэлсэнгүй. Алсад хөлийн чимээ гарч эргүүл ирж яваа байв.

Гарын тэмтрэлт, шөнийн зөөлөн салхинаас болж, ухаа орсон дарга үхээнц хоолойгоор:

-Хэн ялсан бэ? гэхэд дээрэмчин

-Англичууд ялсан гэв.

Дарга:

-Та миний халаасыг тэмтэрч дотор нь байгаа цаг мөнгийг ав гэв.

Дээрэмчин аль эрт цаг, мөнгий нь авсан байв. Гэсэн ч тэр дээрэмчин хайж байгаа янзтай тэмтэрч үзээд

-Юу ч алга! Гэхэд дарга:

-Дээрэмдсэн байна. Аваагүй сэн бол би танд өх байсан юм гэв.

Эргүүлийн хөлийн чимээ улам ойртсоор

-Хүн айсуй гэж дээрэмчин хэлэв.

Цэргий дарга арай гэж гараа өргөөд дээрэмчнийг татан зогсоож:

-Та миний амийг аварлаа. Алдар хэн гэдэг вэ? гэхэд дээрэмчин хариуд нь:

-Би тантай адилхан францын цэргийн албан хаагч хүн.

Би одоо явалгүй болохгүй. Намайг барьж авбал дор нь буудна.

Би таны амийг аварлаа. Цаашдаа арга олж үз гэж шивнэв.

-Та ямар тушаалтай вэ?

-Түүрүүч

-Нэр хэн бэ?

-Тенардые

-Би таны нэрийг мартажгүй. Миний нэр Понмерси гэдэг, тогтоож аваарай гэж дарга хэлэв.

## **ХОЁРДУГААР ДЭВТЭР**

## **ОРИОН ОНГОЦ**

I

### **24601 ДҮГЭЭР ХҮН 9430 ДУГААР ХҮН БОЛОН ХУВИРАВ**

Жан Вальжан дахин баригдав. Тэнгис орчмын Монрейль хотод гарсан явдлаас хойш хэдэн сарын сонинуудад хэвлэгдсэн хоёр тэмдэглэлийг энд дурдъя.

Нэгдүгээр тэмдэглэлийг 1828 оны долдугаар сарын 25-ны өдрийн “Цагаан дарцаг” сониноос сийрүүлэв.

“Па дө-Калэгийн т@йрогнуудын нэгэнд ер бусын явдал тохиолдов.

Энэ нутгаар урьд өмнө үзэгдэж байгаагүй Мадлен гэгч хүн хээн жилийн өмнө үйлдвэрийн шинэ арга нээж их орлого олж орон нутгийн хамтаар чинээлэг баян болов. Нутаг орныг баян амьдралтай болгосон учир хотын даргад сонгогдов. Энэ этгээд 1796 онд хулгайн хэргээр шоронд орсон байна. Дараа нь зохих шийдвэрийг зөрчиж суух газраа өөрчилснийг цагдан сэргийлэх илрүүлсэн байна. Хэрэгтний нэр нь Жан Валжан. Жан Вальжан дахин хоригджээ. Жан Вальжн шоронд орохын өмнө өөрийн үйлдвэрийн орлогоос зүй ёсоор олсон хагас саяас илүү мөнгөө хөрөнгөтөн Лафитийн хадгаламжаас авч амжсан бололтой. Жан Вальжаныг Тулоны хорих газар

луу явуулсны дараа уг мөнгийг чухам хаа нуусныг магадлавч байгаа газры нь тодруулж чадсангүй”

Нилээд дэлгэрэнгүй хоёрдугаар тэмдэглэлийг мөн өдрийн “Парисын сониноос авч сийрүүлэв.!!!

“Жан Вальжан гэдэг суллагдсан хоригдол Варын эрүүгийн шүүхэд баригдсаныг анхааралгүй өнгөрүүлэх нөхцөлгүй санж. Энэ муу хоригдол сонор сэрэмжит цагдан сэргийлэхийг мэхлэв. Нэрээ өөрчилж өөр нэртэй болоод манай хойт зүгийн хотуудын нэгний даргд сонгогдож. Энэ хотод нилээд том үйлдвэр нээж. Гэсэн ч эцэстээ прокурорын цуцалтгүй хяналтанд орон баригдаж хэрэг илэрсэн байна. Хамт амьдарч байсан янхан хүүхэн нь Үан Вальжаныг баригдахад сэтгэл түгшин ухаан алдаж нас барж. Хар арьстны хамгийн хүчтэний чадал бүхий тэр хоригдол оргох арга олж зугтан явтал түүнийг цагдан сэргийлэх гурав дөрвөн хоногийн дараа нийслэлээс Монфермейль тосгон орох жижиг морин тэргэнд суугаад хөдлөх гэж байтал Парист барьсан байна. Хоригдол гурав дөрөв хоногийн дотор манай хамгийн төм хорөнгөтнүүдийн нэгэнд хадгалуулсан мөнгөнийхөө ихэнхийг авч амжсан гэлцэнэ. Авсан мөнгө нь зургаан долоон зуун мянган франк санж. Жан Вальжан Вр тойргийн шүүхэд баригдаж, найман жилийн өмнө гэгээн цагаан өдөр жаал хүүг дээрэмдсэн хэрэгт ял шийтгүүлэхэд өмгөөлөгч авахаас өөрөө татгалзав. Жан Вальжан өмнө зүгт байдаг хуйвалдагч этгээд нарын тусламжаар хулгй үйлдсэнийг улсын прокурор уран чадварлаг илтгэлдээ илрүүлэн тэмдэглэв. Үүнийг үндэслэж Жан Вальжаныг цаазлах ял зааж. Гэтэл хоригдол этгээд ял давж заалдахаас татгалзсан аж. Төгсгөлгүй энэрэнгүй ван ялыг хөнгөвчлөн алах ялыг бүх насаа нь хорих ялаар солив. Жан Вальжаныг тэр дор нь Тулоны шорон руу явуулжээ...

Жан Вальжаны пайз солигдож 9430 болж.

Жан Вальжан баригдмагц Монрейль хов хоосон болж ажилчид таран бутарч туйлын ядуу байдал ноёрхож амьдрал доройтжээ”.

## II

### **АВРАХААР ОЧООД АЛГА БОЛСОН НЬ**

1823 оны 10-рсарын эцсээр далайн хүчит шуурганд цохиулсан “Орион” онгоц гэмтэл олоод засвар хийлгэхээр Тулонд хүрч ирэв...

Тэр онгоцыг нэг өглөө харж байсан олон хүмүүс өр өвдмөөр бэрх явдлыг үзжээ.

Онгоцныхон далбаа бэхэлж байв. Онгоцны шоронгийн дэдэ талд гарч явсан усан Үэрэг тэнцүүр алдаж гэнэт найгах д далайн эргээс харж байсан улсууд дуу алдав. Усан цэрэг шоргийн хөндлөн модон дээр тэгнэгдэн хөндлөвчийн хамтаар шоргийг тойрон эргэж гар сарвагануулан байснаа олсон шатнаас эхлээд нэг гараараа дараа нь нөгөө гараараа барин авч агаарт дүүжлэгдэхэд нүд эрээлжлэн алс дор тэнгисийн ус гүвэгнэн цэлэгнэнэ. Олсон шат гэнэт хүчтэй хөдөлсөн учир дүүжин адил савлуурдан байна. Усан цэрэг дээсний үзүүрээс уясан чулуу адил шидэгдэн бөнжигнөнө.

Энэ хүнд туслах амьтан өөрөө амь алдахаас гарцаагүй болсон учир нэг ч усан цэрэг амаа ангайхгүй зогсоно.

Олсноос зуурсан цэрэг эцсийнхээ хүчийг алдах магад гэж сэргийлэн огт дуу гаралгүй агаарт дүүжлэгдэн явааг харсан хүмүүс нүд хальтран нүүрээ буруулна.

Шорог бэхэлсэн олсыг даган нэг хүн ирвэс адил асч явааг гэнэт харцгаав. Тэр хүнийг улаан хувцсаар хоригдол гэж танив. Ногоон малгай өмссөн болохоор насаараа шоронд хоригдох ялтан байна гэж мэдэцгээв. Шоронгийн дунд талбайд хүрэхэд хүчит салхи ногоон малгайг авч хаяхад буурал толгой харагдав. Тэр хоригдол залуу хүн биш нь лявтай.

Онгоц засварлах ажилд оролцуулахаар явуулсан хоригдлуудын нэг нь олон түмний үймээн дунд усан цэргийн даргаас зөвшөөрөл авч амь үрэгдэхээр байсан хүнийг аврахаар дээш авирч явсан нь тэр санж...

Хоригдол шоргийн үзүүрт тулаад авч явсан олсныхоо нэг үзүүрийг бэхлэн уяад нөгөө үзүүрийг унжуулав. Тэгээд унжуулсан олсоо дагаж дүүжлэгдэн бугаад агаарт савагдан байсан цэргийг шүүрэн сугавчлаад гэдрэг буцаж шоргийн дээд талын жижиг талбай дээр байсан нөхдөд нь гардуулав.

Хоригдлын энэ зоригт явдлыг харсан хүмүүсийн зарим нь “өршөөл үзүүлж хөөрхий амьтныг суллан тавибал зохино” гэж хашгирна.

Доошоо, хоригдол нөхөд рүүгээ бууж явсан аврагч гэнэт тэнцүүр алдсан адил зог тусаад тэнгисийн ус руу унахад услууд дуу алдан нүүр буруулав.

Хөөрхий шоовдор амьтан хоёр том усан онгоцны хоорондуур унасан, амьд үлдэхэд бэрхтэй байж. Хойноос нь усчуудыг явуулавч олсонгүй. Унасан учир хүн өөрөө ч усан дороос хөвж гарч ирсэнгүй. Орой болтол усан доогуур шумбан хайгаад үхсэн ч юм олсонгүй, амьд ч юм олсонгүй.

Маргааш нь Тулоны сонинд:

“1823 оны арван нэгдүгээр сарын 17”. “Орион” онгоц дээр засвар хийж байсан хоригдол хүн, аюулд учирсан усан цэргийн амийг аварч яваад усанд унаж живлээ. Хаа ч бие нь олдсонгүй. Шоронгийн данс шүүрдвэл тэр хоригдол 9430 тоот пайзтай Жан Вальжан гэдэг хоригдол мөн байв” гэсэн тэмдэглэл нийтлэгджээ.

## **ГУРАВДУГААР ДЭВТЭР**

# **ҮХСЭН ЭХЭД ХЭЛСНЭЭ БИЕЛҮҮЛЭВ**

I

## **МОНФЕРМЕЙЛЬД УС ХОВОР**

Хүн амьтан цөөнтэй Монфермейльд амьдрал сайн юм. Хямд элбэг боловч өндөрлөг газар учраас ус ховроо. Хол газраас ус зөөхөөс хөөрхий өөдөс охин Козетт тун их айдаг. Тенардьегийнх Козеттыг зарцлахын хамт мөнгө хөлс авда гучрас явуулах дургүй байлаа. Козетт Тенардьегийнд зарцын үүрэг гүйцэтгэх ус дутахад ганцаар явж авч ирнэ. Харанхуй шөнөөр шигүү ойн дундуур зүсэн явж горхиос ус авч ирнэ гэхээс Козетт зүрх хагартал айж дандаа хүрэлцэхүйц устай байлгахыг туйлаас хичээнэ.

1823 онд Христосын төрсөн ойг Монфермейльд маш өргөнөөр тэмдэглэхэд олон янзын зочид Тенардьегийнд ирэв. Тэдний дотор нилээд хэдэн тэрэгчид, нүүдлийн худалдаачид морь малтайгаа Тенардьегийнд ирсэн байв. Ирсэн зочи дархи ууж хоол идэж зугацан наргиж байхад уранхай дээлтэй муруй шаахайг ороолтгүй өмссөн Козетт охин хоол цайны өрөөний вандангийн хөндлөвч дээр сандайлан сууж

Тенардыегийн хоёр охинд зориулан ноосон оймс нэхэж сууна. Вандан дор суугаа Козеттын хажууд муур эрхлэн наадна. Зэрэглээ нэг тасалгаанаас Энопиль, Азельма хоёрын тоглон надж хүүрнэлдэх чимээ сонсдоно.

Зуухны хажууд хүхэд зоддог ташуур өлгөөстэй.

## II

### ТЕНАРДЬЕГИЙНХНИЙГ БҮРЭН ТОДОРХОЙЛБОЛ

Тенардые тавин нас хүрэхэд эхнэр нь гуч хүрэх шахаж байлаа. Эр эм хоёр нсны хувьд аргагүй тэнцүүгүй.

Эхнэр Тенардые махлаг өндөр, цайвар үстэй, өргөн цээжтэй гэрэлтсэн ягаан хацартай, хөнгөн шаламгай. Энэ эхнэр ор хураах, өрөө таслагаа цэвэрлэх, аяга шанага угаах, оёх, нэхэх зэрэг бүх ажлуудыг ганцар гүйцэтгэнэ. Тэр эхнэрийн цор ганц зарц нь Козетт охин. Козетт охин, заанд зарцлагдсан хулгантай адил эхнэрийн түрэмгий дуунд хогшил хөрөнгө, хүн амьтан үүд хаалга бүгд догдлон чичирнэ. Хэрэлдэхийн хувьд улаан хөлтийг урдуураа үл гишгүүлэгч энэ авгай зангидсан гараар ганц буулгаад самар бут цохидогтоо их бардамнана...

Ярьж хөөрхий нь үзсэн хүн “Харгис цагдаа байна” архи залгилж йага нь “архичин” Козеттыг загнаж байгаа нь “яргачин” адил гэмээр.

Тенардые өөрөө эцэнхий, цонхигор цагаан, хэрзгэр ялаг. Болгоомжлохдоо инээмсэгэлж, хүн болгонтой, гуйлгачинтай ч хүртэл зөөлөн харьцана. Архи хичнээн уувч үл согтоно. Боловсрол ихтэй материалист маяг гаргана. “Өөртөө” дэглэмтэй хүн гэнэ. Үнэн магдалбал луйварчин худалч хулгайч. Зоригт баатар түрүүч явахдаа “аймшигт шархадсан генералын” амь аварсан гэх мэтээр ханхалзана.

Эр эм хоёрыг зэрэгцүүлбэл эм нь зөвхөн өөрийн охидыг хайрлаж, зөвхөн нөхрөөсөө айна. Сүүн тэжээлтний ангид ордгоороо зөвхөн эхийн шинжтэй, бусад талаар эхийн байдал огт үгүй. Ганцхан охиноо хайрлахаас биш эрэгтэй хүүхдээ ер үл анзаарна.

Нөхөр нь өдөр шөнө, өглөө үдэшгүй баяжихсан гэхээс өөр юу ч боддоггүй хүн...

Тенардые эхнэртээ дүрэмдэхдээ:

“Буудылын эзэн хүн бол ирсэн болгонд хоол унд өгч бохир даавуунд дулаан унтуулж, гэрэл түлшээр хангаж зусардах, явуулын хүнийг зогсоон түрийвчий нь хоослох, жуулжлан гэр бүлийг долигнон хонуулж эрэгтэй эмэгтэй хүүхэд багачууд гэж ялгалгүй тонон дээрэмдэх, онгорхой, хаалттай цонхнууд, галын дэргэдэх ор сандал, зөөлөн суудал, урт, дөрвөлжин, түшлэгтэй сандлууд, дэр гудас, дэвссэн сүрэл эд бүхнээс хөлс мөнгө авдаг байх ёстой. Ирсэн зочин тлинд нүүрээ харахаас эхлээд дагаж яваа нохой нь ялаа аваад үмхэх хүртлээс ч мөнгө авах ёстой. Нэг үгээр хэлэхэд ирсэн хүн болгоны хэтэвчийг хоослох аргатай байх хэрэгтэй” гэнэ.

Нөхөр нь бусыг тонох дээрэмдэх арга сүвэгчлэхэд эхнэр нь одоо яаж түүнийг цуглуулан шингээх арга хайдаг аюултай хоёр гэр бүл болсон байжээ.

Энэ хоёрын хооронд орсон Козетт хоёр давхар дарлалд тарчилна. Эхнэр нь Козеттыг үхтэл занчина. Нөхөр нь Козеттыг хоосруулан өвлийн хүйтнээр хөл нүцгэн гүйлгэнэ.

Козетт шатаар өөд уруугаа дэгдэн угаах цэвэрлэх арчих, цайлгах будах, үүрэх зөөх зэрэг хамаг хүнд хүчир ажлыг үүрнэ. Эр эм хоёрын хэн нь ч гэсэн хөөрхий шоовдор амьтанг өчүүхэн ч хайрлах сэтгэлгүй. Тенардыегийн гэр аалзны шүлсэн тортой яг адил. Тэр бэрх торонд орсон Козетт хүчээ барин тийчилнэн Хөөрхий

жаахан энэ зарц боолчолын шинжийг өөртөө шингээжээ. Козетт аалзны аманд орсон ялаанаас огт ялгаагүй.

Эрхээ алдсан эвий шоовдор өөдөс Козетт элдвийг тэвчин шүд зууна...

### III

## ХҮНД ДАРС, АДУУНД УС

Хуучин зочид дээр нэмж дөрвөн жуулчин ирэв. Наймхан настай Козетт гунигт бодолд оров. Козетт нас бага боловч гунигт бодолд орон, доош харан суух нь жижиг эмгэн адил.

Зовлонд учирсан жаахан Козетт харанхуй шөнө болох үед хамаг усаа хүн, малд өгч дуусаад хоосон болсныг санаж, яасан бэрх зовлон бэ? гэж санаа алдана. Тенардые авгай савны таг онгойлгосноо:

-Эй моньд! Ус уусчээ. Дээлийн гол юу хийж суугаа юм бэ? Ус авч ирэхгүй гэж зандрахыг сонсоод Козетт амьсгаа хураан хярж сууна...

Дараа нь нүүдлийн худалдаачны нэг нь орж ирээд ууртайгаар:

-Миний моринд ус өхгүй яасан юм бэ? гэхэд Козетт

-Таны морь ханатлаа ус уусан юмсан даа! гэв.

-Худал бүү хэл! Огт ус уугаагүй байна. Одоохон ус уулгаад орхи! Гэж худалдаачин хэлэхэд Тенардые авгай Козеттыг ширээний дороос чихдэн гаргаж харанхуй шөнөөр усанд хөөв. Өөрөөсөө хоёр хувь том хувин барьж гарах гэтэл авгай базлан чангааж:

-Май арван таан сү аваад яв: Замдаа дэлгүүрээс том талх авч ир гэв.

Козетт хэдэн мөнгийг авч энгэрийнхээ халаасанд хийгээд гудамжинд гарснаа дэлгүүрийн цонхон дээр байгаа олны анхаарлыг өдөржин татсан цагаан том хүүхэлдэйг харж: “Насандаа, гоё хүүхэлдэй барьж тоглож үзээгүй явсан юм сан, одоо энэ сайхан тоглоом авч тоглох сон доо. Надад тийм хувь заяа байгаа болов уу?” гэж бодохоос зовлон зүдрэлээ мартан зогсжээ. Гэтэл нөгөө авгай араас нь аль муугаар уурлаж:

-Мөн! Дээлийн гол чи явахгүй энд юугаа хийсэн юм бэ? Хонгоны чинь махыг шулаад хаячихъя байз хөө! Гэхийг сонссон Козетт хувингаа барьсаар харанхуй руу жирийлгэж далд оров.

### IV

## ГАВ ГАНЦААРАА

Загнуулсандаа айж ухаан алдах шахсан Козетт хөлийн эрчээр гүйсээр Монфермейлийн захад гарснаа айл амьтангүй нүх шиг харанхуй тал руу ширтээд зүрх алдан гэдрэг буцан харайв. Гэтэл ус, талхгүй хоосон буцаж очвол Тенардые авгай цохиж ална байх гэхээс айж бас буцахаар шийдэв. Нүх шиг харанхуй ойн зүг гүйн гүйсээр сүглэгэр харанхуй шугуй дотор орж элдэв амьтан үзэгдэх магад гэхээс хажуу тийшээ ч харалгүй урагшлан явсаар шигүүн ойн гүнд байгаа горхины дэргэд очив. Харанхуйгаас айж хүч нь гурав дахин нэмэгдсэн Козетт голын эрэг рүү тонгойж хувингаа дүүргээд өндийтөл өвөрт нь байсан мөнгө гулсан ус руу шолхийн унав. Козетт мөнгөө унасныг ч анхаарсангүй. Хувинтай усаа бариад гэдрэг буцаж явтал

гэнэт хувин хөнгөрөх шиг болж ямар нэг хүний гар оосроос барьж өргөн явахыг мэдээд эргэн харвал өндөр нуруутай хар хүн байв. Козеттыг чимээгүй дагаж ирсэн тэр хүн гүйцэн ирж хувинтай уснаас дамжлан явалцав. Харанхуй дотроос хүн гарлаа гэж тэр хүүхэд огт айсангүй.

## V

### УУЛЗАХЫН ӨМНӨХӨН

Мянга наймн зуун хорин гурван оны шашны баярын өдрийн үд дундын хойхон ямар нэг хүн Парисын “Эмчилгээ” цэцэрлэгийн хүнгүй талаар ихэд удтал холхиж байв. Тэр хүн хоосрон буй Сен-Марсо хорооны захаар хамгийн хямд үнэтэй байрыг хайж байгаа бололтой.

Магадалбал тэр хавьд үнэхээр байр олсон байж...

Цал буурал, үс, үрчлээс нүүр, цайвар цагаан уруул, ядарсан гэмгүй байдалтай царайг харахад тавиас илүү настай бололтой. Нусны алчуурт боосон жижиг зүйлийг зүүн гартаа барьж, гачуур зорж хийсэн бололтой таягийг баруун гартаа тулжээ. Эзгүй газрыг барьж явахыг харвал хүнтэй уулзахгүйг хичээжээ. Түүнийг харах тушаал авсан сэргийлэхийн цагдаа харсаар байгаад чадсангүй мэхлүүлэв.

Цагдааг мэхэлсэн хүн яв явсаар аньи орох морин тэрэгний буудал хүрч:

-Суугаад явах байр байна уу? гэхэд улаач:

-Миний хажууд гадна талд суух ганц байр байна гэв.

-Тэр байранд чинь сууя.

-Суу, суу

-Улаач хөдлөхийн өмнө тэр хүний өнгө муутай хувцас, хөнгөн ачааг хараад хөлсөө урьдчилан төлөхийг шаардав.

-Ланьи хүрэх үү?

-Тэгнэ Ланьид бууна гээд замын хөлс төлөв.

Тэр хүн орой зургаан цагийн үед тэрэгнээс буугаад Монфермейль орох замаас баруун талаар явж ойд орроод орчныг анхаралтайгаар ажин ширтэж аячархан ахлхлан явснаа нэг зүйл хайж олоод цааш явна. Тэр хүн явсаар ой дотор ус авч явсан Козеттой уулзсан ажээ.

## VI

### КОЗЕТТ ОХИН ХАРАНХУЙ ДОТОР ТАНИХГҮЙ ХҮНТЭЙ ХАМТ

Козеттой уулзсан хүн аяархан дуу хоолойгоор:

-Хүү минь яасан ч хүнд юм авч явна вэ дээ гэхэд Козетт дээш харж:

-Ноёнтон минь тийм ээ! гэв.

-Нааш өг. Би аваад явъя гэхэд Козетт оосроо тавив. Тэр хүн:

-Яасан хүнд юм бэ гээд Жаал охин минь хэдэн настай вэ? гэж асууна.

-Би наймтай ноёнтон минь.

-Холоос явна уу?

-Ойн дундах горхиноос

-Тэр чинь хол уу?

- Холоо. Хорь гаруй минут явна.
- Эх байхүй юу чамд?
- Мэдэхгүй. Надаас бусдад эх бий. Надад байхгүй.
- Нэр хэн бэ?
- Козетт
- Танайх хаана вэ?
- Монфермейльд
- Хэн чамайг ийм харанхуйгаар модон дотроос ус авахуулахаар явуулсан бэ?
- Ноёхой Тенардые.
- Тенардые эмэгтэй ямар ажил хийдэг вэ?
- Гэрийн эзэн эмэгтэй. Буудлын эзэн хүн.
- Өртөө буудал уу? Сайн байна. Би тэнд чинь хоноё. Намайг дагуулаад оч.
- Би тэр үг очиж явна.

Нилээд дуугүй явж байсан хүн:

- Тенардыегийнх зарцгүй юм уу? гэж асуухад Козетт:
- Зарц байхгүй гэв.
- Чи тэднийд ганцааран уу?
- Тиймээ ганцаар гээд жаахан чимээгүй явснаа Козетт:
- Надаас ондоо хоёр жижиг охинтой.
- Хэн хэн гэдэг вэ?
- Понинь, Зельма гэдэг. Козетт ингэж хоёр охины нэрийг хэлдэг байж.
- Тэд юу хийдэг юм бэ?

Козетт дуу алдан:

-О? Их хөөрхөн хүүхэлдэйтэй. Ондоо гялалзсан сайхан тоглоомуудтай. Тэд тоглож наадаж байдаг.

- Өдөр турш уу?
- Өдөржингөө.
- Чи тоглодог уу?
- Үгүй. Ажил хийдэг.
- Өдөржин үү?
- Тийм ээ гээд Козетт азнаснаа:
- Ажил дууссан хойно зөвшөөрөл аваад заримдаа би тоглодгоо гэв.
- Чи юугаар тоглодог вэ?
- Юугаар ч хамаагүй. Надад тоглоом цөөхөн. Понинь, Зельма хоёр тоглоомоороо тоглуулах дургүй...

Буудалд улам ойртон очиход Козетт нөгөө хүний гараас татан:

- Бид гэрийн гадаа ирлээ гэв.
- Яагаа вэ тэгээд?
- Би хувингаа авъя.
- Яах юм бэ? Юунд
- Намайг хүнээр юмаа хүргүүлж ирснийг авгай үзвэл үхтэл зоддог юм гэхэд үл

таних хүн хувингаа өгөв.

Хэдэн минутын дараа тэд буудалд

**VII**

## **УНТАХЫН ӨМНӨ**

Козетт усаа гэртээ оруулаад:

-Эрхэм ноёхон чинь энэ ноён манайд унтаад явъя гэнэ.

Харанхуй дотор зогсоо хүнийг харсан агай:

-Та морил гэв.

Дараа нь:

-Манайд нэг ч эзгүй өрөө алга даа гэхэд явуулын хүн

-Намайг дуртаа газраа унтуул. Адуу малын хашаа хороо ч байвал болно.

Хөлсий нь тусгай ертөөнийх шиг төлье гэв.

-Дөчин сү өгөөрэй.

-Дөчин сү! Төлье.

-Тиймээ.

Улаачингуудын нэг нь:

-Дөчин сү! Мөн хэцүүеэ. Тусгай өрөө хорин сү байдаг юм гэв.

Хүйтэнд даарч хөхөрсөн биетэй Козетт охин хоолны бандан дор орон, юм нэхэж байтал Тенардые авгай:

-Байз! Талх яасан бэ? гэхэд Козетт тэр дороо бандан дороос үсрэн гарав.

Талх замаас авахаа мартсан Козетт амиа аргалж:

-Талхны газар хаалттай. Цохиод цохиод онгойсонгүй гэв.

Авгай уурлаж:

-Үнэн худлыг маргааш шалгаж үзнэ. Худал бол хонгы чинь сорно. Аль нааш нь арван таван сү гэв.

Козетт өврөө уудлан үзвэл арван таван сү алга болсон байж...

Мөнгө гээснийг мэдсэн авгай дэгээнээс өлгөөтэй ташуур шүүрэн автал ирсэн хүн халаасаа уудалж мөнгө газар хаяад:

-Өршөөгөөрэй та. Энэ ажлын өврөөс мөнгө унах шиг боллоо.

Энэ биш үү? Гэж хорин сү өгсөнд авгай:

-Мөн байна. Миний өгсөн мөнгө гэв.

Козетт бусад охины хамт тоглохоор хийж байсан зүйлээ орхих гэхэд Тенардые авгай шүд тажигнуулан.

-Чамайг ч нэг барилаа! Ингэж ажил хийдэг юм уу? Ташуур хэд амсахаар чи муу ажил хийхгүй хайш зайлах вэ! Манай хоол гударч байгаа хойно ажил хийх хэрэгтэй. Гар хосон суугаад хоод идэж байх амны хишиг энүүнд байхгүй гэх мэтээр загнахад хонц хүн:

Наадаг хөөрхий амьтан гээд нэхэж суусан оймсыг таван франкаар худалдан авав.

Козетт Тенардыегийн хоёр охины тоглоомоор тоглож суутал авгай үзээд амандаа орсноор хараан загнаж доромжлон байтал ирсэн хонц гадагш гаран одж анхаарлыг татаж байсан нөгөө гоё хүүхэлдэйг худалдан авч ирээд Козеттод өгөв. Козетт ийм гоё тоглоомтой болно гэж зүүдлээгүй байсан учир хүүхэлдэйд хуруугаа нэг хүргээд авгай руу харж авч болох эсэх тухай зөвшөөрөл гуйна.

Хөдлөх хөдөлгөөн бүрдээ хараал сонсдог Козетт муу санаархан тоглоомтой болсондоо итгэхгүй нилээд байснаа гэнэт шүүрэн авч бандангийн доогуур далд оров.

## VIII

### ТООЦОО ГАРГАСАН НЬ

Хонц өглөө босохоос өмнө Тенардые дор дурсан тооцоо гаргж мөнгө авахаар эхнэртээ шилжүүллээ.

Нэгдүгээр өрөөнд унтсан ноёноос авах зүйлийн жагсаалт

Оройн хоол 3 франк

Тасалгаа 10 франк

Гэрэл 5 франк

Түлш 4 франк

Үйлчилгээ 1 франк

Бүгд 23 франк

Хоноц эртхэн босоод үүргээ үүрч таяга тулаад явахаар завдан байтал авгай:

-Та яасан эрт босоо вэ? Одоо явах нь уу? гэхэд

-Явъя! Гэв.

-Та Монфермейльд ямар хэргээр ирсэн бэ?

-Хэрэг байхгүй. Зүгээр замдаа хоноод явж байна. Хоногийн хөлс хичнээнийг төлөх вэ?

Авгай тооцоогоо өхөд түүнийг авч үзээд:

-Таны аж амдрал ямар байна вэ? гэж сонирхоход авгай: "Бид их өр төлдөг, орлого бага мөнгөний хэрэгцээ маш их" гэх мэтээр үглэж байснаа:

-Та Козеттыг аваад яв. Нүд балай чих дүлий газар далд оруулж үз гэж гуйжээ.

-Болно. Аваад явъя.

-Үнэхээр үү? Козеттыг аваад явах уу?

-Аваад явъя.

-Одоо юу?

-Одоо. Та дууд хүүхдээб гэсэнд Тенардые авгай:

-Козетт! Гэж дуудав.

-Хүүхэд иртэл би мөнгөө төлье! Хэдийг би төлөх вэ? гэж хонц хэлтэл,

-Хорин гурван франк гэж авгай хариулаад хонц хүн хорин гурван франк гаргаж өгөв.

-Козеттыг дууд гэж хонц хэлэв. Тенардые энэ үеэр гарч ирээд эхнэрээ гаргаж хоноц хүнтэй хоёул үлдээд:

-Мянга таван зуун франк төлөөд аваад яв! гэхэд тэр хүн зохих мөнгө гаргж ширээн дээр тавиад:

-Козеттыг авч ир! гэв.

Тенардые авгай:

-Козетт! Бушуу нааш ир! гэж дуудав.

Хэдэн минутын дараа Козетт охин ирэхэд хонц хүн үүргээ задалж эмэгтэй хүүхдийн бүрэн хувцас гаргаж өмсгөөд тэндээс гарч Лаврийн зүг хамт гарч одов.

## IX

### ОЛОН САНАА АЛИНД Ч ҮГҮЙ

Козетт үл таних хүнтэй явсан хойно Тенардые эхнэрээ дуудаж мянга таван зуун франк үзүүлсэнд эхнэр нь:

-Энүүхэн үү? Гэж нөхрөө амьдралдаа анх удаа зэмлэсэнд нөхөр нь:

-Чиний хэлдэг түмэн зөв! гээд малгайгаа өмсөж авсан мөнгөө өвөртлөөд хонц хүний хойноос гүйж гарав. Тенардые арай гэж Козетт хонц хоёрыг гүйцэж очоод:

-Та өршөөгөөрэй. Энэ мянга таван зуу- франкаа буцааж ав! гэхэд Козеттыг авч явсан хүн:

-Юу гэсэн хэрэг вэ? гэж асуухад Тенардые:

-Козеттоо буцааж авъя. Учрыг танд хСлье. Би хүний үрийг аль нэг тохиолдсон хүнд өхгүй. Эхэд нь өгнө. Ядахдаа эхийн гарын үсэгтэй бичиг авч ирсэн хүнд өгнө. Мэдэхгүй танихгүй хүнд өхгүй гэв.

Үл таних хүн өврөө уудажл эхлэхийг харсан Тенардые “За учиртай даа! Мөнгө гаргах нь байна. Суурьтай үзнэ дээ” гэж боджээ.

Нөгөө хүн өврөөсөө нэг жижиг цаас гарга: “Та уншиж үз” гээд цаасаа өгсөнд түүний дор:

“Тэнгис орчмын Монфермейль хот

1823 оны 3-р сарын 25

Ноён Тенардые:

Та үүнийг үзүүлэгч энэ хүнд Козеттг өгч явуулаарай. Аар саар зардлыг төлнө.

Ёслогч Фантинь” гэжээ.

Тенардые Фантиний гарын үсгийг ажиг мэдээд:

-“Аар саар зардлыг” та тө! Гэхэд хариуд нь:

-Козеттын эх нэгдүгээр сард танд зуун хорин франк өгнө гэж байгаа, хоёрдугаар сарын эцэст гурван зуун франк, мөн гуравдугаар сарын эхэнд гурван зуун франк тус тус гуйвуулсан. Түүнээс хойш есөн сар өнгөрлөө. Хэлэлцээ ёсоор сар бүр арван таван франк танд төлөх ёстой. Эд бүгд нийлж зуун гучин таван франк байх ёстой. Гэтэл та зуун франк илүү авсан. Одоо өгвөн зохих гучин таван франк байхаас би дөнгөж саяхан танд нэг мянга таван зуун франк өгсөн гэхэд Тенардые:

-Ахиж мянгыг нэмж өхгүй бол Козеттыг буцааж авна гэж авирлав.

Үл таних хүн:

-Козеттоо явъя хоёул гэж ажигчгүй хэлээд зүүн гараараа Козеттыг хөтлөөд баруун гартаа газар байсан таягаа авав.

Жинтэй хүнд таягаас нь айсан Тенардые юу хийж чадсангүйдээ: “буутайгаа ирэх минь яалаа” гэж амаа барьж хойноос нь харж төнгөний бодол болон шүлсээ залгЁсаар хоцров.

**Х**

## **АМЬД ҮЛДЖЭЭ**

Жан Вальжан үхсэнгүй амьд үлджээ.

Жан Вальжан тэнгисийн ус руу үсрэн орохдоо дөнгө гинжгүй байж. Эрэг дээр зогсож байсан усан оноц хүрээд тэнгээ оой болтол нуугдаж байгаад хүрэлцэхүйц мөнгөтэй байсан учир хувцас худалдан өмсөж оргон зугтаад Парис хот оржээ. Тэндээсээ Монфермейльд очсон байна.

Жан Вальжан Парис ороод хамгийн түрүүнд долоо найман нстай охинд тохирох хувцас худалдан авах ёстой байв. Хувцас худалдан авч суух байр олоод дараа нь Монфермейльд очсон аж.

Парис ирсэн хойно зарим нэг сонин, Жан Вальжан үхсэн гэж баталж байв. Энэ мэдээг уншаад сана нь нилээд тайвширчээ.

Жан Вальжан Козеттыг Тенардьегийн савраас салган авсан өдрөө оройхон Парис орж “Эмчилгээ” цэцэрлэгийн зүг Козеттыг хөтлөн алхав.

## **ДӨРӨВДҮГЭЭР ДЭВТЭР**

# **ГОРБУГИЙН ОВООХОЙ**

I

### **ЭЗЭН ГОРБУ**

Винь-Сен-Марсаель гудамжны цаахна хоёр цэцэрлэгийн хооронд холоос харахад жижиг овоохой мэт боловч ойрхноос харахад сүм адил том байшин байж... Тэр байшин бараг бүтнээрээ нуугдмал байдалтай, зөвхөн цонх хаалга нь харагдана.

Энэ байшинг өртөөчнүүд 50-52 дугаар овоохой гэж нэрлэж. Тэр хавийн хүмүүс түүнийг Горбугийн овоохой гэдэг ж...

Яг энд Жан Вальжан толгой хоргодох газар олж Жан Вальжан зэрлэг шувууны адил энэ эзгүй газрыг шилэн авч үүрээ хийхээр шийдсэн ж.

Жан Вальжан гаднаас ирж хаалга онгойлгон орж хаалгаа маш нямбайгаар хаагаад Козеттоо тэрэн шатаар өөд гарч өрөөндөө орж эвхмэл орон дээр хүүхдийг сэрээлгүй аяархан тавив.

Есөн сарын өмнө нас барсан эхийн нь гарыг үнсэж байсан Жан Вальжан энэ удаа унтаж байгаа охины гарыг үнсэв.

Өглөө болж үүр гэгээрнэ. Өнчин хины өмнө өвдөг сөгдөн сууна. Жан Вальжан.

Өвлийн сүүл сарын бүдэг гэрэл цонх нэвтлэн дээвэрт тусан сүүдэгнэнэ. Гадуур өнгөрч явсан хүнд ачаатай тэрэгнээс болж овоохой донслон хөдлөхөд Козетт гэнэт сэрж:

-Ноёхой минь би одоохон бослоо! Гэж хашгиран босон харайгаад нүдээ сайн нээж амжаагүй мөртлөө тасалгааны булан руу гараар тэмтэрч:

-Бурхан минь! Миний шүүр хаачаа вэ? гэв.

Козетт нойроос бүрэн сэрж харвал Жан Вальжан инээд алдан сууна.

-О, тийм шүү дээ! Би өөр газар ирснээ мартчиж, Сайхан нойрсов уу ноёнтон минь! гэв.

Козетт хөлдөө байсан хүүхэлдэйг авч тоглох суухдаа мянга түмэн асуудал асууж байснаа: “Энд хичнээн сайхан чөлөөтэй юм бэ!” гээд

-Би энэ өрөөг шүүрдэх үү? Гэж асуусанд Жан Вальжан

-Тогло хүү минь тогло! Гэв.

Бүтэн өдөр турш Козетт хүүхэлдэйгээ барин өвгөний дэргэд тоглож суухдаа хэлэхийн аргагүй жаргалтай байж.

II

### **ЗОВЛОНТ ХОЁР УЧРАХАД ЖАРГАЛТАЙ**

Дараа өдөр үүр цайхад Жан Вальжан, Козеттын орны өмнө амьсгаа хураан зогсож сэрэхийг хүлээн байна.

Хэзээ хэнд ч дурлаж яваагүй Жан Вальжаны сэтгэл санаанд ороогүй зүйл нэвтрэн орж. Хорин таван жил ертөнц дээр ганцаар амьдарч явсан Жан Вальжан сэтгэлтэй бол хүнтэй ханилан сууж үр хүүхэд төрүүлж явсан удаагүй.

Захирагч лам Жан Вальжаны сэтгэлд сайн хүний шинж төрүүлсэн бол Козетт охЁн хайр дурлалын гэгээг төрүүлсэн байна...

Жан Вальжан, Козетт хоёр нарт ертөнц дээр хагас зуны зөрөөтэй төрсөн авч насаар огт адилгүй, амссан зовлонгоороо яг адил тэр хоёрыг байгаль дэлхий холбожээ. Энэ хёорын амьдрал али алинда нэмэр тус болов. Козетт эцэг хайж, Жан Вальжан үр хайж яваад зовлонг хоёр гэнэтийн учралаар уулзаж халуун гараа атгалцан хамаг сэтгэлээ ойлгож салшгүй холбоотой болжээ.

Зайдуу газар толгой хоргодох орон олсон Жан Вальжан Козетт хоёр өдөр хоногийг жаргалтай өнгөрөөсөөр. Жан Вальжан байр хөлслөн авахдаа зургаан сарын хөлсийг урьдчилан төлөөд гэрийн эзэн эмгэнийг зарцаар авчээ.

Ингэж амьдарч суухдаа Жан Вальжан Козеттыг бичиг үсэгт сургаж эхэлсэн байна.

### III

## СЭЖИГЛЭЛД ОРСОН НЬ

Жан Вальжан болгоомжлоод өдрийн цагаар гэрээсээ гардаггүй, харин орой болгон ихэнхдээ Козеттой хоёул, заримдаа ганцаараа бүрэнхийгээр цэцэрлэг дотуур хүнгүй газраар зугаална. Ойр хавийн сүм дуганаар орно. Хэрэв Козетт гэртээ үлдвэл түүнийг зарц эмгэн харна. Жан Вальжан Козеттой хамт явахдаа гараас нь хөтөлж эелдэг зөөлнөөр ярилцана.

Козетт туйлын хөгжилтэй охин мэт аж.

Зарц эмгэн хоол унд хийж хоршоо худалдаагаар явна.

Жан Вальжаныг гудамжинд харсан хүн түүнийг ядуу хоосон амьтан байна гэж санана. Зовлон амссан наст эмгэнүүд өрөвдөхдөө мөнгө хайрлахад Жан Вальжан хүлээн аваад талархал илэрхийлэн нахилзана. Гуйлг гуйж суугаа ядуу хүн үзвэл Жан Вальжан өөрөө бас хэд гурван мөнгө өгөөд хүн харах магад гэж сэргийлэн хурдан холдоно. Энэ нь нутгийн хүмүүсийн сэтгэлд юм төрүүлжээ. Нутгийнхан “мөнгө хайрлаж явдаг гуйлгачин” хүн гэж Жан Вальжаныг нэрлэх болов...

Шинэ сууцанд шилжин ирсэн Жан Вальжан хэд хоносны дараа дан хантаазтайгаа байшингийн гудамд мод хөрөөдөж байх үеэр зарц эмгэн гэрт ажил хийж байгаа Жан Вальжаны гадуур цамцны дотор бөөн мөнөг хийж шидсэн байхыг үзээд цамцны халаас болгонд дотор “гэнэтийн аюулд” хэрэглэхээр зориулан тоймгүй олон төрлийн мөнгө цаас хийснийг бас мэдэв...

Ингэж амьдарсаар тэд өвлийн адаг сар хүргэв. Сен-Медар сүмийн дэргэдэх худгийн хажууд дандаа сууж байдаг гуйлгачинд Жан Вальжан сэтгэл харамгүй мөнгө өгдөг байж. Тэр хүнд мөнгө өгөхгүй өнгөрдөг удаа тун цөөн. Заримдаа зэрэгцэн суугаад ярьж хөөрдөг ч байж....

Нэг орой Жан Вальжан ганцаар явж бйагаа вөнгөө гуйлгачнаа хараад ойртон очиж мөнгө өгсөнд гуйлгачин Жан Вальжанг эгц ширтээд доошоо харав. Гэнэт аягүй харахыг мэдсэн Жан Вальжаны дотор арзас гэжээ.

Тэр гуйлгачин хүн Жавер байсан бололтой ажээ.

Хэд хоносны дара оройн нйаман цагийн орчим Жан Вальжан Козеттоо ном зааж байтал гадаа хаалга онгойн хаагдахад сэжиг авч дуугаа хураав. Гаднаас ирсэн хүнээс зэвүүсэн Жан Вальжан шөнөжингөө унтаж ядан байж үүрээр зүүрмэглэтэл гудамд хаалга онгойход цочин сээв. Тэгтэл нэг эрэгтэй хүний хөийн чимээ гарав. Жан Вальжан босон харайж хаалганы завсраар харвал хувцастай, сугандаа таяг тулсан Жавер үзэгдэв.

Өглөөний долоон цаг эмгэн ирж тасалгаа цвээрлэхэд Жан Вальжан:

-Шинэ гийчинтэй болоо юу? гэхэд

-Тиймээ гэв.

-Нэр нь хэн гэдэг юу бэ? гэхэд

-Дюмон гэл үү, Домон гэлүү тэр хавилдуу нэртэй юм байж билээ гэжээ.

Орой бүрий болоход ойр хавийг ажин харахад нэг ч хүн байсангүй болохоор Жан Вальжан гэртээ ороод баглаатай юмаа авч:

-Козеттоо явъя! Гээд гараас нь хөтлөн гарч одов.

## **ТАВДУГААР ДЭВТЭР**

### **ХАРАНХУЙ**

### **ШӨНӨӨР**

### **ХАВЧИГДАН**

### **МӨРДӨГДСӨН НЬ**

I

## **БУРУУЛАН ЯВСАН НЬ**

Байсан газраасаа холдон багсгар цэцэрлгээс гарсан Жан Вальжан жаахан Козеттоо дагуулан урагшлан явж байснаа замаас гэнэт хажуу тийш гарч шархадсан гахай шиг отон зогсож хавь ойроо ажин ширтээд хойноос дагасан амьтан алга болохоор алсыг чиглэн алхаж үүрээ зөгнөсөн араатан адил хоргодох газрыг хайж явна.

Шөнийн арван нэгэн цагийн хонх жингэнэх үеэр 14-р байшинд байсан цагдан сэргийлэх газрын дэргэдүүр Понтуаз гудамжийг огтлон гараад сэжиг төрж эргэн харвал гурван эрэгтэй хүн мөрдөн айсуу.

Жан Вальжан Козетт хоёр ачаатай тэрэгний сүүдэр талд давхарлан нуугдаж Аустерлизийн гүүрийг ажиггүй туулав.

Сартай саруул шөнө дунд Жавераар толгойлуулсан хэсэг цагдаа тэдний хойноос мөрдсөөр явна. Түүнийг ажин х арсан Жан Вальжан нэг жижиг гудамжаар орон явж байтал тэр гудам “У” адил хоёр салав. Жан Вальжан гудамны баруун салааг барьж хүн цөөнтэй газрыг чиглэв.

Козеттын хөлж эцэж түргэн явж чадахаа болиход өвгөн тэврэн явав. Козетт үг дуугарсангүй биед нь улам наалдан явна. Нхилээд явсны хойно эргэн харахад ар талын гудамжны гүнд юм сүүдэгнэн хөдөлж байв.

Жан Вальжан хурдлан харайсаар Сент-Антуаны орчмын “Жижиг Пинпос” гудамж хүрэв: Тэндээс цааш явах гэтэл өмнө нь ямар нэг хүн сүүдэгнэн бйв.

Өмнө хойно нь алсад сүүдэгнэн байгаа хүмүүс Жаверын даргалсан цагда нар мөн бололтой. Лавлан бодоход цагдаа тэр хавийн газрыг нэгд нэггүй мэддэг

шинжтэй. Сандарсан Жан Вальжан урагш хойшоо хараад учраа олж ядахдаа дээшээ тэнгэр ширтэнэ...

Жан Вальжан бурхан шиг мэргэн бодолтой, хоригдол хүний аюулт авъяастай. Тухайн байдалд тохируулан хоёулан ээлжлэн ажиглана.

Тулгоны шоронгоос олон удаа оргон зугтаж явахдаа элгэн хад шиг эгц ханыг ямар ч тулгуургүй зөвхөн булчин махбодын хүчээр давж байжээ. Жан Вальжан ямар ч шатгүйгээр зөвхөн биеийн хүчээр байшингийн зургаан давхарт ч хүрч чаддаг байж. Эв эгц хана өөд авирахдаа дагж, мөр, хөл, гуя хумс аль байдгаа ашиглан мацахдаа гарахгүй давахгүй газар байсангүй.

Хүнд байдалд тулгарсан Жан Вальжан арван хэдэн метр өндөр хажуугийн ханыг давахаар шийджээ.

Гэтэл Козеттыг яах вэ? Козетт хана өөд авирах чадалгүй билээ нуруундаа үүрээд давах уу? Гэтэл хүүхэд үүрээд авирах нөхцөл ер байсангүй. Өрөө түрүүлж авирч гараад дараа нь хүүхдийг араасаа татан гаргая гэтэл оосорлон татах дээс байсангүй. Дээстэй бол аргалж болох санж. Харанхуй шөнө танихгүй газар Жан Вальжан хаанаас дээс олох билээ? Энэ үед Жан Вальжан бүхэл бүтэн вант улын эзэн байсансан бол улс гүрнээ урт дээснээс өхсөн байлаа. Олс дээс ч үгүй улс гүрэн ч үгүй Жан Вальжаны нүдний харц Жанро гэдэг мухар гудамжинд байгаа дүүжлээстэй дэн чиглэв.

Тэр үеийн Парис хотод нэг нэгнээсээ холгүй зайтай дэн олон байсан аж.

Жан Вальжан нүд ирмэх зуурын түргэнд гэнэт үсрэн дүүжлээстэй байсан дэнгийн дэргэд хүрээд дээсий нь тас огтлон аваад гэдрэг Козетт дээр үсрэн ирэв.

Хүнгүй газар шөнө дунд харанхуй дотор ирсэн Козетт, Жан Вальжаны үл ойлгогдох олон янзын байдалд орсон Козеттоос өөр хүүхэд аль эрт уйлж суумаар болжээ. Гэтэл Козетт эцгийнхээ хормойноос чангаах төдийгөөр хязгаарлана.

Ойртон яваа шөнийн эргүүлийн хөлийн чимээ улам тод дуулдана.

Козетт аяархнаар:

-Аав аа би айж байна хэн ирж яваа юм бэ? гэхэд эцэг нь:

Дуугуй бай! Тенардые ирж явна. Чи орилж уйлбал Тенардые авгай ирээд чамайг аваад явчина шүү. Чимээгүй суу. Над бүү саад хий! Гэв.

Жан Вальжан хүзүүнийхээ ороолтыг авч Козеттын бүсэлдгээр ороолгоод ав ирсэн олсныхоо нэг үзүүртэй залгаж нөгөө үзүүрийг шүдээрээ зуугаад өмд гутлаа тайчин хана дээгүүр давуулан шидээд өөрөө огт ажиггүй авирсаар хана дээр гарч хойноосоо Козеттыг татан гаргав.

Энэ үеэр Жавер дарга цэргээ дагуулан ирээд:

-Мухар гудамжийг нэгж! Бусад Пикюс ба шулуун гудамж руу эргүүл явуулсан.

Тэр, энэ мухраас хаашаа ч гарахгүй баригдана! Гэхэд цэргүүд пижигнэлдэн гүйлдэж байв.

Жан Вальжан Козеттоо тэрэн цааш бууж өмд гутлаа олж өмсөв. Шөнийн хүйтэнд даарсан Козетт дугжирч эхлэв. Жан Вальжан гадуур цамцаараа Козеттыг хучин сараалжин дотор хэвтүүлээд орчныг ажвал цэцэрлэгээс өөр хэн ч үгүй мэт. Гэнэт аялан дуулах чимээ сонсдоод чимээ тасрав.

Козеттыг чагнасанд амьсгаа хураасан мэт байв. Жан Вальжан ихэд сандарч ямар ч гэсэн дулаан байр олж оруулъя гэж шийдээд харанхуй цэцэрлэгийг уруудан гүйж явтал хонх жингэнэх шиг болж. Сайн жиж харсанд хөлдөө хонх уясан хүн айсуу. Жан Вальжан өөрөө уудалж мөнгө блэтгээд гэнэт тэр хүний дэргэд үсрэн очиж:

-Май зуун франк ав! гэхэд цаад хүн цочин сандарч гайхан харна.

-Та зуун франк аваад намайг ганцхан шөнө дулаан хонуулаач гэж, Жан Вальжаны нүүр сарны туяанд тод гэрэлтэнэ. Цаад хүн:

-Хүүш! Мадлен гуай байх чинь вэ! Та тэнгэрээс унаа юу? Яаж энд ирээ вэ? Та хаагуур орж ирсэн бэ? гэсэнд

Жан Вальжан:

-Та хэн бэ? гэв

-Та намайг танихаа байгаа юу. Таны энд ажилд оруулсан хүн чинь байна гэхэд Жан Вальжан сая өвгөн Фошлеван мөнийг танив.

Энэ өвгөн тэргэнд даруулаад байхад Жан Вальжан амий нь авраад Парис руу цэцэрлэгийн ажилд оруулахаар явуулсныг уншигчид мартаагүй биз ээ.

## II

### БАЙРТАЙ БОЛОВ

Жан Вальжан:

-Танаас дүүжлээстэй юун хонх юм бэ? гэхэд Фошцлеван:

-Энэ үү? Надаас зугтаж байхын тулд байгаа юм гэв.

-Юунд зугтах юм бэ?

-Энэ байшинд дандаа эмэгтэйчүүд судаг, залуу охидууд оло нбий. Тэд надтай уулзвал аюулд орно. Би ирж байгаагаа мэдэгдэхийн тулд хонхтой явдаг. Энэ хонхны чимээгээр тэд зайлан явдаг.

-Энэ юун байшин бэ?

-Жижиг Пикюсын сүм.

-Та хаанаас хэрхэн яаж орж ирсэн бэ? Энэ рүү эрэгтэй хүн оруулдаггүй юм.

-Та яагаад энд суудаг юм бэ?

-Ганцхан намайг энд суухыг зөвшөөрсөн юм.

-Бм энд үлдэлгүй болохгүй шүү гэж Жан Вальжан хэлээд:

-Та байртай юу гэв.

-Миний байр, тэр нурж унасан сүмийн цаана байна. Миний байшин гурван өрөөтэй, таныг тэнд оруулж амий чинь аваръя.

-Зүйтэй. Та миний хоёр хүсэлтийг биелүүлж өгнө үү. Нэгд, миний тухай хэд ч бүү хэлээрэй. Хоёрт, мини тухай олон юм мэдэхийг бүү оролд гэж Жан Вальжан хэлэхэд Фошлеван зөвшөөрч хоёул Козеттг аваад байшинд оров.

### ЗУРГАДУГААР ДЭВТЭР

## ХҮҮРИЙН ГАЗАР ОЛДСОН БҮХНИЙГ ЗАЛГИДАГ

### I

#### ГАРАХ АРГА СҮВЭГЧИЛСЭН НЬ

Козеттыг байшинд оруулж унтуулаад Жан Вальжн Фошлеван хоёр д арс ууж жаахан ярилцаж суугаад унтав. Жан Вальжан орондоо ороод: “Би энд бйанга үлдэх

ёстой юм” гэж энэ үг Фошлеваны толгойд шөнөжин эргэлдэж хонов. Фошлеван үүрээр сэрээд:

-Козетт та хоёр эндээс толгой цухуйлгаж хэрхэвч болохгүй. Хэрэв хүнд үзэгдэх юм бол хэрэг буруудах нь тэр гэв.

-Зүйтэй. Энд байнга байх ямар арга байна вэ?

Өвгөн Фошлеван хариулах гэтэл хонх дуугарав. Фошлеван:

-Эмэгтэй лам нас барсан байна. Намайг дуудаж байна гээд хонхоо зүүсээр гарч одов.

Фошлеван гэлдэрсээр сүмд ортол ахлагч дар эх угтан аваад...

-Гэгээн дар эх бурхан боллоо. Би дархийг энд сүмийнхээ ёроолд оршуулах ёстой. Гэтэл дүрэм ёсоор заавал авсанд хийж гадагш гарган хүүрийг газар оршуулах хэрэгтэй юм. Өвгөн Фошлеван та таалал төгссөн Дархийг энд оршуулж ажил гүйцэтгэ. үүнийг маш нууц хийх хэрэгтэй. Эндээс заавал авс гаргж хүүрийн газар аваачих хэрэг гарна. Бид авс бэлтгэе. Та авсанд ямар нэг зүйл хийж дотроо юмтай шиг болгон бэлэн бэлтгээд гадагш гарга? Гэв.

Фошлеван энэ бүхнийг хүлээн аваад дараа нь:

-Би нас хөгширлөө. Тэнхээ чадал муутай болж ганцараа бүх ажлыг хийж чадахаа байх нь ээ. Би нэг ахтай. Ах мань жижиг охинтой. Ахыгаа туслагч цэвэрлэгчээр авах хүсэлтэй. Охины нь сүмд оруулж хүмүүжүүлэе. Миний гачигдлыг болгоож, хүсэлтийг хангаж хайрлана уу? гэж мөргөв.

Дархи, өвгөний үгийг сонсож:

-Маргааш хүүр оршуулсны дараа ахыгаа онитой нь хамт авч ирээрэй гэв...

Фошлеван буцаж ирээд:

-Бүтэл муутайхан байна. Маргааш та хоёрыг авч ирэхийг зөвшөөрлөө. Та нарыг тэнд аваачихын өмнө эндээс заавал урьдаар гарах хэрэг тулгарлаа. Эндээс гарна гэдэг хүн тун бэрх байна. Жаал охиныг гаргахад хэцүү юм алга. Козеттыг би жийрэгтэй арагт хийгээд үүрэн гарахад онцын сжиг төрөхгүй байх. Жан Вальжан таныг эндээс гаргах арга тун алгаа. Та энд орж ирсэн газраараа буцаж гарах арга олохгүй юу? гэхэд Жан Вальжан:

Ирсэн газраараа буцах ямар ч нөхцөл алгаа гэжээ.

Фошлеван, таалал төгссөн Дархийг сүмийн дэргэд оршуулаад гадагш нь хоосон авс гаргаж хүүрийн газар аваачиж булах хэрэг тохиолдлоо гэж хэлэхийг сонссон Жан Вальжан:

-Хоосон авс гэв үү? Гэхэд

-Тиймээ хоосон авс гаргах болоод байна. Тэр авсанд ямар нэг зүйлийг хийж гаргах үүргийг надад өгсөн юм гэтэл Жан Вальжан:

-Авсыг та өөрөө бөглөж хадах уу?

-Тэгнэ. Би хадна.

-Би тэр авсанд чинь оръё.

-Та бүтэж үхнэ байх аа. Гадуур нь бүрээд хадах юм шүү.

-Та намайг дотор нь оруулаад хадахдаа миний амны ойролцоо агаар орох жижиг нүх гаргаж үз. Би ч тэвчихийн ихээр тэвчье гэж Жан Вальжан хэлэхэд, Фошлеван:

-Та ханиах, найтаах бол яах вэ? гэв.

-Амь гарахаар оргож яваа хүн ханиах, найтаахгүй явах тэвчээртэй байдаг юм...

Олон жил харанхуй гянданд сууж, оргон зугтаж явахдаа хэрэгцээт цагт ханиахгүй, найтаахгүй өнгөрөөх хатуужил олж, багтахгүй саванд багтаж, гар хгүй газраар гарч чаддаг болсон Жан Вальжан авсанд орохыг юман төдий бодсонгүй.

## II

### ДӨРВӨН БАНЗНЫ ХООРОНД

Аргагүй бйдалд орж уймарч байсан Фошлеван:

-ТэхэSc өөр арга алга шив ээ гэхэд Жан Вальжан:

-ХүүрЁйн газар очоод авснаас амьд гарах арга байна уу? юу юугүй шороогоор булаад хаячихвал би чинь амьсгалах газаргүй болж бүтэж үхнэ шүү дээ гэхэд Фошлевн:

-Та авснаас мь гарна гэж итгэж байхад, би таныг нүхнээс суга татна гэдэгт эргэлзэхгүй. Тэндхийн хүүр булагч өвгөн Метъентэй би сайн танил Метъен гуай архичин хүн. Жаахан архи балгуулчаад: "За та явж амар даа. Би таны өмнөөс хүүр булчаад харъя" гэхэд өвгөн яваах өх болно. Явсан хойгуур нь би таныг нүхэн доторхи авснаас татан гаргана гэхэд Жан Вальжан:

-Тохирлоо. Санаа зовох юмгүй. Цөм ёсоор бүтнэ Фошлеван гуай гээд гээд гары нь чанга атгав.

Маргааш өдөр нь хүүр оршуулах газрын зүг бөөн цуваа хөдөлж ядан явахыг харсан хүмүүс малгайгаа авч гашуудан өнгөрөөж байлаа. Гашуудлын цувааны ард өвгөн Фошлеван явжээ. Гашуудлын цуваа явсаар хүүрийн газрын шороонд тулан зогсоход үл таних хүн оршуулах зөвшөөрөл үзэж байж.

Фошлеан тэр хүнээс:

-Та ямар ажилтай хүн бэ? гэхэд

-Би хүүр булагч гэжээ.

-Хүүр булагч аа?

-Тийм ээ.

-Та юу?

-Мөн би.

-Метъен хүүр булагч байсан биш үү.

-Байсан.

-Хаачсан бэ?

-Үхсэн. Оронд нь би хүүр булагчаар орсон. Миний нэр Гривье гэдэг.

Фошлеван арга барагдахад:

-Хоёул яваад жаахан архи балгая. Гашуудалтай үед зүрх чангардаг юм гэхэд Гривье:

-Би боловсролтой хүн, хэзээ ч архи уухгүй. Аргагүй уухад хүрвэл хүүр булсны дараа ууна гээд огт халгаасангүй.

Энэ мэтээр ярилцан явсаар байтал гашуудлын цуваа нүхний дэргэд очин зогссонд Дархийн хойдхыг лам нар уншаад авсны нүх рүү аяа<sup>o</sup>хан хийжээ.

Хүүр булагч хүрзээ авч шороо хаяхаар бэлдэн байв. Хэрэ хэдэн хүрз шороо хаявал авсны нүх хаагдаж Жан Вальжаны амьсг а хаагадахд тулгарсан байлаа.

Энэ байдлыг аргацаах гэсэн Фошлеван:

-Хамт архи дарс уухгүй болохоор олигтой танилцсан ч болдоггүй юм. Сэтгэлийн бодлыг шилтэй архиар тайлдаг юм. За хоёул жаахан балгая. Эр хүн юунаас ухардаг юм бэ? гэхэд Гривье:

-Би долоон хүүхэдтэй. Долоон хүүхдээ хоолтой байлгая гэвэл би архи уухгүй явах ёстой. Тэдний өлсгөлөн миний хүслийн дайсан гээд шороо хүрэдэн хаяв. Гривье гурав дахь хүрз шороо хаяад:

-Өнөө шөнө хүйтэн болох нь ээ. Талийгаач хучлага муутай бол биднийг дуудах болно гэв.

Энэ үеэр Фошлеван хүүр булагчин халаасанд байсан цагаан юмыг сэм суйлан авав.

Хүүр булагч дөрөвдөх хүрз шороо хаяад тавдахаа хүрздэтэл Фошлеван:

-Хүүш! Нэвтрэх бичгээ авч ирсэн үү? Удахгүй нар жаргаж хашааны халга хаагдах нь байна. Нэвтрэх бичиггүй бол хаалгаар гарахгүй болно шүү гэхэд Гривье тэмтэрч үзээд:

-Надад нэвтрэх бичиг алга, байх нь ч байгаа юмсан. Би гэртээ мартаа юм уу даа гэхэд Фошлеван:

-Нэвтрэх бичиггүй бол арван таван франкаар торгуулах чинь тэр ээ! гэв.

Арван таван франкаа° торгуулна гэдэг үг сонссон Гривье айхдаа хүрзээ газар алдав. Энэ байдлыг ашигласан Фошлеван:

-Одоохон гүйгээд нэвтрэх бичгээ аяаад ир. Нэвтрэхтэйгээ бол торгууль төлөхгүй шүү дээ, бушуу гүй гэхэд Гривье:

-Ачийг мартажгүй гээд гүйж одов.

Фошлеван, Жан Вальжаныг авсанд хийж хадсаны дараа авсыг дамжлан явсаар тэргэнд тавиад хүүрийн газар авч ирсэн буян ном айлдаад нүх рүү хийх зэргийг нэг үед мэдсэн боловч нөгөө үе амьсгаа давхцан мансуурч явжээ. Гэнэт их чимээ гарч анхны хүрз шороо хаяхад Жан Вальжаны амьсгаа авч байсан нүх бөглөрчээ. Дөрөвдөх хүрз шороо хаясны дараа Жан Вальжан ухаан алджээ.

Хүүр булагч Гривье гүйж чимээ тасармагц Фошлеман: авсан дээрээс бөхийж аяархнаар:

-Мадлен гуай! Гэв.

Ямар ч хариу дуугарсангүй.

Фошлеван улам сандарч авсны дээр унаад:

-Та энд байна уу? гэв

Авсны дотор таг чимээгүй.

Нүд орой дээрэ гарч амьсгаа дахацсан Фошлеван авсны дээд тагийг онгойлготол Жан Вальжаны нүд аниастай цав цагаан нүүр гарч иржээ. Фошлеван дөнгөж сонсдохоор:

-Үхжээ! Гээд зангидсан гараа цээжиндээ зөрүүлэн:

-Амий нь би мөн аварваа! Гэж хашгирав.

Фошлеван ганцаараа:

-Метьен байгаагүйгээс боллоо. Хүн амийн хэрэг гарлаа. Нөгөө жаал охины нь би яах вэ? Аваачиж орхисон айл юу гэх болоо? Хүний сайн нь ингэж амархан үхдэг байж. Өөрөө энэ сүмд ямар лайгаараа орж ирсэн хүн бэ? Одоо яана аа? гээд үсээ үгтээж сууна.

Хүүр оршуулах газрын хаалга хаагдах чимээ тэртээ модны цаанаас сонсогдоно.

Жан Вальжаны дээрээс бөхийсөн Фошлеван гэнэт босон харайж ар тийшээ болов. Жан Вальжаны нүд нээгдээд өвгөнийг ширтэж байж.

Үхлийг үзэхэд аягүй байдгийн адилаар сэхээрэлтийг харахад мөн аягүй шиг байдаг. Зүрх уушиг амаараа гар х шахсан Фошлеван, Жан Вальжаныг үхсэн амьдыг ойлгож ядан хувхай царайлан зогсоно. Өвгөнийг харж байсан Жан Вальжан:

-Би унтжээ гээд өндийхөд Фошлеван сөгдөн сууж:

-Дархи минь! Би мөн ч айлаа даа! гээд босож:

-Баярлалаа Мадлен гуай минь гэв.

Ухаа алдаад мансуурч байсан Жан Вальжан эрүүл цэвэр агаар амьсгалаад ухаан орсон нь тэр санж...

Жан Вальжан авснаас гарч Фошлеваны өгсөн архинаас балгаж хүч аваад онгойлгосон авсаа дахин хадаж булаад гурван минутын дараа нүхийг булж дуусгаад хүүр оршуулах газраас ажиггүй мултран гарав. Буцаж явах замдаа Фошлеван өвгөн хүүр булагч Гривьегийн нэвтрэх бичгийг хүүр оршуулах газрын манааичд олж орхисноо мэдэгдээд Козеттоо авч Жан Вальжан гурвуул эмэгтэй лам нараар дүүрсэн сүм рүү гэдрэг оржээ...

Авсанд орж амь тавихаа шахж явсан Жан Вальжан Фошлеваны туслах цэцэрлэгч болж хөлдөө хонх зүүн хоржигнуулан явах боллоо. Козетт охин сүмд орж хүмүүжин өссөөр байлаа. Козетт охин өсөн торниж ухаан суух бүр Жан Вальжаны жаргал улам нэмэгдсээр, он жил дараалан өнгөрсөөр байхад охин Козетт өсөн томорсоор л байлаа.

## **ГУРАВДУГААР ХЭСЭГ**

# **МАРИУС**

## **НЭГДҮГЭЭР ДЭВТЭР**

## **ПАРИСЫГ ШИРХЭГЧЛЭН СУДАЛСАН НЬ**

I

### **ХҮҮХЭД**

Ой мод шувуугаар дүүрэн шиг өнчин хүүхдүүд Парисаар элбэг ойн шувуу болжмор нэртэй байдаг, өнчин хүүхдүүд гамен нэртэй болдог...

Гамен дандаа галтай цогтой, баяр баясгалантай. Өдөр бүр өлөн ходоодоо хоолоор дүүргэдэггүй боловч орой болгон хүссэн үедээ цэнгэлдэх хүрээлэнд ордог Гамены ганц биед өмссөн цамц, угласан гутал байггүй, ороод унтах орон байр ч олддоггүй. Эд бүхнийг хэрэглэдгүй элэн халин хөөрөх жигүүртэн гамен хоёр адил. Гаменууд долоогоос арван гурван нас хүртлээ үргэлж бөөгнөрөн явж, гадаа гудамжинд унтаж хонож, эцэг хүний өмд өмсөж, газар чирч, эс таин хүний хуучин том малгай шалхайлган тавьж хоёр чих нь үзэгдэхгүй явна. Гамен үргэлж гүйн харайж, юм хайн, гэтэн шанай, хийсэн ажилгүй ганс зууж, газар дэлхий эргэтэл хараан, архины газар хэсүүчилж, элдэв олиггүй хулгайч нартай аавын цээж гарган ярилцаж, шалиг завхай

дуу хангинатал хадааж явдаг юм. Өчүүхэн бие, өмссөн хувцас, үг яриа нь чамин боловч сэтгэл зүрхээр ариун цэвэр гэнэн цагаан. Гамены сэтгэл санаа гэмгүй ариун сувд шиг. Ариун сувдыг шавхйа ру хийвч мууддаггүйтэй адил гамены санаа элдэвт автагдж эвдэрдэггүй нь сайхан.

Том хотоос: “Энэ чинь юу вэ?” гэж асуувал: “Миний хүүхдүүд” гэж хариулах болно.

## II

### ЗАРИМ НЭГ ОНЦГОЙ ШИНЖҮҮД

Парисын гаменийг хоттой нь зүйрлүүлбэл хааны хажуудах хулганатай адил. Гамен заримдаа цамцтай явдаг, лавлан үзвэл тэр нь ганцхан ширхэг байдаг, заримдаа шаахайтай харагддаг, сайн ажиглавал өсгий нь уначсан явдаг. Эх шигээ тустай гэгр орон байсан ч эрх чөлөө элбэгтэй гудамжинд явах нь сайхан санагддаг. Гамен өөртөө тохирсон тоглоом наадамтай. Тоглож наадаж явахдаа ч хүртэл хөрөнгөтөнг үзэн ядаж бйдаг. Хүчит борооны үед хүнд тусламж үзүүлж нэг гудамжнаас нөгөө гудамж хүртэл зам зааж өгөөд хөлс шан авдаг. Албаны хүн францын ард түмний ашиг сонирхолд зориулан хэлсэн үгний утгыг давтан хашгирч, газар шагайж олз ашиг хайж явдаг... Гамен үг хэлээрээ Талейрнаас дутуугүй. Гэнэт инээдэмт юм үзүүлж хүнийг инээлгэх чадалтай. Гашуудлын цуваа явж байвал түүний хойноос дагадаг. Нас барсан хүний дэргэд доктор явж байхыг гамен хараад: “Хэзээнээс эхэлж ингэж бүтээсэн ажлаа эмч доктор өөрөө ава д явж байх болоо вэ?” гэж хашгирдаг.

Нөгөө нэг нь олны дотор шөвөгдөн ороход нүдэндээ шилтэй том эрэгтэй хүн:

-Хогоо! Чи юунд манай авгайн “бөгс тэвэрдэг” болоо вэ? гэж уурлхад гамен:

-Хаанаас даа ноёнтон минь! Та муу юм санаад байвал намайг нэгжээд үз л дээ гэнэ.

## III

### ТҮҮХЭЭС ДУРДЪЯ

Энэ номд дурдсан хэргүүд гарч байх үед гудамж бүрийн адагт одоотой адил цагдаа нар байсангүй. Тэр үед Парисаар жижиг тэнэмэл хүүхдээр дүүрэн байв. Тоо бүртгэлээс үзэхэд эзгүй газар, баригдаж байгаа байшин, гүүрүүдийн дороос хоёр зуун жар орчим гэр оронгүй хүүхдүүд жил бүр баригдаж байжээ. Энэ нь нийгэмлэгийн хамгийн хүнд өвчнүүдийн нэг юмаа. Бүх насанд хүрэгсдийн гэм тэхрэг тэнэмэл хүүхдүүдээс үүсдэг байна. Гэсэн ч Парисын гаменууд харахад муу олиггүй мэт боловч сэтгэл зүрхээрээ ариун цэвэр байдаг юм. Энэ манай ардын хувьсгалын үнэнч явдлуудын дунд гайхалтай тодордог юм. Тэнгисийн усны давс хэвээрээ байдаг адил Парисын дотор элдэв бохиросх амгаалах ямар нэг үл мэдэгдэх үзэл санаа оршдог. Парисын агаараар амьсг лсан хүн ариун сэтгэлтэй байдаг.

Энэ мэтээр магтан хэлэх боловч гэр оронгоос хагацсан өнчин хүүхдүүдийг харахад зүрх шимшрэн элсг эмтэрдэг. Одоо үед хүн ийм хөгжилтэй болсон байхад хоол идэх Ёлүү амнаас нэг хэдийг хороохоор өөрийн мах цусны тасархай үе залгамжлах үр хүүхдээ гудамжинд хаядаг явдал харамсалтай. Гэсэн ч энэ ердийн

явдал болсон болохоор “Парисын гудамжны хөвөөнд хаягдана” гэдэг тусгай өгүүлбэр хүртэл бий боллоо.

Ялдамд дурдвал, хүүхдийг ингэж хайр гамгүй хаядаг явдал эзэнт хуучин төрд огт хамаагүй байж. Нийгэмлэгийн доод давхарт ажилгүй дэмий тэнэж явагчид дээд давхаргааны эрх ямбатанд ашигтай. Энгийн ардын хүүхдийн дунд эрдэм ном дэлгэрүүлбэл хор болно гэдэг үзлийг яг баримтлах болов. “Бүдүүлэг юм” бидэнд хэрэггүй гэдэг явдал шаардагдав.

Тэнэмэл хүүхдүүд байгаа цагт бүдүүлэг танхай хүүхдүүд гарах нь дамжиггүй.

Эрх ямбат харгис төрд хүүхэд хэрэглэх цаг болход гудамж цэвэрлэдэг байв.

XIY Луйн үед эзэн вангийн зарлигаар тусгай усан онгоцны газар байгуулж, сүм дуганы мөргөл ёслолын үед малгай авч ёслоогүй хүнийг баривчлан авч онгоцны газар луу явуулдаг байв. Гэр оронгү арван тав хүрсэн хүүхдийг мөн барин авч усан онгоц дээр ажил хийлгэхээр явуулдаг болов.

XV Луй хааны үед Парист хүүхдүүд алга болох явдал үзэгдэв. Цагдан сэргийлэх газрын цагдаа нар үл ойлгогдох зорилгор хүүхдийг хулгайлан авч байлаа. Хүүхэд дутах үед цагдаа нар эх эцэгтэй хүүхдийг ч хүртэл булаан авдаг болсон байна. Хүүхдийг нь баривчлан авч байхыг харсан эцэг цагдаа нарт эсэргүцэл үзүүлж хүүгээ өмөөрөхөд хэрэг буруутдаг боллоо. TSp үед засгийн газар энэ хэрэгт оролцож дүүжлэн лах ял заадаг байлаа. Дүүжлэн алах ялыг хэнд ногдуулдаг байсан бэ? Цагдаа нарт уу? Үгүй! Дүүжлэн алах ялыг эцэг хүнд ноогдуулдаг байлаа.

## IV

### ГАМЕНУУДЫН ЯВЦУУ ДЭГЛЭМ

Парисын гаменууд явцуу дэглэмтэй. Гаменуудын тоонд гадны хэн нэг хүн ордог ч юм биш.

“Гамен” гэдэг үг анх 1834 онд ардын ярианаас бичгийн хэлэнд шилжин хэвлэд гарсан юм. “Клод Го” гэдэг өгүүллэгт анх удаа гарсан байна. Энэ үг хэвлэд гарахын х амт бөөн шуугиан дэгдээд гамен гэдэг үг суурьшил олов.

Гаменууд нэг нэгийнгээ хүндэтгэн үзэж хайрлах шалтгаан үндэс маш олон янз. Парисын сүм дуганы орой дээрээс хүн унахыг үзсэн гамен нөхдийнхөө дунд их нэртэй болсон удаатай. Хүн ордоггүй газраар орж элдэв баримал хөшөөг үзсэн гамен мөн их хүндтэй болж Хөмрөн унасан тэрэг үзсэн гамен бусдын хайр хүлээжээ. Хөрөнгөтөн хүний нүдийг сохлох шахсах нэг цэрэг үзсэн гамен алдаршсан байна.

Үүнээс болж зарим гамен: “Зургадугаар давхраас хүн унахыг олон харж чадахгүй би яасан хувь заяагүй хүн бэ?” гэж гунихардаг байсан байна.

Гамен шашны асуудлын талаар ямар нэг зориг гаргадагтаа бас алдартай болдог. Эрх чөлөөт өргөн дэлгэр бодолто явах нь хамгийн чухлаа.

Хэрэтийг алахад очих нь гамен бүхний үүрэг. Элдвийг харахаар яваа гаменд эгц хана, өндөр шорог мод саад тоотгор болдог байсан удаагүй.

Элдвийн гай зовлонг нүдээрээ үзсэн гамен их тустай. Зангидсан гарыг их тустай гэж үздэг байж. Би мөн хүчтэй дээ! гэж хэлэх их дуртай.

## V

### АРД ТҮМНИЙ ДУНД ИРЭЭДҮЙ ҮҮСДЭГ

Зуны цагаар гамен мэлхий болдог. Орой бүрэнхй болоход гаменууд ичих айхаа больж цагдаагийн дүрэм зөрчин Сень мөрөн рүү толгойгоороо үсрэн ордог. Гаменууд ламыг шоолон доромжилж элдвээр дүрсгүйдэгээс гадна Парисын цагдаа нэг бүрийг бүрэн төгс мэддэг учраас үзсэн газартаа нэрий нь хэлж чаддаг, хаана ямар нэртэй цагдаа харуулд зогсдогийг таван хуруу шигээ мэддэг санж...

Мольер, Бомарше нарын амьрал гаменыхтай адил явсан ж. Парисын гамен бусдын хайрыг булаадаг мөртөө элэгч доогч зэрлэгдүү зантай. Олиггүй хоол иддэг учраас шүд муутай, ходоод нь байн байн хоржигнож явдаг, ухаантай сэргэлэн нүдтэй, хутгаар тоглохдоо хөнгөн гавшгай авъяастай... Парисын гамен бол хуучин ертөнцийн гай зовлонг нүүрийнхээ үрчлээсэнд шингээсэн хүүхдүүд.

Гамен үндэсний чимэг боловч түүний зовлон зүдрэлийн илрэл. Энэ өвчин зовлонг эмлэн эдгээх хэрэгтэй байна. Юугаар эмчлэх юм бэ? гэвэл эрдэм номын сургаалаар эмчлэх хэрэгтэй.

Эрдэм ном хүнийг эдгээдэг

Эрдэм ном хүнийг эдгэрүүлдэг.

Нийгэмлэгийн харилцаанд айн нөлөөг үзүүлдэг цор ганц булаг бол шинжлэх ухаан, утга зохиол, урлаг гэгээрэл мөн. Хүмүүсийг цуцалтгүй хөгжүүлэх хэрэгтэй...

Парисын энгийн ардууд том болсон хойно гамен хэвээрээ байдаг. Парисын зах хязгаараар ардын амьдрал буцалж байдаг. Энд ариун цэвэр, үнэнч амьдрал байдаг. Эндхийн ардууд эцэхийг мэдэхгүй хөдөлмөр хийж энх жаргал үзэлгүй зовж явдаг.

Хөл нүцгэн, гар хоосон, бичиг үсэггүй, харанхуй бүдүүлэг, дарлагдсан ардуудын агуу их зорилгыг биелүүлэхэд чиглүүлж болох юмаа. Хэн ард түмний гүн рүү харж чадвал тэндээс ёстой үнэнийг үзэж чадна. Ард түмний дунд ирээдүг Үүтээх их хүн байдаг юм...

## VI

### ЖААХАН ГАВРОШ

Энэ зохиолын хоёрдугаар хэсэгт дурдсан явдлуудаас хойш найм буюу есөн жилийн дараа Пампль цэцэрлэг, Шатуд, районы хавьд арван нэг, арван хоёр настай хүүхэд олонтой тохиолддог байлаа. Энэ хүүхдийн гана байдал, дээр заасан гамены дүртэй яг тохирох санж. Энэ үл таних хүүхэд эмэгтэй хүний цамц, эрэгтэй хүний өмд өмсжээ. Гадны хүмүүс тэр хүүг уранхай цоорхой хувцсаар хувцаслажээ. Тэр хүүгий эцэг нь хүүгээ бодохгүй, эх нь хүүгээ хайрлахаа больсо нбайжээ. Тэр хүү эцэг эхтэй мөртөө өнчин ганцаар явдаг хүүхдийн тоонд багтдаг. Гудамжинд байх нь тэр хүүхдэд туйлын сайхан байдаг аж. Гудамжны хөвөө эхийн сэтгэлээс зөөлөн санагддаг байв.

Эцэг эх нь тэр хүүг амьдралын гүн рүү өшиглөн хөөжээ. Хүү юу ч хэлсэнгүй эцэг эхийн хатуу сэтгэлд захирагдсан байж.

Дуу чимээтэй, хөнгөн шаламгай хэрсүү энэ жаал хүүгийн нүүр нь цовоолог авч гашуудалтай маягтай. Энэ хүү хот дотуур тэнүүчилж онгорхой цоорхой юмыг чимхлэн хулгайлж, инээдэмт дууг аялан явдаг бйав. Амьдралын гүнд хаягдсан гэж хэлбэл байдгаараа баярлаж, тэнэмэл хүү гэвэл уурлаж уцаарлаж явдаг байлаа. Эд хөрөнгө, идэх хоол, хучих хөнжил, хайрлах хүнгүй энэ жаал хүү өөрийн эрхээр чөлөөтэй явдагтаа баяртай цэнгэлтэй.

Арчаагүй энэ амьтнууд том болоод өөрийн эрхгүй нийгэмлэгийн эргүүлэгт орж элдүүлдэг. Гэсэн ч тэд багадаа юм болгоноос мултарч чаддаг. Тэднийг хоргодуулах нүх мунддаггүй юм.

ХэдийгСэр энэ хүүхэд гудамжинд хаягдсан боловч сардаа нэг хоёр удаа “За явъя! Ээждээ очъё” гээд байсан газраасаа хөдөлдөг байв. Тэ° хүүхэд явсаар 50-52 дугаартай Горбогийн овоохойд очдог байлаа.

Энэ овоохойд Жа- Вальжн сууж байхад байсан эзэн эмгэн нас барж @ронд нь эмгэн Бюргон эзэн болжээ. Горбогийн олиггүй овоохой болсон байшинд сууж байгаа айлуудын дундаас эцэг, эх том болсон хоёр охиноос бүрдсэн нэг айл хамгийн ядуу амьдралтай байжээ. Тэд дөрвүүл дээврийн доорхи өчүүхэн тасалгаанд суудаг байв. Эзэн эрэгтэй хүн нь Жондрет гэдэг байлаа.

Гэрийн дотор ам бүл дөрвүүл энэ айл жаал хүүгийн гэр байжээ. Хүү гаднаас ороод ирэхэд халаах гал, инээх хүн тэр айлд байдаггүй байлаа. Уйтгар гуниг, өлсгөлөн гачигдалд автагдсан энэ айлынхан хүүг ороод ирэхэд:

-Чи хаанаас ирэв ээ? гэхэд хүү:

-Гудамжнаас ирлээ гэдэг байлаа.

Гараад явахад нь:

-Чи хаачих нь вэ? гэхэд хүү

-Гудамжинд гаръя гэж хариулдаг байв. Эх нь хүүгийнхээ хойноос:

-Чи юугаа хийж наашаа ирээд байдаг юм бэ? гэдэг байлаа.

Эх эцгийн хайр халамжаас хагацсан энэ хүү эзгүй хээрийн талд ургасан өнчин сонгино шиг болжээ. Гэсэн ч гутаж гуньсангүй, хэнийг ч буруушаасангүй. Тэр жаал хүү жинхэнэ эцэг эх чухам ямар байдгийг мэддэггүй явжээ.

Энэ хүүгийн эх нь охин хүүхдэдээ хайртай байжээ.

Энэ хүүг Тампль цэцэрлэгийн хавинхан жаахан гаврош гэдэг байжээ. Яагаад түүнийг Гаврош гэдэг байсан болоо? Мгаад эцэг нь Жондрет гэдэг нэртэй болохоор тэгж нэрлэсэн бизээ.

Жондретынхны суудаг өрөөний хажуугийн муу тасалгааг Мариус гэдэг нэг ядуу залуу эзэмшин суудаг байлаа.

Мариус чухам хэний хүү хэн гэгч болохыг ярьв.

## **ХОЁРДУГААР ДЭВТЭР**

# **ИХЭМСЭГ ХӨРӨНГӨТӨН**

I

## **ЕР НАСЛАВЧ ШҮД НЬ ХЭВЭЭРЭЭ ХҮН**

Бушера, Норманди, Сэ-тонаж гудамжны айлуудын настайчууд өвгөн Жильнорманыг мартаагүй дурсан суудаг.

Залуудаа олноос онц ялгарч яваагүй ноён Жильнорман 1831 онд их настайд болсон авч хөнгөн гавшгай хэвээрээ байгаагаараа олны анхаарлыг татсаар байж.

ХҮIII зууны олноос онцгой энэ ихэмсэг хөрөнгөтөн ерэн нас хүрчээд нуруугаар шулуун, дуугаар чанаг хэвээрээ байв. Хурц харатай Жильнорман архи ууж, цадталаа хоол идээд чих дүжиртэл хурхирч унтдаг байв. Жильнормны гучин хоёр шүд нэг нь ч

унаагүй хэвээр байж. Эмэгтэй хүнтэй ойртохоо байсаар арваад жил болж байна гэдэг байж... Жилдээ арван таван мянган ливрийн орлоготой Жильнорман өв хөрөнгө залгамжлан авч жилдээ зуун мянган франкийн орлоготой болж эхнэр олж гэрлэх хүсэлтэй байжээ.

Ийм учраас Жильнорманыг ердийн нэг наян настны тоонд оруулахад бас бэрхтэй. Жильнорман тавь илүү насалтлаа хүнтэй суугаагүй охинтой байж.

Жильнорман өөрийгөө ертөнцийн юм болгоныг мэддэг сод ухаантай хүн гэж магтдаг байв.

Жильнорман Марэ хороонд зургадугаар байшинд сууж байсан байна. Жильнорман хоёр дахин гэрлэсэн аж...

Жильнорман Бурбоныхныг туйлын хүндэтгэж 1789 оныг үзэн ядаж, тэр үед хичнээн их хүч гаргаж байж хар амиа аварснаа ярьдаг байсан ж. Ямар нэг залуу хүн түүний дэргэд бүгд найр мдах улсыг магтвал уур нь хүрч ухаан алдах шахдаг байж. Ерэн натаа санахдаа:

“Би ерэн гуравдугаар онтой хоёр дахь удаагаа учрахаа больсон байх гэж итгэдэг” гэдэг байж. Зуун нас наслах байх гэж гэрийнхэндээ бас хэлдэг байж.

Жильнорман эрэгтэй эмэгтэй хоёр зарцатай. Эрэгтэй зарцдаа Баск, эмэгтэй зарцдаа Николетт гэдэг нэр өгчээ.

Жильнорман гадаад байдлаар хээнцэр ганган харагдаж эмэгтэй хүний анхаарал татан зугаацаж явдаг байж. Тэгж зугаацсаны нь үр дүн заримдаа үзэгддэг болж.

Гэнэт нэг өдөр урьд нь тэднийд зарцлагдаж байгаад хөөгдсөн эхнэр, гарсан эрэгтэй хүүгээ Жильнорманд авч ирж өгөөд: “Энэ чиний хүү, наадхаа ав” гээд хаячаад явчсан байна. Жильнорман тэр хүүг хараад “Гайхах юу байх вэ? Есдүгээр Шарль вангийн хоноц хү ангулэм наян тавтайдаа арван тавтыг авгай болгон авч байсан удаа бий” гээд өлгийтэй хүүхдийг авч хүмүүжүүлэхээр шийджээ.

Хүүхдээ үлдээснэ тэр зарц эмэгтэйг Маньон гэдэг байж. Зарц агсан Маньон нэг жилийн дараа бс нэг хүү гаргаад авч ирэхэд Жильнорман Маньоны хоёр хүүг эхэд нь буцаан өгөөд тэдний тэтгэвэрт сар бүр наян франк байнга төлж байхаар амлажээ...

Жильнорман хоёр удаа эхнэр авч гэрлэсэн аж. Анхны эхнэрээс нэг охин гарад бүх насаараа эрийн бараа харалгүй амьдарсар байсан байна. Хоёр дахь эхнэрээс бас нэг охин гараад, Ватерлоогийн тулалдаанд хурандаа цолтой явсан цэргийн нэг даргатай сууж гучаад настайдаа үхжээ.

Амьд үлдсэн их охиныгоо “Жильнорманы их охин” гэж нэрлэжээ. Энэ их охин өөрийн зээ Теодюльтай их дотно байдаг байж. Энэ эмэгтэй гэрийн ажил хийж эцэгтээ тус хүргэн амьдарсаар байж.

Жильнорманыд их охиноос нь гачн нэг жижиг хүү байдаг байж.

Тэр хүү Жильнорманы зээ юмсанжээ. Энэ хүүгийн туха© дахин гарна.

## **ГУРАВДУГААР ДЭВТЭР**

### **ӨВӨГ ЭЦЭГ, ЗЭЭ ХОЁР**

I

#### **ЭРТНИЙ БАЯЧУУДЫН ЦУГЛАРДАГ ГАЗАР**

Сэрвандонгийн гудамжинд ноён Жильнорман амьдран сууж байхдаа баячуудын цуглардаг хэд хэдэн газрыг хэсүүчлэн явдаг байлаа. Хөрөнгөтөн гаралтай ноён Жильнорманы очсон газар бүр нь элэгсэг дотноор хүлээн авдаг байжээ.

1817 оны орчим Жильнорман долоо хоногт хоёр удаа айл саахалтын баян эмэгтэй Дө Т-гийн айлчилдаг байв. Дө Т-гийн нөхөр ХҮИ Луй хааны үед францаас Берлинд сууж байсан онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдын тушаалд дэвшин ажиллаж байжээ. Энэ айлд нилээд олон тооны баячууд цугларан архи дарс ууж, авгай хүүхэн эргүүлдэж цагийг өнгөрөөдөг байсан ажээ. Цугларагч олны дунд ноён Ламат, Жильнорман хоёр их үнэлэгддэг байв. Жильнорманы хэлсэн үг болгон нь хууль мэт санагддаг байсан билээ.

Жильнорман айлд очихдоо дандаа өөрийн төрсөн дөчин настай охиноо дагуулж, хонгор халиун үстэй, ягаан хацартай баяртай хөгжилтэй долоон настай хүүг хөтлөн явдаг байж. Гаднын баян айлуудаар орход: “Яасан ч өрөвдмөөр хөөрхөн амьтан бэ! Ядуу ч амьтан байна даа” гэдэг үг жаал хүүгийн чихэнд дуулдаж явжээ. Энэ бол түрүүчийн дэвтрийн эцэст дурдсан хүү мөн. Хүүгийн эцэг нь Луарын дээрэмчин байсан болохоор улсууд хүүг “Ядуу ч амьтан байна даа!” гэдэг байж.

Луарын дээрэмчин хүн яваандаа Жильнорманы бага охинтой ханилан сууж үвсан аж. Бага охинтойгоо сууж байсан тэр дээрэмчинг Жильнорман өөрийн “гэр бүлд бузар орсон юм” гэж тооцдог аж.

## II

### ЖОРЖ ПОНМЕРСИ

Тэр жил Вернон хот орсон хүн зугаалан явж бйгаад саравта арьсан малгайтай, өмдтэй, одонгийн ор гаргасан хөвөнэтэй цамцтай, модон ултй шаахайтай тавин нас хүрч үс нь бууралтсан, нар салхинд харласан нүүртэй, магнайнаасаа авад хацраа хүртэл сорвитой эрт отор суусан хүнтэй тохиолдож болох байлаа. Энэ хүн 1871 онд Сен Мөрний зүүн эрэгт бага зэрэг цэцэрлэг хөгжүүлж нэг зарцын хамт ганц бие амьдран сууж, цэцэрлэгтээ ургасан гоё ганган цэцгүүдийг бусдад гайхуулан худалдаж явжээ. Өөрийн лам, гэрт нь ирдэг гуйлгачнуудаас өөр хээтй ч тэр уулздаггүй. Таньдаг ламы нь Мабоф гэдэг байлаа. Гаднаас ирсэн хүн цэцэрлэг ногоог нь үзэхийг хүсвэл тэр хүн дуртай оруулдаг байлаа. Тэр хариг хүн Луарын дээрэмчин мөн байжээ.

Цэргийн аян дайн, цэргийн зүтгэлтэн нарын намтрын талаар сонирхон “Монитор” болон их армийн мэдээ сэтгүүлүүдийг сөхөж харсан хүний нүдэнд Жорж Понмерси гэдэг нэр олонтой дайралдах сан. Бага залууда энэ Жорж Понмерси Сэнтожийн хооронд цэрэг явж хувьсгал болоход сэнтонжийн хороо Рен мөрний армид нийлсэн байна. Понмерси өөрийн армийн хамтаар олон тооны дайн тулалдаанд орж явсан байна. Жорж Понмерси Наполеоныг Эльбийн арал хүргэж өгч явжээ. Ватерлоогийн тулалдааны үед Жорж Понмерси морин цэргийн нэг салаа даргалж, Люнебүргийн батальоны тугийг олзлон авч эзэн хааны өлмий дор хаясан байна. Энэ тугийг булаан авахдаа сэлэмд нүүрээ цавчуулж шарх олжээ. Сэтгэл баяссан эзэн хаан: “Чамд хурандаа, барон цол олгож, хүндэт Лежьоны дарга болголоо!” гэж хариулжээ. Энэ учраас нэг цагийн дараа Понмерси Оэны замын хажуугийн хонхорт унажээ...

Энэ хүний талаар уншигчид үүний урьд зарим нэг зүйлийг мэдсэн билээ. Ватерлоогийн тулалдааны дараа Понмерсийг хонхроос татан гаргасныг уншигчид

бас мэднэ. Тэндээс Понмерси цэрэгтээ нийлж Луарын лагерьт хүрэлцэн ирсэн байна...

Эзэнт төрийн үед хоёр дайны хоорнд Понмерси Жильнорманы бага охинтой суусан байна. Жильнорман Понмерсийг охинтойгоо суулгах их дургүй байсан байна. Жильнорманы охин Понмерситой ханилан суугаад нэг хүү төрүүлээд 1815 онд нас баржээ. Эхнэрээс үлдсэн энэ хүү хурандаа Понмерсигийн амьдралыг чимэх ёстой байлаа. Гэтэл өвгөн аав болох Жильнорман тэр хүүг өөрөө авч өсгөнө. Хэрэв өхгүй бол хөрөнгөндөө эзэн суулгахгүй гэж дүрэмдээд хүүг эцгээс нь салган авчээ. Хүүгээсээ хагацсн Понмерси цэцэг тарьж цэцэрлэгч болжээ. Понмерси өөрийнхөө хүүтэй огт уулзахгүй, үг яриа ярихгүй явах үүрэг авсан байна. Хэрэв уулзаж ярицлвал Жильнорман тэр хүүг Понмерсийнд буцаан өгөөд хөрөнгөндөө эзэн болох эрхий нь хасахаар тогтсон байжээ.

Жильнорманы охин бөгөөд Понмерсигийн эхнэрээс гарсан тэр хүүд Мариус гэдэг нэр өгчээ.

Мариуст эцэг бий гэдгийг түүнд хэн ч хэлдэггүй нуудаг байжээ.

Ингэж Мариус өсөн томорсоор байх зуур Понмерси гэрээсээ нууцаар гарч Парис ороод Мариусыг Сэн-Сюльпис сүмд өргөлд оруулах үеэр холоос нуугдан харж, Жильнорма-ы их охинд үзэгдэх болов уу гэхээс айж зүрх түгшин явдаг байлаа.

Хүүгээ үзэхээр энэ сүмд орох болсон Понмерси лам Мабофтой танилцжээ. Мабоф өөрийн хамба ламын хамт Понмерсигийнд хёр удаа зочлон очиж ярилцах зуур Понмерис өөрийнхөө бүх түүхийг танилцуулжээ.

Мариус өвөг эцгээ дагаж айл хунараар орж явахад гаднын хүмүүсийн яриг ажиглан харж явсаар өөртөө эцэгтэй гэдгээ үл мэдэг таавалах болжээ.

Өвөг эцгийн гар дээр байсан Мариус том болж дунд сургууль төгсгөөд дээд сургуулийн шүүх цаазын ангид орон суралцжээ.

1827 онд Мариус арван долоо хүрчээ. Нэг орой гэртээ ирэхэд өвгөн аав гартаа ямар нэг захидал бариад зогсож байв.

-Мариус чи маргааш Вернон ор! Гэж Жильнорман хэлэх дМариус

-Юу хийх мю бэ? гэж асуув.

-Эцэгтэйгээ очиж уулз!

Мариус өөрийнхөө эцэгтэй амьд уулзана гэж ер бодоогүй явсан учир энэ үг сонсоод маш гайхжээ. Мариус өөрийнхөө эцгийг хүүгээ хайрлах сэтгэлгүй олиггүй хүн гэж боддог байж. Өвгөн аав нь

-Эцэг чинь өвдсэн бололтой. Чамайг ирж уулз гэж шаардсан байна. Маргааш өглөө яв! гэжээ.

Мариус маргааш нь оройн бүрэнхийгээр Вернон оржээ. Айл амьтнаас асууж сурагласаар очиход эцэг нь дөнгөж нас барсан байж. Эцгийн нь хүүрийн дэргэд гурван хүн гашуудан зогсож байв.

Понмерсигийн зарц хүүхэн Мариуст нэг бичиг өгчээ.

Хурандаа Понмерсигийн бичсэн зурвасанд:

“Хүүдэ зориулан бичив.

Ватерлоогийн тулалдаан дунд эзэн хаанаас над барон цол шагнасан юм. Гэтэл миний цуса урсгаж олсон энэ алдар цолыг, сэргэн босголтын төр зөвшөөрөхгүй байна. Ийм учраас тэр цолыг миний хүү цаашид залгамжлан эдэлж явах эрхтэй миний хүү энэ тушаалыг эдлэх авъяас төгө«дөр юм” гэжээ.

Зурвасын нөгөө т лд хурандаа бичихдээ:

“Ватерлоогийн тулалдааны үед нэг түрүүч миний амийг аварсан юм. Тэр хүний нэр нь Тенардые. Сүүлийн үед тэр хүн миний тэдэж байгаагаар бол Парисын

ойролцоо Шеле юм уу Монфермейль хоёрын нэгэнд буудлын газар амьдарч байсан юм. Миний хүү Тенардьетай ямар нэг учралаар тохиолдвол байдаг чадлаараа тус хүргээрэй” гэжээ.

Мариус Венонд хоёрхон хоноод Парис орж сурах бичгээ уншиж элдвийг мартжээ. Хурандааг хоёр хоногийн дараа оршуулаад гуравдахь хоногтоо мартжээ.

Эцгийгээ амьд дээр нь уулзаж чадаагүй өнгөрөөсөн Мариус зан хувирч гэртээ тогтохоо больжээ. Мариус зав л гарвал гэрээсээ холдон сураг чимээгүй болдог болсон аж.

Мариус нэг өдөр Монфермейль орж Ватерлоогийн тулалдааны үеийн түрүүч, буудлын эзэн Тенардьег эрж сураглавал Тенардье хов хоосроод алга болсон байж. Тенардье аль зүгт явсан ч мэдэгдэхгүй.

Мариусын хийж байгаа ажлыг мэдсэн өвгөн аав Жильнорман ихэд уурлаж:

-Эрхэмсэг ноён барон та над шиг хөрөнгөтэй нэг сууцанд хоргодох цаг өнгөрчээ гээд гараараа занган:

-Гар! Зайл! Гэжээ.

Өвөг эцгийн байшингаас хөөгдсөн Мариус хөлсний тэргэнд сууж латин хороо зүглэжээ.

Мариус цаашдаа яасан бол оо?

## **ДӨРӨВДҮГЭЭР ДЭВТЭР**

# **ДАРЛАГДАГСДЫН ХАНЬ НӨХӨД**

I

## **БҮЛГЭМ**

Юм бүхнийг хайнга хамаагүй үзэх болчсон мэт замбараагүй үед хувьсгалын анхны амьсгал үүсэж байв. 1789 ба 1792 оны ариун амьсгаа агаарт тарж байла. Залуучууд гуужиж эхлэв. Цаг үеийн хөдөлгөөний хүчинд автагдсан хүмүүс өөрийн эрхгүй аяндаа өөрчлөгдөж байлаа. Цгийн зүүний эргэлтийг дагаж хүний сэтгэл санаа хөдөлсөөр байлаа. Хүн болгон өөрийнхөө замаар урагшаа алхав. Харгис хаант үзэлтнүүд дундыг баримтлагчдын эгнээнд шилжиж дундыг баримтлагчид ардчилсан үзэлтний эгнээнд шилжив.

Эрчлэн айсуй долгион мэт энэ хөдөлгөөнийг мянга мянган буцах долгион саатуулж ядан байв. Эрчлэн эвхрэн эрчээ чиглэсэн хүчит долгион замдаа тохиолдсон болгоныг хольж хутгадаг учраас тэр долгионд хумхигдсан хүмүүсийн үзэл санаа ч гэсэн бас үймрэн хугалдаж олон янз болдог билээ. Энэ үеийн хүн Наполеон, эрх чөлөө хоёрын өмнө адихан нахилзаж байлаа...

Эргийг чиглэсэн эрчит долгион шиг ирээдүйг мөрөөдсөн давштад урсгал бас гарсан юм.

Давшилтад үзэлтний урсгалын өмнө хоёр янзын бэрхшээл байлаа. Хуурамч урвамтгай хуучин дэглэмд аюултай нууц ажил явагдах боллоо. Энэ бол хувьсгалын шинж тэмдэг. Олныг мэхлэх гэсэн төрийн нууц бодлого ард түмний далд нууц санаатай тулгарч мөргөлөв. Төрийн эргэлт хийх хуйвалдааны эсрэг хандаж хурц болсого бүрэлдэн тогтов.

Тэр үеин францад Герман, Итали зэрэг оронд үүссэн том нууц байгууллагууд шиг газар үүсээгүй боловч энд тэнд жижиг нийгмүүд гарч эхлэв. Экед Күгүрд, Парист “Дарлагдагсдын хань нөхөд” гэдэг нийгэм үүсэв.

“Дарлагдагсдын хань нөхөд” ард олонд эрх чөлөө олгох зорилго тавьжээ. Энэ нийгэмлэгийн гишүүд өөрсдийгөө дарлагдсан ард түмний хань нөхөд гэж нэрлэжээ. Энэ нийгэмлэгийн гишүүд Парисын “Коринф”, “Мюзэн” гэдэг хоёр газар цуглардаг байсан аж. Гишүүдийн олонх нь оюутнууд байв.

Нийгмийн удирдагчдын нэрсийг дурдвал: “Анжолрас, Комберфер, Жан Прувэр, Фой, Күрфейрк, Баорель, Легль буюу Лэглэ, Жоли, Грантэр нар болно.

Эдгээр залуучууд нь хоорондоо нөхөрсөн холбоотой нэг гэр бүл шиг байж. Дэглиэс бусад нь цөм Францын, өмнө зүгин нутгийн залуучууд байж. Залуучуудаас бүрдсэн энэ бүлгэм маш гайхалтай.

Анжолрас ганцаараа баян айлын хүүхэд, чадвартай авъяаслаг. Хичээнгүй янзтай харцгы ажвал түрүүчийн хувьсгалын зарим нөлөөг шингээсэн бололтой. Анжолрас тэр хувьсгалын хэв заншлыг ойлгожээ. Хувьсгалын агуу их хэргүүдийг ширхэгчлэн мэдэж, ардчилсан ёсны байлдагч цэрэг болжээ. Хорин хоёр нас хүрсэн мөртөө арван долоот шиг санж.

Хувьсгалын шинж чанарыг агуулсан Анжолрасын дараа хувьсгалын үзэл санаа болсон Комберфер орно. Анжолрас хувьсгалт дайн зарлах юм гэхэд Комберфер хувьсгал ялсны дараах бодлогыг боловсруулах маягтай хүн Комберфер юм бүхний энгийн нүдээр чөлөөтэй харж ойлгодог, хүмүүсийг нэг түгээмэл зорилготой болгон хүмүүжүүлэх хүсэлтэй. Хувьсгал ч хэрэгтэй, соёлч боловсон амьдрал мөн хэрэгтэй болно гэдэг байв. Ирээдүй бол сургуулийн багш нарын гарт байна гэж батлаад сургах хүмүүжүүлэх ажлыг их сонирхон судалдаг байж. Шинжлэх ухаан сайн нэвтэрвэл одоогийн байдлыг өөрчилж болох юм гэдэг хүмүүсин нэгэнд Комберфер ордог байлаа. Анжолрас удирдагч, Комберфер орлогч болж чадах байв. Нэгтэй нь хамт дайн хийхэд сайн, нөгөөтэй нь цуг жуулчин хийхэд сайн баймаар аж... Үүгээр Комберферыг тэмцэх чадалгүй гэж байгаа хэрэг биш. Саад болгоныг биеэр туулж хүчит цохилт өхөд дандаа бэлэн байдаг хүн. Комберфер нэг хэвийн байхыг ч зөвшөөрдөггүй, хэт түргэн давшихыг ч зүйтэй гэж үздэггүй байлаа. Нэг хөгжил нэг газраа хөдлөхгүй байгаад байвал ялзрал үхэлд хүргэнэ гэж үздэг байлаа...

Жан Прувэр Комберферээс илүү ов зальтай уян хатан хүн байж. Прувэр ард түмэнд хайратй, эмэгтэйчүүдийг энхрийлэн үздэг хүүхэд багачуудын хүнд зовлонт байдлыг тэвчиж чаддаггүй хүн. Гэрэлт ирээдүй, бурхан хоёрт нэг адил итгэдэг Жан Прувэр ямар эрдэмтнээс дутахгүй их мэдэцтэй, яруу найрагт хамгийн дуртай, итали, латин, грек, еврей хэлийг мэддэг байлаа. Фой бол өнчин ганц биетэй, ажилчин. Өдөрт арай гэж гурван франк олдог байсан Фой ертөнцийг чөлөөлөх сэн гэдэг үүрдийн ганц мөрөөдөлтэй бйж. Боловсролтой, чөлөөтэй болхыг мөн хүсдэг байж. Хэний ч тусламжгүйгээр өөрөө бичиг үсэг сурч, өнчин ганц биеэрээ бүхэл бүтэн ард түмнийг үрчилж аваад хамаг мөрөөдлөө эх орондоо зориулж, Фой ертөнц дээр эх нутаггүй нэг ч хүн байлгахгүйг хичээдэг аж. Голчлон Францын талаар сонирхож байсан үл гүйцэлдэх үзэлтэй залуучуудын бүлгэмийн дотор Фой ганцаараа хараат харь орны ашиг сонирхлыг өмгөөлдөг байлаа. Грек, Австри Венецийг тус тус булаан эзэлсэн явдал Фой-гийн дургүйцлийг хүчтэй болгодог ажээ. 1772 оны гурван гүрний дэрээм, гэмт хэргийг үнэн голоосоо үзэн яддаг хүн байв.

Польшийг их гүрнүүд ширээний ард сууж байгаад хувааснаас хойш төрийн тусгаар тогтнолыг халдан зөрчих явдал олонтой болж, Польшийг хуваан залгисныг бүтэн зууны турш урвагчид дарлагчид зөвтгөн баталж байв. Энэ урвалт шинэхэн үеийн

бузар хэргийн нэгд орно. 1772 онд дээрмээ эхлээд 1815 онд олсноо хуваалаа гэж Фой ярьдаг байлаа.

Варшав татарын хот болон хувирч чадахгүйн нэг адил Венец Германы хот болохгүй. Үүний төлөө тэмцэвэл хөдөлмөр үргэдхийн гарз! Эрт орой хэзээ нэгэн цагт бусдын хөлд гишгэгдсэн орон товойн гарч байраа эзлэх нь эргэлзээгүй. Түрэмгийллийг эсэргүүцэх эрхт тэмцэл хэзээ ч унтрахгүй. Бүхэл бүтэн ард түмнийг тонон дээрэмдсэн хэргийг хугацаа өнгөрлөө гэж хөнгөтгөн хүчингүй болгож болохгүй! Хүнд том хуйвалдааны үр дүн удаан тогтохгүй. Үндэстнүүдийг нусны алчуур шиг үнгэн доромжил болохгүй!

Курфейрак бол үнэнч, хувьсгалт бүлгэмийн татах хүчний төв болж байлаа. Курфейрак цагаан санаатай, олонтой эвтэй байснаараа бусдын хайрыг татжээ.

Баораль олон үгтэй, хурц ухаантай шиг маяг гаргадаг, зан байдлаар ширүүн догшин. Дээд сургуульд арван нэгэн жил суралцаад шүүх цазны ухааны талар юу ч сурч мэдсэнгүй: “Би өмгөөлөгч болхгүй” гэдэг нэрийдлээр санаагаа амрааж явдаг байж. Баораль шинээр үүсэж Үайгаа бүлгэмүүдтэй харилцаа барьж дарлагдагсдын хань нөхөдтэй нэгдмэл нэгдэлтэй болгох ажил хийдэг байв.

-Мод харилцаа холбооны газрын эрхлэгч байсан Лэглийн хүү бүлгэмийн халзан гишүүн Лэглийг нөхөд Боссюэ гэж нэрлэжээ:

Боссюэ ухаанатай, эрдэмтэй боловч бүтээсэн зүйл огт байсангүй. Санасан бодсон зүйлээ бүтээж явсан удаа ер үгүй. Боссюэ өмгөөлөгчийн мэргэжилтэй болохыг яарсангүй, шүүх цаазны ухааны Баоралийн маягаар судалдаг байлаа. Боссюэд байнгын орон сууц байсангүй. Таних нөхдөөр хэсүүчлэн хонож явдаг байлаа. Анагаах ухааны ангийн оюутан Жолигийн голдуу хонож өнжиж явжээ.

Залуучуудын дотроос хамгийн худлаар өвддөг нь Жоли байж. Анагаах ухааныг судлаад Жоли эмч болохоосоо өмнө өвчтөн болсон байна. Хорин гурвн настайдаа янз бүрийн өвчинд автагдсан хүн гэж өөрийгөө үзээд өдөржин толинд хардаг байж. Гэсэн ч Жоли бусад нөхдөөсөө баясгалантай нь байж.

Хоорондоо огт адилгүй эдгээр залуучууд цөм адил давшилтад ёсонд итгэдэг байжээ. Эд цөмөөрөө францын хувьсгалын төрсөн үр хүүхэд нь юм. Эдний хамгийн хөнгөмсөг нь “Наян есдүгээр он” гэдэг үгийг дуулаад томоотой хянамгай болдог байж.

Эд хамтран нэгдээд өөрийн үзэл санааг биелүүлэхээр нууц ажил зохиов. Эдний дунд сэтгэл санаагаар дорой нэг хүн байж. Түүнийг Грантэр гэдэг. Грантэр ард түмний эрх, хүний эрх, нийгмийн гэрээ, францын хувьсгал, бүгд найрамдах улс, ардчилал, давшилт ёс зэргийг бараг хэрэггүй зүйл гэж үзээд доромжилдог байв.

Амьдралдаа тохиолдох бүхнийг хамагүй зүйл гэж үзээд, “Архи дүүргэсэн хундаганаас өөр үнэн юм амьдралд байхгүй” гэж ярихда их дуртай байлаа...

## II

### ОРОНД ЧИНЬ БИ ХАСАГДЛАА

Нэг өдөр Лэгль гадаа зогсоод харж байтал морин тэрэг ирж явахыг үзэж. Ойртон очиж харвал морин тэргэн дотор нэг залуу сууж байлаа. Залуугийн хажууд бйгаа үүргийн гадаа талд наасан бичгийг уншиж үзвэл Мариус Понмерсий гэсэн үг бичээстэй байв.

Лэгль:

-Ноён Мариус Понмерси! Гэхэд морин тэрэг зогсож Мариус:

-Юу вэ? гэв.

-Марису Понмерси гэдэг та юу?

-Тийм, би байна.

-Би таныг хайж байсан юм.

-Юунд? Би таныг танихгүй юм байх чинь вэ! гэхэд Мариус алиа хүнтэй уулзлаа гэж бодов.

-Та уржигдар хичээлд ирээгүй байсан

-Магадгүй.

-Магадгүй гэх юм алга. Лав байгаагүй. Би тантай адил оюутан хүн. Уржигдар оюутнуудын ирцийг бүртгэж үзлээ. Профессор Блондо хиеэл тасалсан хүнд их дургүй, ирээгүй хүнийг оюутны тооноос хасах байлаа. Тэгээд таны нэр дурдахад: “Би Мариус Понмерси байна” гэж хариулав. Дараа нь миний нэр дуудахад намайг төлөөлж дуугарах хүн олдсонгүй болохоор таны оронд би хасагдлаа.

Та бусдыгаа хөөдөлгүй хичээлдээ явж байж үзээрэй гэжээ.

Лэглэ:

-Таны гэр хаана вэ?

-Миний гэр энэ тэрэг. Өөр орон байхгүй гэж Мариус хариулав.

Энэ үед Курфферан хүрч ирээд:

-Оронгүй бол манайд очъё гээд тэргэнд сууж:

-Прот Сен-Жак буудалд очъё гэв.

Мөн орой Мариус Курфейракийнд орж суусан байлаа.

### III

## ОЛНЫ ДУНД ОРОВ

Хэд хоноход -эг нэгтэйгээ танилцаад Курфейрак нэг өглөө Мариусаас:

-Танд баримталсан улс төрийн үзэл бий юү? Гэхэд гомдсон маягаар:

-Байлгүй яах вэ дээ! гэв.

-Ямар үзэлтэй вэ?

-Ардчилсан Бонапартын үзэлтэй.

-Эргэлзээтэй хэрэг байна даа гэж Курфейрак хариулжээ.

Маргааш нь Курфейрак Мариусыг дагуу«ж “Мюзэн” гэдэг гуанзанд аваачжээ. Тэнд бүлгэмийн бүх залуучууд бараг цөмөөрөө «угларсан байлаа. Гратэр, Баорель, Прувэр, БоссюS, Комбефер, Курфейрак нрын хоорондын маргаан дундаас гүн цэцэн санаа аянда тодорч байлаа.

Олны шуугиан үймээний дунд Боссюэ Комбеперийн хэлснийг засамжлан:

-Мянга найман зуун арван таван оны зургадугаар сарын арвн найман, Ватерлоо гэв.

Ватерлоо гэдэг үг сонссон Мариус улам их анхаарал тавих болов.

Курфейрак:

-Арван найм гэдэг өдөр дандаа миний сонирхол татаж байлаа. Энэ өдөр Бонапартын хувь заяа шийдэгдэж байсан юм.

Нэг ч үг дуугаралгүй сууж байсан Анжолрас Курфейрак руу хандаж:

-Яргалалт гэмт хэргийн үүсэл болсон юм гэж чи хэлэх гээ юү? Гэж асуухад, Ватерлоо гэдэг үг сонсоод тэвчиж ядан суусан Мариус босон хананд өлгөөтэй байсан Франц орны зургийн дэргэд очиж тусгайд нь зурсан арлын зургийг хуруугаараа зааж:

-Энэ Корсик арал. Энэ жижиг арал Францыг агуу том орон болгосон гэхэд Анжолрас:

-Франц агуу их үрэн болоход ямар ч Корсик хэрэг байхгүй Франц хэвээрээ л байвал их гүрэн мөн гэв.

Мариус босч Наполеоны түрэмгий бодлогыг өмгөөлөн хамгаалсан чанарын үг хэлжээ.

Үүнээс блж Мариус их бодолд орсон байна. Мариус өөрийн өвгөн аав, танилцсан нөхөдтэйгээ тохирсонгүйдээ гунихарч “Мюзэн” гуанзанд дахин очихоо б йжээ.

Мариусын сууж байсан зочид буудлын эзэн нэг өглөө Мариусынд орж ирээд:

-Ноён Курфейрак таныг даасан биз гэхэд, Мариус хариуд:

-Тиймээ гэв.

-Би мөнгө хураах гэсэн юм.

-Курфейракийг нааш нь явуулчаарай. Надад ярилцах хэрэг байна гэв.

Эзэн гарсны хойно Курфейрак ирээд:

-Та цаашда мөнгөгүй яаж амьдрах хүсэлтэй байна вэ? гэхэд Мариус:

-Цаг, гутал хувцсаа зараад амьдаръя гэж бодож байна г эжээ.

-Цаг, гутал хувцсаа худалдаж идэж дуусаад Мариус Порт-Сен-Жак буудлаас нүүжээ...

Мариус ядуу бэрхийн зовлонг биеэр амсч ухаан суух үедээ Горбогийн овоохой болсон байшинд очиж нэг муу тасалгааг жилийн арван гурван франкаар хөлслөн суужээ.

## **ТАВДУГААР ДЭВТЭР**

# **ХОЛЫН ЗАМД УЧИРСАН ХОЁР ОДНЫ ТУХАЙ**

I

## **ТААВАРЛАЖ ӨГСӨН НЭР**

Энэ үед Мариус гоё ганган царайтай, дунд зэргийн нуруутйа шигүүн багсгар хар үстэй, ухаантай нүдтэй, сортолзсон хамартай идэр залуу байлаа. Харахад үнэнч, төлөв зантай, бардам хянамгай мөртөө гэмгүй царайлсан нүүртэй гэмээр хүнтэй ярилцахдаа цөөхөн төлөв үгтэй зан авир сайн, хөөрхөн амтай, ягаан уруултй цагаан шүдтэй, жижиг нүдтэй, гэмгүй цагаан харцтай.

Олиггүй ядуу явж байхдаа Мариус охидын харцас ичиж, зөрж өнгөрөхдөө хойноос нь харвал ухаа алдатлаа зугтах буюу нуугддаг байлаа. Намайг хувцас муутай болохоор охидууд шохоорхон харж дооглон инээж байгаа даа гэж Мариус боддог байлаа. Үнэн хэрэг дээрээ тэд Мариусын үзэсгэлэнт гоё царайтай болохоор амтархан харж арав таван үг солилцон амраг сэтгэлээ илчлэхийг хүсдэг байлаа...

Люксембург цэцэрлэгийн хамгийн зайдуу хүнгүй газарт, яJ нэг суудал дээр эрэгтэй хүн нэг залуухан охины хамт суугаад ярилцаж Мариус үзсээр жил гаруй өнгөрчээ. Тэр эрэгтэй хүн жар орчим настай, чийрэг биетэй, ядарсан байдалтайгаараа халагдсан цэргийн хүнтэй төсөөтэй, хэрэв тэр хүн одон зүүсэн бол

Мариус түүнийг лав цэргийн дарга ясан хүн байна гэж бодох сон. Охин дагуулсан хүн нүдэнд бүлээн царайтай, цал буурал толгойтой.

Буурал өвгөнийг дагаж явдаг жаал охин санаандаа тохирсон суудэл дээр очиж суухыг анх харвал арван гурав, арван дөрөвтэй, дэрс шиг туранхай, дэндүү царай муутай юм шиг байжээ. Хоёр нүдний нь хараа хойт өдөр үзэсгэлэнтэй ганган хүүхэн болохыг тодорхойлжээ. Тэр охин өмссөн хувцас нэг талаар залуу хүнийх шиг, нөгөө талаар хөгшин эмгэнийх шиг, хувцасласан маяг нь сүмийн дотор хүмүүжиж байгаа охидынхтой төсөөтэй. Өвгөн охин хоёр эцэг үр хоёртой яг адилхан байж.

Эхний хоёр гурван өдөр Мариус тэр настай эрэгтэй хүн, жаал охин хоёрыг ажиж байхад эрэгтэй нь арай өвгөн болоогүй, охин нь арай хүүхэн болоогүй мэт санагджээ. Дараа нь Мариус тэднийг анзаарахаа ч байж. Настай хүн охин хоёр мөн Мариусыг ер ажигласангүй, хоорондоо тайван хүүрнэж сууж.

Мариус өөрийн мэдэлгүй аяндаа өвгөн охин хоёрын сууж байдаг газраар цэцэрлэг дотуур зугаалах болжээ.

Өвгөн охин хоёрыг дандаа алсаас хардаг болсон Мариус, тэр хоёрыг хувцасны нь өнгөөр хоосон тааварлаж: “хар охин” “цагаан ноён” гэж оюутнууд дууддаг болсныг дууриаж бас “цагаан ноён” гэх болжээ.

## II

### ХАВАР

Мариус, өвгөн охин хоёрыг анх үзсэнэс хойш хоёр дохь жилдээ хуучин зугаалан явдаг газраа очихоо болиод бараг хагас жил болжээ. Гэнэт зуны нэг нартай сайхан өдөр Мариус Люксембургийн цэцэрлэг рүү очихоор явахад сэтгэл нь их баясч явсан аж. Мариус цэцэрлэгт ороод өөрийнхөө дассан газар луу хүрч очвол нөгөө хоёр хуучин байрандаа суусан хэвээрээ харагдав. Хажуугаар нь зэрэгцэн өнгөрөхөд өвгөн ер өөчрлөгдсөн шинжгүй, харин охин хачин оол болсон үзэгджээ. Энэ лав түрүүчийн ирдэг охин биш, өвгөний хоёрдугаар охин мөн байлгүй дээ гэж Мариус боджээ. Хуучин заншлаар Мариус ураш хойшоо сүлжиж явж байгаад сайн ажвал нөгөө охин мөн байв. Хагас жилийн дото рөсөн том болж танигдахаа байжээ. Жаахан байсан амьтан өсч идэр залуу хүүхэн болж. Энэ охин зүгээр өсөөд зогссонгүй харагдсан залуугийн хайрыг татмаар болсон аж. Зарим нэг мод хаврын дулаан үед гуравхан өдрийн дотор ногоорон цэцэглэдгийн адил тэр охин зургаахан сарын дотор үзэсгэлэн төгөлдөр болон өөрчлөгджээ. Тэр охины урган цэцэглэх цаг иржээ...

Мариус охины өмнүүр долоо найм дахин өнгөрсөн боловч царайг нь сайн харж чадсангүй.

Дараад өдрүүдэд Мариус Люксембургийн цэцэрлэгт очиж заншсанаараа эцэ, охин хоёрын урдууд хэрэн өнгөрдөг байлаа.

## III

### ХАВРЫН НӨЛӨӨ

Цэлмэг өдрийн тунгалаг нар Люксембургийн цэцэрлэгийг гийгүүлэн, хурмастын нүүрийг дагина угаасан адил хумсын чинээн ч үүлгү манаран цэнхэртэнэ. Багсгар шугуйгаар болжмор жиргэнэ. Байгалийн үзэсгэлэнд байдаг сэтгэлээ захиуулан

Мариус цээж дүүрэн амьсгалж зүрх догдлон явсаар хүүхний сууж байсан урт сандлын өмнүүр өнJөрөх үед хартал нөгөө охин бас урдаас нь нэг зэрэг хажээ. Хоёр нүдний харц ингэж солбилцжээ.

Хүүхний харцанд юу илэрсэн байв аа? Үүнд Мариус хариулж хэлэх үггүй сэн. Тэр харцанд онцын юм юу ч үгүй байсан мэт болов гэгээн цагаан өдөр цахилгаан цахих шиг болжээ.

Хүүхэн доош харахад Мариус цааш яваад өгчээ.

Мариусын харсан хүүхний харцанд тайлбарлаж болшгүй нэг зүйл гялс гээд далд орох шиг болж Мариусын зүрх пал гэжээ.

Охин хүний харц нуугдмал сэтгэлийг хөндөх өдөр нэг ирдэг. Тэр өдрийг тохиолдуулж, түүний нүдийг харсан хар хүү хайрын сэтгэлд автагдах нь тэр ээ!

Гэнэт тохиолдох охиныг энэ харц агаар тэнгэрт үүр гийхтэй яг адилаа! Ингэж үл мэдэгдэх улаан туяа ухаан санаанд нь тодордог. Энэ туяаны үзүүр хүрсэн өвчин зүрх торонд орсон болжмор шиг бултганан цохилдог. Янаг дурлалын анхны харцанд оногдсон залуу нууц торонд зүрхээ баглуулаад аливаа бодолд автагдаж нэг үе гуньж нөгөө үе хөөрөн баясаж эхэлдэг...

Мариус орой гэртээ ирээд өөрийн хувцсыг ажин хараад маргаашнаас нь эхлэн хамгийн цэвэр сайн хувцсаа өмсөхөөр шийджээ.

Мариус, өвгөн охин хоёрын өмнүүр анхандаа холуур өнгөрдөг байсан бол өдөр ирэх бүр улам ойртох болж, өмссөн хувцсаа байн байн засч, цөөн хардаг байсан бол олон дахин харах болжээ.

Таньж мэдэхгүй хүн лон дахин хойноос нь дагаж мөрдөөд байхыг мэдсэн цагаан ноён хар санаад байсан газраасаа охиноо дагуулан нжүү холджээ. Мариус олон дахин цагаан ноёны урдуур хойгуур хэрж гоёмсоглон явахдаа өвгөн охин хоёрыг Jүргээн холдуулах болов уу? гэж @гт бодсонгүй явжээ.

## IV

### СЭТГЭЛИЙН ГУНИГ

Мариус Цагаан ноён охиныхоо хамт ирдэг газраар өдөр бүр очиж тэр хоёрыг олж харах а байжээ. Гэсэн ч Мариус хоёр өдөр дараагар Люксембургийн цэцэрлэгт нар жаргааж харанхуй болтол хүлээгээд охины байдаг байшинги@н цонх харахаар шөнийн саруулд гарээ.

Арван цаг хүртэл зогсон харуулдаад юу ч олж харсангүй. Мариус хоолоо ч идсэнгүй явжээ. Халуурсан хүн хоол идэх дургүй бодгийн адил догдолсон сэтгэлийг дурлал тэжээдэг учир Мариус цатгалан явжээ.

Энэ мэтээр нэг долоо хоног өнгөрөхөд Цагаан ноён охиныхоо хамтаар нэг ч удаа Люксембургийн цэцэрлэгт ирсэнгүй. Гунигтйа бодолд орсон Мариус өдрийн цагт харуулдахгүй, оройн цагаар цонхны улаан гэрлийг үзээд санаагаа хуурч явдаг байлаа. Гэрэлт цонхын цаана заримдаа хүний сүүдэр сүүдэгнэн харагдвал Мариусын зүрх улам хүчтэй цохилдог болжээ.

Наймдах өдрийн орой нөгөө газар ирэхэд өвгөн охин хоёрын суудаг өрөөний цонх гэрэлгүй байв. “Юу болох нь энэ билээ! Дэн асаагүй бйна. Одоо хав харанхуй болсон бай.а. Тэд лав гэртээ алга даа” гэж Мариус бодоод арав хүртэл хүлээж. Шөнийн арван хоёр хүртэл хүлээгээд бас гэрэл харсангүй. Шөнийн нэг болгоход хэвээрээ байгаад байхлаар их гунихралтай буцжээ.

Маргааш нь дэмий явж Люксембургийн цэцэрлэгт очоод юу ч олж харсангүй. Оройн бүрэнхийгээр нөгөө байшин руу очиход гуравдугаар давхар хав харанхуй байлаа.

Мариус хаалга тоншиж хашаанд ороод:

-Гуравдугар давхарт суудаг ноён гэртээ байна уу? гэж асуусанд

-Нүүгээд явсан гэдэг хариу сонсоод үс нь арзас гэжээ.

-Хэзээ нүүсэн бэ?

-Өчигдөр.

-Одоо хаана байгаа болоо?

-Бүү мэд.

-Очсон газрынхаа хаягийг хэлээгүй юу?

-Хэлээгүй.

Байшингийн эзэн Мариусыг таниад:

-Та байсан юм уу! Та чинь тагнаж мөрдөж яваа хүн үү? Гэжээ.

## **ЗУРГАДУГААР ДЭВТЭР**

## **ҮҮРИЙН ТАВАН ЖИН**

I

### **УУРХАЙ БА УУРХАЙЧИД**

Хүн нийгэмлэгийн дотор театртай адил доод давхрын нүх гэж байдаг. Нийгэмлэгийн гишгэж байгаа гаеарт заримдаа сайн юманд заримда муу юманд зориулагдсан нүх уурхай байдаг. Газар дорхи тэр уурхай олон давхраа. Уурхай дотроо гүнзгий ба гүнзгий бус гэж хуваагдана. Газрын энэ гүн харанхуй дээд, доод тал гэж бас байдаг.

Хүн нийгэмлэгийн барилгын дор, уран сайхан барилга, олиггүй муу нуранхай балгасын дор, хөрсөн доорхи хоосон харанхуй зай гэж байдаг. Энэ харанхуй нүхэнд шашин, гүн ухаан, улс төр, эдийн засаг, хувьсгал зэргийн үндэс уурхайнууд байдаг. Бүх уурхайнуудын доод талд харанхуй гаслан, там байдаг. Энэ тамын дотуур хамгийг залгих хар сүг тэнүүчлэн явж үнэнч сэтгэл ариун амьдралд аль олиггүй зовлонт сэв суулгаж сүйтгэдэг.

Харанхуй бүүллэг ёс устаагүй цагт хүн нийгэмлэгийн дорхи хар там, харц олны зовлон арилахгүй. хүн нийгэмлэгийн хөл дорхи хар нүхэнд аль муу хорлонтой амьтнууд хорхой шавьж мэт үүрлэн үржиж байдаг.

II

### **ДЭЭРЭМЧИД**

1830 оноос 1835 он хүртэл Парисын суурин дорхи нүхэнд Клакесу, Гольмерь, Бабет, Монпарнас гэдэг дөрвөн дээрэмчин үүрлэж байлаа. Ов заль булчин махбод тэнхээ чадлын хувьд хэнийг ч дагуулахгүй Сдгээр дөрвөн дээрэмчин хамтран мулгай дээрэм хийж амь зуух нууц танил олонтой, нууц сүлбээ хэлхээ ихтэй байжээ.

Дээрэмчнүүдийн хамгийн олиггүй нь Монпарнас. Хорин нас наслаагүй бага залуу Монпарнас залт нүүрт, гялгар хар үстэй, гялалзсан хурц нүдтэй, ямар ч хүнд гэмт хэрэг хийх авъяастай ажээ. Аль мууг хамгаас түрүүнд сурдаг Монпарнас анхандаа гамен вж гудамжны шавхай дотор өсөөд эцэстээ дээрэмчин болсон аж. Хөнгөн шингэн, хурц авхаалжтай хатуу зоригтой энэ залуу хүнийг тонон дээрэмдээд алж орхидог бузар мэргэжилтэй санж.

Бабет, Монпарнас нарын дөрвөн дээрэмчин Сен аймагт хулгай дээрэм аллагаа хядлагаа явуулдаг байв. Тэд з амаар яваа хүмүүсийг гэнэт газар дороос гарсан адил гэтэн дайрч дээрэмдэн алдаг байж.

Дээрэм хядлагын талаар сонирхдог, гэмт хэрэг хийх хүсэлтэй хүмүүс тэр дөрвөөс дэмжлэг гуйдаг байжээ. Гэмт хэрэг үйлдэхэд тэдэнд хүн хү дутна гэж байсангүй.

Дээрэмчнүүд харанхуй болоход Сольпетриер эмичлгээний газрын хавьд цугларан зөвлөж шөнийн харанхуйг яаж олзтойгоор ашиглахаа ярьж тохирдог байж.

Дөрвөн дээрэмчний бүлэг нөхдийг “Үүрийн таван жин” гэж нэрлэжээ. Ардын амтат сайхан хэлээр үүр гэгээрэхийн өмнөх үеийг “Үүрийн таван жин” гэдэг. Чоно нохой хоёрын ялгаж болохгүй бүдэг бадаг үеийг үүрийн үнэгэн бүрэний гэдэг билээ. Шөнийн дээрэмчид ажлаа дуусгаад гэгээ гарахаас өмнө тардаг байсан тул тэднийг тардан нь “үүрийн таван жин”-гийн ухнан шогшоонууд гэж нэрлэсэн бололтой ажээ.

## **ДОЛДУГААР ДЭВТЭР**

### **ХОРЛОНТОЙ ЯДУУ ХҮН**

I

#### **БҮРХ МАЛГАЙТАЙ ХҮҮХЭН ХАЙСАН МАРИУ‘, САРАВЧТАЙ МАЛГАЙТАЙ ЭРЭГТЭЙ ХҮНТЭЙ УУЛЗАВ**

Зун өнгөрч намар боллоо. Удсангүй өвлийн улирал ирлээ. Цагаан ноён залуу охин хоёр нэг нь ч Люксембургийн цэцэрлэгт огт үзэгдсэнгүй. “Залуу охины зөөлөн харц, хөөрхөн царайг олж харахсан гэхээс өөр бодол Мариуст байсангүй. Тэр охиныг Мариус газар болгонд эрж хайвч нэг ч удаа олж харсангүй. Мариус залуу охины тухай бодол хүслэн болсоор байгаад эзнээсээ хагацсан нохой шиг болж хувирчээ. Сэтгэлтэй болсон охиноо олж уулзахгүйгээс цааш яаж ч явсан ялгаа алга, би дууссан хүн гэж Мариус бодох болсон аж.

Нэг өдөр Мариус явж байгаад ажилчны хувцатсай, урт саравчтай малгайтай буурал үстэй хүнтэй уулзжээ. Буурал үстэй хүн цагаан ноён мөн байх шиг санагдаад Мариусын сэтгэл хөдөлж элдэв бодолд оржээ. Буурал үстэй хүнийг дагаж гэрт нь очвол охинтой уулзаж болно гэж ухаараад толгой өндийлгөж хартал нөгөө хүн аль хэдийн үзэгдэхээ болсон байлаа. “Ердийн нэг адил төсөөтэй хүн яваад өнгөрсөн ч байж болох юм даа” гэж бодсоор хоцорчээ.

II

#### **ХОЁР ОХИН**

Мариус урьдын адилаар Горбогийн байшинд суусаар олноос тасархай амьдарч байв. Хажуу талд нь Жондретынх айл байдаг санж. Бусад айлууд цөм нүүсэн буюу хөөгдсөн байлаа. Мариус нэг удаа Жондретын орон сууцны мөнгө төлсөн байжээ...

Мариус хоол идэхээр бодол бодон Сен-Жак гудамж зүглэн явж байтал хүн түлхэх шиг болжээ. Эргэн харвал өгөр даасан нүүртэй ширэлдэн унжсан үстэй, уранхай өмдтэй салмархай дээлэтэй хоёр хүүхэн өнгөрч яваа үзэгдэв. Тэр хоёрын өндөр нуруутай нь:

-Анжаа на<sup>о</sup>ын арганд орохоо шахлаа гэжээ.

Хоёр хүүхэн цагдаад арай баригдсангүй мултарч гарснаа тэгж ярьсныг Мариус ойлгожээ.

Мариус явах гэтэл хөлий нь хажууд газар дээр нэг боодолтой юм хэвтэхийг үзжээ. Энэ юу байдаг билээ гээдавч үзвэл дөрвөн дахиа бололтой зүйл байв. Түүнийг нөгөө өнгөрсөн хоёр охин лав хаясан байх гээд хойноос нь дуудсанд тэд дуулсангүй алга болжээ. Мариус захидлуулыг дараалан уншиж үзэхэд дөрөвдөх захидалд:

“Сен-Жак-доо-О-Па сүмийн өглөгчин буянт ноёд” гэж хаягласан байж. Цааш нь дурдахдаа:

Ядралын туйлд хүрсний минь соёрхож туслалцаа үзүүлэх буюу биеэрээ морилон ирж бидний байдлыг болгоож хайрлана уу

Таны өмнө сөгдөн ёслогч

Жүжигчин Фабантү”

Гэжээ. Энэ дөрвөн захидлыг нэг хүн байж. Бичигч хүн өөрөө хаа суугаа бичсэнгүй аж.

Мариус гэртээ ирээд захидлуудыг дугтуй дотр нь хийгээд унтжээ.

Өглөө босоод ажлаа эхлэх гэж байтал нэг хүн хаалга тоншиход Мариус:

-За ор! Гэжээ.

Хаалга онгойж хүн орж ирээд,

-Та өршөөгөөрэй гэжээ.

Харсан чинь нэг охин орж ирсэн байв.

### III

## ГУЙЛГАЧИН ОХИН

Хаалгар орж ирсэн охины бие туранхай. Хүйтэнд даарч ядарсан байв. Дан өмд цамцтай охины ёрдгор мөр цухуйн дагжин чичирнэ. Ов зальтай нүдтэй, улаан гартай, арван таван настай мөртөө тавин настай эмгэн адил үрчийсэн нүүртэй тэр охихэ

-Танд би захидал ач ирлээ гэж согтуу хоригдлын дуугаар хэлэв. Хүйтэнд даарч бээрсэн охины захидлыг Мариус задалбал:

“Зэргэлдээ суудаг залуу минь ээ! Та хагас жилийн өмнө сайн санааны үүднээс намай төлөөлж манай орон сууцны хөлс төлснийг би мэдлээ. Буянаа дэлгэрэг гэж таныг би ерөөе. Бид дөрвүүл хоёр хоногийн турш идэх хоолгүй хоосон сууж, эхнэр минь өвчтэй хэвтэж байгаа гачигдлыг миний их охин танд өөрөө ярьж өх болно. Та бидний зовлонт хүнд байдлыг анхааран үзэж тусална байх гэж итгэж байна.

Таныг үнэн голоос хүндэтгэн ёслогч Жондрет

Жич. Миний охин эрхэм ноён Мариус таны тусламжийг хүлээх болно” гэсэн байв. Энэ захидлыг, өчигдрийн дөрвөн захидлыг бичсэн хүн зохиосон нь ил болов.

Мариус Горбогийн овооход ирж суусаар удсан болов өөрийн айл зэргэлдээ хүмүүсийн ядуу байдлыг сайн мэддэггүй байж. Жондрет хоосорч ядарлын туйлд хүрээд гэдэс тэжээх арав таван мөнгө олохын тулд янз бүрийн хүнд захидал бичиж охидоороо хүргүүлдэг байсныг Мариус тааж мэджээ.

Мариус захидал ншаад зогсож байх үеэр гаднаас ирсэн охин огт ичсэн янзгүй өрөөн дундуур нь хэсүүчлэн явж Мариусын эд хогшлыг онгичин, уншиж байсан номы нь эргүүлж тойруулан үзэж бичиг үсэг мэддэгээ гайхуулан нүүрээ толинд харж санаа алдсанаа баясгалант дууны аялгуугаар:

Үмх талх ч олдохгүй  
Өлсөж байна аав минь  
Өмссөн хувцас ч байхгүй  
Өлбөрч сууна ээж минь  
гэж дуулав.

Мариус урьд өдөр дөрвөн захидлыг авч охинд өгсөнд охин алга ташин баясаж:

-Яасан сайн юм бэ! Бид үүнийг газар болгон хайгаад олоогүй м. Та үүнийг цэцэрлэг дундаас олсон уу? Бид яаран гүйж яваад унагаасан байх аа. Бид аав ээжээсээ айхдаа захидлуудыг аваачиж өгсөн боловч олигтой хариу ав агүй юм гэж худал хэлсэн... Бид өнөөдөр хоол идвэл мөн ч сайхан байна. Идэх хоол байхгүй болсон гэхийг сонссон Мариус, тэр охин ямар зорилготой ирснийг тааварлаж өврөөсөө мөнгө хайж эхлэв.

Жондретын охин Мариусын байдлыг ер ажсан шинжгүй:

-Би заримдаа үдэш гэрээс гараад өглөө болтол буцаж ирдэггүй. М найх энд нүүж ирэхээсээ өмнө өнгөрсөн өвөл гүүрэн дор амьдарч байлаа. Хөлдөж үхэхгүйн тулд дэмий нэг нэгтэйгээ шахцалдан суудаг байлаа. Дүү даараад уйлаад байх дээр ус руу унаж үхсэн дээр гэж бодогддогсон. Би явах дураа хүрэхэд гав ганцаараа яваад өгдөг. Заримдаа гадаа хонхорт унтаж хонодог, удаан хугацаанд гэдэс өлөн явахад толгой эргэж хавьтсан хүн болгон чулуугаар шидэхэд, байдаг чадлаараа зугтаж яваа шиг нүд эрээлжилдэг гэжээ.

Мариус дахин энгэр өврөө уудалж тэмтрэн үзээд таван франк арван зургаан сү олж охинд өгсөнд:

Таван франк арван зургаан сү! Яасан ашгүй сайн юм бэ? Одоо амаараа гартал идсэн ч хоолтой боллоо гээд гарч явлаа...

Мариус нөгөө охин гараад явснаас хойш өөрөө жинхэнэ ядуу зүдүү байдлыг таван жил хоосон дутмаг явахдаа үзээгүй явснаа гайхаж ёстой хоосон хүн гэдэг саяын гарсан хүүхэн шиг байдаг байна гэж боджээ.

Тэр хүүхэн харанхуй зовлонгийн орноос ирсэн шиг санагдав. Тэр хүүхэн Мариусын өмнө гаслангийн аль муу талыг нээн үзүүлжээ. Би элдэв бодол, янаг дурлалаар хөөцөлдсөөр явж айл байгаа хүнийхээ амьдралыг харсангүй тусгүй явж дээ гэж Мариус өөрийгөө зэмлэх шахжээ.

Мариус дээвэр өөдөө харсанд нэг цоорхой үзэгдэв. Өндөр юман дээр гарч тэр цоорхойгоор харж эхлэв.

#### IV

### НҮХЭНДЭЭ ХОРГОДСОН АРААТАН

Ой модонд агуй нүх байдагтай адил хотуудын дотор аль муу ховдог сэтгэлтэн хорлон санаатан хоргодож байдаг нүх овоохойнууд байдаг. Хотын доторхи нүхэнд суудаг амьтнууд хамгийн олиггүй ямар ч үр ашиггүй юм. Хөвчийн ойд нуугдан байдаг ан амьтан хортой аймшигтай боловч ариун амьдралтай ашиг тустай байдаг удаатай. Хүний үүрээс араатны үүр хор багатай.

Мариус байшингийнхаа цоорхойгоор хараад эзгүй хээрийн хадны агуйгаас дор юмыг үзжээ. Мариусын нүдэнд гэмтэж салбарсан сандал, доголлон хөлтэй ширээ, нохойн идүүрээс дор орсон хоёр, ор, лаазны шүлс хир тоосоор дүүрэн дөрвөн жижиг шилээс өөр юм харагдсангүй.

Хана туургаас нь ус чийг идээ бээр шиг дааварлаж, цонхны бүдэг гэрэлд хүний нүүр хий сүгийн царайтай адил болж үзэгдэнэ.

Үзэг, бэх, цаас тавиатай ширээний ард өлөн шорой шиг царайтай харахад дээрэмчин бололтой жар орчим настай нэг хүн сууж байжээ. Тэр хүн урт буурал сахалтай, эмэгтэй хүний татанхай цамц өмссөний цаанаас улаан буурал үстэй цээж гар хоёр цухуйсан байв. Цамцны нь цаана хиртэй өмд цухуйж, хүлээтэй майжгий шаахайны цоорхойгшор хав хар хумстай хуруунууд арзайжээ.

Гэр нь гол зогоох талхны өөдөс ч алга, харин татах тамхи үзэгдэнэ. Тэр хүн амандаа ганс зуугаад ямар нэг юм бичиж суужээ. Ажиглавал Мариусын олсон захидалтай адил гуйлга гуйсан захидал бичиж байв.

Нүцгэн хөлөө дороо хийсэн тантгар тарган авгай зуухны дэргэд суужээ. Бодвол дөч юм уу эсвэл зуун настай бололтой. Энэ авгай мөн цамцтай цэмбэний тасархайгаар нөхсөн өмдтэй, ширэлдсэн зэвхЭй шаргал үстэй толгойгоо, халта<sup>о</sup>тсан хиртэй хумсаараа шир шир м ажиж суужээ. Хоёр орны нэг дээр хувхай цагаан царайтай, салмархай хувцастай, тал бие нь ил цухуйсан охин сандайлан суусан байв.

Энэ охин Мариусынд ирсэн эмэгтэйн дүү лав мөн бололтой.

Гэрийн дотор хөдөлмөрийн ямар ч багаж хэрэгсэл харагдахгүйг үзвэл тэднийд ажилтай хүн нэг ч үгүй бололтой...

Мариус ажиж байсан газраасаа гэдрэг буухыг завдан байтал тэр овоохойн хаалга гэнэт онгойв.

Харсанд тэдний их охин санж. Тэр охин амьсгаагаа бага зэрэг дараад:

-Ирж явна! Гэхэд эцэг:

-Сен-Жак сүмд байдаг ноён уу? гэв.

-Тийм! Одоохон миний хойноос ороод ирнэ. Би гэрээ зааж өгсөн гээд эцэг рүүгээ ойртон очиж:

-Аваа та намайг тэмтрээд үз дээ би хөдөлж үхэхэ шахлаа! Гэхэд эцэг нь:

-Хохь чинь! Би өөрөө хөлдөж үхэх гэж байна! гэв.

Аяархан хаалга цохих чимээ сонсогдов. Жондрет босон харайж нахилзан бөхөлзсөөр инээд алдан хаалгаа онгойлгож:

-Буянтан минь та морилж хайрла! Ганган бүсгүй та дээш морил! гэхэд хаалга дээр настай эрэгтэй хүн, залуухан охин хоёр үздэгдэв.

Мариус хуучиндаа зогсож ажиглан ширтсээр байлаа. Энэ үеэр Мариусын үзэж харсан, сэтгэл хөдөлсөн хоёрыг илчлэн хэлэх үг олдсонгүй.

Гаднаас орж ирсэн бүсгүй сэтгэл дурыг тастан нөгөө охин мөн байжээ. Түүний нүд, ам, хамар, дух гэрэлт хөөрхөн царайг гэнэт харсан Мариус сандран чичирч: "Мөн! Хонгор минь мөн!" гэж бодохоос зүрх нь амаар гарах шахаж нүд нь харанхуйлж байлаа. Мариус гээгдсэн амрагаа сая олж авлаа гэж бодох болов.

Тхинтой хамт ирсэн хүн Цагаан ноён мөн байлаа. Хамт ирсэн эмэгтэй дотогш ороод ширээн дээр нилээд том боодолтой юм тавьжээ.

Жондретын их охин хаалганы цаана нуугдан гаднаас ирсэн охины цэвэр ганган хувцсыг харж шүлс залгин үзэсгэлэнт царайг нь ширтэн гайхжээ.

Цагаан ноён Жондрет руу ойртон очиж:

-Энэ боодолтой юман дотор шинэ дээл, оймс, ноосон хөнжлүүд бий, авч хэрэглээрэй гэхэд Жондрет газар мөргөтлөө нахилзан:

-Бурхан явуулсан буянт хүн та мөн! гэв.

Энэ үед гаднаас ирсэн хоёр, олиггүй муу муу ядуу овоохойг ажин харж байв.

Жондрет их охиноо угз татан ав ирээд:

-Хог оо! Би чамд юу хэллээ! Авч ирсэн мөнгө хаа байна? Энд лав мөнгө авч ирээгүй байна! Энэ зөнөгийн нэрийг хэн гэж захидал дээр бичлээ? Гэв.

-Фабанту гэж охин хариулахад Жондрет:

-Би өөрөө жүжигчин болсон шүү дээ! гэснээ:

-Бид хоосорлоо. Манайд түлэх түлш, идэх талх байхгүй болсныг та харж байна. Хэдэн ядуу хүүхдээ бүлээцүүлэх зүйл олдохоо байлаа. Ганц сандалтай байсан маань хэмхэрч гүйцлээ. Цонх хагархай, цас шороо чихсээр. Эхнэр минь өвчтэй, орноосоо босохоо байсан. Бага охин шархдаад арай чуу байна. Би хувцасгүйгээд эхэнрийнхээ цамцыг өмсөөд байна. Гадаа өмсөөд гарах хувцас алга... Маргааш хоёрдугаар сарын дөрвөнд би орон сууцны мөнгө төлөх ёстой. Тэр мөнгийг өнөөдөр орой олж өгөхгүй бол маргаш биднийг цас бороо хүйтэн салхиар дүүрсэн гудамжинд хөөж гаргана гэж байшингийн эзэн шаардсан. Би бүтэн жилийн мөнгийг төлөх болоод байна. Жилийн сууцын үнэ жаран франк юмаа гэв.

Жондрет гэтэл худал хэлэв. Жилийн сууцны үнэ зөвхөн дөчин франк юмсанж. Мариус тэдний өмнөөс орон сууцны нь мөнгийг төлснөөс хойш төдий л удаагүй байж. Цагаан ноён ширээн дээр таван франк гаргаж тавиад:

-Ноён Фабанту минь ээ! Миний биед тавхан франк байна. Би одоо охиноо гэрт нь хүргэж өгөөд орой танд мөнгө авчирч өгье. Зургаан цагт жаран франк авчирч өгье гээд охиноо хөтлөн буцав.

Мариус тэр хоёрын хойноос гарч суугаа газры нь мэдэхээр мөрдөн явж байтал Цагаан ноён охинтойгоо хамт тэргэнд суугаад явжээ.

Хойноос нь хөлсний тэргэнд суугаад хөдлөх гэтэл өвөрдөх мөнгө нь хүрэлцсэнгүй хоцроод бодолд орон буцаж байрандаа ирэхэд Жондретын их охин Цагаан ноёны охины сууаг газрын хаягийг олж өхөөр амлажээ.

Мариус үс толгойгоо базлан орох газраа олж ядан гэртээ хэвтэж байтал Жондрет чанга дуугаар эхнэртээ

-Лав мөн гэж би чамд хэлж байна шүү! Би түүнийг танилаа... Найман жил өнгөрсөн боловч би андахгүй танилаа. Чи таньсангүй гэж үү?

-Үгүй

-Би чамайг "анхааралтай хар" гэсэн шүү дээ. Өндөр намын хэмжээ, нүүр царай нь яг мөн байна. Хувцсаар нилээд сайжирээ. Зальт муу өвгөнийг гарта оруулж авсан. Одоо бүрэн тонохоос нааш гараас мултардаг юм биш... Хоёр охин минь гарцгааж бай. Яг таван цагт энд байгаарай. Ажил гарна шүү гэхэд хоёр охин нь гарч явав.

Жондрет эхнэр рүүгээ эргэж:

-Саяын ирдэг чинь нөгөө манайд байсан охин мөн байна.

Танигдахгүй болчихож гэхэд эхнэр ь:

-Миний хоёр охины өмнө сөгдөж явса- муу эм мөн бол амьдаар нь тамалж алаад гэдсий нь гартал дэвсэн юмсан гэж цовхчино.

Жондрет тарган авгайгаа татан ойртуулаад:

-Ги одоохон “үүрийн таван жингийнхээр” ороод Цагаан ноён оройн зурган цагт ирэх үеэр чадалтай эрс олох гээд саравчтай малгайгаа өмсөж гарч одов.

Энэ бүхнийг сонссон Мариус цэгдэн сэргийлэхэд очиход сэргийлэх газрын орлогч дарга Жавер угтан уулзаж дээрмийн аюул ирэх гэж байгааг анхааралтай сонсон авч, зургаан цагийн үед цагдаа нар очиж нуугдан хүлэсж байгаад Мариус чимээ өхөд дайран орж дээрэмчдийг барихаар ярилцжээ.

Жавер Мариуст нэг гар буу өгч Жонретынд яг дээрэм эхлэх үед буудаж дохио өх үүрэг өгчээ.

Мариус цагдан сэргийлэх газраас гарч гэртээ ирээд нөгөө жигладаг цоорхойгоороо шагайн хэвтэж байтал Жондрет хоёр охин гадаа харуулдан зогсоох үүрэг оноож маш сонор сэрэмжтэй байхыг анхааруулахыг үзжээ.

## V

### ЖОНДРЕТЫН ЖИНХЭНЭ НЭР

Хэрэг ойртвол буудахаар бугаа цэнэглэсэн Мариус цоорхойгоор шагайн хэвтэж байв. Алс холын хөлгийн туурайнаас болж цонхны шил хөдлөх шиг болов. Сен-Медарын хонх зургаан цаг болсныг тунхаглав.

Зургаан цаг болохыг тэсэж ядан хүлээж байсан Жондрет өрөөн дотуураа урагш хойш алхалж байснаа дөнгөж суух гэтэл хаалга тогшив.

Жондретын авгай хаалгаа онгойлгож:

-Морилж хайрла ноёнтон минь! гэхэд Жондрет босон харайж

-Морилж хайрла буянтн минь! гэж эхнэрээ дэмжин хэлтэл мөнгө авч ирж өхөөр болсон нөгөө Цагаан ноён ганцаараа орж ирэхийг Мариус үзэв:

Цагаан ноён:

-Фабантүн таны орон сууцны хөлс болон бусад чухал хэрэгцээн зориулж мөнгө авч ирлээ гээд мөнгө өгсөнд Жондрет:

-Буянаа дэлгэрж жаргаж явах Үолтугай та гэснээ эхнэр рүүгээ хурдан ойртож

-Тэрэг явсан уу? гСж асуухад эхнэр нь гүйн гараад буцаж ирснээ нөхрийнхөө чихэнд:

-Явчсан байна гэв...

Цагаан ноён байрнаасаа босон хана түшин зогсож эргэн тойрноо ажвал Жондрет ба түүний эхнэрээс гадна дөрвөн эрэгтэй хүн сууж байлаа. Тэд Цагаан ноёныг ер анхаарсан шинжгүй.

Жондрет элдэв зовлонг чих дүжиртэл тоочиж, энд тэндээ өлгөөтэй байгаа элдэв муу сайн зургаа байдгаар нь магтаж худалдан авахыг Цагаан ноёноос ятгаж гуйжээ. Жондрет:

-Та хэрэв миний зургуудыг худалдан авахгүй бол би ус руу орж үхэхээс өөр арга алгаа гэжээ...

Жондретын хаалга гэнэт онгойж гурван эрэгтэй хүн орж ирэхэд Жондрет:

-Бүгд бэлэн үү? Гэхэд

-Бэлэн гэв.

-Монпарнас хаа байна?

-Охинтой чинь ярилцахаар үлдсэн.

-Аль охинтой.

-Их охинтой.

-Морин тэрэг дор байна уу?

-Байна.

-Сайн байна гэж Жондрет хэлэв.

Гар хоосон байсан гурван эрэгтэй овоолоотой төмөр дотроос нэг нь төмөр хайчилдаг хайч, нөгөө нь хүнд шовх төмөр, гурав дахь нь алх шүүрэн аваад хаалаг бөглөн зогсов.

Дохио өгөхгүй бол болохгүй боллоо гэж мэдсэн Мариус буугаа өргөж буудахад бэлэн болов.

Жондрет Цагаан ноён руу ойртон очоод:

-Та намайг танихгүй байна уу? гэхэд Цагаан ноён эгц өмнөөс ширтэн:

-Танихгүй байна гэв.

Жондрет улам ойртон очоод нүдээ эргэлдүүлэн, шүдээ зуун:

-Би Фабантү ч биш. Миний нэр Тенардые гэдэг. Би Монфермейльд буудлын газрын эзэн байсан! Намайг Тенардые гэдэг юм! Мэдэв үү! Одоо таньж байна уу? гэв...

Буудахаар бэлдэж байсан Мариус Тенардые гэдэг нэр! Сонсоод ухаан алдах шахаж эцэг нь үхэхдээ: "Тенардые гэдэг хүн миний амийг аварсан юм. Хэрэв миний хүү тэр хүнтэй дайралдвал юу байгаагаараа туслаарай!" гэж гэрээсэлснийг санах.

Мариусын сэтгэл хоёрдож цагдан сэргийлэх газраас авсан үүргээ биелүүлэхгүйд хүрэв. Хайр дурыг татсан охины эцэг Цагаан ноёныг алуулахгүйсэн гэвэл дохио өгмөөр. Тенардые гэдэг хүнд тус хүргээрэй гэсэн эцгийн гэрээслэлийг бодохоос мэдээ өгч Тенардыег бариулахгүй суумаар болж аль ч аргаа олж ядан багтран суужээ.

Цагаан ноён цонхоор гадагш үсрэн гарах гээд Тенардыегийн цуглуулсан "Үүрийн таван жингийн" дээрэмчдэд баригдан хүлэгджээ. Цагаан өвгөнийг барьж хүлсэн дээрэмчид шуугилдан багширч олсон олзоо хэрхэн залгихаа шийдэж олзоо авч оргон холдохоор болжээ.

Дээрэмчид цонхоор түрүүч нь гарах гэж байтал

-Миний малгай та нарт хэрэг болох уу? үгүй юу? гэж нэг хүн үүдний тэндээс дуугарав.

Цөм эргэн харахад Жавер орж ирсэн байв.

Жавер инээд алдан гартаа барьсан малгайгаа дээрэмчид рүү өхөөр сунгаж байв.

Цагдаа үзээд айж сандарсан дээрэмчид хаясан зэвсгээ хальт мульт шүүрэн аваад үзэлцэхэд бэлтгэтэл Жавер:

-Байгаа газраасаа бүү хөдөл! Цонхоор битгий гар. Хаалгаар гарцгаа. Та нар долуул байхад бид арван тавуулаа ирсэн! Та нарт зайлах газар алга гээд гаднаас харуулын цагдаа нарыг дагуулан оруулаад дээрэмчдийг бариулж хүлүүлэв.

-Гары нь дөнгөлөөрэй гэж Жавер тушаагаад дээрэмчдийн нэр усыг асууж бүртгэж гарчээ.

Жавер орноос хүлээтэй байсан Цагаан ноёны хүлгийг тайлуулаад хүлээж бай гэж хэлээд дээрэмчдийг асууж байцааж дуусаад:

-Хүлээтэй хүнийг нааш ирүү гэжээ.

Цагдаа нар цөм эргэн тойрон харав.

-Яваа? Алга болоо юу? гэж Жавер асуув.

Жавер дээрэмчдийг асуун байцааж байх хоорондуур тэр хүн цонхоор үсрэн гарч оргон алга болсон ажээ.

Жавер шүд зуун:

-Ээ золигоо хамгийн аюултайгий нь алдлаа гэжээ.

## VI

### УЙЛЖ СУУСАН ХҮҮ

Дээр дурдсан хэргийн дараах өдөр нэг жаал хүү Аустерлицны гүүрээс Фонтэньблу орохоор явжээ. Уранхай хувцастай эцэнхий тэр хүү чадлаараа дуу аялан явжээ. Хүү явсаар жижиг Банкье гудамжны булан хүрээд хог ухаж байсан тахир эмгэнийг дайрснаа огл харайгаад:

-Хүүш яадаг билээ! Би тэнд томоос том нохой байна гэж бодсон юм гэхэд эмгэн өндийн

-Яалаа гэнээ! Чадалтайсан бол хонгоны чинь махыг зулгаах сан! гэжээ.

Энэ үед хүү нилээд холдоод

-Зулгаа, зулгаа! Зулгаадаг бол та нохой мөн дөө. Хэдийд зулгаадаг байлаа гэж эмгэний уурыг улам хүргэжээ.

Цонхигор цагаан нүүрний нь үрчлээс зүг бүр арзайн салбарлаж завжинд нь тулсан, эмгэн бүр өндийж зогсоход ядралын туйлд хүрсэн нь илэрхий үзэгдэв.

Хүү эмгэний байдлыг хараад:

-Таны байдал төлөв миний сэтгэлд тохирохгүй байна гээд цаашаа явахдаа:

Хээр гарч

Хэрээ алахаар

Күпдесабо хаан

Хэсүүчлэн явжээ...

Гэж дуу аялсаар 50/52 дугаарын байшинд очиж хаалгы нь балбажээ.

Ард нь хоцорсон нөгөө эмгэн уурлаж үглэсээр хүүг гүйцэн ирж:

-Юу вэ? юу вэ? Бурхан минь. Хаалга үүд хэмхчиж хамаг юм сүйтгэлээ чи! Гэж ашлав.

Эмгэн тэр хүүг ажин хрж гамен мөнийг таниад:

-Энэ чинь манай гайхал чөтгөр байна шүү гэхэд хүү:

-Сайн байна уу! Та манай Бүргөмүш гуай юу? Би өвөг дээдэстэйгээ уулзахаар ирэв гэхэд эмгэн:

-Хэнд ч энд байхгүй гэв.

-Юу! Аав хаачсан бэ?

-Форс шоронд орсон шүү

-Мөн! Ээж хаачсан бэ?

-Сэн-Лазар орсон.

-Тэгвэл миний эгч нар яасан бэ?

-Модлонет руу явсан.

Хүү чихээ маажиж:

-Аах яасан хэцүү юм бэ? гэж санаа алдав.

Хүү өсгий дээрээ эргэж холдон одождоо:

Хоёр модоор

Хөл хийсэн

Күбдесабо хаан

Хээр гаран

Хэрээ алахаар

Хэсүүчлэн агнахдаа  
Хоосон хүнд  
Хоёр сүг  
Хаядаг байх..  
Гэж дуу аялсаар далд оржээ.

## **ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ**

# **ПЛЮМЕ ГУДАМЖНЫ БАЙДАЛ БА СЭН-ДЕНИ ГУДАМЖНЫ ТУХАЙ ТУУЛЬ**

## **НЭГДҮГЭЭР ДЭВТЭР**

## **АНЖОЛРАС БА ТҮҮНИЙ ТУСЛАГЧИД**

Тухайн байдлыг тодорхой мэдсэн Анжолрас нууц шалгалт явуулав:  
Бүгд, “Мюзэн” гуанзанд цугларч нууц хурал хийж байсан аж.  
Анжолрас:

-Хүчээ бүртгэн үзэж, хэнд найдахаа бодож олоход хялбар санж. Цэрэгтэй болохыг хүсэгч хүн тэднийг олж бэлтгэх хэрэгтэй. Дайтахад хэрэгтэй зүйлээ бэлтгэх ёстой. Бид хүчээ бүртгэе. Үүнийг хойш тавих хэрэг алгаа. Хувьсгалч нар дандаа яарах нь чухал. Дэвшилтат ёс өөд хурдан тэмүүлцгээе! Гэнэтийн аюулд автагдахаа байцгаая! Сэрэмжгүй байж бусыдн гарт орохоо байя. Газар болгоноо шалгаж үзье. Өнөөдрийн дотор ажлаа төгсгөл болгон дуусгая. Курфейрак чи олон төрлийн мэрэгжлийнхтэй очиж уулз. Лхагва гаригт тэд амарда юм. Фой Гласвер ор. Комбефер Пикпюс гудамжинд очихоор болсон. Тэнд их хөдөлгөөнтэй байгаа байх. Баораль Эстрапад руу оч. Прувэр Гренэль-Сэнт-Оюрэ гудамжны хуурамч байдлыг мэдээд ир. Жоли хүн эмнэлгий нсургуулийн байдлыг очиж мэ. Боссюэ чи шүүхийн танхим хүрээд залуучуудтай уулз. Би өөрөө Күгүрд явъя гэж хэлэхэд Курфейрак:

-Зүйтэй гэв.

-Болоогүй байна.

-За юу болоогүй байна вэ?

-Онц чухал хэрэг байна.

-Ямар хэрэг вэ? гэж Курфейрак асуусанд Анжолрас:

-Мэнийн талбайд очих хүн алга. Тэн зурагчид, чулуучид, сурагчид олон бий. Тэд идэвхтэй улсууд юм шүү очиж хөдөлгөх хэрэгтэй. Одоо тэнд чухам юу юм болж байгааг бас сайн мэдэхгүй байна. Сэтгэл санаа нь үймэрч гутаж байгаа байх. Тэр зүүг рүү би мартагтай Мариусыг явуулах санаатай байсан юм. Гэтэл Мариус ирсэнгүй. Явуулах хүн олдохгүй байна гэхэд Грантэр

-Би явах уу? Би энд байна гэв.

-Чи юү?

-Тийм ээ.

анжолрас шийдэмгий байдалтайгаар:

-Грантэр чи яв даа. Чамайг туршиж үзье гэж хэлэв...

Хорин хэдэн минут өнгөрсний дараа нууцаар хуралдаж байсан залуучууд цөм ноогдсон газар луугаа явчсан байж...

## **ХОЁРДУГААР ДЭВТЭР**

### **ЭПОНИНЬ**

I

#### **БОЛЖМОРЫН ТАЛБАЙ**

Тенардьегийнд болж байсан хэргийг цоорхойгоор шагайн харж байсан Мариус, Жавер хэдэн гэмт этгээдээ тэргэнд суулган явсны дараахан бас гэрээсээ гарч одов. Мариус Курфейракийнд очихоор зүглэжээ. Мариус явсаар Шилний гудамжинд сууж байсан Курфейракийнд очиж:

-Би танайд унтахаар ирлээ гэхэд Курфейрак орон дээрэс гудас авч газар дэвсээд:

-Унт даа гэжээ.

Маргааш өглөөний долоон цагт Мариус Горбо овоохойд буцаж очоод өөрөө төлөөд, байдаг юмаа тэргэнд ачаад нүүжээ... Нутаг сольсон.

Мариус хоёр сар гаруй болтол Курфейракийнд суиж амьдарсаар байх болжээ.

Өөрийн таних залуу өмгөөлөгчөөс Тенардые яс цоожинд суусныг мэдээд Ма<sup>о</sup>иус даваа гариг бүр Тенардьед таван франк дамжуулан өгдөг байлаа.

Өөртөө мөнгөгүй болсон Мариус Курфейракас тав таваар нь мөнгө зээлдэж өгдөг байжээ.

Гэсэн ч Мариусын амьдрал тогтвортой биш. Хайрыг булаасан охиноо олж харахаа байсан Мариус сэтгэлийн гунигт автагджээ.

Нэг өдөр гадуур зугаалж яваад тохиолдсон хүнээс

-Энэ ямр нэртэй газар вэ? гэж асуусанд:

-Болжморын талбай гэдэг юм гэжээ.

Үүнээс хойш Мариус Болжморын талбай бол миний хайрт охины явдаг газар байх ёстой гэж бодоод өдөр болгон түүгээр явж сэтгэлээ хуурдаг байж.

II

#### **МАБОФ, МАРИУС ХОЁРТой ТОХИОЛДСОН ЯВДАЛ**

Мабоф өвгөн өдөр болгон цэцэрлэг ногоны ажил эрхэлж амьдардаг байлаа. Нэг өдөр Мабоф өвгөн цэцэрлэг дотуураа явж байтал үл таних дуу:

-Мабоф гуай би таны цэцэрлэгийг услаад өх үү? Гэжээ.

Энэ чинь хэн байдаг билээ гэж эргэн харахад нь туранхай, өндөр нуруутай охин зогсож байжээ. Тэр охин нүд ирмэхийн завсар хувинд ус хийж цэцэрлэг усалж эхэлжээ. Охин цэцэрлэг усалж дуусахад өвгөн:

-Заяа муутай ах чинь чиний тусыг юугаар хариулах билээ дээ? гэхэд охин:

-Та над нэг зүйлээр тусалж чадах байха гэв.

-Юугаар туслах вэ?

-Ноён Мариус хаа суудгийг хэлж өгвөл их тус болноо.

Өвгөн ойлгож ядан:

-Ямар ноён Мариусыг хэлнэ вэ? гэсэнд охин:

-Танайд байсан залуу яагаа вэ дээ гэжээ.

Мабоф баахан бодож байгаад:

-Болжморын талбайд яваад очтол тэнд чи түүнийг олж харах болно гэжээ...

Мабоф өвгөн үл таних охинтой танилцсанаас хойш хэд хоносны дараа Мариус Курфейракаас таван франк зээлдэн аваад Тенардые дээр очихын өмнө гадуур зугаалж явтал нэг хүний дуу:

-Нөгөө залуу маань энэ байна гэжээ. Мариус гайхаж харсанд, дээрэмчин нарын хамтаар Цагаан ноёныг алах гэж байсан Тенардыегийн охин Эпонинь мөнгийг мэдэв.

Эпонинь Мариусыг таниад:

-Би таныг мөн их гайхлаа. Хайсныхаа үрийг ч үзлээ. Таныг хайсаар зургаан долоо хонолоо. Мабоф өвгөн над таны явдаг газрыг зааж өгсөн юм. Тэгээгүй бол би таныг олохгүй байх сан. Та одоо хаа ямар газар сууж байна вэ? гэхэд Мариус чухам хаа сууж байгаагаа хэлсэнгүй.

Эпонинь:

-Та намайг тус хүргэвэл юм болгоноор тусална гэснээ санаж байна уу? гэхэд

Мариус:

-Саналгүй яах вэ! Чи ямар тус хүргэх гээ вэ? гэв.

-Би түүний суудаг газрыг мэдсэн.

-Хэний суудаг газар вэ?

-Хаа суудгийг мэдээд өгөөрэй гэж та надаас өөрөө гуйсан биш билүү? Нэг охины байдаг газрыг мэдээд хэлээрэй гэснээ мартаа юу?

-Аа тийм! Хаа байна аа? Намайг дагуулаад яваачээ! Би чамд хүссэн бүхний инь өгье гэхэд Эпонинь:

-Намайг дагаад яв! Яг байгаа хаягийг нь би сайн мэдэхгүй. Хэлж чадахгүй байна. Би таныг дагуулж аваачаад суудаг байшинг зааж өгье гэв.

Мариус тэр охины байгаа газрыг Тенардыед бүү хэлээрэй гэж Эпониниос ихэд гуйсан учир Эпонинь эцэгтээ огт дуулгахгүй байя гэж ам алдсан байна.

Эпонинийн тус хүргэсний хариуд Мариус өвөртөө байсан таван франкийг авч өхөд Эпонинь авсангүй:

-Таны мөнгө над хэрэггүй гэж хариулжээ.

## **ГУРАВДУГААР ДЭВТЭР**

## **ПЛЮМЕ ГУДАМЖ ДАХЬ БАЙШИН**

I

### **НУУЦЛАГДСАН БАЙШИН**

Нууц амрагтай байсан Парисын түүхийн танхимын дарга өнгөрсөн зууны дунд үеэр Сэн-Жермэний орчимд айл амьтнаар ховор Плюме гудамжинд хоёр давхар байшин барьжээ. Байшингийн хажууд нилээд хэмжээний цэцэрлэгт тарьжээ...

1829 оны аравдугаар сард гуалиг нуруутай нэг хүн тэр байшинг хөлслөн авч хуучин эзний үлдээсэн гэрийн хэрэгслүүдийг засан тохижуулаад зарим нэг зүйлийг шинээр нэмжээ.

Байшинг хөлслөн авсан хүн Жан Вальжан байж. Жан Вальжан Козетт охин, зарц авгай Түсэ нарын хамт нүүдэллэн ирж, баян хөрөнгөтөн Фошлеван гэдэг нэрээр тэнд суурьшжээ.

Жан Вальжан чухам ямар шалтгаанаас жижиг Пикпюс гудамжнаас энд нүүж ирсэн бэ? гэхэд онцын шалтгаан байхгүй ажээ.

Жан Вальжан сүмд байхдаа Козеттоо өдөр болгон нүдээрээ харж сэтгэл зовох юмгүй тайван жаргалтай байж. Охиноо олноос тасархай авч амьдралтай танилцуулахгүй зожиг болгох нь тусгүй зүй бус хэрэг гэж боджээ. Козетт өсөж томорсон хойноо намайг буруутай олиггүй хүн гэж буруушаах магад гэж бас Жан Вальжан болгоомжлов. Охиноо хойчийн өдөр гомдоохгүйн тулд сүмийг орхиж зайлсан ж. Өвгөн Фошлеван нас барж, Козетт сургуулиа төгсөх цагийг тохиолдуулан Жан Вальжан сүмийн эзэн ламд бараалхаж, хөдөө гарч өмч хөрөнгөндөө эзэн болон амьдрах хүсэлтэй байгаагаа илэрхийлж. Козеттоо аваад сүмээс гарсан байжээ. Ямар нэг осол болж Жавер мэтийн амьтны гарт орохгүйн тулд Жан Вальжан хотын хоёр хэсэгт хоёр байр авчээ. нэг байр нь баруун гудамжинд, нөгөө нь зэвсэгт хүний гудамжинд байж. Энэ хоёр гудам хоорондоо алслагдсан учир Жан Вальжан Козеттоо дагуулан нэг гудамжнаас нөгөөд нь очиж сар хиртэй болж явдаг байлаа. Үүнээс гадна Жан Вальжанд бас гурав дахь байр байсан аж.

## II

### БЭРХШЭЭЛТ БАЙДАЛ

Козетт сүмээс гарахдаа -ас залуу дөнгөж арван дөрөв хүрч байлаа. Арван өөрвөн настай охин аливааг мөрөөдөн хүсэх болсон байна...

Козетт сүмээс гарч Плюме гудамжинд очоод эрх чөлөөтэй золгосон боловч ба± л ганцаардмал хэвээрээ байж. Жан Вальжан гэрийнхээ хажууд байга цэцэрлэгийг зааж “чи энд юу дуртайгаа хийж байгаарай” гэж Козеттод хэлэв. Козетт охин хүүхэн болж хүсэл мөрөөдөлд ортлоо цэцэрлэг дотуур явж навч ногоо сонирхож чулуу наадам цуглуулн эрхэлж өдрийг өнгөрөөнө. Өөрийн тулгуур болсон Жан Вальжаныг эцэг шигээ хайрлан өхөөрдөж дэмжиж тусална. Жан Вальжан хуучныхаа адилаар ном их уншиж түүнийгээ Козеттод ярьж өгдөг байлаа. Люксембургийн цэцэрлэгт орон хоёулхнаа сууж байхдаа насан турш үзсэн уншсан болгоноо Козеттод уран хоншоор ярьж өхөд Козетт анхааран сонсож хүсэл мөрөөдөлд ордог байжээ.

Козетт сайн санаат эцгээ үргэлж дагаж явахдаа дуртай...

Козетт нэг өдөр толинд нүүрээх араад үзэсгэлэнтэй болсноо мэдэж сэтгэл нь аймшигтай хөдөлжээ. Үнэн хэрэг дээрээ Козетт улам гоё царайтай болж бие нь хөөрхөн хэлбэртэй болсоор байхыг харсан Жан Вальжаны сэтгэл түгшүүртэй болжээ.

Охин Козеттын төгөлдөр үзэсгэлэн орчин тойрныхоо анхаарлыг татмаар болоход өвгөн Жан зовох болов.

“Энэ чинь яасан гоё охин болоо вэ? Би одоо яах билээ?” гэж Жан Вальжан дотроо бодно.

Урьд дандаа Жан Вальжантай хамт байхыг хүсдэг байса- Козетт

-Аав аа та явж зугаал д а, ганцаараа гэх болжээ...

Ганцаардмал тайван байсан Козетт янаг дурлалыг мөрөөдөх боллоо. Мариусын байдал Козеттынхтой мөн нэг адил байжээ.

Аадрын бороог асJаруулан шүршиж аянгын цахилгаан»г гялалзуулан байж аясын салхинд хөөгдөн нийлдэг агарын багсар үүл шиг амраг хоёрын учрах цаг аргагүй нэг тохиолдох бизээ...

Козеттын байдлыг туршиж Жан Вальжан нэг өдөр:

-Люксембургийн цэцэрлэгт очих уу? гэхэд Козеттын царай өнгө орж:

-Очьё гэжээ.

Тэд Люксембургийн цэцэрлэгт очихоо болсьноос хойш гурван сар өнгөрчээ. Мариус мөн цөхрөлөө бараад тэнд очихоо больсон байж.

Тэр хоёр Люксембургийн цэцэрлэгээр зугаалавч Мариус эс дайралджээ.

Маргааш нь Жан Вальжан:

-Люксембургийн цэцэрлэгт очих уу? гэж асуухад Козетт:

-Үгүй гэж хариулжээ...

## **ДӨРӨВДҮГЭЭР ДЭВТЭР**

## **БУСДЫН ДЭМЖЛЭГ БУРХНААС ИЛҮҮ**

I

### **ОЛСОН ШАРХЫГ СЭТГЭЛЭЭР ЭМНЭВ**

Жан Вальжан Козетт хоёрын амьдрал, өдрөөс өдөрт гунигтай болсоор.

Тэд өлссөн хүмүүст талх өгч, даарсан олонд хувцас тусалж сэтгэлэ тайтгаруулж цагийг өнгөрөөх боллоо. Жан Вальжан Козетт хоёр ядуучуудтай уулзаж, ядарсан зүдэрсэн олон хүүхдийг баясгаж чадвал Козетт ойрдоо овоо баясгалантай байдаг юм. Иймэрхүү амьдралтай болоод байх үедээ тэд Жондретынд очсон аж.

Маргааш нь Жан Вальжан гартаа хүнд шархтайгаар тайвн буцаж ирээд яагаад шархтсанаа дутуу дулимаг тайлбарлажээ. Олсон шархнаасаа болж Жан Вальжан бүтэн сар гэртээ өвчтэй хэвтжээ.

Козетт эцгийнхээ шархыг өглөө, орой бүр аятай зөөлнөөр хичээнгүйлэн бооход Жан Вальжаны сэтгэл улам баясах боллоо.

Козетт өдөр турш Жан Вальжаны дэ°гэд байж аялал жуулчлалын тухай ном уншиж өхөд өвгөний сэтгэл баясаж элдэв муу юм бодохоо больдог байв. Козеттын уяхан хоолойг сонсож суухдаа Жан Вальжан улам сэтгэл сэргэж, урган цэцэглэж байгаа байгалийн гоёмсгийг харан:

-Миний охин дандаа гэрт битгий суу. Гадуур цэцэрлэг дундуур зугаал гэхэд Козетт:

-Тэгье дээ гээд цэцэрлэг дотроо зугаалан явах болжээ.

II

### **ЭМГЭН ПЛЮТАРКИЙН ЯРИА**

Нэг орой Гаврошид идэх хоол байсангүй. Гаврош урьд орой нь ч гэсэн хоол олж идээгүй санж. Гэдэс өлсөж гунихарсан Гаврош хүү Сальпетриерийн хаиар явж хүнгүй газраас олз олж хоол идэхээр шийдээд замын нэг тосгонд хүрч цэцэрлэг дотроос алим авч идэхээр хашаагаар орох газар хайж байтал цэцэрлэгийн доторхи чулуун сандал дээр өвгөн сууж, түүний өмнө эмгэн зогсож байхг үзэв. Эмгэн өвгөн хоёр хоорондо ярилцаж эхлэв.

Эмгэн ь

-Мабар гуай минь ээ! Манай эзэн уурлаад байх боллоо гэхэд өвгөн

-Юунд гэж асуув.

-Бид бүтэн есөн сарын мөнгө төлөөгүй байна.

-Гурван сарын дараа арван хоёр сарын төлбөрийн өртэй болох нь ээ.

-Биднийг гудамжинд гаргаж хаяна гэж хэлсэн. Манайд түлэх түлш ч алга.

Худалдаад авъя гэхэд мөнгө бас алга.

-Нарны элчээр амьдарна даа.

-Махны худалдаачин мах өхөө байсаа.

-Зүгээр юм биш үү, Би мах шингээхээ больсон. Мах идэхээр гэдэс өвдөөд байх

юм.

-Өдрийн хоол юугаар хийх вэ?

-Талх байвал болноо.

Талхны худалдагч мөнгөгүй бол талх өхгүй гэсэн.

-Та юугаа идэх юм бэ?

-Эмгэн Плютарк минь манайд алим байна шүү дээ.

-Үгүй мөнгөгүй яаж амьрах юм бэ?

-Над мөнгө алга гэж хариулахад эмгэн гэр лүүгээ явж өвгөн байрандаа үлдэв.

Гаврош өвгөний дэргэд мөлхөн очоод хэвтэж байтал харанхуйд дунд хоёр хүн цувран ирж яваа харагдав. Айсуй хоёр хүний нэг нь Монпарнас мөнийг Гаврош танив.

Монпарнас хамт яваа хүнээ багалзуурдан автал өвгөн байдаг чадлаараа үзэлцэж дээр доро орон ноцолдож байгаад залууг дороо хийв...

Өвгөн босож

-За бос чи! Гэхэд Монпарнас уруу царайлан өндийхөд өвгөн:

-Чи хэдэн настай вэ? гэв.

-Арван естэй.

-Чиний бие эрүүл чадалтай байж юунд ажил хийдэггүй юм бэ?

-Ажил хийхэд уйтгартай байна.

-тэгээд чи юу хийдэг хүн бэ?

-Зүгээр суудаг

-Чи ямар ажилтай байх дуртай вэ?

-Хулгайч болох дуртай гэж Монпарнас хариулахад өвгөн:

-Амьд насанд ажил хийж хоолоо олж идэхээс илүү жаргал байдаггүй юм. Хэн ажил хийхгүй байна вэ, тэр хүн хүний муугаар амьдардаг. Амьд явахын нэг хууль бол ажил хийх явдал мөн. Бусдын хүчээр амьдарна гэдэг бол гэмт хэрэг үйлдэж байгаа хэргээ. Хулгайч болно гэдэг адгийн хэрэг гэх мэтээр өвгөн ятгаж байгаад:

-Чи надаас юу авах гээ вэ? Чамд миний түрийвчтэй мөнгө хэрэгтэй юу? Май ав, энэ мөнгийг гэж мөнгөө өгөөд жиг ч үгүй цааш явчи.

Энэ үеэр Мабор үүрэглэсээр байв.

Гаврош чив чимээгүй мөлхөн явсаар Монпарнасын ард очоод нөгөө хүний өгсөн түрийвчтэй мөнгийг халааснаас нь сэм суга татан аваад могой шиг гэдрэг мөлхөн буцжээ.

Гаврош бусдын халааснаас хулгайлсан мөнгөө Мабор өвгөн рүү шидээд жирийлгэж алга болов.

Хөлний нь дэргэд түрийвчтэй мөнгө тусахад Мабор нойрноос сэрж газарт хэвтээ мөнгийг авч гэртээ ороо гайхаш тасрахдаа  
-Май, энэ мөнгө тэнгэрээс уналаа гэж Плютарк эмгэнд хэлжээ.

## **ТАВДУГААР ДЭВТЭР**

# **ЭХЛЭЛТЭЙГЭЭ АДИЛГҮЙ ТӨГСГӨЛ**

I

## **ХҮНГҮЙ ГАЗАР ГАРСАН УЧРАЛ**

Дөрөв таван сарын өмнө хүн хүнд байсан Козеттын сэтгэлийн зовлон аажмаар багасаж эхлэв. Хавар болж хамаг байгаль цэцэглэн ногоороход бага залуу Козеттын сэтгэл уяран тайвширч элдэв бодол мартагдсаар зүрх сэтгэл нь хөдлөхөө больж хайрт эцгээ хамгаалахаас өөр хүсэл мөрөөдөл бараг гарахаа байв.

Козет гэнэт нэг өдөр Мариусыг санаж: “Би түүнийг мөрөөдөхдөө больдог яасан хачин явдал бэ?” гэж боджээ.

Козетт мөн тэр нэг долоо хоногт сагсалзсан гялгар цэрэг хувцастай, нимгэн зөөлөн царайтай цэргийн дарга нэгийг үзжээ. Энэ дарга Козеттын гэрийн гадуур олон дахин өнгөрөх болж. Тэр дарга Жильнорманы ойр төрлийн Теодюль байж. Теодюлийн нөхөд:

-Чамайг нэг хөөрхөн амьтан нүднийхээ булангаар нууцхан харад байх боллоо, чи юу гэж бодож байна вэ? гэжээ.

Яг энэ үеэр Мариус дахин тайван бус байдалд орон: “Үхэхээсээ өмнө чамайгаа олж харах сан” гэх болж. Хэрэв Козетт цэргийн даргыг нууцаар харж байгааг энэ үед Мариус үзсэн бол тэр дороо үхэх байжээ...

Козетт сэтгэл хэдийгээр нэг үе тайвширсан боловч гантигийн гадаргууд дөнгөж дангаж наалдаж байгаа цэцгийн үр шиг тогтворгүй болсон аж:..

Козеттын сэтгэл зүрхэнд юу нуугдаж байсан болоо? Гэвэл ганцхан тайвшран нуугдсан хайр дурлал буцлан сэргэх үеэ хүлээж байв.

Энэ үед эвгүй учрал тохиолдсон аж.

Дөрөвдүгээр сарын эхний өдрүүдэд Жан Вальжан ажил хэргээр гадагш явахдаа: “Гурав хоноод ирнэ шүү” гэжээ.

Жан Вальжан байхгүй хойгуур Козетт оройн цагаар “Анчид төөрсөн нь” гэдэг дуу аялан дуулаад аргагүй янзын бодолд оржээ.

Цэцэрлэгийн дотор ямар нэг хөлийн чимээ гарахыг Козетт гэнэт сонсов. Цонхонд ойртон очиж чагнавал эрэгтэй хүн явж байх бололтой. Дээш гүйж хоёрдахь давхарт гараад цонх онгойлгон харвал цэцэрлэгт хэн ч байсангүй. Тэхэд чихэнд нь дэмий юм сонсогдсон байлгүй дээ гэж боджээ.

Маргааш өдөр нь бүрэнхий болох гэж байх үеэр Козетт мөн цэцэрлэг дотуураа зугаалж явав. Гэтэл бас л хөлийн чимээ сонсогдох шиг болжээ. Козетт гэртээ орохоор явж битал усанд туссан сүүрээ хараад зогссонд тэр усан дотор дугариг малгатай хүний дүр бас цухалзжээ. Козетт сандрахдаа хөдөлсөн ч үгүй, үг ч

дуугарсангүй. Хэсэг зуур дүжирсэн шиг зогсож байгаад ажин харахад хэн ч хавьд нь байсангүй. Орчин тойрноороо сайн шагайж харавч нөгөө хүний сүүдрдийг ер олсонгүй.

Жан Вальжаныг ирэхэд Козетт үл таних сүүдэр үзэгдээд лга болсныг тоочин ярьсанд:

-Хачин юм даа! гэж гайхжээ.

Козетт шөнө унтаж байгаад нойрон дунд гадаа юм хөдлөөд байх шиг болохоор босон харайж цонхоо онгойлгон харсанд гартаа том таяг тулсан хүн явж байх нь үзэгдэв. Козетт хашгирах гэтэл сарны гэрэл тэр хүний нүүр дээр тусахад эцэг нь явж байхыг мэдэв. Жан Вальжан сэрэмжилж гурван шөнө унталгүй цэцэрлэг дотроо явж хоножээ.

Гурав дахь шөнөдөө Жан Вальжан:

-Козетт оо! Гэж дуудахад Козетт гүйн гарсанд эцэг:

-Чамайг айлгаад байдаг сүүдрийг хар даа гээд шалбааг руу заау.

Козетт ширтэн харвал яах аргагүй дугариг талгайтай хүний сүүдэр шиг юм усан дотор гүвэлзэж байв. Тэр дүр Үол дээрээ бөмбөгөртэй янднгийн сүүдэр мөн байлаа.

Үүнийг эцэг охин хоёр олж мэдээд санаа амарч инээлджээ. Гэсэн ч хэд хоногийн дараа дахин нэг учрал болов.

Мөн дөрөвдүгээр сард Жан Вальжан юманд явсан, байхгүй хойгуур Козетт орой цэцэрлэг доторхи сандал дээр амран сууж байлаа. Сэрүүн салхи үлээж сэтгэлд аятай ургаа мод найган ганхаж үлээх салхитай шивнэлдэх мэт.

Козетт сууж байсан газраасаа босож элдвийг бодон нилээд зугаалж яваад буцаж сандал дээрээ очиж суутал сандлын тэнд нилээд томоохон чулуу шинээр бий болсон харагджээ. Козетт дахин айж цочин бодолд автагдаад гэртээ түргэн орж унтав.

Өглөө нь босоод нөгөө чулуугаа авч үзэхээр шийдэж газраас авбал харин дор нь захидал аятай цаас байж. Козетт түүнийг шүүрэн авч онгойлгосонд дотор нь уран үгээр урсган бичсэн захидал байлаа.

## II

### ЧУЛУУНД ДАРАГДСАН ЗҮРХ

Тэр захидалд дурдсан нь:

Ертөнцийг биедээ агуулсан бурхан бол дурлал.

Дагинаас одон ертөнцөд илгээсэн баярыг дурлал гэдэг.

Дурлалд автагдсан сэтгэл мөн ч гунигтайяа. Олны анхаарлыг татагч онцгой амраггүй суух мөн ч уйтгартай байна. Хайрыг татсан хүн ахмгаас лүү байдаг гэдэг мөн ч үнэн юм да. Амрагийн харц алтан дэлхийд ховорхон... гэх мэтээр хагацсан сэтгэлийг хайргүй илэрхийлэн тэр захиа төгссөн Үоловч хаанаас хэний үр хэн гэгч бичсэн нь тодорхойгүй байжээ. Янагийн захиаг уншсан Козетт ямар ч аргагүй сэтгэл хөдлөн огсож байтал нөгөө ганган дарга. Теодюль гэрийн хавилдуу ихэмсэг зантайгаар алхалж явах нь аягүй санагдав. Тэр дарга үзэсгэлэнтэй мэт харагдагч үнэн зүрхний амрагаас илүү байж чадсангүй...

Орой болж Жан Вальжан явсны дараа Козетт гоёж эхлэв. Нүүр гараа засаж үс гэгээ самнаад гоёлынхоо хувцсыг өмссөн Козетт цэцэрлэг дотуураа зугаалан явсаар сандал дээрээ очиход нөгөө чулуу хуучин янзандаа байсаар байв. Козетт сандал

дээр суугаад хайрлан энхрийлж байгаа мэт хажуугийнхаа чулууг аяархнаар алгаараа дарав.

Гэнэт Козеттын бие аягүй болж хажуудаа хүнтэй байгаа шиг санагдахад эргэн харвал сэтгэлийн нь амраг сэмхэн ирээд зогсож байжээ. Борх зүрх нь пол пол цохилсон Козетт босон харайж гэдрэг ухарсаар гэнэт нэг модыг тулан зогсож хоёр нүдээ бүлтийлгэн холоос ирсэн хүүгээ ойртож ядан ширтжээ. Учраагүй удсан өнөөх залуу:

-Намайг ирлээ гэж бүү сандар даа. Сэтгэл зүрх минь уйтгар гунигт дарагдаад байхлаар сэм чамда би ирлээ. Бичсэн захидлаа чулуун дор хийсэн юмсан. Бишгүй чи уншиж үзсэн байх. Битгий сандар даа. Анх уулзсан азтай тэр цагийг санаж байна уу? Түүнээс хойш тун ч удаж даа. Люксембургийн цэцэрлэгт бид нэг нэгийгээ анх харснаа санана уу? Тэхэд зургадугаар сарын арван зургаан байж билээ. Чамайгаа алга болсноос хойш чадлынхаа хирээр их ч хайж явлаа. Нэг удаа дулж байхы чинь сонсоод магнай тэнийсэн юм. Би чам дээрээ байн байн ирж байя. Миний үхэх ч ойртсон бололтой. Дурласан сэтгэлээ илэрхийлэн хэлэх үг олдохгүй байна. Би хэлж бацаа үгээ ч өөрөө сайн ойлгохгүй байна шүү. Битгий над уурлаарай мэдэв үү? Гэв. Козетт:

-Яах вэ! гээд мансууран унах гэтэл Мариус ухасхийн тогтоож гуйван дайван байж амраг бүсгүйгээ тэврэн авч хүчтэй дурласны улмаас юу хийж байгаагаа өөрөө мэдэхгүй тулгардан байхад Козетт хоёр гары нь аятайхнаар атган зүрхэн талдаа тулгасанд Мариус:

-Чи надад хайртай юу? гэхэд Козетт үл сонсогдохоор шивнэн:

-Надаар хэлүүлэх юу байх вэ, чи өөрөө ойлгож байгаа биз гэжээ.

Козетт улаан нүүрээ дурлалд мансуурсан залуугийн цээжинд наахад хоёул сандал дээр суугаад хоёр амаргийн хушуу нийлэхэд холын од гялалзан ширтэв.

Учирсан хоёр үнсэлцэн дасаад урьд урьдаасаа харанхуйн дунд баясгалант нүдээ гялалзуулж ширтэлцэв.

Козетт толгойгоо залуугийн мөрөн дээр тавиад:

-Нэр чинь хэн бэ? гэхэд

-Миний нэр Мариус. Чиний нэр хэн гэдэг вэ? гэсэнд

-Козетт гэдэг гэжээ.

Сэрүүхэн салхи илбэж моны мөчрийг найгуулсан сэлүүхэн шөнийн гүнд учран золгосон хоёр үгээ ярилцан суув.

## **ЗУРГАДУГААР ДЭВТЭР**

## **ЖААХАН ГАВРОШ**

I

## **ШООВДОРЛОГДСОН НЬ**

1823 оноос эхлэн Тенардьегийнх хоосрон доройтож, өрөнд баригдав. Тэр үед тэднийх хоёр охин, гурван хүү бүгд таван хүүхэдтэй болжээ.

Тенардые авгай сүүлчийн хоёр хүүхдээсээ холдон салж санаа амарчээ. Энэ эх хүний шинжээ алдаж зөвхөн хоёр охиноосоо бусдыг үзэн яддаг байжээ. Эрэгтэй хүүхдээ бодохоос бөөлжис нь хутгадаг байж.

Тенардыегийнхэн хоёр нялх хүүхдээсээ яаж яс хагацсаныг тайлбарлая.

Жильнорманаас болж хоёр эрэгтэй хүүхэд төрүүлсэн Маньон авгай хүнд эпидеми өвчин дэлгэрэх үед хоёр хүүгээ нэг өдөр үхүүлжээ. Хоёр хүүхдийнхээ хүчээр тэтгэврийн наян франк сар бүр авдаг байсан Маньон төрсөн үрээсээ хагацаж хүнд байдалд орж тэтгэвэр авах эрхээ хасагдахад тулгарчээ. Хүнд байдлаас мултрахын тулд Моньонд хоёр эрэгтэй хүүхэд хэрэгтэй болов. Гэтэл нас хүйгээр тохирох хоёр хүүхэд Тенардыегийн бйасан аж. Маньон авгай Тенардыегийн хоёр хүүг авахаар болоход Тенардые тэднийг өгсний шагналд сар бүр арван франк авахыг шаарджээ. Маньон авгай олон таван үггүй хоёр хүүг аваад сар бүр алдалгүй Тенардыегийн арван франк төлсөөр байв.

Маньон авгай ч гэсэн хоёр хүүхдээ огт үхүүлээгүй хүн болж Жильнорманаас сар бүр наян франк авсан хэвээрээ үлджээ. Өөрийн төрсөн хүүхдийг үхүүлээд хүний хүүхэд аваад байгааг Жильнорман гэсэн ер мэдсэнгүй, Жильнорманаас хагас жилд хоёр хүүхдээ нэг удаа эргэж ирэхдээ ч гэсэн хоёр хүүхэд нь үхээд оронд нь хүний хүүхэд олоод байгааг огт мэдэхгүй явах болов. Жильнорман хүүхдээ харахаар ирэхэд Маньон:

-Энэ хоёр хүүхэд тантай мөн ч адилхан шүү гэхэд Жильнорман сэжиггүй буцдаг байлаа.

Хүнд хоёр хүүгээ өгсөн Тенардые тэр цагаас эхлэн Жондрет гэдэг нэртэй болж нэрээ өөрчилсөн аж. Тенардыегийн хоёр охин, хүү Гаврош нар хоёр жижиг дүүтэй байгаад алдсанаа бүдэг бадаг мэддэг байжээ.

Маньон авгайнд тэр үед аюулт дээрэмчин англи авгай толгой хоргодон сууж тонох дээрэмдэх бузар ажлаа явуулдаг байлаа.

Жондретынх баригдсаны улмаас бөөн хулгайч нарын үүр уурмай илрээд дээрэмчин англи эмэгтэй, Маньоны хамт мөн шоронд оржээ.

Тэхэд Тенардыегийн хоёр жаал хүү орох орон оочих усгүй болж гудамжны тэнэмэл хүүхэд болон хувирсан байна.

## II

### ГАВРОШИЙН АЧ ТУС

Хавар цагт Парист хойт зүгийн хүйтэн салхи салхилж тухгүй байдалд орох нь олонтой.

Их са«хитай зутруу орой уранхай муу хувцастай боловч дандаа хөгжил баясгалантай явдаг жаахан Гаврош үсчний байшингийн дэргэд зогсож байжээ. Үс засуулж байгаа эмэгтэйг Гаврош ажиглан харж байтал нэг нь тавтай, нөгөө нь долоотой бололтой хоёр жижиг хүүхэд чихэлдсээр үсчний хаалга руу ороход үсчин.

-Юунд хаалгаар чихэлдээд хүйт оруулаад байна вэ! гэжээ.

Хоёр хүүхэд уйлалдсаар тэндээс гарч цааш явахад салхитай бороо улам ширүүсэж эхлэв.

Гаврош тэр хоёр хүүхдийг гүйцэн очиж:

-Эвий хөөрхий та хоёр яагаа вэ? гэж асуухад томн ь

-Бидэнд унтах газар алгаа гэсэнд Гаврош:

-Уйлаад байх юу болоо вэ! Гунихрах юм огт алга гэж гайхжээ.

Гаврош дарга маяг гаргаж:

-Өөдсүүд минь миний хойноос явцгаа гэхэд их нь:

-Жаа эрхмээ! Гээд хойноос нь дагаж Бастилийн зүг явжээ.

Заримдаа өмссөн хувцас нь цөм багадсан арван гурав дөрвөн настай гуйлгачин охин дагжин чичирч байхыг хараад Гаврош хүзүүнийхээ дулаан ороолтыг авч нүцгэн мөрөн дээр нь тохоод ажиг ч үгүй өнгөрөн явсаар талхны газрын өмнө зогсоод:

-Хүүхдүүд ээ та нар хоол идсэн үү? Гэхэд ахмад нь:

-Эрхмээ, бид өглөөнөөс хойш өл залгаагүй гэв.

-Та нарт аав ээж байхгүй юмаа даа.

-Бид хоёрын аав ээж бий. Чухам хаа бйгааг бид мэдэхгүй байна.

-Тийм эцэг эхийг мэдсэний ч хэрэг байдаггүй юм даа. Гаврош уранхай дээлийнхээ өвөр халаас бүрийг нэгжин үзэж

-Бид гуравт хоол идэх мөнгө байна гээд талхны газар орж лангуу дээр нь хэдэн мөнгөө хаяж:

-Худалдагчаа бид гуравт талх өгөөч гэж талх худалдан авч хоёр хүүхдээ хооллоод цааш явав.

Замд нь Монпарнас дайралдаж:

Гаврошоо, бид нэг сонин юм үзлээ. Нэг хөрөнгөтөнтэй учраад хэтэвчтэй мөнгийн нь авч өвөртлөөд хэдэн минутын дараа үзсэн чинь нөгөө мөнгө маань аль хэдийн алга болсон байлаа гэж түүхээ ярьжээ. Тэгээд Гаврошоос

-Чи хаачиж явна вэ? гэхэд Гаврош хоёр хүүхэд рүү харан:

-Хүүхдүүдээ аваачиж унтуулъя гэв.

-Хаана унтуулах нь вэ?

-Гэртээ

-Чи гэртэй юм уу?

-Гэр орон бий.

-Хаана?

-Би нэг заан дотор амьдардаг.

-Чи хүүхэд хаанаас олоо вэ?

-Над нэг үсчин бэлэглэсэн юмаа.

Энэ үеэр цагдаа ирж явахыг Гаврош хараад Монпарсад:

-За баяртай. Би хүүхдээ аваад заан руугаа явлаа. Хэрэв н амайг дуудах ажил гарвал би заан гэртээ байна, холдохгүй. Манайд зарц байхгүй. Хэрэгтэй бол манайд очоод “ноён Гаврошоо!” гэж дуудаарай гэв.

Гаврош эвдэрч нурсан маш том зааны баримал дотор сүрэл ногоо дэвсэж ор засаад үхэр оготнод идүүлэхгүйн тулд халхавч тор барин түүн дотроо унтдаг байжээ.

Гаврош нөгөө хоёр хүүхдээ дагуулан явсаар заан дотор оруулж гадуураа халхавчтай муу орон дээрээ хэвтүүлж, байгаа жаахан талхаа хуваан идээд хэвтэж байтал хоёр хүүхэд үхэр оготноос айж:

-Эрхм ээ энэ юу гүйгээд байна вэ? гэжээ.

-Үхэр оготно гэдэг юм.

-Үхэр оготно гэж юу вэ?

-Хулгана байхгүй юу

-Та мууртай байх нь яасан юм бэ?

-Манай муурыг энэ том ховдог хулганууд идсэн юмаа.

-Энэ хулганууд биднийг идчих магадгүй юм шив дээ?

-Магадгүй, за битгий ай. Та хоёрт нэвтрэн хүрч чадахгүй. Би хажууд чинь байна газар айх юм байхгүй. Олон юм ярилгүй унт хүү минь гэв.

Өглөө үүр цайхын өмнөхөн Монпарнас ирж Гаврошийг сэрээж

-Чиний хэрэг болоод бйана, очиж туслаач гэхэд Гаврош

-За тэлье гэв.

Яг энэ шөнө шоронд орсон “үүрийн таван жингийн” улигт хулгай нар шоронгоос оргожээ. Мөн тэдний хойноос нь Тенардлье бас оргож гарахаар сэм ярилцан байж. Гэтэл Тенардлье шоронгоос оргон гарч өндөр дээрээс бууж чадахгүйд хүрээд бусад нөхдөөсөө тусламж авъя гэхэд гар хүрэхгүй тул хүнд байдалд орсон байлаа. Тенардье тусламж үзүүлэхийн тулд хөнгөн гавшгай хүн хайх боллоо. Тэгээд дээрэмчдийн нэг нь Гаврошийг авчирч байшин өөд авируулан туслалцаа үзүүлэхээр шийджээ. Тийм учраас Монпарнас Гаврошийг очиж шөнөөр дагуулан гарчээ.

Гаврош Монпарнасын хамт хүрэлцэн ирж өндөр өөд хөл нүцгэн авиран гарч Тенардье аргамж хүргэж өгсөн байна. Гаврош үүргээ биелүүлсний дараа:

-За гүйцээ юү? Би эрхмүүдэд одоо хэрэггүй байхаа. Хэрэггүй бол би явж хүүхдээ сэрээлгүй болохгүй гээд гүйн одов. Гаврош гүйж далд орсон хойно Бабет Тенардье:

-Чи саяын хүүг харав уу1 гэж асуухад Тенардье:

-Ямар хүү? Гэжээ.

-Яагаа вэ чамд аргамж аваачиж өгдөг хүү.

-Сайн ажсангүй шү.

-Тэр чинь танай төрсөн хүү мөн байхаа.

-Юу? гэж Тенардье гайхжээ.

## **ДОЛДУГААР ДЭВТЭР**

## **БАЯСГАЛАН БА ГУНИГ**

I

### **ХУРЦ ГЭРЭЛ**

Плюме гудамжны айлыг мэдсэн Эпонинь тэнд очсон дээрэмчдийг буцааж хөөгөөд дараа нь Мариусыг тэр зүг явуулав. Мариус Козеттын зугаалдаг цэцэрлэг рүү нэвтрэн орсон цагаас хойш орой болгон Козеттой очиж уулздаг ба@лаа. Хэрэв Козетт үнэнч бус хуурамч сэтгэлтэй хүнд дурласан бол үхэх байжээ. Гэтэл Козетт тохирсон ариун цагаан сэтгэлтэй хүнтэй учирч бүх сэтгэлээ түүнд гамгүй зориулжээ. Янаг дурлал дундыг баримтлах гэж ба@даггүй юм. Дурлал нэг бол авардаг эсхүл үхэлд хүргэдэг. Хүний бүх хувь заяа энэ хоёроос гардаггүй. Дурлал үхэлд хүргэх бол хүний амьдралыг сэргээдэг. Дурлал нэг талаар өлгий шиг сайхан боловч тохиороогүй үедээ үхэлд учруулдаг.

Козетт бурхны авралаар амьдралыг өөд татан сэргээх дурлалтай золгожээ.

1832 оны 5 дугаар сарын тэнүүн аниргүй шөнөөр Мариус Козетт хоёр нууцаар учирч өтгөн ногоон авчны дунд хоёр сэтгэлээ холбож нэг нэгэндээ чимэг болон суудаг байлаа. Цэцэг ного дэлгэрсэн цэнгэлт сайхан цагаар хоёр зүрхээ холбож нэг нэгэндээ тулгуур чимэг болон байхдаа сайн юманд саад олон тохиолддогийг сэтгэж

ер бодсонгүй. Мариус Козеттыг хараад ханадаггүй харин уушгаа дүүртэл үнэрлэн амьсглахдаа сая санаа сэтгэл нь гүйцдэг байж. Козетт Мариусын хүссэн болгоныг хангаж хөөрхөн төрсөн биеийнхээ аль сайныг түүнд зориулдаг аж. Козетт хичнээн баяртай байал Мариус төдий чинээн жаргалтай.

Козетт, Мариусын хоёр гарыг атгаж эц өмнөөс нь хайрын нүдээр ширтэн суухдаа:

-Миний нэр Эфрази гэдэг гэхэд Мариус

-Чамайг Эфрази гэдэггүй Козетт гэдэг шүү дээ гэв.

-Тийм бишээ. Козетт гэдэг сайхан нэр биш. Намайг бүр бага байхад минь

Козетт гэж нэрлэсэн. Миний жинхэнэ нэр Эфрази. Энэ нэрэнд чи дургүй юу?

-Дуртай, Козетт гэдэг нэр тийм муухай нэр биш шүү.

-Чамд Козетт гэдэг нэр илүү санагдаж байна уу.

-Дээр байлгүй яахав дээ.

-Би ч гэсэн дээр байх гэж боддог. Намайг Козетт гэж нэрлээрэй гэв...

## II

### АНХНЫ СЭЖИГ

Жан Вальжан юунд ч хардаагүй байж.

Мариусыг бодвол багыг мөрөөддөг Козетт баяр баясгалантай, царайлаг байхад Жан Вальжаны сэтгэл тайван суудаг байв... Жан Вальжан нэг өглөө Козеттод:

-Чиний ар тал чинь цагаа болчсон байна гэжээ.

Урьд өдөр нь Мариус Козеттыг тэврэн үнсэхэд Козетт мэдэлгүй бйашигний хананд хүрсэн учраас ар тал нь будаг болсныг Жан Вальжан ажжээ.

Мариус Козетт хоёр хүн амьтанд үзэгдэхгүйн тулд дандаа нууц газар сууж амьсгаа хураан аяархнаар шивнэлдэн хүүрнэдэг байлаа.

Мариус шөнө дунд болгоод Куфейракийнд очиж унтдаг болж. Куфейрак Баоральд хэлэхдээ:

-Мань Мариус шөнийн нэг цагт арай гэж гэртээ ирдэг боллоо.

-Дуугүй хүний доодох нойтон г эдэг шүү дээ. Гайхах юм алга гэлцэнэ.

-Мариус чи саранд очиж тойрсон хүн шиг болжээ. Нуугаад юу хийх юм бэ, амраг бүсгүйн чинь нэр хэн гэдэг вэ? гэхэд Мариус юу ч хэлдэггүй байлаа.

Нэг өдөр Мариус Козеттой очиж уулзахаар явж байтал:

-Сайн байна уу? Мариус гуай гэх шиг болоход эргэн харсанд Эпонинь байжээ.

Мариус гайхаж:

-Эпонинь гуай юу гэхэд

-Та юунд намайг гуйлах болоо вэ? Над гомдоо юу гэхэд

-Үгүй гэжээ.

-Сайхан нойрсоорой Мариус гуай гээд Эпонинь ямар нэг үг хэлэх гэснээ байгаад явчжээ.

## III

### ЭПОНИНЬ ДЭЭРКМЧИНГ АЙЛГАВ

Маргааш нь 1832 оны зургадугаар с рын 3-ны өдөр Мариус хуучин замаараа явж байлаа. Гэтэл модны завсраар Эпонинь гүйж явахыг үзээд зам буруулан явсаар

нөгөө болзоот цэцэрлэг лүүгээ ороход Эпонинь мөн хойноос нь үзэгдэхгүй дагасаар дэргэд нь очив.

Удсан ч үгүй Плюме гудамжны өнцгөөр архи уусан бололтой зургаан хүн гарч иржээ. Тэд аяархнаар хоорондоо:

-Хэрэгтэй газартаа ирлээ.

-Цэцэрлэгт хүн байгаа болов уу?

-Байж магадгүй бололтой гэлцэв. Тэдний зургаа дахь хүн үг ярилгүй зогсож орчин тойронг ажиж сараалжин хашааны орох газрыг тэмтрэн үзэж байтал түүний гарыг ямар нэг хүн бариад авах шиг болохоор цочин харвал цайвар цагаан царайтай охин зогсож байж.

-Энэ чинь ямар хогийн амьтан бэ? гэж тэр хүн хэлсэнд охин:

-Би таны охин байна гэжээ.

Ингэж Эпонинь эцэг Тенардьетайгаа уулзав.

Эпонинийг үзсэн Бабет, Монпарнас Брюжон нар тавуул аажуухан дөхөж ирлээ. Тэд гартаа хорлох зэвсэг барьсан үзэгдэв.

-Чи энд юү хийж байгаа юм бэ? Чи биднээс юугаа авах гэсэн юм бэ? Солиорч байна уу чи? Бидний ажилд саад болохоор ирээ юү? Гэж Тенардые өгүүлэв.

Эпонинь инээд алдан эцгийнхээ хүзүүгээр тэврэв.

-Би энд ирсэн дээ аав минь. Би үүгээр явахад яадаг юм бэ! Харин та нарт энд хийх юм алга. Та нар ямар хэргээр ирээ юэ? Аав аа! Намайг үнс. Би таныг үзээгүй болсоор их удлаа. Та шоронгоос суллагдаа юү?

-Би суллагдаад явж байна. За чи одоо яв гэжээ.

Тенардые тэргүүтэй зургаан дээрэмчин хашаа руу орж дээрэм хийхийг завдтал Эпонинь замыг хаан зогсоод:

-Намайг сонсоцгоо! Та нар энэ сараалжийг эвдэн байшинд орвол би байдаг чадлаараа орилж хаалга балбан хамаг амьтныг цагдаагийн хамт дуудан ирүүлж, та зургааг баривчлуулна шүү гэж чанга дуугарахад дээрэмчид айн сандарч зугтав. Эпонинь мөн тэдний хойноос явж зайлжээ.

#### IV

### МАРИУС ХАЯГАА ЗААЖ ӨГӨВ

Дээрэм хийхээр ирсэн зургаан хүн Эпониниос айн гэдрэг буцаж алга болж байх үеэр Мариус Козеттын хамт цэцэрлэг дунд нуугдан сууж байлаа.

Энэ удаа Мариусыг ирэхэд Козетт нүдэ улайтал уйлсан байв.

-Чи яагаа вэ? гэж Мариус асуухад Козетт:

-Юм бэлтгэж бай Над ажил гарлаа. Бид эндээс нүүнэ гэсэн. Бид Англи руу явах байх аа гэхэд Мариус сандран чичирч:

Та явчвал би яана аа? гэв.

-Бидэнтэй хамт яв!

-Би та нартай явах их хүсэлтэй боловч алс газар очих зардал мөнгө алга байна. Би тэр их мөнгө хаанаас олох вэ? Гэсэн ч би чамаасаа хэдэн өдөр хагцаад дараа ирж уулзъя, юү ч гэсэн чамд хаягаа хэлж өгье. Би Шилний гудамжийн 16 тоот байшинд сууаг юм шүү гэж байдаг газрынхаа хаягийг Козеттод хэлжээ.

Козетт Мариус хоёр дараа нь уулзахдаа яг 9 цагт ирэхээр тохирч салав...

Өвгөн Жильнорман ерэн хоёр нас хүрч байлаа. Жильнорман хэдий нас өндөр болсон авч ердийнхөө төлөвийг огт алдаагүй байлаа. Жильнорман бүтэн дөрвөн жилийн турш Мариусыг тэсэж ядан хүлээж байв.

Мариус үзэж чадахгүй үхнэ байх гэж бодохоос гол нь харанхуйлдаг Жильнорман сэтгэл санааны талаар хүнд байдалтай байсан үеэр нэг өдөр Мариус ирж:

-Эрхэм ноёнтон минь та намайг хайрлаж үзСэч дээ гэхэд Жильнорман:

-Ямар хүсэлтэй ирээ вэ?

Учраа хэл гэсэнд

-Би гэрлэх санаатай. Таны зөвшөөрөл гуйхаар ирлээ гэхэд Жильнорман мөнгө төгрөг гарган баярхаж:

-Тэнэг минь! Чи тэр охиноо авах л үгүй юу гэсний улмаас Мариус уурлаж:

-Таван жилийн өмнө та миний эцгийг доромжилсон Өнөөдөр эхнэрий минь дайрч байна. Тантай ахин үг дуугарах дур над алга гээд гарч явахад Жильнорман:

-Мариус! Мариус! Гэж хашгирсаар өөртөө гомдон хоцров.

## **НАЙМДУГААР ДЭВТЭР**

## **НУТАГ СОЛЬСОН НЬ**

I

### **ЖАН ВАЛЬЖАН**

Мөн өдөр Жан Вальжан элдэв ослоос болгоомжлон Козеттыг гэрт нь орхиод ганцаараа Марсовын талбайн зайдуу нэг буланд ирээд сууж байлаа.

Ажлын цамц, бор өнгөтэй өмд өмсөж урт саравчтай малгай өмсчээ. Жан Вальжан нэг өдөр зугаалж яваад цэцэрлэг дотор Тенардьег олж хараад маш их сэжиг төржээ. Тенардые энд ирсэн хойно аюул гарах нь дамжиггүй гэж бодов. Жан Вальжан Парис хот, Франц нутгийг орхиж Англи орохоор шийдэ.

Жан Вальжан өглөө эрт цэцСрлэг дотуур зугаалж яваад ханан дээр: Шилний гудамж дугаар 16 гэж сийлсэн байхыг үзээд бүр ч их сэжиглэжээ.

II

### **МАРИУС**

Мариус Жильнорманыхаас их гомдож буцав. Тэднийд их итгэж очоод муужиртлаа гунихарч гарчээ.

Мариус шөнийн хоёр цагт гэртээ буцаж ирээд хувцсаа тайлалгүй бүхлээрээ унтжээ. Өглөө нойрноос сэрэхэд Курфейрак:

-Генерал Ламаркийг оршуулахад очих уу? гэв.

Мариус бүтэн өдрийн турш өөрийн эрхгүй тэнүүчилж явахад бороо хаялсаар. Өдрийн хоолны оронд талхны газраас хэрчим талх худалдаж аваад идэхээ бас мартжээ.

Харанхуй болоход Мариус Козеттод хэлснээрээ яг есөн цагт хуучин уулздаг байсан цэцэрлэгтээ хүрч очив. Козетт уулздаг газраа алга байлаа. Мариус тэр хайн газрыг нэгжин үзээд нэг ч хүний бараа харсангүй.

Үхэхээс өөр арга гэж бодсон Мариус санаа алдан байтал нэг хүн:

-Мариус гуай таны нөхөд чинь Шанврарийн бэхлэлт дээр хүлээж байна. Та очихгүй юу? Гэв.

### III

## МАБОФ ӨВГӨН

Жан Вальжан түрийвчтэй мөнгө Мабоф өвгөн тус болсонгүй. Хөнгөмсөг сайхан зантай Мабоф одон ертөнцөөс хайрласан бэлгийг хүлээж авсангүй. Од мичид алтан зоос асгардаг юм гэж ер итгэсэнгүй. Тэнгэрээс унасан түрийвчтэй мөнгө бол Гаврошийн хайрласан мөнгө мөн гэж ер ухаарсангүй. Мабоф тэр мөнгөө өөрийн хорооны цагдан сэргийлэхэд хүргэн өгчээ.

Түмэн бодисын цэцэрлэгт туршлага хийгээд амжилт олдсонгүй өрөнд баригдсаар байсан Мабоф байдгаа худалдаж дуусчээ.

Эмгэн Плютарк Мабофт:

-Өнөөдөр хоол бэлтгэх мөнгө алга гэжээ. Жаахан талх дөрөв таван төмсөөр хоол хийдэг заншилтай аж.

-Зээл авахгүй юу?

-Надад зээл юм өх хүнгүйг та сайн мэднэ шүү дээ.

Мабоф савтай ногоо уудалж юм бүрийг алдалгүй нэгжиж байгаад нэг юм авч сугавчлаад гадагш гарчээ. Хоёр цаг өнгөрсний дараа номгүй буцаж ирээд гучин сү гаргаж ширээн дээр тавиад:

-Май, үүгээр хоол хий! Гэжээ. Маргааш өдөр нь Мабоф цэцэрлэг дотроо сууж байтал Парис хотоор ер бусын их шуугиан гарав. Тэр шуугиан их бууны галлалт, олон хүний хашгирахад адил санж.

Мабоф гадуур өнгөрч яваа хүнээс:

-Энэ юун чимээ вэ? гэхэд

-Самуун дэгдэж байна гэжээ.

-Самуун гараа юу?

-Гарахаар барахгүй, нүдэлдэж байна.

-Юунд нүдэлдээ юм бэ?

-Хэн мэдэх вэ!

-Хаана тэр вэ!

-Арсекалын хавилдуу юм уу даа.

Мабоф гэртээ орж малгайгаа өмсөөд сандарсан байдалтай гарч одов.

## ЁСДҮГЭЭР ДЭВТЭР

## 1832 ОНЫ 6 ДУГААР САРЫН 5

Бослого юунаас үүсдэг вэ? Юу ч үгүй байснаа юм болгоноос үүсдэг. Бага багаар хуралдаж байгаа цахилгаан, гэнэт дүрэлзсэн гал, үл үзэгдэх салхи, тэнэмэл

хүнээс бослого үүсдэг. Тэр бослогын үеэр уран илтгэгчид, мөрөөдөгч хүмүүс, зовлонг туулж хүрсэндээ хүрэх чадалтнууд, өлсгөлөн зовлон үүсэн гардаг.

Бослого юуг чиглэдэг вэ? гэвэл нийгмийн байгуулалтыг эвдэн, хууль зөрчиж, харгис хүчийг устгахаар явдаг.

Хийсэн ажил тавьсан зорилгогүй хүмүүсээс эхлэн орох оронгүй дандаа гадаа унтдаг улсууд, өдөр болгон гуйлга гуйж явдаг өлсгөлөн харгислалын нүцгэн шалдан үрсүүд бослогонд хамрагдсан ордог.

Бослого бүрийн үеэр хоршоо худалдаа хаагдан, мөнгө төгрөг ховордон арилжаа худалдаа зогсож, үйлдвэр хэвийн байдлаа алддаг боловч шинийн үр цацагддаг юм. Үнэн, үнэн бус хорсол хоёроос үймээн самуун, бослого гардаг. Шудрага ёсыг үндэс болгосон ардчилсан маягийн улсууд дотор заримдаа босогчид засгийн эрхийг эзлэн авдаг. Тэр цагт бүх ард түмэн цөм босож өөрийн эрх ашгийг хамгаалахын тулд гартаа зэвсэг барихад хүрдэг. Олон нийтийн Spx ашгийн үүднээс ард түмэн хэсэг явцуу этгээдийн эсрэг явуулах дайныг бослого гэдэг, харин хэдэн явцуу бүлгээс нийт ард түмний эсрэг хандсан дайралтыг үймээн самуун гэдэг. Бослого ариун зөв хэрэг, самуун бол шударга бус гэмт хэрэг юм...

1832 оны хавар гурван сарын турш халдварт хүнд өвчин дэлгэрч олны байдал түгшүүртэй болсны улмаас Парисын ард түмний сэтгэл санаа алдагдах болов. Том хотыг их буутай зүйрлүүлж болно. Их буу шиг цэнэглэгдсэн хот дотор гал гарвал дэлбэрэх нь дамжиггүй байлаа. 1832 оны 6 дугаар сард нас барсан генерал Ламаркийн үхэл цэнэгтэй хотод гал оруулав.

6 дугаар сарын 5-нд генерал Ламаркийг оршуулахаар зарлсан байлаа. Мөн өглөө, түүний урьд өдрөөс эхлэн мурий тахир гудамж болгонд хүн болгон чадлынхаа хирээр зэвсэглэж байлаа.

Цэргийн их хүнтэй ёслол үйлдэж генерал Ламаркийг оршуулахаар гашуудан хөдлөх цагаар уур хилэн нь туйлдаа хүрсэн олон түмэн зэвсэгт тулалдаанд босов...

## **АРАВДУГААР ДЭВТЭР**

# **ШУУРГАТАЙ НӨХӨРЛӨСӨН АТОМ**

I

## **ГАВРОШИЙН УРАН САНААНЫ ҮНДЭС**

Ард түмэн цэрэг хоёрын хооронд тулалдаан болж эхний эгнээ гэдрэг ухрах үед хүмүүс маш замбараагүй болов. Энэ үеэр гарта мөчир барьсан нусгай бор хүү Менильмонтан гудамж уруудаж явтлаа худалдааны усан онгоц дээр хуучин цагийн гар биу байхыг үзэж барьж явсан мөчрөө газар хаяад оронд нь гар буу шүүрэн авч зугтжээ.

Хоёр минутын дараа тэр хүүтэй, айж цочин харайж явсан хөрөнгөтнүүд дайралдав. Тэр хүү буугаа гозолзуулан:

-Шөнийн харанхуйд юу ч үзэдгүй та нар саруулхан өдөр бүхнийг харах авъяастай. Хурц тугийн гэгээн мөрүүд та нарын хутга шиг шөвөгдөн донсолдог. Хуучин төрийн ганган хээнцэр ноёд хорвоон сайхныг мартсан байн гэж дуу дуулж явжээ.

Жаахан Гаврош дайнд оролцохоор явахдаа тэгж дуу аялж явсан ажээ.

Гаврош өглөө эрт явж Тенардыег шоронгоос гаргаад буцан заан гэртээ очиж хоёр жаал хүүхдийг сэрээн, олсон жаахан хоолоо хувааж өгөөд:

-Би явлаа. Та нар эцэг эхээ олохгүй бол орой энд ирж хоол унд идээд унтаарай гэжээ.

Үлдсэн хоёр хүүхэд орой нь эргэж ирэлгүй ор сураггүй болж. Манай нийгмийн ёроолд ингэж алга болдог амьтан олоон. Гаврош тэр хоёрыг хоёр гурван сараар олж харсангүйдээ: “Миний найз хүүхдүүд хаашаа алга болоо вэ?” гэж духаа маажжээ.

Ард түмний дууг нарийн сайн тогтоосон Гаврош уран урагчидтай нөхөрлөж, гурван сар хиртэй хугацаанд хэвлэлийн газарт сурагч болж явсан аж.

Гаврош цаашаа босогчдын зүг рүү явж байхдаа хэдэн баян тарган улсуудыг хараад:

-Энэ хөрөнгөтөн баячууд яасан булай тарган юм бэ! Гэдсээ хагартлаа идээд хэвтэхээс өөр юу ч мэддэггүй хогууд! Гэжээ.

## II

### ГАВРОШИЙН АЯЛАЛ

Гаврош гартаа буу бариад гудамжаар гүйж явахдаа зориг нь улам бадрах шиг санагджээ. Марсельез дууг аялан явах завсартаа:

-Яасан сайхан юм бэ! Миний хууч хөдөлж зүүн савар өвдөж байгаа боловч олныг х раад сэтгэл баясаж байна. Олиггүй хөрөнгөтөн та нар урамт дууг минь сонсоод уур хүрэх болно. Явсар газар болгонд олны уур хилэн буцалж байна. Эрэгтэйчүүд ээ! Босох цаг бол! Хорт дайсныг цус урсган дарцгаа! Би энхрий нөхдөө олж үзэхгүй ч гэсэн эх орныхоо төлөө амь насаа өгнө. Баяр жаргал мандтугай! Эцсээ хүртэл тулалдацгаана! Хатуу дарлал үзэж бид ханалаа! Гээд онхолдсон тэргийг босгож ядарсан хүнд тус хүргээд цааш явав.

## III

### ҮСЧИН ҮГЛЭВ

Гаврошийн аваачиж хонуулсан хоёр хүүхдийг хөөсөн үсчин энэ үе цэргийн хүний үс засаж байлаа. Үсчин тэр цэргийн хүнтэй үймээн самуун, нас барсан генерал Ламаркийн тухай ярьж байснаа дараа нь эзэн хааны тухай ярилцав.

Үсчин:

-Дайны талбарт үхэхээс сайхан юм хаа байх вэ! Өдөр бүр эм тан ууж гэр сахисаар нас барахын оронд их бууны суманд үхсэн дээр гэж би өөрөө санадаг гэхэд цэрэг:

-Та зүйтэй юм хэллээ гэв.

Гэнэт хүчит донсолгоон гарч цонхны шил зүг бүр эрээлжлэн хагархад үсчин цав цагаан болж цочив.

-Энэ чинь нөгөөх хэлдэг мөн!

-Юу?

-Их бууны сум дэлбэрлээ.

Үсчин шал дээгүүр бөмбөрч яваа чулууг дээш өргөж үзээд хагарсан цонх руу гүйн очиж харвал Гаврош хүү Сен-Жаны зах руу зугтаж яваа харагдав.

Хоёр хүүхдийн өшөө хонзонг хадгалж явсан Гаврош үсчний цонхоор чулуу шидсэн аж. Үсчин Гаврошийн хойноос харж уурласаар хоцорчээ.

## IV

### ГАВРОШ ГАЙХСАН НЬ

Сен-Жаны зах зээл дээр Аножлрас, Курфейрак, Комбефер, Фой нараар командлуулсан хэсэг хүмүүстэй Гаврош очиж нийлэв. Тэндхийн бараг хүн болгон зэвсэглэсэн байлаа.

Гавроё тэднээс хаашаа явж байгааг асуухад Курфейрак Гаврош хамт явъя гэж хэлэв.

Тэдний хойноос оюутан, зурагчин, нууц бүлгэмийн гЁшүүд, ажилчид, усан буудлын ача ачигчид гартаа буу, мод барьсаар шуугин дагажээ.

Олны дунд өөдгүй царайтай нэг өвгөн барьсан зэвсэггүй явж байхыг Гаврош хараад:

-Хэн бэ? гэж гайхжээ.

-Настай өвгөн л байна.

Гаврошийн анхаарлыг татсан өвгөн хүн Мабоф байжээ. Улсуудын зарим нь Мабофыг урьд ардын хурлын гишүүн байсан гэлцэв. Тэд явсаар шилний гудамж руу ороход Гаврош хамгийн түрүүнд гарч сэтгэл хөдөлгөм дуугаа аялсаар алхаж байлаа. Цугларсан олон Сен-Меррийг зүгэлсээр.

## V

### ШИНЭ ХҮН

Хүний тоо, нүд ирмэх бүр олширсоор. Шинээр, өндөр нуруутай бууралдуу үстэй хүн орж нэгдэв. Гадна байдлаараа нилээд хүдэр маягийн эр санж. Дуулж, исгэрч цовхчин харайж явсан Гаврош тэр хүнийг ажиж харсангүй.

Шилний гудамжинд ирэхэд Курфейрак гэртээ ороод мөнгө, малгайгаа авч, гэрээсээ гүйн гартал араас нь:

-Курфейрак таныг хүн сураглаж байна гэжээ.

-Хэн бэ?

-Мэдэхгүй.

-Хаа байна?

-Энд хүлээж байна.

Энэ үеэр эцэнхий цагаан царайтай ажилчин залуу гарч ирээд:

-Би Мариустай уулзах гэсэн гэхэд

-Мариус байхгүй гэв.

-Өнөө орой ирэх болов уу?

-Би мэдэхгүй гэж Курфейрак хэлээд:

-Би лав өнөө орой ирэхгүй гэжээ.

Залуу, сайн ажиж харснаа:

-Та хаачиж явна вэ? гэжээ.

-Бэхлэлт дээр очно.

-Би хамт явалцъя, болох уу?

-Өөрөө мэдээ. Гудамж чөлөөтэй, явган зам, хүн болгоны өмнө зай тавьж байна гэж Курфейрак хариулав.

Нөгөө залуу бас жагсагчидтай нэгдэж явсаар Сендени гудамжинд хүрэв.

## **АРВАН НЭГДҮГЭЭР ДЭВТЭР**

### **“КОРИНФ”**

#### **I**

### **“КОРИНФЫН” ТҮҮХ**

Орчин үеийн Парисынхан Төв захын зүгээс Рмбото гудамж руу орохдоо Мондотур гудамж өөд харсан сийрсэн савт мухлагийг үзэж болох бүлгээ. Тэр мухлагийн үүдэнд нэгдүгээр Наполеон хааны дүрийг сийрсээр дүрслэн: “Наполеоны дүрийг энд үзүүлсэн юм” гэж бичжээ. Гэвч тэнд гучин жилийн өмнө энд тохиолдсон аюулт явдлыг огт санадаггүй юм.

Яг энд байдаг Шанврери гудамжны алдарт “Коринф” гэдэг гуанз оршжээ.

Коринфт Курфейрак өөрийн нөхөдтэй уулздаг байлаа. Грантэр үүгээр явж байгаад Коринфыг олсноос хойш залуучууд энд цугларч хоол унд идэж уун хөөрөлддөг болов.

Өвгөн Гюшлу сайн зан гаргаж ирсэн хүн болгоныг зочлон хүлээж авдаг байлаа.

Гюшлугийн эхнэр нь сахалтай, үзэмж муутай эмэгтэй, Гюшлу 1830 онд нас барсны сүүлээр эхнэр нь залгамжлан авч Коринфыг дорой байдалд оруулсан боловч Курфейрак нөхдийнхөө хамт энд цуглардаг заншилтай олжээ.

#### **II**

### **НАРГИАНЫ ТӨГСГӨЛ**

Лэгл, шувуу шиг дуртай газартаа унтдаг байлаа. Лэгл ихэвчлэн Жолигийн д байрладаг аж.

Лэгл Жоли хоёр үргэлж хамт хоол ндаа идэж, цуг унтдаг байв. Тэр хоёр зургадугаар сарын тавны өглөө “Коринфт” цуг очоод хоёрдохь давхарт гарч хол захиалан идэх гэж байтал:

-Үүгээр өнгөрч яваад сайхан үнэр гарахлаар тэссэнгүй ороод ирлээ гэв.

Ажвал Грантэр орж ирээд ширээний цана сууж шил улаан архи захиалав.

-Энд мөн ч тайуан байна. Парис ёроолоороо эргээд байна гэж хэний ч санаанд ормооргүй байна. Энд дээр үед сүм байсан гэхэд Грантэр:

-Лам нарын тухай ярихын хэрэггүй гэжээ.

Грантэр хоёрдохь шил арха уух гэж байтал есэн настай эрэгтэй хүүхэд орж ирээд Лэглиэс:

-Боссюэ гэж намайг өхөөрдөж өгсөн нэрээ. Чамд юу хэрэгтэй юм бэ? гэв.

-Намайг дарлагсдын нэрийн өмнөөс тантай уулзаад ир гэж шан өгч явуулсан.

Лэгель хорин сү хажуугийнхаа хүнээс зээлдэж:

-Май гэж өхөд, хүү:

-Их баярлалаа. Би Гаврошийн нөхрөө. Явж ажилдаа оролгүй болохгүй гэжээ.

Анжолрас, Гаврош, Курфейрак нараар толгойлуулсан хүмүүс: “Зэвсэглэцгээ!” гэж хашгирсаар ойртон явааг Грантэр, Жоли, Лэгель гурав хараад хамтарч халхавч бэхлэлт босголцохоор гадагш гарцгаав. Цугларсан олон ард, байдаг ч хүн хөрөнгөө шавхаж халхавч бэхлэлт босгоод ширүүн тэмцэлд ороход бэлэн боллоо.

### III

## ЗАМААС НИЙЛСЭН ХҮН

Гүн харанхуй шөнө болсон байхад цөм хуучин хэвэндээ. Хааяа нэг холоос холд буун дуу сонсогдов. Түр зуур тайван байсан явдал засгийн газар цэргээ хуралдуулж байгаагийн шинж. Бэхлэлт дээр тавин хүн жаран мянган дайсныг хүлээж байлаа.

Аюулт тулалдаан хүлээсэн Гаврошийн хойноос очсонд Гаврош их ажилтай байлаа.

Замаас нийлсэн хүн доод танхимд ороод аль бүдэг гэрэлтэй газар олж суув. Барьсан бугаа тулан суугаа тэр хүний ажил төрөл ихтэйг Гаврош ажсангүй.

Сонин зэвсэгтэй тэр хүнийг харсан Гаврош зог туссанаа ойртон очоод өлмий дээрээ гишгэн сэмхэн тойров. Зэвсэгт хүн гадаа байхдаа бэхлэлт дээр болж байгаа бүхнийг алдалгүй ширтэж байсан бол байшинд ороод орчныгоо ажихын оронд гүн бодолд орсон байлаа.

Энэ үеэр Анжолрас хүрч ирээд:

-Чамайг бага биетэй болохоор амьтан харахгүй. Чи бэхлэлтийн цаагуур наагуур явж юу болж байгаг сайн хараад ир. Ирээд үзсэнээ тодорхой ярь! гэхэд Гаврош өндийж:

-Бага хүүхдүүд хэрэгтэй болох цаг байдаг юм уу! Яасан сайхан юм бэ? Би одоохон явлаа. Одоохондоо хүүхдэд итгэж, том хүнд итгэлгүй байгаарай гээд Гаврош нөгөө буутай хүн рүү заан:

-Та энэ амьтныг сайн ажаарай? Гэв.

-Юунд?

-Хорлогч тагнуул байна.

-Лав уу?

-Арав гаруй хоногийн өмнө намайг чихдэн чирч байсан юм.

Анжолрас Гаврошоос түргэн холдож усан буудлын ажилчин хүнд хэдэн үг шивнэв. Ажилчин гүйн гараад тэр дороо гурван нөхдөө дагуулсаар орж ирээд сууж байгаа хүнийг бүслэн тойрмогц Анжолрас ойртон очоод:

-Та хэн бэ? гэж гэнэт асуухад нөгөө хүн цочиж Анжолрасыг зэвүүнээр харан инээмсэглээд ихэмсэг зангаар:

-Яах гээ вэ? гэжээ.

-Та тагнуул уу?

-Би төрийн төлөөлөгч цагдаа.

-Нэр чинь хэн бэ?

-Жавер.

Анжолрас дөрвөн нөхдөдөө дохио өгмөгц тэд Жаверыг эргэн харахын завдалгүй заамдан авч газар унагаад дээсээр хүлэн нэгжив. Түүний өврөс олдсон хатуу дөрвөлжин цаасны нэг талд “Хяналт, сонор сэрэмж” гэж бичээд Францын сүлд дарсан, нөгөө талд нь: “Цагдаагийн харгалзагч Жавер тавин хоёр настай” гэсэн байв.

Үүнээс гадна цаг, нилээд хэдн алтан зоос өврөөс нь олоод авсангүй буцааж өгөв. Цээжмэгчний халааснаас дугтуйтай эвхсэн цаас олж уншихад:

“Улс төрийн үүргээ гүйцэтгэсэн хянагч цагдаа Жавер Сен мөрний баруун эрэгт гарсан хорт явдал үнэн худлыг шалгах үүрэгтэй” гэсэн байв.

Эд бүхнийг х рж байсан Гаврош:

-Муур хулганы гарт орно гэдэг боллоо доо гэв.

Анжолрас Жаверт:

-Таныг бэхлэлт нурахаас арван минутын өмнө буудан ална гэв.

-Одоо алах нь яасан юм бэ?

-Бид драиа хайрлаж гамнаж байна.

-Дариа гамаад байвал намайг хутгалаад алчихгүй юу.

-Бид шүүгч нар болохоос биш алан хядагч нар биш гээд Анжолрас Гаврошийг

дуудан:

-Чи яв! Даалгасан үүрэг биелүүл! гэхэд Гаврош:

-За гээд явсаар хаалга дээр очоод:

-Наадхынхаа бууг над өгөөрэй гээд гүйн гарав.

#### IV

### БОСЛОГОНД ХАТУУ САХИЛГА ХЭРЭГТЭЙ

Бэхлэлт дээр байгаа хүмүүсийн дотор ачаа ачаалагчийн хувцастай Кабюк гэгч байжээ. Кабюкийн авирлаж бйгаа нь согтуу хүний шинжтэй.

Кабюк гэнэт хашгиран:

-Нөхдөө! Тэр байшингийн цонхны цаана сууж буудвал хэн ч ойртохгүй мөн ч сайхан аа! гээд бэхлэлтийн гүнд байгаа таван давхар том байшинг заахад нөгөө нэг архичин:

-Тэр байшингийн хаалга хаалттай юмаа гэжээ.

-Очиж хаалгы нь цохиё.

-Онгойлгохгүй.

-Эвдээд хаячихгүй юү! Гээд Кабюк тэр байшингийн үүдэнд очиж нилээн олон дахин цохиж, цөхрөлөө барж байтал эзэн хаалгаа онгойлгож:

-Ноёдоо юу хэрэгтэй вэ? гэхэд Кабюк:

-Онгойлго гэж шаарджээ.

-Онгойлгож чадахгүй гэж цаад хүн хэлтэл буун дуу тас гэв.

Хүн алахыг мэдсэн Анжолрас гүйн ирээд яргаичн Кабюкийг заамдан авч газар сөгд гэж тушаагаад хайргүй буудан алаад хэлсэн нь:

-Иргэд ээ! Энэ хүний үйлдсэн хэрэг бузар юмаа. Би үүнийг алснаараа аймшигт хэрэг үйдлээ. Энэ хүн, хүн алсан учраас би хариуд нь аллаа. Энд хүн алдаг явдал аюулт гэмт хэргээ. Бослогонд хатуу сахилга хэрэгтэй учраас би үүнийг буудлаа. Хувьсгалт үйл хэргийн төлөө тэмцэгч бид алдар нэрээ хамгаалах ёстой. Олиггүй хэрэг хийгээд дайсанд ашиглуулахын хэрэг алга. Тийм учраас би энэ хүнийг цаазлав. Нөхдөө ирээдүйн нийгэмд харанхуй бүдүүлэг ёс устаж дэвшилт ёс ялах болно. Тэр

цагт хүн амийн бузар хэрэг гаргахгүй. Хүн болжон нөхөрсөг дотноор амьдран жаргах гэрэлт өдөр удахгүй болно. Тэр жаргалт өдрийг ойртуулахын тулд бид амиа хайрлахгүй тэмцэж байна гэв.

Анжолрасын үйлдсэн хэргийг хэн ч буруушаасангүй харин зарим нь нэг нэгэндээ баяр хүргэж байлаа.

Ийм явдал гарсны дараахан Мариусыг өглөө сураглаж байсан залуу шөнө болоход босогчидтой нийлэхээр ирж байхыг Курфейрак үзэв.

## **АРВАН ХОЁРДУГААР ДЭВТЭР**

### **БАЙЛДААН ДУНД**

I

#### **ТУГ. НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ**

Арван цаг болтол хэн ч үзэгдсэнгүй. Анжолрас, Комбефер хоёр буугаа барьсаар том бэхлэлтийн гармын дэргэд сууцгаав. Тэр, холуур яваа хөлийн чимээ сонсохыг туйлын хичээнэ.

Чив чимээгүйн дунд хөгжилтэй хөөрхөн цангинасан хоолой дуу аялсаар айсууг сонсоод:

-Гаврош байна гэж баясан хэлэхэд Комбефер,

-Бидэнд дохио өгч байна гэв.

Гаврош амьсгаадан гүйж ирээд:

-Дайсан айсүй байна. Миний буу хаа байна аа? гэхэд босогчид цөм сэжиг авч зэвсгээ тэмтрэх нь сонсогджээ.

-Чи миний карабин авах уу? гэж Анжолрас асуухад Гаврош:

-Над их том буу хэрэгтэй гэжээ.

Гаврош Жаверын бууг авлаа.

Анжолрас, Комбефер, Гаврош нарын дөчин гурван буугаа цэнэглээд хүлээж байтал холын явган замаар хөлийн чимээ гарч эхлэв.

Харанхуйн дундаас нэг нь:

-Хэн явж байна? гэж асуухад бууны замаг дуугарч Анжолрас:

-Францын хувьсгалаа! Гэхэд

-Галлаад! Гэж нэг хүн команд өгөв.

Бэхлэлтийн дээгүүр бууны дуу нижигнэсэнд мандаж байсан улаан туг унажээ. Хүчит их бууны сум бэхлэлтэд тусч хэдэн хүнийг шархдуулав. Босогчдын эсрэг бүтэн хороо байлдаанд орж байгаа бололтой абйж.

Курфейрак:

-Нөхдөө дариа аргилж буудалгүй түр хүлээцгээе. Бүрэн ил гарахыг хүлээе гэв.

Анжолрас:

-Хамгаас түрүүнд тугаа босгон мандуулъя гээд хөлийнхөө хажууд унасан тугийг эмхлэн авч байх үеэр бэхлэлтийн цаана буу дахин сумлаж байгаа сонсогдов. Хэн зориг гаргаж бэхлэлт дээр туг хатган мандуулах вэ? гэж Анжолрас хэлэв...

II

## ТУГ. ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ

Босогчид явсаар “Коринф” ирж бэхлэлт байгуулснаас хойш өвгөн Мабофыг хэн ч анхаарахаа больсон байлаа. “Хэн туг мандуулах вэ?” гэж Анжолрас дахин асуухад Мабоф тугийг Анжолрасын гараас салган аваад бэхлэлт өөд аажмаар авирч эхэллээ. Улаан туг орой дээрээ мандуулсан өвгөн Мабоф:

-Хувьсгал мандтугай! Бүгд Найрамдах Улс мандтугай! Нөхөрлөлийн төлөө тэмцэж амь насаа өгцгөөе гэв.

Олны дотор дамжин шивнэлдэх чимээ гарах шиг болоход нэг хүн:

-Зайл! Гэхэд Мабофын царай хувхай цагаан болж тугаа дээш өргөн:

-Бүгд Найрамдах улс мандтугай! Гэсэнд:

-Галлаад гэж дохио сонсдон их бууны сум бэхлэлт рүү нижигнэн буув.

Өвгөний хөл нугас гээд тугаа дээш өргөснөө тас гэдрэг унав. Улаан цус доогуур нь бургилан урсаж хувхай даасан нүүр тэнгэр ширтэн хэвтжээ. Үнэн хэргийн төлөө хайран амиа алдсан өвгөний үлгэр жишээгээр баатарлагаар тэтцэх санаа олныд отор төржээ.

МаҮофын биеийг доод давхарт оруулж явахад Анжолрас:

-Чамайг удахгүй ийм болгоно гэж Жаверт хэлэв.

Энэ үед хэдэн хүн бэхлэлт рүү гэтэн айсуйг харсан Гаврош:

-Анхааралтай бай! гэхэд Курфейрак, Анжолрас нар гүйлдэн гарвал харгис цэрэг Гаврошийг жадлахаар заван байтал буу дуугарч тэр цэрэг унав.

Ажвал дөнгөж саяхан ирсэн Мариус буудсан ажээ.

Дараа нь Мариус дарьтай савны дэргэд очоод цэрэг рүү хандаж:

-Зайлахгүй бол дарь тэсэллээ шүү! гэхэд дайрч байсан дайсан ум хумгүй зугтаж алга болов.

Гудамжны байлдаан дунд хүнд шархатсан Эпонинь арай гэж мөлхсөөр Мариусын дэргэд ирж Мариусыг эрт дээрээс эхлэн хүсэн мөрөөдөж сэтгэл зүрхээ өгч явсан зэргээ тоочин байтал Гаврошийн дуулах чимээ сонсогдов.

Эпонинь өндийн суугаад:

-Энэ жаал хүү миний дүү байгаа юм гэжээ.

Эпонинь амьсгаа хураахынхаа өмнөхөн захидал гаргаж өгөөд үхэв.

### III

## ГАВРОШ ЗАХИА ХҮРГЭХЭЭР ЯВАВ

Эпонинийн гардуулсан захидлын дугтуй дээр “Шилний гудамжны 16 тоот байшинд суугаа Курфейракийнд байгаа Мариуст гэжээ”

Захиаг задалбал:

“Хайрт минь ээ! Миний аав одоохон нутаг солихыг шаардаад байна. Өнөө орой бид нүүж Зэвсэгт хүний гудамжийн долоон тоот байшинд орно. Хэд хоногийн дараа Англид очно.

6 дугаар сарын 4. Козетт” гэжээ.

Мариус хариу захидалдаа:

“Бид хоёр ханилан сууж чадахгүй боллоо. Би өвгөн ааваасаа чамтай суух зөвшөөрөл гуйсанд татгалзлаа. Чамтай хамт явъя гэхэд мөнгө алгаа. Чамта© уулзахаар очоод олсонгүй. Би чамд хэлсэн үгэндээ хүрнэ. Би үхнэ. Чи энэ захиаг уншиж байх үед миний зүрх сэтгэг чиний дэргэд очно” гэж бичээд Гаврошид өгч түргэхэн хүргэхийг шаардсанд Гаврош зэвсэгт хүний гудамжийг чиглэн явахдаа:

“Арван хоёр цаг болоогүй байна. Зэвсэгт хүний гудамж төдий л хол биш юм. Би энэ захиаг хүргэж өгөөд бэхлэлтдээ буцаж ирж амжина” гэж бодож явжээ.

## **АРВАН ГУРАВДУГААР ДЭВТЭР**

### **ЗЭВСЭГТ ХҮНИЙ ГУДАМЖ**

I

#### **НҮҮСЭН НЬ**

Зургадугаар сарын тавны өдрийн урд орой Жан Вальжан Козетт, Тусен хоёроо дагуулан нүүж зэвсэгт хүний гудамжинд иржээ. Козетт Тусен хоёр үг хөөрөлдөхгүй гунигтайгаар нүүж явахад сэтгэл ихэд түгшсэн Жан Вальжан тэдий уйтгарласан байдлыг ер ажсангүй. Нүүж байгаагаа олонд мэдэгдэхгүйн тулд Жан Вальжан заавал орой нүүх шийдвэр гаргажээ. Энэ нь Козеттос Мариус захиа бичих бололцоо олгосон аж.

Тэд зэвсэгт хүний гудамжинд хүрэлцэн ирэхэд хав харанхуй болсон байв. Шинэ байранд тэд ороод нэг ч үг ярилцалгүй унтав.

Жан Вальжан нутаг солиод санаа амар тайвшран байтал Козеттоос Мариусд бичсэн захидал ба түүний дугтуй дээр бичсэн бололтой хаягийг олж үзээд дахин түгшүүрт байдалд оржээ.

Мариус Жан Вальжаныг дандаа эвгүй байдалд оруулж байгааг мэджээ.

Жан Вальжан харанхуй бодолд ороод сууж байтал зарц Тусен гаднаас ирэхэд:

-Хаа юу болоод байна аа? гэж асуухад Тусен:

-Юу гэнээ гэв.

Жан Вальжан дахин лавлаж:

-Тулалдаан болж байна гэж та ярьсан байх аа! гэхэд Тусен:

-Сэн-Меррийн хавь дайтаж байгаа бололтой гэжээ.

II

### **ГАВРОШ ГУДАМЖНЫ ГЭРЭЛД ДУРГУЙЦЭВ**

Жан Вальжан сэтгэл зовж бодол болсоор шөнө орой болов. Гадна гудамжаар хөлийн чимээ бүрэн тасарсан байлаа. Дэн асаагч 7 дугаар байшингийн хашааны гаднах дэн асаагаад зайлан одов. Холд, буун дуу нижигнэн хүмүүс шуугилдах чимээ сонсогдсоор. Арван нэгэн цаг болж цагны хонх дуургарахад Жан Вальжан өчүүхэн ч хөдөлсөнгүй. Энэ үеэр түүнийг харсан хүн гайхаж амьд амьтан биш байна гэж санах аж. Их буу галлаж Шанврерийн бэхлэлтийг буудах шиг болоход Жан Вальжан цочин босож буу дуугарсан зүг рүү харав.

Жан Вальжанаас холгүй гудамжаар хөлийн чимээ гарахад өндийж харвал залуу хүү гүйж явлаа.

Гаврош зэвсэгт хүний гудамжинд ирсэн нь тэр аж. Гаврош дээшээ харж хэн нэг хүнийг хайж байх бололтой.

Жан Вальжан:

-Жаал аа чамд юу хэрэгтэй вэ гэхэд

-Хоол хэрэгтэй гэж хариулаад гялайсан гэрэл харж:

-Дэн байна. Таанууд дэглэмд захирагддаггүй юм байна. Энэ муу дэнг одоохон устгая гээд чулуу шидэж дэнг хага цохив. Гаврош Жан Вальжан руу харж:

-Энэ гудамжны үзүүрт байгаа том сараалжийг нуриааж бэхлэлт баривал тун ч сайхан болох санж гэв.

Жан Вальжан ойртон очиход Гаврош:

-Танайх энд үү? Гэхэд Вальжан

-Манайх энэ дээ. Чи яах гээ вэ? гэв.

-Та надад долдугаар байшин зааж өгнө үү?

-Долдугаар байшингаар яи юу хийх гэсэн бэ?

-Зүгээр сонирхсон юм.

Жан Вальжан муу санаархан:

-Чи надад захиа авч ирээ юү? Гэв.

-Та чинь эхнэр хүн биш байна.

-Козеттод гэсэн захиа байна уу?

-Козетт гэв үү? Аав тэгж бичсэн байх шиг болсон. Хачин нSp вэ? Намайг бэхлэлт дээрээс явуулсан юм. Та энэ захиаг эзэнд нь өгөөрэй гээд з хидлаа Жан Вальжанд гардуулав. Гаврош бэхлэлт чиглэн хөдөлсний дараа Жан Вальжан буугаа авч Төв захын зүг гарлаа.

Нам гүм унтсан гудамжныг хэрэн яваа Гаврош:

Саяхан нэг охинтой

Сайхан оро± залуу

Сэтгэл ханатлаа зугаалсан

Хайрт ганган охинууд минь

Хаашаа та нар гүйлдээ вэ?

Өдөр болгон нэгийг сольдог

Өөдгүй залууг Пьерро чи

Уруудах зам руу хандаа юу?

Хайрт ганган охидууд минь

Хаашаа тар нар гүйлдэ вэ?

Хачин дурлалд автагдаад

Хайрт янагаа тэврэхдээ

Хамаг байдгаа мартдаг!

Хайрт ганган охидууд минь

Хаашаа та нар гүйлдээ вэ?

Найрт сайхан өдрөө

Нандин сэтгэлээ ханагж

Наргин зугаалж явсан сан.

Хайрт ганган охидууд минь

Хаашаа та нар гүйлдээ вэ?

Сюзеттын хөөрхөн хараа

Сэтгэл таатаад байхлаар

Санаа үймрэн явдаг сан.  
Хайрт ганган охидууд минь  
Хаашаа та нар гүйлдээ вэ?  
Алтан хуудсыг уншихад  
Алиа Мадлен санагдана  
Аливаа сайхан бодогдоно.  
Хайрт ганган охидууд минь  
Хаашаа та нар гүйлдээ вэ?  
Хүнгүй газар уулзаад  
Хөл нийлүүлэн алхахад  
Хөгжилтэй сайхан байдаг.  
Хайрт ганган охидууд минь  
Хаашаа та нар гүйлдээ вэ?  
Янаг хонгор Стелльтэй  
Яруу дуугаа аялсаар  
Явахаас илүү жаргалгүй  
Хайрт ганган охидууд минь  
Хаашаа та нар гүйлдээ вэ? гэж дуулсаар  
яваад гэнэт зогсож:

-Дуугаа тасалъя гээд тэргээ дэрлэн хэвтэж байгаа согтуу хүнийг ширтэв.  
Гаврош “Энэ тэргийг авч Бүгд Найрамдах Улсын хэрэгт зориулъя” гээд тэргийг авч  
оронд нь:

“Бүгд Найрамдах Франц Улс тэрэг хүлээн авлаа. Гаврош” гэсэн бичиг үлдээв.

Гаврош олсон тэргээ хоржигнуулан түрж хөдлөв. Ингэж чимээ г арга явах нь  
Г врошийн биед аюултай байлаа. Вангийн хэвлэлийн хажууд байгаа харуулын  
цэргүүд дуу чимээний улмаас хөдөлж баривчлан авах магад байлаа. Харуулын дарга  
чимээ сонсоод “бөөн дээрэмчид ирж яваа бололтой. Очиж харъя” гээд гартал Гаврош  
тэргээ түрсээр ирж, яг тулгараад:

-Нийгмийн дэглэм сахигч ноёнд мэнд хүргэе. Та энд салгалсаар л байна уу?  
гэж гайхахад дарга:

-Нусгай жаал чи хаа очиж яваа юм бэ? гэсэнд Гаврош:

-Би таныг хөрөнгөтөн буржуй гэж нэрлээгүйсэн билээ. Та намайг юунд  
доромжлоо вэ? гэв. Дарга уурлаж:

-Чи хаа очих гэсэн хог вэ? гэхэд Гаврош өмнөөс нь:

-Эхнэр хөнгөрөх болчоо эмч залахаар явна гээд улигт дарга руу тэргээ түлхэн  
мөргүүлээд өөрөө хар эрчээрэ зугтан арилахад, цэргүүд замбараагүй буудавч үр дүн  
олсонгүй.

Гаврош “бэхлэлт дээрээ хожигдолгүй очих юмсан” гээд цааш гудамж бүрийг  
бултагнан тойрч явахдаа:

Хартан дайсанд хядуулсан боловч

Хата нэгнээ чинь бөх байна.

Харгис ертөнцийг сөнөөн даръя!

Хайрт ганган охидууд минь

Хаашаа та нар гүйлдээ вэ?

Илд зэвсгээ барин босож

Эзэрхэг дайсныг сөнөөхөөс өөр

Эр хүнд жаргал байхгүй!

Хайрт ганган охидууд минь

Хаашаа тэр нар гүйлдээ вэ?  
Атаат дайсныг хиар цохих  
Аюулт дэглэмийг сөнөөн дарж  
Алдар гавъяагаа цууриатуулъя!  
Хайрт ганган охидууд минь  
Хаашаа та нар гүйлдээ вэ? гэж урам зоригтой дуулсаар бэхлэлтийг чиглэж явжээ.

## **ТАВДУГААР ХЭСЭГ**

# **ЖАН ВАЛЬЖАН**

## **НЭГДҮГЭЭР ДЭВТЭР**

## **ГУДАМЖНЫ ТУЛАЛДААН**

I

### **ХОЁР БЭХЛЭЛТ**

Хоёр бэхлэлийн нэг нь Сэнт-Антуаны орчмыг халхалж нөгөө нь Тамплийн хавийг хамгаалжээ. Зургадугаар сарын цэлмэг хөх тэнгэрийн дор иргэний дайны үед босгосон гайхамшигт энэ бүтээлийг харсан хүн хэзээ ч мартажгүй.

Сэнт-Антуаны бэхлэлтийн өндөр нь гурван явахар байшинтай шиг урт нь хоёро зуун арван гурав орчим метр маш том аж. Энэ бэхлэлт бүтэн гурван гудамжийг халхалжээ. Гол том Үэхлэлтийн ар талд арван еөсөн туслах бэхлэлтүүд байж. Африкийн данид алдраа цууриатуулсан цэргийн жанжнуудын тактик хоорондоо нягт холбоотой бэхлэлтүүдийг мөргөөд бут цохигдож байлаа.

Үүнээс холгүй хоёр давхар байшин хиртэй өндөр бэхлэлт байгуулагджээ. Уран чадварлагаар босгосон Тамплийн энэ бэхлэлт дээр босогчид хоорондоо ойрхон зайтай байрласан байв.

Цэрэг, дарга буюу засаг төрийн төлөөлөгч хэн нэг хүн зэлүүд гудамжаар хөндлөн гарах бүр бууны сум шунгинж түүнийг шархдуулан алдаг байлаа. Хэрэв гудамж огтолсон хүн зугтаж гарвал хойноос нь буудсан сум байшингийн хананы туйлуу руу шигддэг байлаа. Заримдаа их бугаар ч бас буудаж шагайсан болгоноо алддаггүй унгаадаг байв. Энд тэндгүй үхсэн хүүр овоорч улаан цус нөжрөн хүрэнтээд байшин бүрийн үүд хаалгаар шархадсан хүмүүс шахалджээ. Босогчдын эсрэг довтлох гэсэн цэргүүд байрнаасаа гарч ядан мунгинана.

Тамплийн хавийг бүрхсэн бэхлэлтийн дээр байрласан наян хүн арван мянган цэрэгт дийлдэлгүй гурав хонож, дөрөвдэх өдөрт дайсанд дийлдсэн, дайснууд нүх сүв бүхнээр шургалж бйшингийн дээврийг хүртэл гартаа оруулав. Бослогонд оролцсон наян хүний нэг нь ч сандран зугатсангүй эцсээ хүртэл эрэлхгээр тулсаар хайран амиа алдахад бослогын дарга Ба°телеми ганцаараа амь мултарчээ.

Дурдсан хоёр бэхлэлтийг Курне, Бартелеми нар босгожээ. Сэнт-Антуаны бэхлэлтийг Курне, Тамплийнхийг Бартелеми бүтээн босгосон учир тэр хоёры- авъяас чадвал бэхлэлтэд шингэсэн байв...

Хоёул английн Лондонд зугтан очоод байхад Бартелеми Курнег буудан алаад өөрөө дүүжлүүлсэн аж...

## II

### ҮҮР ЦАЙХЫН ӨМНӨ

Өмнө гарсан хоёр бэхлэлтийг бодвол Шанврерийн бэхлэлт хэмжээгээр багаа. Анжолрасаар удирдуулсан босогчид шөнийг цагийг ашигтай өнгөрүүлэв. Мариус юу ч анхаараагүй шинжтэй. Бэхлэлтийг зөвхөн сэргээгээд зогссонгүй харин гүйцээн барьжээ.

Эзэлсэн байшингийнхаа доод давхрыг элдэв хог новшноос салган гал тогооны газрыг шарх боох өрөө болгож, асгарсан дарийг цуглуулж, сүм дуган, эзэнгүй байсан буу зэвсгийг хувиарлажээ.

Үхсэн хүүрийг Мондотурт овоолжээ. Хайин гудамжны явган замаар цус урсаж байв.

Анжолрас нэг хоёр цаг унтаж амрахыг нөхдөдөө зөвлөсөн боловч түүний үгэнд гурав дөрвөн хүн орж унтав. Бусад нь тус бүрдээ ажил хийцгээв.

Фой тэр цагийг ашиглаж.

Ард түмэн мандтугай! Гэсэн лозунг эсрэг талынхаа байшингийн хана дээр сийлэв. Хадаасаар чулуун дээр сийлсэн энэ гурван үг 1848 он хүртэл хэвээрээ байж.

Шөнө гурван эмэгтэй зэргэлдээ байшин руу орж алга болсон байв. Шархтсан хүмүүсийн ихэнх нь дахин дайнд ороход бэлэн болов.

Байшингийн доод давхарт Мабофын хүүрийн дэргэд Жавер модноос хүлээтэй хэвээрээ.

Хүмүүсийг хооллох зүйл огт байсангүй. Талх мах бүгд дууссан аж. Арван зургаан цагийн турш байлдсан тавин хүн эзэлсэн байшингийнхаа өчүүхэн жижиг идшийг барж Өлсгөлөнг ажиггүй тэвчсэн болсогонд оролцогсод “Одоо гурван цаг боллоо. Хол хэрэг алга. Дөрвөн цагт бид нэгийгээ үзэлцэнэ” гэв...

Шөнийн хоёр цагийн үед бүртгэл явуулсанд гучин долоон хүн үлдсэн байв.

## III

### ГЭГЭЭ ОРОХ ТУТАМ БАЙДАЛ ТҮГШҮҮРТЭЙ

Анжолрас тагнуулд гаав. Бослогонд оролцогсод ялалтдаа итгэсээр байв. Хүч дутвал нэмэлт хүч ирнэ гэж горьдсоор байлаа.

Анжолрас эргэж ирээд:

-Бүх Парисын цэрэг, дайнд бэлэн байна. Түүний гурван хувь манай бэхлэлтийг отож байна. Үндэсний гаварди дайнд бэлджээ. Нэг цагийн дараа бидэн рүү довтлох нь, өчигдөр боссон ард түмэн өнөө өглөө хөдлөхгүй нь ээ. Гаднын дэмжлэг хүлээх цаг өнгөрчээ. Бид олноос тасарсан байна гэв.

Холын харанхуйд байгаа бүлэг хүмүүсийн нэг нь Анжолрасад:

-Яасан ч яах вэ! Энэ бэхлэлтээ улам өндөр болгоод эцсээ үзтэлээ байлджья!

Гэжээ.

Энэ үгийг цөм баяртай хүлээн авав.

Үүний жишээгээр зоригжсон Сэн-Мери гудамжны бэхлэлтийнхэн: “Бидэнд тусламж ирсэн, ирсэн ирээгүй ч хамаа алга! Нэгд нэгэнгүй үхэхээс буцахгүй!” гэлцэхийг сонсвол хоёр бэхлэлт хоорондо холбоотой байсан бололтой.

Байдал хэдий хүнд байсан боловч зарим нөхдөө ар гэр лүү нь явуулахаар ярилцаж байтал гэнэт Жан Вальжан иржээ.

-Бид ч удахгүй үхэх гэж байгааг та мэдэж байна уу? гэхэд Жан Вальжан хариу дуугарсангүй.

Анжолрас олон нөхөд рүү гээ хандаж:

-Нөхдөө бид ирээдүйн төлөө тэмцэж байна. Урагшаа зоригтой давшицгаа! Удахгүй Европын үрхэнд сайн сайхан жаргах цаг ирнэ. Түүнээс цааш дэлхийн төйд жаргалын үр дэлгэрнэ гэв.

МарЕус Жан Вальжаныг хараад Козеттын тухай бодолд унав...

Анжолрас хүлээтэй байгаа Жавер дэр очиж:

-Чамд юу хэрэгтэй байна аа? гэхэд Жавер:

-Намайг хэдийд алах вэ? гэжээ.

-Хүлээж бай. Гарздах сум ховор байна.

-Тэгвэл над ус өгөөч гэж Жавер хэлэхэд Анжолрас ус авч уулгаад:

-Болов уу? гэхэд Жавер:

-Баганаас босоогоор хүлээтэй зогссоор байгаад ядарч байна. Намайг энэ хүнтэй адил хүлээд хэвтүүлэхгү юу гээд Мабофын хүүрийг заав.

Жаверын хүлээг тайлж байтал гаднаас нэг хүн орж ирээд түүнийг ихэд гайхан ширтэхийг Жавер мэдээд эргэн харвал Жан Вальжан байхыг таньж: “Сонин юм болох нь доо” гэж боджээ.

Гэгээ ороход энд тэндгүй хөдлөх чимээ сонсогдон харгис цэргүүд их буу цэнэглэхэд босогчид буугаа мөн цэнэглэв.

Хоёр талын анхны бууны дуу нижигнэхэд гэнэт Гаврош бэхлэлт дээр гүйж ирэв.

Гаврошийг улсууд тойрон хүрээлэхэд Гаврошийг Мариус хажуу тийш нь чангааж аваачаад чичрэн байж:

-Чи юунд ирээ вэе гэхэд Гаврош ихэмсэг зан гаргаж:

-Юунд! Та өөрөө юу хийж байгаа юм бэ? гээд Мариусыг цоо ширтэв.

Мариус зандрангүй хоолоогойр:

-Чамайг хэн буцаж ир гэсэн юм бэ! Миний захиаг эзэнд нь хүргэж өгсөн үү?

-Таны захиаг зарцад өгсөн. Хүүхэн унтаж байна билээ. Сэрэхтэй зэрэг өгөөрэй гэсэн гэв.

Мариус захиагаар дашрамдуулан Козеттой хагацах ёс гүйцэтгэн, Гаврошийг аврах санаатай байж. Гэтэл санасандаа хүрсэнгүй.

Бэхлэлт дээр байгаа Фошлеваныг явуулсан захидалтайгаа холбон үзэж, Гаврошоос:

-Чи энэ хүнийг таних уу? гэж асуусанд Гаврош:

-Би танихгүй гэжээ.

Мариус Фошлеваны тухай түр зуур бодол болон байх үеэр Гаврош: “Бэхлэлийн нөгөө үзүүрт хүрээд:

“Миний буу хаа байна аа?” гэж хашгирч байлаа.

Курфейрак Гаврошид буу өг гэж тушаав.

Гаврош ирэхдээ бэхлэлт бүслэлтэд орсон байна гэж мэдээлж Гаврошийн замд бослого дарахаар бэлтгэж байгаа цэргүүд олон удаа дайралджээ. Бэхлэлтийн эсрэг талд цэргийн гол хүч цуглараад байгааг үзжээ.

Гаврош энэ мэдээг сонсоод:

-тэднийг суман мөндрөөр дарахыг би зөвшөөрнө гэв.

Энэ үед Анжолрас маш анхааралтай дайсны хүчийг ширтэж байлаа. Анжолрас:

-Толгойгоо бөхийлгөж хана даган сууцгаа гэж команд өгмөгц сарниун байсан босогчид байр руугаа гүйцгээтэл сум, бэхлэлт хэрмийг мөргөн хальтарч хоёр хүн алж, гурван хүн шархтуулав. Энэ янзаар удвал бэхлэлтийнхэн дийлдэх төлөвтэй байлаа. Айн сандарсан чимээн дунд Анжолрас:

-Хоёр дахь буудалд саад хийхийг бодъё гээд дайсны буудагчийг буудан унагаав.

Жан Вальжан байлдаанд оролцолгүй буугаа хоёр хөлийнхөө хооронд хавчуулан сууж байхыг харагсад “Хайран буу ашиглагдахгүй байна” гэлцэв.

Харин бэхлэлтийн цоорхойг бөглөж гудас олж ирээд Жан Вальжан нямбайгаар тагласан явдал сайшаалтай болов.

Гудамжинд ингэж дайн болж байхад Козетт өндөр цонхтой жижиг байшиндаа нойрноос сэрж байлаа. Парист юу болж байгааг Козетт эс мэдэж. Козетт дөнгөж сэрээд байхдаа сэтгэл баясаж байгаад гэнэт Мариусыг бүтэн гурван хоног үзээгүй сэн гэж бодоходоо гунигтай боллоо. Козеттын захиаг Мариус лав авсан байх гэж бодож байлаа. Козетт яасан ч Мариусгүйгээр амьдарч чадахгүйгээ санаав...

#### IV

### ГАВРОШ СУМАН МӨНДРИЙН ДУНДУУР

Гудамжинд ширүүн тулалдаан болсоор...

Бэхлэлтийн ёроолоор буун суман дундуур гудамжинд юм сүүдэгнэн байхыг Курфейрак гэнэт үзэв.

Шил хийдэг сийрсэн сав авсан Гаврош цоорхойгоор гарч гудамжинд алуулсан үндэсний гвардиудын дайзнаас сум түүж явсан нь тэр аж.

-Чи юу хийж явна аа? гэж Курфейрак хашгирсанд Гаврош ажиг ч үгүй:

-Сийрсн саваа дүүргэж явна! Гэв.

-Бууны сум шүнгинэж байхыг үзэхүй байна уу?

-Бороо орж л байна. Яадаг юм бэ!

-Бушуу нааш ир! гэж Курфейрак хашгирсанд:

-Одоохон очлоо! Гэж Гаврош хариулав.

Гаврош ганцхан үсэрч гудамжны яг дунд хүрэв.

Фаникогийн отряд гэдэг ухрахдаа тоймгүй олон цэргээ алуулан гудамжинд хаясан байв.

Гудамжны явган зам дагуу хориос доошгүй үхсэн хүүр байв. Гаврош энэ хорь гаруй хүний дайзнаас сум түүж бэхлэлтийн улсуудад өхөөр боджээ.

Гудамжаар дүүрэн утаа манаран хоёр уулын хооронд тунаран байгаа манан шиг харагдав. Тэр утаа аажмаар дээш хөөрч өдрийн гэрлийг халхлав. Даайтаж байгаа хүмүүс нөгөө талд байгаа хүний барааг үзэхгүй шахуу болжээ.

Багшран харанхуйлсан утааг Гаврош ажиглан үзэхгүй урагшлан явсаар байв. Балчир жижиг биетэй Гаврош сүүдэгнэн явж, долоо найман хүүрийн дайзтай сум хоослов.

Сийрсэн саваа шүдэндээ зуусан Гаврош дөрвөн хөллөн мөлхөж нэг хүүрнээс нөгөөд очиж эргэлдэн түдэгнэж самар цөмж байгаа хэрэм адил дайзтай сум цуглуулан хоосолсоор явна.

Бэхлэлтийн хүмүүс дайсанд сэдэв өгч магад гэж сэжиглэн Гаврошийн хойноос дуудахгүй байж.

Үхсэн даргын өврөөс д рины сав олоод:

-Архины хундага хиймээр юм байна гээд Гаврош түүнийг авч өвөртлөв.

Гаврош явсаар дарины утаа бага бага болсон газар очиход үндэсний гваридиуд үзээд хоорондоо "тэр юу вэ?" гэлцэн буугаа сумлав.

Үхсэн түрүүчийн дайз хоосолж байтал сум үхсэн хүүрийг сийчэн гарахад Гаврош:

-Хогууд чинь үхсэн хүүрийг буудаад яах нь вэ! гэж тургив.

Хоёр дахь сум хажууд халт тусаад исгэрэн алаг болоход гурав дахь сум Гаврошийн сумтай сийрсэн савыг онож унагав.

Гаврош өндийн хараад гвардийг галлаж байхыг мэдэв.

Гаврош хавиргалдан босч зөөлөн хонгор үсээ салхинд хийсгэн байж галлаж байгаа үндэсний гвардиудын эгц өмнөөс ширтэж

Вольтер ахын буруу уршгаар

Булт Нактерынх үзэмжгүй болж

Удамт Полессын ардууд

Рүссог дууриагаад өөдгүй болж гэж дуулаад

Асгарсан сумаа түүж цөмийг сийрсэн савандаа хийгээд суман мөндрийн эсрэг чиглэн дайзтай сум хоосолсоор явахад дөрөвдөх удаагийн сум чихий нь шүргэн өнгөрөв.

Гаврош хуучин янзандаа:

Вольтер ахын буруу уршгаар

Бүтсэнгүй миний санаа

Ухаант Рүссогийн алдаагар

Угийн хүслэн ханасангүй гэж дуулахад тав дахь сумаа дайсан сумлав.

Вольтер ахын буруу уршгаар

Бузар дайсныг би дууриагаагүй

Ухаант Рүссогийн алдаанаас болж

Улигт амьдралд учрав би гэж Гаврош дуулан хорт сумны эсрэг явахад ховдог дайсны эгдүү хөдлөв. Ингэж явах Гаврошид сайхан санагдаж буу буудах бүрд дууны шинэ бадгийг уянгалуулж явав.

Дайснууд зай чөлөөгүй шагайн бүдэвч онохгүй байлаа. Гаврошийг бууныхаа хараанд оруулаад дайснууд инээдалдсаар байхад Гаврош энд тэнд унан босон хомоолын чинээн юмны цаана нуугдан далд орж, алаг даага шиг сүүдэгнэн үсэрч дайзтай сум хоосолж, барьсан сав руугаа хийсээр явав. Гаврошийн нөхөд хойноос харан санаа алдан зогсоход өчүүхэн Гаврош уянгат дуугаа аялан дуулсаар явжээ.

Нүдээ бүлтийлгэж шүлсээ цувруулсан шунахай дайсны сум эцсийн эцэст эвий амьтанг нүхчин гарахад гуйван дайвсаар унах нь харагдав. Газар унасан Гаврош тэр дороо босон суухад булбарай зөөлөн хацры нь дагаж бүлээн цус хүрэнгэн урсжээ.

Гаврош хоёр гараа дээш сунгаж буун дуу гарсан зүг эргээд:

Өсөх балчир насандаа

Өөдгүй ядуу явала ч гэсэн

Өстөн дайсны өмнө

Өвдөг хэзээ ч нугалахгүй гэж гал бадарсан дуугаа чичигнэн дуулж байтал хоёр дахь удаагийн суманд нэрвэгдэж аав ээжээс заяасан алтан амиа алдаж цовоо явсан нүдээрээ цустай газар харуулдан унав.

Баярт дуугаа аялан цууриатуулсаар бяцхан Гаврош хартан дайсны өмнө хайран амиа ингэж алджээ.

## V

### ЭЦЭГ БОЛСОН АХ

Яг энэ үеэр нэг нь долоотой, нөгөө нь тавтай хоёр жаал хүү гараасаа хөтөлцөн Люксембүргийн цэцэрлэг дотуур гүйж явлаа. Хүйтэн бороонд норсон, уранхай дээлтэй туранхай хоёр хүү өд нь өрвийсэн болжмортой адил санж. Ахдаа хөтлүүлсэн бага хүү: “Би өлсөөд байна, хоол идье” гэсээр явна.

Цагдан сэргийлэх газар бослого гарах магад гэж сэргийлэн цэцэрлэгийн үүд хаалгыг хаасан учир Люксембүргийн цэцэрлэгт хүн ер байсангүй.

Гэр орноос төөрөөд чөлөөтэй тэнүүчлэн яваа хоёр хүүхэд бол Гаврошийн асрамжинд орж хоносон хүүхэд мөн байж. Тенардьегээс Маньон авгайд өгсөн Снэ хоёр эцсийн дэмжлэгээс хагаггаж салхин аялсаар явж байсан нь тэр ж.

Алс холд буун дуу гарч аьмтан шуугилдаж байхад хоёр хүү жижиг нурын дэргэд ирээд нуугдтал тавиад настай цэндгэр хөрөнгөтөн зургаан настай шалхгар хүүгээ хөтөлсөөр нурын захад ирэв. Зургаан настай шалхгар тарган хүү гартаа амттай талх барьжээ. Гэдэс цатгалан хүү талхаа үгтээж амандаа хийснээ гадагш тургиж хаяад гүйжээ. Аав нь:

-Чи юунд уйлав аа? гэхэд

-Би талх идэх дургүй байна гэж хүү хариулав.

-Энэ нууранд хөвж яваа хун шувуунд талх чулууд! Гэж эцэг хэлэхэд хүү талхаа ус руу хаяв.

Хөвж яваа хун талх хараад айсүй байхад эцэг хүү хоёр буцаж одов.

Нуугдаж байсан хоёр хүү усанд хаясан талхыг хун шувуунаас урьтан авч хуваан идэж голоо норгов.

Талхны их хэсгийг дүү нь авч багы нь ах өөрөө авчээ.

## VI

### СУМАНД СИЙЧҮҮЛЭВ

Мариус, Кмбефер хоёр хойноосоо гудамж руу гүйлдэв. Мариус нас барсан Гаврошийг тэвэрсээр, Комбефер сийрсэн савтай сумбарьсаар буцаж ирэв.

Мариус бөхийж Гаврошийг авч байхад толгой нь шархадсаны учир Мариусын нүүрийг даган цус гоожиж байв.

Энэ үеэр Жан Вальжан огт хөдлөлгүй сууж байхыг хараад Комбефер:

-Бэхлэлт дээр ирээд байлдахгүй суухын хэрэг алга! Гэхэд Анжолрас:

-Аавын хүү алагтай булагтай, арын мод урттай богинотой байдаг гэдэг юм даа гэжээ.

Гудамжнаас авч ирсэн Гаврошийг Мабоф өвгөний хүүргийн дэргэд тавиад хар юмаар бүтээжээ...

Босогчид харгис дайсантай амь хайрлахгүй тулалдсаар байв.

Анжолрас, Мариусад дайн командалж байх тушаал өгөөд эцсийн удаа доод давхарт орохоор хөдлөв:

Анжолрас Жаверын хажууд очоод гар буугаа гаргаж өмнө нь тавиад:

-Хэн сүүлд гарах хүн энэ буугаар тагнуулыг алаарай гэтэл Жан Вальжан орж ирээд Жаварыг аваачиж алах хүслээ илэрхийлсэнд Анжолрас:

-Наад тагнуулаа аваачиж учры нь хай! Гэсэнд Жан Вальжан Жаверыг алахаар дагуулан хөдлөв.

Жан Валжан Жаверыг нилээд зайдуу аваачаад хүлээг тас огтлон суллаж:

-Та суллагдсан. Бушуу зайл гэхэд Жавер гүйж далд оров.

Жаверын бараа тасармагц Жан Вальжан агаар өөд хий буудаад буцаж бэхлэлт дээр очихдоо:

-Би үүргээ биелүүлээд ирлээ гэжээ...

Дайсны дайралт далайн шуурга шиг ширүүсэв. Дайсан урьд шөнө нь харанхуйгаар бэхлэлтийн дэргэд могой шиг чимээгүй мөлхөн ирж хүчээ хуралдуулсан байв. Өдөр болсон хойно дайсан их буугаар зай чөлөөгүй галлаж дайран довтолж, явган цэргүүд бэхлэлт рүү шууд дайран довтолов.

Босогчид эхлэлт дээрээсээ хариу гал нээсэн боловч дайсан сэхээ авахуулсангүй газар болгоноор дайрав. Гэсэн ч бослогынхон зүрх шантралгүй давуу хүчтэй дайсны эсрэг тулалдав. Хоёр талаас амс гэх чөлөөгүй ширүүн байлдсанд гудамж үхсэн хүнээр дүүрэв.

Ширүүн тулалдаан дундуур бослогонд оролцогчдын сум цөөрч эхэв. Курфейрак толгой нүцгэн зогсож байтал:

-Чиний малгай яасан бэ? гэж Боссеюэ асуухад Курфейрак:

-Их бууны сам аваад явчсан гэв.

Буудсан сумны хонгио бүх бэхлэлтийг цас шиг бүрхжээ.

Дайсны дайралт хойно хойноосоо тасрахгүй байсан учир байдал аюултай Үолсоор. Арав дахин дайраад бэхлэлтийг авч чадсангүй. Гардан бай«даан эхлэв. Жад, гар буу, сэлэм, зангидсан гар бүхнийг хэрэглэн улаан халз учрав. Дээр, доор, хажуу, өмнөт зүг бүрээс бууджээ. Цусаа урсгасан аюул тэмцлийн дундуур Боссеюэ, Фой, Курфейрак, Жоли нар алагдаж, шархадсан цэргийг татан босгохоор өндийсөн Комбефер цээж рүүгээ дайсанд гурав жадлуулан үхэв.

Мариус байлдсан хэвээр. Тархи толгойдоо учир тоймгүй олон шарх олсон Мариусын нүүр улаан цусанд будагдан танигдахгүй боллоо.

Анжолрас ганцаараа шархдаагүй байж. Анжолрас зэвсгээ бариад баруун зүүн тийшээ гараа сарвалзуулахад хажуугийн хүн гартаа тохиолдсон бууг авч өгч байж...

Анжолрас, Мариус хоёроос өөр бослого удирдах хүн үлдсэнгүй. Энэ түгшүүрт цагийг дайсан ашиглан шороо шиг багширсан бэхлэлтийг сэт цохин оров...

Үндэсний гвардиуд доод давхрыг эзлээд хоёр дахь давхар өөд гарахад тэнд Анжолрас ганцаараа амьд үлдсэн байж. Анжолрас сумаа дуусч сэлмээ алдаад бууныхаа гол төмрийг гартаа атгажээ. Анжолрас бильярдын ширээгээр халхавч хийж, тасалгааны буланд шигдэн нүдээ ч ирмэхгүй зогсоход дайснууд:

-Бослогын удирдагч энэ байнаб Энэ чинь их буучинг алсан. Өөрөө буланд орсон хохь нь. Тэндээ байг. Дор нь буудаж алъя гэж хашгирцгаав.

-Намайг бууд! Гэж Анжолрас хэлэв.

Анжолрас бууныхаа хугархайг газар хаяад хоёр гараа зөрүүлэн сугавчилж цээжээ бууны ам руу харуулв.

Хорин цэрэг тасалгааны нөгөө талд жагсаж буу сумлав.

-Буугай шагай гэж дарга тушаав. Энэ үеэр нэг дунд тушаалын дарга ирээд:

-Битгий бууд гээд Анжолрасаас:

-Нүдий чинь боох уу? гэв.

-Хэрэггүй.

-Их бууны түрүүчЭйг та алсан уу?

-Тиймээ!

Өчигдөр оройноос хойш сандал дээр согтуу унтаж байсан Грантэр энэ үеэр сэрж, Анжолрасын байгаа газар орсныг цэргүүд анхаарсангүй. Грантэр өндөр бүдүүн хоолойгоор:

-Бүгд Найрамдах улс мандтугай! Би энэ хүнтэй хамт үхнэ! Гээд Анжолрастай зэрэгцэн зогсов.

-Бид хоёрыг одоохон ал! Гэж Гран тэр хэлээд Анжолрас руу эргэж:

-Чамтай хамт үхэхийг зөвшөөрөх үү! Гэсэнд Анжолрас инСэд алдан гары нь атгажээ.

Анжолрасын инээсэн төлөв арилах завгүй буун дуу нижигнэж найман сум нэг зэрэг Анжолрасыг сийчэн гарчээ. Анжолрас хадуулсна адил хананд наалдан зогссоор байв. Грантэр Анжолрасын хөлийн хажууд унав. Гэнэт Анжолрасын толгой салжгас гэж бөхийн унав...

Тулалдаанд гар бие оролцоогүй сууж байсан Жан Вальжан Мариусыг хүнд шарх олж унахыг хараад босон харайж шүүрэн аваад бэхлэлтээс холдож хотын доогуур ухсан муу усны хоолойн нүх рүү шомбос гээд алга болжээ...

Жан Вальжан хүнд шархдан ухаан алдсан Мариусыг үүрч үмхий холойг даган харанхуй нүх дотуур явахдаа хамаг хүчээ барьж амь тэмцэн үхэх шахсаар арай гэж зайдуу газар олж түр амсхийхээр суув...

Жан Вальжан, Мариус, Козетт хоёрын тухай бодолд автагдан байтал үл таних хүн мөрнөөс нь татан

-Олзыг дундуур нь хуваая! Гэжээ.

-Юу вэ? Энд хүн байгаа бололтой. Жан Вальжан өөрийгөө солиорч байна гэж бодоод чагнасанд таг чимээгүй. Хачин юм даа гэж санаад эргэн харав.

Дэргэд нь танихгүй хүн зогсож байв. Тэр хүн Жан Вальжанд чимээ сонсохгүйн тулд гутлаа тайлан бариад өмд цамцтай зогсож байж, ажвал тэр хүн Тенардые мөн ж.

Жан Вальжан Тенардые хоёр ширтэцэн дуугүй зогсов. Тенардые түрүүлж:

-Чи эндээс яаж гаръя гэж бодож байна гэж асуухад Жан Вальжан хариу хэлсэнгүй. Тенардые үргэлжлүүлэн:

-Дуугүй суухын оронд гарах аргаа бодсон нь дээр байхаа гэхэд Жан Вальжан:

-Зүйтэй гэж.

-Тэгвэл олзоо дундуур нь хувааж авъя.

-Чи юу хэлээд байна вэ?

-Чи ч энэ хүнийг цааш нь харуулаа шив дээ. За яах вэ. Надад түлхүүр байна даа гээд Тенардые хуруугаараа Мариусыг зааж,

-Би чамайг танихгүй ч гэсэн чамд тус хүргэх санаатай. Чи найзтай эр шиг байна гэж Тенардые хэлэхэд Жан Вальжан өөрийн нь хүн алсан хүн болгож байгааг сая ойлгож эхлэв.

Тенардые дахин:

-Өвгөөн чи сонс. Чи энэ сайн эрийг алсан хойно лав мөнгий нь авсан байж таарна. Авсан мөнгөнөөсөө миний хувийг нааш нь өг. Би хаалга онгойлгоё гэхэд Жан Вальжан огт үг хэлсэнгүйд Тенардые:

-За маяглаад яах вэ! Олзоо хуваая. Би чамд гарах хаалганы түлхүүр үзүүллээ.

Чи над авсан мөнгөө харуул гэжээ.

Жан Вальжан өврөө уудалж гучин франк авч Тенардыед өгсөнд:

-За одоо гарч болно. Манай энд Яармагтай адил, мөнгө урьдчилан авдаг. Мөнгөө төлснөөс хойш ооо гарч болно гэв.

Тенардые, Мариусыг Жан Вальжаны мөрөн дээр тавиад сувгаас гадагш гарах хаалга онгойлгож Жан Вальжаныг гаргаад хаалгаа дотроос нь цоожлон цааш далд

оржээ. Бодвол муу усны нүхний хоолойг дагаж дээрэмчид байрладаг болсон бололтой.

## VII

### ЖАВЕРЫН ҮХЭЛ

Жан Вальжан Мариусыг голын эрэгт тавиад амарч суулаа. Ухаангүй байсан Мариусын нүүр лүү ус самардан цацаж усы нь арилгаж байтал ард нь юм хөдлөх шиг болж.

Эргээд харахад өндөр нуруутай, урт өмдтэй, хоёр гараа цээжин дээрэ зөрүүлсэн хүн бөхөсхийж, Мариусыг шагайж байж.

Тэр хүн Жавер байжээ.

Жавер Тенардьег мөрлөн хөөж яваад энд ирсэн байв. Бэхлэлт дээрэс суларсан Жавер тэр дороо цагдан сэргийлэхийн даргад очиж гудамжинд юу болж байгааг дэлгэрэнгүй мэдээлээд үүрэгт ажилдаа орж, цагдаа нарын анхаарлыг татах болсон Сен мөрний баруун эргийг тагнахаар томилогдсон ажээ. Баруун эргийг хөвөөлдөн явж байгаад Тенардьег хараад хойноос нь явж байсан нь тэр аж.

Жан Вальжаны хамаг бие арзас гэжээ. Ойр зуурхан хоёр эвгүй уулзалт тохиолдож Тенардьегийн гаас мултран Жаверын саварт орох нь аюултай байлаа.

Газар доогуур явж хамаг бие нь шавар шавхайд болсон Жан Вальжаныг Жавер танилгүй захирангүй дуугаар:

-Та хэн бэ? гэв

-Би.

-Би гэж хэн бэ?

-Жан Вальжан.

Жавэр түүнийг таниад гайхас хийв.

Жан Вальжан:

-Харгалзагч Жавер таны гарт би орлоо. Би танд олзлогдлоо. Би танаас нуугдахын тулд гэрээ зааж өгөөгүй. Надаад явал ч яа. Би танаас ганцхан юм гуйя. Энэ Мариус гэдэг хүн бэхлэлт дээр байлдаж байгаад шархдан ухаан алдсан юм. Би энэ хүнийг өвгөн аавд нь хүргэж өгөлгүй болохгүй гэхэд Жавер морин тэрэг дуудан авч ирээд гурвуул Жильнорманыд очихоор хөдлөв.

Замдаа нэг ч үг ярилцсангүй.

Жильнорманыд Мариусыг хүргэж өгөөд Жан Вальжан:

-Би гэртээ түргэн ороод ирье. Дараа нь та намайг дур зоригоороо шийтгээрэй гээд тэндээс хөдлөн Зэвсэгт хүний гудамжинд гСртээ ороод шатаар явж байхдаа цонхоор харахад Жавер алга болчсон байлаа.

Жавер Зэвсэгт хүний гудамжаас аажмаар холдсоор явлаа.

Жавер анх удаа амьдралдаа нуруугаа үүрч толгойгоо бөхийлгөн явжээ. Жаверын сэтгэл санаанд гүн өөрчлөлт гарч их түгшүүртэйгээр албан газар луугаа явахын оронд Сен мөрийн эрэг чиглэжээ.

“Би Жан Вальжаныг насныхаа турш мөрдөж муу санаа санаж явсан юм сан. Гэтэл Жан Вальжан надаас болж хичнээн хүнд зовлонд учирлаа ч гэсэн намайг өршөөж, ёстой хүний чанараа харууллаа. Хүн ийм нандин авралт сэтгэлтэй байхад би адгууснаас дор юм хийж явжээ. Цаашдаа би ямар замаар явах вэ? Амьтан хүнд тус хүргэхийн оронд хор хүргэж явдаг над шиг ёргүй амьтан үхсэн дээр” гэж Жавер

боджээ. Тэгээд ч Сен усыг харахад ус харанхуй татан хуйларч байлаа. Минутын дараа урт хар дүрс өндийгөөд ус руу унаж живжээ. Үүнийг ганцхан шөнөөс өөр юм харсангүй.

## **ХОЁРДУГААР ДЭВТЭР**

### **ГЭРЛЭЛТ**

I

#### **МАРИУС ИРГЭНИЙ ДАЙНЫ ДАРАА ГЭР БҮЛИЙН ДАЙНД ОРОВ**

Мариус өвгөн аавындаа ирээд удаан хугацаагаар эмчлүүлэн сувилуулж нилээд сайжрав. Мариус ухаан орсон цагаасаа хойш данда Козеттыг мөрөөдөх боллоо. Тийм ч учраас нэг өдөр Мариус:

-Аваа би гэрлэх санаатай байна гэхэд Жильнорман:

-Тэгнэ ч байх гэж бодсон юмаа гээд инээж

-Юу тэгнэ ч байх гэж?

-Сэтгэлтэй охинтойгоо суудаа хүү минь гэхэд Мариус баярлан чичрэв.

Жильнорман цааш хэлэхдээ:

-Үзэсгэлэнтэй хөөрхөн бүсгүйтэй суудаа. Тэр бүсгүй өдөр бүр ирж чиний бие ямар байгааг асуудаг юм. Чамайг шархадсан өдрөөс хойш хөөрхий амьтан өдөр болгон уйлан гашууддаг болсон. Зэвсэгт хүний гудамжийн долоон тоот байшинд суудгий нь хүртэл би асууж мэдсэн. Ханилан суух гээд байгаа бол суудаа гээд Мариусыг тэврэн үнсэв.

Мариус өвгөн аавынхаа гараас мултарч:

-Аваа! Би нэлээд сайжраад байна. Одоо түүнтэй уулзъя, болох уу? гэв.

-Ингэж хэлнэ байх гэж би бодсон. Маргааш уулзаарай.

-Өнөөдөр уулзахад яасан юм бэ?

-Тэгсэн ч болох юм. Би одоохон хүн явуулж хэл хүргэе. Тэр бүсгүйг чинь авч ирж чамтай уулзуулъя...

II

#### **ХОЁР АМРАГ УУЛЗАВ**

Козетт Мариус хоёр учирлаа.

Энэ уулзалт ямар байсныг үгээр хэлж үзгээр бичихэд бэрхтэй. Нарнаас эхлээд дүрслэн үзүүлэхэд бэрх зүйл олон байдаг юм шүү.

Козетт гаднаас орж ирэхэд Мариусын дэргэд бүх гэр бүл цөм цугларсан байж.

Козетт босгон дээр үзэгдэхэд орчин тойронд нь туяа цацрах шиг боллоо.

Яг энэ үеэр Жильнорман найтаах гэж хамраа алчуураар таглаад Козеттыг шагайн харав.

-Мөн ч ганган бүсгүй байна гээд найтаав.

Козеттын сэтгэл хөдлөн баясаж учраа олж ядан зогсож үл мэдэг үг хэлэн царай хувьсан байв.

Козеттын хойноос төлөв зантай, буурал үстэй хүн орж ирээд эвгйү хүйтнээр инээмсэглэн байх нь “Фошлеван” гэгч Жан Вальжан мөн аж.

Жан Вальжан хав хар хувцас өмсөн цагаан галстуг зүүсэн нь гоёмсог сайхан.

Жан Вальжан Мариусын өрөөний хаалганы хажууд зогсжээ. Жан Вальжаны суганд цаасанд боодолтой ном бололтой юм хавчуулаастай. Боодолтой юмны ороолт ногоовтор өнгөтэй учраас хөгцөөр хучигдсан мэт.

Ном үзэн яддаг Жильнорман эмэгтэй:

-Энэ ноён дандаа ном сугавчилж явдаг юм уу даа? гэхэд өвгөн Жильнорман шивнэн:

-Гайхах юу байсан юм Үэ! Эрдэмтэй хүн. Муухай юу байсан юм бэ. Миний танил Булар гэрээс гарахдаа үргэлж зүрхэн талдаа ном хавчуулж явдаг байсан гээд зочдод баяр мэнд хүргэн чангаар:

-Ноён Жан Вальжан! Миний ач хүү барон Мариустай ханилан суух охины чинь гарыг барилцуулъя ачтайгаа гээд Мариус Козетт хоёрын зүг эргэн ёсыг баримталж:

-Одоогоос эхлэн та хоёр хувь заяагаа холболоо! Гэжээ.

Тэр хоёр энэ үгийг дахин давтуулалгүй ойртон, Мариус орон дээрээ өндийж, Козетт өмнө нь зогсоод аяархан хоолойгоор: “Ээ бурхан минь! Тантай ингэж учирдаг байж. Та, Чи! Байлдахаар тийш явсан гэнэлээ! Юунд явсан юм бэ! Бодохоос зүрх чичирнэ. Бүтэн дөрвөн сарын турш би айж үхэх шахаж байлаа. Та дайтахаар явдаг яасан зүрхтэй хүн бэ! Би танд буруу юу хийсэн билээ? Би таныг зэмлэхээ байя. Дахин тийм юм бүү хийгээрэй. Бас биднийг нааш нь урьж авч ирэхээр очиход би бяарласнаас болж бас үхэх дөхлөө. Би мөн их гунихарч үзлээ! Би хувцсаа ч өмсөж амжсангүй. Хүн харах аргагүй байгаа байх. Таны ах дүү төрөл садан миний муухай хувцастайг хараад юу гэх болоо? Та одоо ярь! Би дандаа ганцаараа яриад байна. Бид Зэвсэгт хүний гудамжинд хуучнаараа. Таны мөр аймшигтай шархадсан уу? Зангидсан гар орчмоор том шарх байсан гэж над хэлсэн. Унжсан махнуудыг хайчаад хайчилж хаясан байхаа? Яасан аймаар юм бэ! Би нулимсаа барагдтал уйлсан. Хүн ихийг даадаг юм байна шүү. Танай өвгөн аав их сайхан зөөлөн царайтай хүн байна. Бүү хөдөл. Битгий тохойлд бие чинь өвдөнө. Би жаргалаа үзлээ! Бидний зовлон төгслөө. Би шал тэнэг амьтан болоод байна. Би танд маш их юм хэлэх гэснээ бүгдийг мартчихлаа. Та урьдынхаа адилаар над хайртай хэвээрээ юу? Бид Зэвсэгт хүний гудамжинд суусан янзандаа. Тэнд цэцэрлэг байхгүй гэхэд Мариус:

-Хонгор минь зүрх минь! гэв.

Тад хажуугийнхаа хүмүүсээс ичиж өөр үг ч хэлсэнгүй, халуун гараа энэрэнгүйгээр атгалцав.

Тасалгаа дотор байгаа бүх хүмүүст хандаж Жильнорман өвгөн:

-Чанга ярилцаачээ олон минь! гэснээ Мариус Козетт хоёр луу ойртоод аяархнаар:

-Чи гэлцэж байгаад ярилц даа хоёулаа! Гэв.

Жан Вальжан төлөв аятайгаар:

-Ноёхон Эфронзи Фошлеван зургаан зуун мянган франктай гээд, Жильнорманы ном гэж бодож байсан боодолтой юмаа задлан таван зуун наян дөрвөн мянган франк үзүүлсэнд Жильнорманыхны сэтгэл их баярлав...

Энэ мөнгийг Жан Вальжан Шанматьегийн хэрэг таслалтын дараа Монфермейлийн ойд нуун газар булжээ. Жан Вальжан мөнгө нуухад сэжиг авсан Башка гэгчийг чадлын хирээр хайсан боловч амжилт олоогүй хоосон хоцорчээ.

Жан Вальжан газарт булсан мөнгөө саявтарсан очиж авахад Башка мөн даган мөрдөөд хоосон нүх харан хоцорсон түүхтэй...

Жан Вальжан Жавер цагдаагийн савраас үүрд мултарчээ. “Монито” сонинд Жавер нэртэй харгалзагч цагдаа сэтгэл санаагаар хүнд байдалд ороод хоёр гүүрний хооронд усанд живж үхсэн тухай мэдээг Жан Вальжан олж уншаад: “Намайг барьж авснаа суллан тавьсныг бодоход тэр Жавер цагдаа лав ухаан солиорч явсан байж таарлаа” гэж боджээ...

## **ГУРАВДУГААР ДЭВТЭР**

### **ХАГАЦАЛ**

I

#### **1833 ОНЫ ХОЁРДУГААР САРЫН 16**

1833 оны хоёрдугаар сарын 16, 17-ны шөнөн ам гүм гайхалтай тайван. Мариус Козетт хоёрын ханилсны анхны шөнө байж. Маргааш өдөр нь маш баясгалантай өнгөрчээ...

Урьд өдөр нь Жан Вальжан таван зуун наян дөрвөн мянган франк Мариусад эцгийн нь дэргэд хүлээлгэн өгч Мариус Козетт хоёр хамтаар хөрөнгөжжээ.

Энэ өдрөөс эхлэн Түсэн Жан Вальжанд хэрэггүй болсон тул Козетт тэр бүсгүйг өөрийн зарц болгожээ.

Жильнорманыхан Жан Вальжанд тусгйа цэвэр сайхан бүрэн хэрэгсэлтэй өрөө засан бэлтгэжээ. Козетт энэрэнгүй сэтгэлээр “Ааваа та энд суугаарай” гэхэд Жан Вальжан бараг зөвшөөрөх шахжээ.

Хурим хийхийн өмнөхөн Жан Вальжан баруун гарынхаа эрхий хуруу огтолсон учир бага зэрэг зовлонтой байдалд орсон аж. Жан Вальжан шархандаа бага шаналж, хэнээр ч түүнийгээ боолгодоггүй байлаа. Жан Вальжан тэр шархаа өөрөө боосонд бага зэрэг өвдөж гарын үсэг зурахад саад болох болжээ.

Уншигч олныг хотын захиргаагаар оруулж сүм хийдээд аваачихаа байя. Дурласан хоёрын хойноост өдий л их харах сайн биш байдаг шүү дээ. Гэсэн ч Жильнорманы байрнаас гараад Сен-Поль гэдэг сүм хүрэх замд тохиолдсон нэг учралыг дурдъя.

Вангийн цэцэрлэг гэдэг гудамжнаас эхлүүлээд морин тэрэг явах зам хаагдсан байжээ. Үүний улмаас Сен-Поль сүм рүү шууд очих зам байсангүй. Тэгээд Мариус Козетт хоёрыг сүмд аваачих тэрэг тойруу замаар явах болж.

Хуримын эхний тэргэнд Козетт хадам эгч, аав, мөн Жан Вальжаны хамт, Мариусын хэв заншлыг баримтлан эхнэрээс нь тусад нь тэргэнд суулгасан байв. Тэдний явах замд гудамж дүүрэн тэрэг ээлж дараалан жагсаад хөдөлж ядан байж. Бөөгнөрсөн морин тэрэгний хажуугаар улсууд багшралдан чихцэлдэж тэрэгний цонхоор шагайжээ. Болох бүтэлгүй олон хүн суулгасан тэрэг гудамжны баруун талд яг Козеттын сууж явсан тэрэгний эсрэг зогсоход баруун талын тэргэнд суусан багт хүн:

-Хурим найрын тэрэг байна гэхэд нөгөө нэг нь:

-Манай тэнд хурим ингэж хийдэггүй юм. Энэ чинь хүн оршуулж байгаа тэрэг байна гэжээ.

Гудамжны нөгөө талд байсан Козеттыг шоглох бололцоо байхгүй баг өмссөн тэр хоёр хүн арга тасрахдаа нүүрээ буруулав. Хоёр хүний сууж явсан тэрэгнийхэн цагдаа хараад нүүрээ буруулахыг бодвол тэд төдий л их цэвэр үйл амьдралтай улс биш бололтой. Тэдний дундаас нэг эрэгтэй хүн:

-Чи анхаар! Гэжээ.

-Юу болоо вэ? ааваа?

-Чи тэр өвгөнийг харж байна уу?

-Ямар өвгөн?

-Эхний тэргэнд яваа өвгөнийг хар да.

-Гараа боосон уу?

-Тиймээ.

-Тэгээд юу гэж?

-Би тэр өвгөнийг андахгүй.

-За тэгээд?

-Чи тэрэгнээс гараад тэд чухам ямар маягийн улс болохыг сайн мөрдөж тагнаад ир. За тэг миний охин бушуухан гүй! Миний Азельма чинь дуулгавартай охин байгаа юмаа гэтэл хоёр талын тэрэгнүүд цааш хөдлөв.

## II

### ХҮН ИРЛЭЭ

Мариус Козетт хоёр садан төрлийнхөнтэйгээ хамт сүмээс гэртээ ирсний дараа Жан Вальжан хариад бие нь өдрөөс өдөрт муудсаар байж. Козетт мөн аавыгаа дурсан санаж ирж байна уу? гэж асуух аж.

Зэвсэгт хүний гудамжинд гэртээ ганцаараа байсан Жан Вальжан бие их муудаж хүнд байх үедээ Козетт руу явуулахаар бичсэн захидалд:

“Миний охин Козетт сайн явж сайхан жарг арай. Би чамд санаснаа хэлье. Чиний нөхөр бага зэрэг алдаа хийж намайг яв гэсэн ойлгоц төрүүлсэн явдал зүйтэй. Мариус тун их хүн сайтай юм. Намайг нас барсны дараа нөхрөө хайрлан хүндэтгэж дурлаж яв! Ноён Понмерси та ганц охины минь үргэлж хайрлан энхрийлж байгаарай. Козетт чи энэ захидлыг хүлээж аваад хичнээн мөнгө байсныг санаарай. Энэ мөнгө цөмөөрөө үнэхээр чинийх шүү...” гэж дурдаад сэтгэлдээ “ингээд цөм дууслаа. Миний амьдралын чимэг болсон Козетт охиноо харахаа өнгөрчээ. Сүүлчийн удаа Козеттоо би харалгүй нас барах нь ээ. Ганц минутын төдий Козеттоо харж дууг нь сонсон хацры нь илэх сэн! Тэгээд үхэхэд гомдол алга. Үхэх амархан боловч Козеттоо харалгүй үхэх шиг ерөөлгүй юм байхгүй. Намайгаа хараад ганц үг ч хэлдэг болоосой доо. Ингэлээ гээд хүнд муу юм болох уу? Үгүй. Би гон бие гозон толгой ингээд Козеттоо үзэлгүй үхдэг байж бурхан минь, бурхан минь” гэж боджээ...

Жан Вальжан иймэрхүү байдалтай байхад Мариусад зарц нь нэг захиа авч ирж өгөөд гадаа хүн ирээд хүлээж байна гэжээ. Мариус тэр захидлыг хараад тус хүргэхээр олоогүй хүний бичсэн захидал мөн байгааг сэхээрчээ.

Мариус захиаг задалбал:

“Ноёнтон минь!

Хэрэв бурхан намайг авъяастай төрүүлсэн бол би Барон Тенар болж шинжлэх ухааны академийн гишүүн байх сан. Тийм заяатай төрдөггүй болохоор би Барон болсонгүй. Би ганцхан нэр нэгтэй хүн. Үүнийг та анхаарч үзвэл би баярлах болно. Та над харлцан туслалцаа үзүүлнэ үү: Би нэг эмэгтэйн нууцыг мэднэ. Та тэр эмэгтэйтэй холбоотой болсон байна. Би танд тус хүргэхийн тулд тэр нууцыг толилуулъя. Яма<sup>о</sup> ч эрхгүй мөртөө тантай очиж наалдсан тэр олиггүй эмэгтэйг та хөөвөл жаргах болно. Сайн хүний үр гэмт муу эмтэй суухад бэрх болно.

Би таныг дор хүлээж байн . Таныг хүндэтгэгч Тенар” гэж г рын үсэг зуржээ.

Зурсан нэр бүрэн бүтэн биш аж.

Мариус бичгийнхээ ширээнээс мөнгөний бичиг гаргаж өвөрлөөд зарцдаа:

Гадаа ирсэн хүнээ нааш оруул гэхэд зарц очиж хэлжээ.

Удсан ч үгүй нэг хүн орж ирэв.

Мариус тэр хүнийг ажиж хараад:

-Та ямар хэргээр яваа вэ? гэхэд гаднаас ирсэн хүн матар хорхой шиг нүүрээ үрчийлгэн зэвүүнээр инээж:

-Би урьд дипломат байсан. Одоо амьдралаас уйдаж гүйцлээ. Америкад очиж Панамаас холгүй газар зэрлэг хүмүүсийн дунд амьдрах хүсэлтэй... Хувиа бодогч үзэд ертөнцөд ноёрхох боллоо. Хоосон хүний нохой баян хүнд хуцаж, баячуулын нохой ядуучуудыг хоргоох зэргээр юм болгон хар амиа бодох болж. Ашиг орлого олохын төлөө хүн амиа өгч байна. Алтанд сорогдохгүй хүн алга. Би эхнэр, нэг охиныхоо хамт алттай газар очиж шингэх гэсэн юм. Алтанд ойрхон мөнгө их хэрэгтэй болоод байна. Надад бага зэрэг мөнгө төгрөг хэрэгтэй байна гэхэд Мариус:

-Над огт хамаагүй хэрэг гэв.

-Саяхан өгүүлсэн миний захиаг та уншаагүй юу?

Мариус ирсэн хүнийг туршиж:

-Та тодорхой ярь гэсэнд тэр хүн гараа өвөртөө хийж:

-За тэгвэл би тодорхой ярья. Танд нэг нууц тайлж өх гэсэн юм. Энэ нууц танд ихээхэн хэрэгтэй. Танайд алан хядагч хулгайч орогноод байна. Саяхан гарсан гэмт хэргийг хэн ч мэдээгүй байна. Олиггүй хулгайч нэрээ өөрчлөөд таны байшинд орсон байна. Би танаас хөлс мөнгө шаардахгүй. Нэрий нь хэлээд өгье. Нэр нь Жан Вальжан урьд дээр үед хоригдол байсан хүн гэхэд Мариус хариуд нь:

-Эд бүхнийг би мэднэ, дуулсан гэв.

Үл таних хүн:

Таны эхнэрийн тухай нууц задалъя. Энэ эмэгтэй биеэ худалддаг муу амьтан. Түүнийг би хамгийн түрүүнд хямдханаар хорьхон мянган франкаар худалдъ гэсэнд Мариус:

-Энэ нууцыг би бас мэднэ. Таныг үг над ашиг болохгүй. Ямар санаатай ирсний чинь мэдэж байна гэжээ.

Гадны хүний нүд гялалзан хашгирч:

-Би хоол идэх гэсэн хүн! Танд би нууц хэлж өгье. Над хорин франк өгөөд орхи!

Гэхэд Мариус ширтэн харж:

-Хэлэх гэсэн нууцы чинь, Жан Вальжаныг мэддэгтэйгээ адил мэднэ. Таны нэрийг сайн мэднэ гэж.

-Миний нэрийг үү?

-Тэгэлгүй яах вэ.

-Миний нэр хэлэхэд амарха, Тенар гэдэг.

-дье гэж нэмье.

-Юу?

-Тенардые. Та ажилчин Жондретт, жүжигчин Фабанту, шлэгч Жанфло гэх мэтийн олон нэртэй шүү дээ. Та Монфермейльд хөлсний байшингийн эзэн байсныг хүртэл би мэднэ гээд Мариус:

-Май! Олон юм бүү донгос гэж таван зуун франк нүүр лүү нь шидэв.

Тенардые гартаа бэлэн мөнгө атгаад баярласандаа зэвүү царайлан бөхөлзөн байтал Мариус:

-Тань шиг худалч, хулгайч, зусарч амьтан алга! Та алан хядагч яргачин! Дээрэмчин! Та надтай нэг байшинд байхдаа дээрэм хийж хүн алах гэж байсны чинь би нүдээрээ харсан. Май! Мянган франк аваад зайл! Май дахиад таван зуун франк ав! Та Ватерлоогийн тулалдааны үед миний эцэгт тус хүргэснийхээ ачаар амьд үлдэж байна. Та хүний адаг болсон амьтан. Май ахин гурван мянга фра-к аваад бушуухан долоон уулын цаагуур тонил! Маргааш түргэн Америк руу зайл! Өөр газар очиж дүүжлүүлж үх! Гэв.

Дээр дурдсан хэрэг гарсны дараа хоёр хоноод байхад Тенардые Мариусын туслалцаатайгаар өөрийн охин Азельмагийн хамт Америк руу явжээ. Тенардые америкад очоод ч засарсангүй, бузар хэргээ үргэлжлүүлэв. Мариусын өгсөн мөнгөний ачаар Тенардые боол худалдагч ч болж хувирчээ.

Мариус Козетт хоёр маш яар тэргэнд суугаад Зэвсэгт хүний гудамжийн долоон тоот байшинд очихоор хөдлөв.

### III

## ОХИНОО ҮЗЭЭД БАЯРЛАВ

Хаалга тогшиход Жан Вальжан эргэн хараад:

-За ор гэж сулхан дуугаар хэлэв.

Хаалга онгойж Козетт Мариус хоёр орж ирэв. Мариус үүдэнд үлдэхэд Козетт аавынхаа зүг гүйв.

-Козетт оо! Гээд Жан Вальжан хагартлаа аярлаж, хоёр гараа сунгаж өндийн суухад гар нь чичирч царай нь цайжээ.

Сандран амьсгаадсан Козетт Жан Вальжаныг тэврэн авч:

-Аваа! Гэж хэлэв.

Гайхан сандарсан Жан Вальжан сөөнгө хоолойгоор:

-Козетт оо! Миний хүү чи ирээ юү! Гэснээ Козетт тэврэн авсныг мэдээд:

-Чи минь хүрээд ирэв үү! Чи надад гомдоогүй хэвээрээ байна уу? гэж хашгирчээ.

Мариус уйлахгүйг хичээж нүдээ хагас аниад урагшаа нэг алхаж аяархнаар:

-Аав минь ээ! гэхэд Жан Вальжан:

-Та надад муу юм санаагүй байна уу? Гомдоогүй юу? гэжээ.

Мариус нэг ч үг хэлж чадсангүй.

-Танд баярлалаа гэж Жан Вальжан нэмж хэлэв.

Козетт алчуур малгайгаа авч орон дээр тавиад:

-Саад болоод байх м гэв.

Козетт аавынхаа өвдгийн дэргэд тулж суугаад буурал үсий нь ар тишй илбээд духнаас нь үнсэв.

Ухаан мансуурсан Жан Вальжан юм хэлсэнгүй.

Юу болж байгааг ойлгож ядсан Козетт Мариусын сэтгэлийг илэрхийлэн улам зөөлнөөр үнсэн таалав.

Жан Вальжан шивнэн:

-Хүн мөн ч тэнэг юм аа! Би охиноо ахиж харахгүй боллоо гэж бодсон. Би та хоёрыг орж ирэхийн өмнөхөн: "Ингээд дуусдаг байж. Козеттын багын хувцсыг харсаар биеий нь үзэхгүйгээр нас барах нь" гэж ганцаараа ярьж суулаа. Энэ үер та нар шатаар дээш гарч явсан. Би тэнэг явж дээ? Хүн гэдэг мөн ч тэнэг явдаг юм байна даа! Козеттоо хараагүй байхдаа даанч их зовж байлаа. Одоо миний охин ирээд байхад хичнээн сайхан! Гээд тэнхээ тамир алдарч өчүүхэн зуур дуугүй сууснаа:

-Би Козеттоо үе үе үзэж байхгүй бол болохгүй бэрх байсан. Миний сэтгэл ганцаардаж өөрийгөө илүүдсэн хүн байна гэж бодож байсан билээ. Би өөртөө: "Чи тэдэнд хэрэг байхгүй, оногдсон буландаа хэвтэж бай. Тэднийг уйтгах хэрэг байхгүй" гэж ятгах үг хэлж байлаа. Козеттоо харах шиг жаргал алга. Козеттоо чиний ханилсан нөхөр чинь яасан ганган эр вэ? Чиний зүүсэн зах яасан сайхан юм бэ! Энэ зургийг нөхөр чинь шилж олсон юм. Чамд кашмир хийцтэй алчуур бйах хэрэгтэй гэв.

Козетт аавдаа:

-Та биднийг хаяад явчдаг буруу. Та хаашаа удаан алга болчоод байсан юм бэ? Урьд нь та яваад гурав дөрөв хонохоос илүү болдоггүй байсан. Николеттон явуулахад таныг гэртээ алга гэж очдог байсан. Та хэдийд буцаж ирсэн бэ? Бидэнд юунд хэлээгүй вэ? Та сүрхий өөр болсон байна. Ичихгүй байна уу! Таныг өвчлэй байгааг бид мэдээгүй. Мариусаа аавын гарыг бариад үздээ. Яасан хүйтэн болчоо вэ? гэхэд Жан Вальжан:

-Та надд муу юм санаагүй ирсэн чинь тун сайн байна. Тийм үү Понмерси минж ээ? гэв.

Жан Вальжаны үгийг сонссон Мариусын зүрх хөдөлж:

-Козеттоо сонсов уу. Намаг гомдсон муу санасан байх гэд байна! Энэ хүн надад муу юм хийсэн гэж Козетт чи бодоо юу? Энэ хүн миний амьдралыг авсарса. Үүгээр зогсоогүй чамайг надтай ханилуулсан. Миний амь аврагч, чамтай танилцуулад дараа юу хийсэн бэ? Бусдад туслах гэсээр өөртөө хор хүргэсэн. Ёстой буянтай хүн байгаа юм. Хүнд тус хүргэдэггүй хүйтэн сэтгэлтэй надад: "Би таннд баярлалаа!" гэх юм. Тэгж болохгүй. Би энэ хүний дэргэд суугаад бүх насаа өнгөрөөсөн ч ач тусы нь хариулж чадахгүй. Намаг дайн тулалдаан дундаас аварч үмхий усан хоолойг даган үүрч явсаар биеэ зовоожээ. Энэ хүн чи бид хорёын төлөө байдгаараа зүтгэлээ! Өөрийнхөө биеэр халхалж намагй мянга түмэн үхлээс аварсан. Алтан дэлхийд хүн болж төрснийхөө ач гавъяаг гүцээсэн хүн. Козеттоо! Аав чинь бурхнаас илүү ачтай хүн юмаа. Тан шиг бурхан ч байхгүй гэсэнд Жан Вальжан:

-Битгий тийм үг хэл гэжээ.

-Та юунд санаснаа хэлдэггүй юм бэ? Энэ талаар та буруутай. Та хүмүүсийн амийг аврагчаар түүнийгээ хэлэхгүй нуудаг. Байгуулсан гавъяагаа нууснаараа өөртөө буруу юм хийж байн. Тэгж болохгүй! гэж Мариус хэлэхэд:

-Би үнэнээ хэлсэн гэж Жан Вальжан хэлэв.

Маруис эсэргүүцэж:

-Тийм биш хэлсэн үгэнд чинь үнэнтэй зүйл байвч та бүрэн гүйцэд үнэнээ хэлээгүй, та Мадлен гэдэг нэртэй явсан. Яагаад үүнийг хэлээгүй вэ? гэв.

-Би тантай адилхан бодож явсан. Таны зөв гэж би санасан. Би та нарыг орхих ёстой байсан. Хэрэв та үмхий усан хоолой дундуур үүрүүлж явснаа мэдсэн бол намайг гэрээсээ холдуулахгүй байсан. Ийм учрас би юу ч хэлэхгүй явсан. Хэрэв би үнэнээ хэлсэн бол бусдад саад болох байсан.

-Юунд? Хэнд саад болох юм бэ? Та эндээ үлдэнэ гэж бодож байна уу? Бид таныг орхихгүй аваад явна. Би гэнэтийн учралаас болж эд бүхнийг мэдсэн минь сайн боллоо! Би таныг эндээс аваад явна. Та бид нар салшгүй амьдралтай болсон улсууд. Та Козетт бид хоёрын эцэг. Та энд муухан байшинд нэг ч хонохоо байсан. Маргааш эндээ байнаа гэж бүү бод! Гэж Мариус хэлэв.

-Маргааш болохд би энд ч байхгүй, танайд ч байхгүй болсон байна гэж Жан Вальжан хэлжээ.

Маруис:

-Та юу ярьж байна? Таныг явахыг бид зөвшөөрөхгүй. Та биднээс хэзээ ч хагацахгүй, та манай хүн болсон. Таныг хаашаа ч явуулахгүй гэхэд Козетт угтан авч:

-Бид худлаа хэлэхгүй. Доор тэрэг хүлээж байгаа. Таныг заавал аваачна. Явахгүй гэвэл хүч хэрэглэнэ гээд инээж өвгөнийг өргөх гэж байгаа дүр үзүүлэв.

-Өрөө чинь таныг хүлээсээр бий. Цэцэрлэг дотор хичнээн сайхан байна гэж санана! Тэнд мод бүхэн цэцэглэж амьтан болгон цэнгэж жиргэж байна. Цэцэрлэг дотор танд тусгай жимс тарих газар гаргаж өгнө. Таны тарих гүзээлзгэнэ лав минийхээс илүү ургах байх. Би таны хүссэн бүхнийг хангая. Та ганцхан миний үгэнд ор гэв.

Жан Вальжан Козеттын үгийг сонсохдоо сонсож, үгүйдээ үгүй байв. Жан Вальжан Козеттын дууг сонсож, хэлж байгаа үгийг ойлгосонгүй. Сэтгэлийн нууцын шүр болсон зөөлөн нулимс мэлтэлзэн бүрхсэн Жан Вальжан:

-Бурхны ачаар охин минь дэргэд байсаар байна гэхэд Козетт:

-Аваа! Гэж дуудав.

Жан Вальжан:

-Хамт амьдарвал хичнээн сайхан бэ! Модон дотор шувуу лав дүүрэн байгаа. Козеттогоо хамт зугаалах сан. Нэг нэгнийхээ мэндийг үг ярилцан цэцэрлэг дотуур явах шиг жаргал хаа байх билээ! Өглөөнөөс аваад хамт байж ноогдсон булангаа арчлан тарих юм сан, Козетт намайг гүзээлзгэнээр цатгаж, би Козеттыг цэцгээр чимж явбал мөн ч жаргалаа. Тэгж амьдарвал тун гоёо! Гээд Жан Вальжан зосгоод аяархнаар:

-Харамсалтай байна даа гээд нулимсаа зогсоож инээв.

Аавынхаа гарыг атгасан Козетт:

-Таны гар улам хүйтэн болж. Бурхан минь. Та өвдөж байна уу? Бие тань муу юу? гэж сандарсанд Жан Вальжан:

-Би өвдөөгүй. Надад аятай байна. Ганцхан... гэв.

-Ганцхан юу?

-Ганцхан би үхэх нь.

Козетт Мариус хоёр айн цочив.

-Үхнэ гэж үү? Гэж Мариус хашгирав.

-Санаа зовох хэрэггүй гэж Жан Вальжан хэлэв.

Жан Вальжан санаа алдаж инээгээд:

-Козеттоо! Яриагаа үргэлжлүүл. Жижиг шувуу үхсэн байна. За я'ь би чиний дууг сонсох дуртай байна гэж дахин ярьсанд Мариус мэл гайхаж өвгөнийг ширтжээ.

Козетт яс шархиртал орилон:

-Аав аа! Аав минь ээ! Та амьдрах ёстой. Та амьд явах болно. Таныг амьд яваасай гэж би хүсэж байна.

Та миний үгийг сонсоно уу? гэхэд Жан Вальжан өндийн Козеттоо хараад:

-Намайг битгий үхүүлээрэй. Би чиний үгэнд лав орох байх. Та нарыг ирэхэд би үхэж байсан. Та нарын ирсэн хойно би харин сэргэлээ гэж бодсон гэв.

Мариус:

-Таны бие зүгээр байна чадал тэнхээ чинь барагдаагүй байна. Хүн тийм амархан үхдэг юм гэж та бодож байна уу? Та зовлон үзсэн, дахиж зовохгүй. Та намайг өршөөгөөрэй. Би танаас сөгдөн гуйя! Та бидэнтэй хамт урт удаан амьдарна. Бид таныг хамт аваад явна. Козетт бид хоёр ганцхан сайн сайхны төлөө зүтгэх болно гэв.

Козетт нүдний нулимс бөмбөрүүлэн:

-Та удаан явна гэж Мариус бас хэлж байна шүү дээ аав аа! гэхэд

Жан Вальжан инээсээр байв.

-Ноён Понмерси намайг аваачлаа гээд би өөрчлөгдөх үү? Үгүй. Бурхан өршөөлөөрөө бол. Миний үхэх зүйтэй. Хнд байдлаас ангижрах ганц арга бол үхэл. Бурхан биднээс илүү мэдэгж байгаа ноён Понмерси Козеттой жаргаж, өглөөний нар ши гмандж, өнгөт дэлхий адил цэцэглэж, өргөн мөрөн мэт бялхаж золтой жаргалтай амьарч явах болтугай. Би үхэхээрээ үхье. Одоо яасан ч аргалах нөхцөл алга боллоо. Үүнийг ойлгож үзээч дээ. Нэг цагийн өмнө би ухаан алдаж унасан. Өнгөрсөн шөнө энэ хугацаагаар дүүрэн ус би уусан. Козеттоо чиний нөхөр яасан сайн хүн бэ! Чи надтай байсанд орвол нөхөртэйгөө байсан нь хол дээр.

Хаалганы цаана мөлийн чимээ сонсдоод эмч орж ирэв.

-Сайна байна уу? Үүрд баяртай! Миний хүүхдийг хардаа эмчээ! гэж Жан Вальжан хэлэв.

Мариус эмчид ойртон очоод:

-Хүндэт эрхэм доктороо? Гэх нь лав нэг зүйл асуух гэсэн бололтой. Эмч нүдээрээ хариу өгөв.

Жан Вальжан:

-Бүтэлгүй юм болоо гэж бурхныг зэмлэсний хэрэггүй гэж.

Хүн бүхэн сэтгэл түгшин дуугүй болов.

Жан Вальжан Козетт руу эргэж охины дүрийг үхэл рүү хамт аваачих гэсэн шиг маш анхааралтай харав. Жан Вальжан хэдийгээр үхлийн харанхуй үүдийг татсан боловч Козеттоо харан гайхсаар байж. Козеттын зөөлөн дүр өвгөний өгөр даасан нүүрэнд тусаж байгаа мэт. Үхэлд бас тохирсон баяр байдаг бололтой.

Эмч судас барьж:

-Өвгөн та нарын төлөө санаа зовоод байсан байна шүү гэж Мариус Козетт хоёр луу харан хэлээд Мариусын чих рүү тонгож шивнэн:

-Аргагүй өнгөрчээ гэв.

Жан Вальжан гэнэт Козеттоос хараагаа салгаж Мариус эмч хоёрыг харад дөнгөж сонсогдохоор:

-Үхэх ч гайгүй хэрэг. Амьдрахаа болино гэдэг аюултай байна гэснээ, бүх хүчээ шавхан өндийж босоод ажиггүй алхсаар хананд ойртон Мариус, эмч хоёрыг гараараа зайлуулж жижиг гуулин бурхан авч гэдрэг сууж бурхнаа ширээн дээр тавиад сөөнгө хоолойгоор:

-Их зовсон амьтан энэ шүү гэж дөрвөн мөчөө тэлүүлсэн бурхнаа харан хэлэв.

Дараа нь Жан Вальжаны толгой бөхийж мөр нь унжин өвдөг дээр байсан гар нь хоосон маажлав.

Аавынхаа мөр түшиж байсан Козетт уйлсаар хэдэн үг солих гэсэн боловч санасандаа хүрсэнгүй. Гашуудан уйлах чимээ дунд:

-Аваа! Битгий биднийгээ орхиоч! Бид хагацахын учралаар уулзаагүй сан биш үү?! Гэх үг сонсогджээ...

Үүний дараа Жан Вальжан үхлийг үргээж байгаа мэт толгойгоо сэгсрээд бүр ухаан саруулхан болов. Козеттын ханцуйг шамлан гары нь үнсэхэд Мариус:

-Эмч ээ! Сэргэж байна, ухаан орж байна гэсэнд нь Жан Вальжан:

-Та хоёр хоёул зан сайтай улс! Миний сэтгэлийг түгшээж гомдоосон байсан зүйлийг ярья. Понмерси та энэ мөнгийг хөдөлгөөгүйд би гомдсон. Энэ мөнгө таны эхнэрийн үндсэн хөрөнгө. Та хоёрыг үзээд сэтгэл баясаж байгаагаа хэлье. Хар шилний материалыг англиас, цагааныг Норвегис авч ирдэг. Энэ тухай би бичсэн захидалдаа дурдсан. Захиа тэр байна, уншаарай. Би бөлзөг бугуйвчинд цутгамал оосор хийх арга олж үзэмжтэй, хямдхан болгосон.

Энэ аргаар мөнгө их олж болно. Ийм учраас хөрөнгө хогшил Козеттынх байх ёстой. Та нарын санааг тайвшруулж амьдралдаа тус хийхээр үүнийг ярьж байна гэв.

Эмчээс, битгий орж ир гэсэн зарц эмгэн шатаар гарч ирээд тэссэнгүй Жан Вальжаны чихэнд:

-Лам дуудах уу? гэхэд Жан Вальжан:

-Надад лам байна гэж хэлээд хуруугаа тэнгэр өөд гозойлгожээ.

Козетт аяархан ар талд дэр тавьж өхөд Жан Вальжан:

-Ноён Понмерси та олон юм бодолгүй тайван бай. Энэ зургаан зуун мянган франк яах аргагүй Козеттын өмч хөрөнгө. Үүнийг та хэрэв авахгүй гэвэл миний амьдрал дуусах нь тэр. Шилээр эдлэл хийх талаар бид их амжилт олсон. Манай шилэн эдлэлүүд “Берлиний үнэт эдлэлтэй” тэнцэхээ л тэнцэнэ. Эдгээрийг германы хар шилт зэрэгцүүлж болох уу? Үгүй. Манай хийсэн юм бол дээр, үнээр хямд гэв.

Бидний дотнын хайрт хүн нас барах гэхэд бид аль болохоор үхүүлэхгүйг боддог. Зовлонд нирвэгдсэн Козетт Мариус хоёр гараа барилцан Жан Вальжаны өмнө үхэлтэй яаж тэмцэх арга олж ядан зогслоо.

Жан Вальжан минут бүр доройтсоор, гол тасрах тийш амьсгаа нь жигд бус болон заримдаа цээж нь хэржигнэх боллоо. Хөш хөшиж гар хөдлөхөө байж бие сулрах тутам царай нь улам буянтай хүний шинж илчлэх авч нөгөө ерөнцийн сүүдэр нүдэнд нь бүргэлзэн туссан харагджээ.

Инээж байгаа нүүр улам цайсаар, амьд шинжээ алдаад өөр шинжтэй болжээ. Нүд нь гөлөрч, амьсгаа цөөрөөд үхсэн сүнс маягтай.

Жан Вальжан, Козетт, Мариус хоёрыг дохиогоор дуудав. Амьдралын эцсийн минут болсон бололтой. Алсад гарсан дуу шиг сулхан хоолойгоор ярих нь тэдний хооронд өндөр сүрлэг хана босч байгаа мэт.

-Наашаа ойрт хоёул. Би та нарт их хайртай. Ингэж үхэх тун сайхан аа! Миний Козетт бас над хайртай. Чи надаас огт салдаггүй байсныг би мэднэ. Миний охин намайг хайрлахдаа ар талд дэр тавьж өгсөн. Чи намайг үхэхэд уйлах уу? Удаан бүү уйлаарай. Би чамайг ёстой сүрхий гашуудал ороосой гэж хүсэхгүй. Хүүхэд минь та нарт цэнгэж жаргаж явахаас өөр юу ч хэрэг байхгүй... Би энэ зургаан зуун мянган франкийг шударга хөдөлмөрөөрөө олсон юм шүү. Понмерси та муу юм бүү бодоорой. Та нар тэрэг худалдаж ав. Цэнгэлдэх хүрээлэнд олигтой суудалд суугаад юм үзэ яв. Козеттод гоёлын хувцас хэрэгтэй шүү. Гаднын хнийг сайн зочилж, жаргалтай яваарай. Аягын хариу өдөртөө гэж байдаг. Энэ тухай би Козеттод бичсэн. Козетт чи миний захиаг олж унш! Зуух яээр байгаа лааны хоёр тавиурыг Козетт аваарай. Тэр тавиур цэвэр алт шүү. Тавиурыг анх над өгсөн хүн тэнгэрт санаа амар байгаа эсэхийг би мэдэхгүй байна. Би та нарын тусын тулд байдгаараа зүтгэсэн. Би ядуу хүн. Намайг зайдуухан газар оршуулаад тэр газартаа чулуугаар шав тавиарай. Өөр юм хэрэггүй. Чулуун дээр нэр битгий бичээрэй. Козетт хааяа нэг эргж очвол би баярлах болно. Мариус бас намайг эргэж байгаарай. Би Мариусад хайргүй явсан

удаа бий, түүнд битгий гомдоорой. Одоо Козетт та хоёроос үнэтэй хүн над алга. Мариус танд баярлалаа. Козетты минь жаргалтай байлгаарай, Козеттын зөөлөн ягаан хацар дандаа намайг баясгаж байсан. Жаахан гунихрахтай хамт миний сэтгэл зовдог байлаа. Авдарт таван зуун франк бий, би гар хүрээгүй. Түүнийг ядуучуудад өгөөрэй. Козеттоо чиний багын хувцас тэр орон дээр байгааг үзэж байна уу? Таних байх чи, түүнийг өмсөхөө байснаас хойш арван жил өнгөрчээ. Цаг мөн ч хурдан өнгөрөх юм даа! Бид жаргалтай байсан шүү, хүүхдүүд минь битгий их уйлцгаа. Би та нараас төдий холдохгүй очсон газраасаа та нарыг харж байх болно. Харанхуй шөнөөр та нар миний хойноос харвал би тэндээс инээж байх болно. Козеттоо чи Монфермейльд байснаа санана уу? Чи харанхуй шөнө ус авахаар явж байхдаа их айж явсан. Тэхэд би хувинтай усны чинь сэнжнээс дамжлалцаад явсан. Анх удаа чиний хөөрхөн гарт би хүрсэн. Гар чинь их хүйтэн байж билээ. Тэхэд айхавтар улаан байсар гар одоо хичнээн цагаан бол@о вэ? Би чамд том хүүхэлдэй авч өхөд чи түүнийг Катерина гэж нэрлэсэнэ санана уу? Тэрнийгээ сүмд авч ороогүйдээ чи харамсаж байж билээ. Чи намайг олон удаа инээлгэж байсан, борооны дараа чи усан дотор сүрэл хийчээд хөвж явахыг гайхаж суудаг сан. Би чамд ногоон цэнхэр өдтэй чавх авч өгсөн. Чи түүнийг лав мартсан байх. Чи багадаа хөөрхнөөр тоглож суухдаа их дуртай сан. Интор аваад бөнжигнүүлж байсан. Тэр бүхэн цөм өнгөрчээ. Чамтай хамт ой туулж модон дотор зугаалж, сүмд хоргодон нуугдж байсан бүхэн эртний хэрэг юм. Эд бүхэн дандаа надтай хамт учирч явах юм гэж бодож явсандаа, би их тэнэг байж. Тенардьегийнхэн маш муу айл байсан. Тэднийг өршөөх хэрэгтэй. Козеттоо Би чиний эхнийн нэрийг хэлэх цаг болжээ. Эхий чинь Фантинь гэдэг байсан. Фантинь гэж сайн тогоож ав! Тэр нэрийг хэлэх бүрдээ сөгдөн мөргөж яв! Чамдаа туйлын хайртай байсан ээж чинь зовлон зүдүүр их амсаж ээжийн чинь үзсэн зовлон чиний эдэлж байга жаргалтай тэнцэнэ. Бурхан тийм болгосон байх. Бурхан тэнгэрт мандаад тэндээс бүхнийг ширтэж байна. За хүүхдүүд минь би явдаг замаараа явлаа. Үргэлж нэг нэгэндээ халамжтай яваарай. Нэг нэгэндээ хайртай элэгсэг явахаас илүү юм ертөнц дээр байхгүй шүү. Энд ингэсээр нас барах өвгөнөө санан дурсаж байгаарай. Би Козеттоо хараагүйдээ санаа зовсоор байгаад улам муудсан юм. Би гудамжны өнцөг хүрээд л буцдаг байсан. Улсууд намайг тэнэг гэсэн байх. Би галзуу хүнтэй адил болсон удаа бий. Нэг удаа малгайгаа өмсөхөө мартаад гадаа гарсан. Хүүхдүүд минь би юм үзэхээ мартаад гадаа гарсан. Хүүхдүүд минь би юм үзэхээ болих гээд байна. Хэлэх захих юм их байна санж. За өөрөө мэдэг: Намайг заримдаа дурсаж яваарай даа, буян болно шүү. Ганцхан гэгээнээс өөр юм үзэхээ бйлаа. Юу болоод байна аа? Ойртоцгоо! Би жаргалтай үхэж. Хайрт хонгор хүүхдүүд минь би толгойг чинь илье гэжээ.

Уйлан мэгшсэн Козетт Мариус хоёр өвгөний өмнө сөгдөн гары нь барив. Жан Вальжаны сайхан гар хөдөлгөөнгүй болсон байв:

Жан Вальжан гэдрэг унахад лааны хоёр тавиурын гэрэл нүүрий нь гэрэлтүүлжээ. Хувхай даасан нүүр тэнгэр ширтэж, Козетт Мариус хоёр гары нь үнсжээ. Жан Вальжан амьсгаа хураасан байлаа.

Тэнгэрт ганц ч од харагдахгүй хав харанхуй шөнө боллоо. Энэ харанхуй дунд үхсэн хүний сүнс аваачих гэсэн бурхан далавчаа дэлгэн хүлээж байсан ч байж магад.

#### IV

### ӨВСӨНД НУУГДАЖ, БОРООНД УГААГДСАН ЧУЛУУ

Олон хүний хүрээс холгүй, хотын баячуудын хүрээс зайдуухан, аюулт үхлийн нүүрийг харуулсан дурсгалт гоё найзуудаас холовдор Пэр-Лашез гэдэг хүүр оршуулах газар дээр хуучин хананы ёроолд зангууд ороолгон бүслүүлсэн өндөр мөодны дэргэд шаваг, луулийн дунд чулуу хэвтэнэ. Тэр чулуу хөгц хаг, шувууны баасанд дарагдан гай гамшигт автагджээ. Чулуу бороонд норон ногоорч салхинд үлээлгэн харлажэ. Тэр хавиар ногоо өндөр, чийг ихтэй учир хүний хөл ер гишгэдэггүй болохор огт з ам гарсангүй. Тэнд нар тусмагц мэлхий цугларна. Эргэн тойронд зэрлэг овъёос ганхан, хавар цаг модон дээр шувуу жиргэнэ. Хүний биеийг далдалж чадахаар урт өргөн хэмжээтэй бэлтгэсэн ердийн энэ чулуу ганцаараа харагдана.

Олон жилийн өмнө хэн нэг хүний бичсэн дөрвөн мөр шүлэг өдрөөс өдөрт элэгдэн хуучирсаар бороо шороонд дарагдан уншиж боломжгүй болжээ. Тэр шүлгийг сайн ажиж хичээнгүйлэн уншвал:

Харанхуй хатуу зовлонд дарагдсан хүн

Хайран амиа алдахад энд оршуулсан.

Халамжит өдрийн дараа шөнө болох адил

Хагацалт үхэлтнүүд нэг тохиолдсон гэжээ.

**1862 он.**

Эх сурвалж:

Формат, фонт зэргийг бага зэрэг янзалж pdf

хэлбэр уруу хөрвүүлсэн:

[www.e-pada.com](http://www.e-pada.com)

The Weatherman

<http://weatherman.blog.banjig.net/>